



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОН 06 ДУГААР САРЫН 22-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2023 оны 06 дугаар сарын 22-ны өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2-17
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	18-119
<i>1.Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.04.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	21-52
<i>2.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 32 гишүүн 2023.01.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	52-57
<i>3.“Олон улсын иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай конвенц”-д нэгдэн орсныг соёрхон батлах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.05.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	57-59
<i>4.“Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенцын нэмэлт протокол”-ыг соёрхон батлах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.05.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	59-60
<i>5.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.06.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	60-67
<i>6.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.06.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	67-69
<i>7.Боловсролын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.06.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	69-89
<i>8.“Эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлийг хянан шалгах” асуудлаар хянан шалгах түр хороо байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн нарын 28 гишүүн 2023.06.09-ний өдөр өргөн мэдүүлсэн/</i>	90-91
<i>9.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа 2022.12.30-ны өдөр, Засгийн газар 2023.01.18-ны өдөр тус тус өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	91-99
<i>10.“Онцгой албан татварын тухай хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай” Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 04 дүгээр дүгнэлт</i>	100-112
<i>11.Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл /Засгийн газар 2021.06.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	113-118

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
06 дугаар сарын 22-ны өдөр /Пүрэв гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 73 гишүүнээс 37 гишүүн хүрэлцэн ирж, 50.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 18 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Ц.Анандбазар, Т.Аубакир, Х.Баделхан, Э.Бат-Амгалан, Д.Батлут, Ж.Бат-Эрдэнэ, Б.Бейсен, Х.Болорчулуун, С.Бямбацогт, С.Ганбаатар, Д.Ганбат, Б.Жавхлан, Г.Занданишатар, М.Оюунчимэг, Ц.Сандаг-Очир, Д.Сарангэрэл, Ц.Туваан, Н.Учрал, Б.Энх-Амгалан, Т.Энхтүвшин;

Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Ё.Баатарбилэг, Л.Оюун-Эрдэнэ, Ц.Сэргэлэн;

Эмнэлгийн чөлөөтэй: Ц.Цэрэнпунцаг;

Тасалсан: А.Адъяасүрэн;

Хоцорсон: С.Амарсайхан-1 цаг 06 минут, Ж.Батсуурь-09 минут, Т.Доржханд-08 минут, Д.Өнөрболор-15 минут, Ж.Сүхбаатар-03 минут, Д.Цогтбаатар-31 минут, Б.Энхбаяр-06 минут, Ж.Эрдэнэбат-06 минут.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням, Б.Пүрэвдорж нараас ирүүлсэн албан бичгийг танилцуулав.

Хэлэлцэх асуудлын дараалалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням хэлэлцэх асуудлын дарааллын арван зургаадугаарт орсон Боловсролын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэх асуудлын дарааллын долоодугаарт оруулж хэлэлцүүлбэ гэсэн горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдиннямын гаргасан горимын саналыг дэмжбэ гэсэн санал хураалт явуулбэ.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 16

Бүгд: 40

60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул уг асуудлыг хэлэлцэх асуудлын долоодугаарт оруулж хэлэлцэхээр тогтов.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж үг хэлэв.

Нэг.Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.04.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Соёлын сайд Ч.Номин, Соёлын сайдын ахлах зөвлөх С.Оюунбилэг, Соёлын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Отгонбат, мөн яамны Хууль, эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Батцэцэг, Соёлын бүтээлч үйлдвэрлэл, инновацын хэлтсийн дарга Г.Батхуяг, Соёлын өвийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Даваацэрэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх А.Болортуяа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт Н.Монголмаа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Соёлын сайд Ч.Номин, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибал, Б.Саранчимэг, Ч.Ундрэм, Б.Баярсайхан, Ц.Мөнх-Оргил, Ж.Сүхбаатар, Г.Мөнхцэцэг, Б.Дэлгэрсайхан, Б.Жаргалмаа, Г.Ганболд, О.Цогтгэрэл нарын тавьсан асуултад Соёлын сайд Ч.Номин, Соёлын яамны Хууль, эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Батцэцэг, Соёлын бүтээлч үйлдвэрлэл, инновацын хэлтсийн дарга Г.Батхуяг, Соёлын өвийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Даваацэрэн нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа, Б.Энхбаяр нар үг хэлэв.

Л.Мөнхбаатар: Байнгын хорооны саналаар Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих нь зүйтэй гэсэн санал хураалтыг явуулъя.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 19
Бүгд: 45
57.8 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 12 цаг 20 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 32 гишүүн 2023.01.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Н.Мөнхзэсэм, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж нар танилцуулав.

Төслийн үзэл баримтлалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболор, Н.Энхболд нар үг хэлэв.

Л.Мөнхбаатар: Байнгын хорооны саналаар Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих нь зүйтэй гэсэн санал хураалтыг явууля.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 21

Бүгд: 45

53.3 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 12 цаг 39 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. “Олон улсын иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай конвенц”-д нэгдэн орсныг соёрхон батлах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.05.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ч.Батбямба, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан референт П.Хулан нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Дэлгэрсайхан танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар Хууль зүйн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Олон улсын иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай конвенц”-д нэгдсэн орсныг соёрхон батлах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт,

өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 23
Бүгд: 45
48.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 21
Бүгд: 45
53.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Олон улсын иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай конвенц”-д нэгдсэн орсныг соёрхон батлах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 21
Бүгд: 45
53.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Хуулийн төсөл буцаах тухай” тогтоол баталсанд тооцов.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар “Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./12:49/

Уг асуудлыг 12 цаг 49 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв. “Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенцын нэмэлт протокол”-ыг соёрхон батлах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.05.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ч.Батбямба, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан референт П.Хулан нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Дэлгэрсайхан танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар Хууль зүйн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенцын нэмэлт протокол”-ыг соёрхон батлах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн:	23
Татгалзсан:	15
Бүгд:	38

60.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцов.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар “Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./12:54/

Уг асуудлыг 12 цаг 54 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.06.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Ерэн-Өлзий, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга З.Мөнх-Оргил, Хуулийн хэлтсийн дарга Л.Мөнхжаргал, Эрчим хүчний зохицуулах хорооны зохицуулагч П.Товуудорж, мөн хорооны Үнэ тарифын газрын дарга Б.Эрдэнэбулган нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Л.Батмөнх, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболорын тавьсан асуултад Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн хариулж, тайлбар хийв.

Үдийн завсарлагын цаг болсон тул хуралдаан 13 цаг 07 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 23 минутад эхлэв.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёолоор санал хураалт явуулав.

Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал:

Л.Мөнхбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболорын гаргасан, Хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд, Д.Өнөрболор нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 19
Бүгд: 39
51.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёолоор санал хурааж дууслаа.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 14 цаг 32 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.06.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Ерэн-Өлзий, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга З.Мөнх-Оргил, Хуулийн хэлтсийн дарга Л.Мөнхжаргал, Эрчим хүчний зохицуулах хорооны зохицуулагч П.Товуудорж, мөн хорооны Үнэ тарифын газрын дарга Б.Эрдэнэбулган нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Л.Батмөнх, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрийн тавьсан асуултад Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн хариулж, тайлбар хийв.

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 14 цаг 39 минутад хэлэлцэж дуусав.

Долоо.Боловсролын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.06.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд Г.Ганбаяр, Боловсролын ерөнхий газрын дарга Т.Ням-Очир, Боловсрол, шинжлэх ухааны яамны Сургуулийн өмнөх боловсролын хэлтсийн дарга Ж.Мягмар, мөн яамны Боловсролын нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын шинжээч Ж.Нарантуяа, Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах шинжээч Ч.Баярмаа, Мэргэжлийн боловсрол, сургалтын хэлтсийн дарга А.Халиунаа, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн секторын эрхлэгч У.Туяа, Монголын боловсрол, шинжлэх ухааны үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга З.Цогтгэрэл, Монголын хувийн хэвшлийн бага, дунд сургуулиудын холбооны тэргүүн Н.Номин, Хувийн цэцэрлэгийн үүсгэн байгуулагчдын холбооны тэргүүн А.Цэнгэл, “Бүх нийтийн боловсролын төлөө” Иргэний нийгмийн үндэсний эвслийн ерөнхий зохицуулагч Д.Тунгалаг, Боловсрол, шинжлэх ухааны сайдын орон тооны бус зөвлөх Д.Билгүүдэй нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх А.Болортуяа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт Н.Монголмаа, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн ажлын албаны дарга С.Далхаасүрэн нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай Хууль зүйн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг, Д.Өнөрболор, О.Цогтгэрэл, Г.Мөнхцэцэг нарын тавьсан асуултад Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Л.Энх-Амгалан, ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин, Б.Пүрэвдорж, Н.Ганибал, Х.Ганхуяг, Ч.Хүрэлбаатар, Л.Энх-Амгалан, Т.Доржханд, Ж.Чинбүрэн нар үг хэлэв.

Боловсролын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлэг асуудлаар Улсын Их Хурлын гишүүн,

Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Д.Тогтохсүрэн ажлын 3 өдрийн завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар завсарлага авав. /15:54/

Уг асуудлыг 15 цаг 54 минутад хэлэлцэж дуусав.

Найм. “Эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлийг хянан шалгах” асуудлаар хянан шалгах түр хороо байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн нарын 28 гишүүн 2023.06.09-ний өдөр өргөн мэдүүлсэн/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх С.Дунжидмаа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр, Хууль, эрх зүйн газрын референт Г.Нямсүрэн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн ажлын албаны дарга С.Далхаасүрэн нар байлцав.

Төслийг хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Саранчимэг танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн, Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга П.Анужин “Эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлийг хянан шалгах” асуудлаар хянан шалгах түр хороо байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг дахин хэлэлцүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд буцаах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн П.Анужингийн гаргасан горимын саналыг дэмжжэ гэсэн санал хураалт явуульа.

Зөвшөөрсөн: 20

Татгалзсан: 19

Бүгд: 39

51.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.2-т “нэгдсэн хуралдаан шаардлагатай гэж үзвэл уг асуудлыг дахин хэлэлцүүлэхээр холбогдох Байнгын хороонд буцааж болно” гэж заасны дагуу “Эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлийг хянан шалгах” асуудлаар хянан шалгах түр хороо байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг дахин хэлэлцүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд буцаав.

Уг асуудлыг 16 цаг 02 минутад хэлэлцэж дуусав.

Ес. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа 2022.12.30-ны өдөр, Засгийн газар 2023.01.18-ны өдөр тус тус өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Д.Цолмон, мөн газрын ахлах шинжээч Ш.Цолмон, шинжээч М.Цолмон, Монголбанкны Удирдлага, төлөвлөлтийн

газрын мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх асуудал хариуцсан ахлах референт Б.Гантуяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх А.Болортуяа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан референт П.Хулан, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн ажлын албаны дарга С.Далхаасүрэн нар байлцав.

Хуулийг төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, Б.Баттөмөр нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар хариулж, тайлбар хийв.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төслийн талаарх ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар, Л.Мөнхбаатар, Б.Пүрэвдорж нар /цаашид “Ажлын хэсэг” гэх/-ын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 20¹.1 дэх хэсэг, 3 дугаар зүйлийн “нөлөө бүхий хувьцаа” гэсний дараа “эзэмшигч, түүний эцсийн өмчлөгч” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	27
Татгалзсан:	14
Бүгд:	41

65.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн Тайлбарын “17.1-д заасан” гэсний дараа “томилогдох” гэж нэмж, “18.1.1-д заасан төрийн захиргааны” гэснийг “18.2-т заасан” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	27
Татгалзсан:	14
Бүгд:	41

65.9 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 20¹.3 дахь хэсгийн “зөрчсөн нь” гэсний дараа “Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тухай, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон холбогдох бусад хуульд заасны дагуу Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт, шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор гэм буруутай нь тогтоогдсон бол тухайн” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27
 Татгалзсан: 14
 Бүгд: 41
 65.9 хувийн саналаар дэмжигдлээ.

4. Улсын Их Хурлын гишүүн Б.Дэлгэрсайханы гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн Тайлбарын “төрсөн,” гэсний дараах “дагавар,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28
 Татгалзсан: 13
 Бүгд: 41
 68.3 хувийн саналаар дэмжигдлээ.

5. Улсын Их Хурлын гишүүн Б.Дэлгэрсайханы гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн Тайлбарын “хамтран амьдрагчийн” гэсний дараа “одоо хамт амьдарч байгаа” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ үг хэлэв.

Зөвшөөрсөн: 28
 Татгалзсан: 13
 Бүгд: 41
 68.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр. Найруулгын санал

Л.Мөнхбаатар: 1. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 20¹.1 дэх хэсгийн “Засаг даргын албан тушаал эрхэлж байгаа хүн” гэснийг “Засаг дарга” гэж өөрчилж, “хөтөлбөр” гэсний дараах “эсхүл” гэснийг хасаж, 20¹.3, 29.6 дахь хэсгийн “20¹ дүгээр зүйлд” гэснийг “20¹.1, 20¹.2-т” гэж өөрчилж, мөн 29.6 дахь хэсгийн “төр,” гэснийг хасаж, төслийн 2 дугаар зүйлийн “мөн хэсгийн “дарга,”” гэсний өмнө “байгууллагын” гэж, “тэдгээрийн” гэсний дараа “тэргүүн дэд дарга, дэд дарга” гэж, “орлогч” гэсний дараа “дарга” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 29
 Татгалзсан: 12
 Бүгд: 41
 70.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн агуулга, зарчмыг хөндөхгүйгээр нэр томъёо, хэл найруулга, дэс дарааллыг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28
 Татгалзсан: 12
 Бүгд: 40
 70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаарх ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал

Л.Мөнхбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “2023 оны 07 дугаар сарын 01-ний” гэснийг “2023 оны 10 дугаар сарын 01-ний” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 13
Бүгд: 40
67.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 1 дүгээр зүйл нэмэх:

1 дүгээр зүйл.2023 оны ... дугаар сарын ... -ны өдөр баталсан Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнө хууль тогтоомжийн шаардлагад нийцүүлж байгуулагдсан уг хуулийн 20¹.1-д хамаарах гэрээ, хэлцэл хүчин төгөлдөр хэвээр байна гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 13
Бүгд: 41
68.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Найруулгын санал

Л.Мөнхбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн дэс дараалал, зүйл, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 11
Бүгд: 41
73.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулж дууслаа.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 16 цаг 35 минутад хэлэлцэж дуусав.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн,

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Хувийн тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгүүдийн асуудлаар Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Д.Тогтохсүрэн ажлын 1 өдрийн завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар завсарлага авав. /16:37/

Арав. “Онцгой албан татварын тухай хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай” Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 04 дүгээр дүгнэлт

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Үндсэн хуулийн цэцийн гишүүн Ж.Эрдэнэбулган оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа, Хууль зүйн байнгын хороо хариуцсан референт П.Хулан нар байлцав.

Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн Ж.Эрдэнэбулган, Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Дэлгэрсайхан, Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нар тус тус танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл, Б.Баттөмөр, Б.Пүрэвдорж, Ш.Адьяа нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн, Хууль зүйн байнгын хорооны дарга Б.Энхбаяр нар хариулж тайлбар хийв.

Байнгын хороодоос гаргасан саналаар санал хураалт явуулав.

Л.Мөнхбаатар: 1.Онцгой албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн 4.1.5 дахь заалтад “газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн, керосин.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... тэгш байдал, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж заасныг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	27
Татгалзсан:	11
Бүгд:	38

71.1 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Онцгой албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн хүснэгтийн 6 дахь заалтад “Газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн, керосин, 1 тонн” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... тэгш байдал, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж заасныг

зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 11
Бүгд: 39
71.8 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Онцгой албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн хүснэгтийн 10 дахь заалтад “Газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн, керосин, 1 тонн, 285 000 төгрөг” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... тэгш байдал, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж заасныг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 12
Бүгд: 39
69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Онцгой албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн 4.1.5 дахь заалтад “газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн, керосин.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсгийн “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.” гэж заасныг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 12
Бүгд: 39
69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Онцгой албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн хүснэгтийн 6 дахь заалтад “Газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн, керосин, 1 тонн” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсгийн “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.” гэж заасныг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 11
Бүгд: 39
71.8 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Онцгой албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн хүснэгтийн 10 дахь заалтад “Газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн, керосин, 1 тонн, 285 000 төгрөг” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсгийн “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.” гэж заасныг

зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 11
Бүгд: 39
71.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хороодын саналаар санал хурааж дуусав.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар “Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 04 дүгээр дүгнэлтийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг танилцуулав.

Л.Мөнхбаатар: “Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 04 дүгээр дүгнэлтийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 12
Бүгд: 40
70.0 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар “Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 04 дүгээр дүгнэлтийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. *Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно.*

Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа. /17:27/

Уг асуудлыг 17 цаг 27 минутад хэлэлцэж дуусав.

Арван нэг.Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл /Засгийн газар 2021.06.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд Г.Ганбаяр, Боловсролын ерөнхий газрын дарга Т.Ням-Очир, Боловсрол, шинжлэх ухааны яамны Сургуулийн өмнөх боловсролын хэлтсийн дарга Ж.Мягмар, мөн яамны Боловсролын нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын шинжээч Ж.Нарантуяа, Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах шинжээч Ч.Баярмаа, Боловсролын нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын ахлах шинжээч А.Цолмон, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн секторын эрхлэгч У.Туяа, Монголын боловсрол, шинжлэх ухааны үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга З.Цогтгэрэл, “Бүх нийтийн боловсролын төлөө” Иргэний нийгмийн үндэсний эвслийн ерөнхий зохицуулагч Д.Тунгалаг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх А.Болортуяа, Ё.Энхсайхан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт Н.Монголмаа нар байлцав.

Хуулийг төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням, Улсын Их Хурлын гишүүн, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд Г.Ганбаяр нар хариулж, тайлбар хийв.

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн төслийн талаар Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням, Г.Амартүвшин, Ё.Баатарбилэг, Э.Батшугар, Б.Баярсайхан, Х.Булгантуяа, Х.Ганхуяг, Б.Жаргалмаа, Ц.Мөнх-Оргил, Г.Мөнхцэцэг, Ц.Мөнхцэцэг, Б.Пүрэвдорж, Ч.Ундрам, С.Чинзориг, Т.Энхтүвшин нар /цаашид “Ажлын хэсэг” гэх/-ын гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “эдгээртэй” гэснийг “эдгээр хуультай” гэж өөрчилж, 2.2 дахь хэсгийн “нэгдэн орсон” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 20
Бүгд: 37
45.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Чойжилсүрэнгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Б.Чойжилсүрэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 19
Татгалзсан: 18
Бүгд: 37
51.4 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “эдгээртэй” гэснийг “эдгээр хуультай” гэж өөрчилж, 2.2 дахь хэсгийн “нэгдэн орсон” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 16
Бүгд: 37
56.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн “оюун ухаан” гэснийг “танин мэдэхүй” гэж, 3.2 дахь хэсгийн “ёс зүйтэй” гэснийг “ёс суртахуунтай” гэж, 3.3 дахь хэсгийн “Сургалтын байгууллага” гэснийг “Хүүхдийн цэцэрлэг /цаашид “цэцэрлэг”

гэх/, ерөнхий боловсролын сургууль” гэж, “захиргааны байгууллагатай” гэснийг “захиргааны байгууллага, иргэний нийгмийн байгууллагатай” гэж өөрчилж, 3.3 дахь хэсгийн “асран хамгаалагч” гэсний дараа “харгалзан дэмжигч,” гэж /цаашид тохиолдол бүрд/ нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг явуулья.

Зөвшөөрсөн: 20

Татгалзсан: 17

Бүгд: 37

54.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Санал хураалтыг дараагийн чуулганы нэгдсэн хуралдаанаар үргэлжлүүлэн хэлэлцэхээр хуралдаан 17 цаг 49 минутад завсарлав.

Уг асуудлыг 17 цаг 49 минутад хэлэлцэж дуусав.

Бусад. Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж хэлэлцэх асуудалтай холбогдуулан үг хэлэх үедээ “2018-с хойш тэтгэврийн зөрүүг буцааж олго” гэсэн бичиг бүхий хуудсыг ширээн дээр байршуулсан байв.

Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд, Д.Тогтохсүрэн, С.Чинзориг нарын урилгаар Өвөрхангай аймгийн Баян-Өндөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2003 оны төгсөгчдийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайханы урилгаар Монгол Улс болон Америкийн Нэгдсэн Улсын хөгжмийн багш нар, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн урилгаар Ховд аймгийн Мөст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 1993 оны төгсөгчдийн төлөөлөл, Баянгол дүүрэг, Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн ахмад шүүгч, ажилтнуудын төлөөлөл, Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2003 оны төгсөгчдийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрамын урилгаар Сэлэнгэ аймгийн Зүүнхараа хотын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 1983 оны төгсөгчид, Улсын Их Хурлын гишүүн Г.Занданшатарын урилгаар Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын Ерөнхий боловсролын 28 дугаар сургуулийн төгсөгчдийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Б.Саранчимэг, Э.Бат-Амгалан нарын урилгаар Баянзүрх дүүргийн иргэдийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Ё.Баатарбилэг, Г.Тэмүүлэн нарын урилгаар Архангай аймгийн Булган сумын цэцэрлэгийн багш нарын төлөөлөл Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 11 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч С.Энхзаяа, Ш.Мөнхцоож нар хариуцан ажиллав.

Хуралдаан 6 цаг 15 минут үргэлжилж, 73 гишүүнээс 47 гишүүн хүрэлцэн ирж, 64.4 хувийн ирцтэйгээр 17 цаг 49 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН

БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 06 дугаар сарын 22-ны өдөр,
Пүрэв гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 18 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Л.Мөнхбаатар: Гишүүд суудлаа эзлээрэй. Улсын Их Хурлын эрхэм гишүүдийн амрыг эрье. Нийт гишүүдийн олонх ирсэн тул хуралдааныг эхлүүлье.

Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 06 дугаар сарын 22-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдөр 16 асуудал хэлэлцэнэ.

Нэг, Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

Хоёр, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Улсын Их Хурлын гишүүн, Тэмүүлэн нарын 32 гишүүн өргөн мэдүүлсэн.

Гурав, Олон улсын иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай конвенцод нэгдэн орсныг соёрхон батлах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, зарчмын зөрүүтэй санал 1-тэй.

Дөрөв, Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенцын нэмэлт протоколыг соёрхон батлах тухай хуулийн төсөлтэй

хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Тав, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, анхны хэлэлцүүлгийг явуулна.

Зургаа, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, анхны хэлэлцүүлэг.

Долоо, “Эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлийг хянан шалгах асуудлаар хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Улсын Их Хурлын гишүүн Чинбүрэн нарын 28 гишүүн өргөн мэдүүлсэн.

Найм, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Улсын Их Хурлын гишүүн Адышаа болон Засгийн газрын өргөн барьсан төслүүдийг нэгтгэн анхны хэлэлцүүлэг хийнэ. Зарчмын зөрүүтэй 9 саналтай.

Ес, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, анхны хэлэлцүүлэг хийнэ.

Арав, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, анхны хэлэлцүүлэг.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

Арван хоёр, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осолд

мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, анхны хэлэлцүүлэг.

Арван гурав, Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, анхны хэлэлцүүлэг.

Арван дөрөв, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 04 дүгээр дүгнэлт.

Арван тав, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Засгийн газар өргөн мэдүүлсэн анхны хэлэлцүүлэг, зарчмын зөрүүтэй 33 саналтай.

Арван зургаа, Боловсролын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, эцсийн хэлэлцүүлэг хийгдэнэ. Зарчмын зөрүүтэй 9 саналтай.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13.4-т гишүүн энэ хуулийн 9.5-д заасан нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхээр тогтсон асуудлыг хойшлуулах, дараалал өөрчлөх, асуудал нэмэх горимын санал гаргах бол Улсын Их Хурлын даргад нэгдсэн хуралдааны өмнөх өдрийн 17 цагаас өмнө үндэслэл бүхий саналаа бичгээр ирүүлнэ гэж заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Гонгорын Дамдинням, Бөхчулууны Пүрэвдорж нараас бичиг ирүүлсэн байна.

Үүнийг та бүгдэд танилцуулъя. Монгол Улсын Их Хурлын дарга Гомбожавын Занданшатар танаа Миний бие Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13.3.1, 13.4-ийг үндэслэн 2023 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн чуулганы хуралдаанд хэлэлцэх асуудлын дараалалтай

холбоотойгоор үг хэлэх хүсэлтэй байгаа тул үг хэлэх дараалалд оруулахыг хүсье гэсэн байна.

Улсын Их Хурлын гишүүн Гонгорын Дамдинням үг хэлье.

Г.Дамдинням: Хэлэлцэх асуудлын дараалал, өглөөний мэнд гишүүддээ бас хүргэе. Хэлэлцэх асуудлын дараалал өнгөрсөн долоо хоногт Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөлөөр хэлэлцэгдээд батлагдахдаа Боловсролын ерөнхий хуулийг 7 дугаарт хэлэлцэхээр оруулсан байсан юм. Тэгээд өнөөдөр уншигдаж байгаа дарааллыг харахад 15-д нь Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, тэгээд хамгийн төгсгөлд нь 16-д нь Боловсролын ерөнхий хуулийг тавьжээ.

Энэ чинь бас юм логиктой байх ёстой байх л даа. Боловсролын ерөнхий хууль батлагдаж байж Сургуулийн өмнөх ерөнхий боловсролын тухай хууль явах ёстой юм. Тэгээд энэ хууль нэлээн л зовлонтой л урагшилж байгаа, том ч хууль. Улсын Их Хуралд 2021 оны 06 дугаар сарын 24-нд өргөн баригдаад, одоо ингээд 2 жил гаруй хугацаанд явж байгаа. Монгол Ардын намын бүлгээр 2 удаа ороод дэмжигдчихсэн ийм хууль. Анхдугаар хэлэлцүүлэг нь хийгдсэн.

Одоо 9 зарчмын зөрүүтэй санал үлдсэн. Үндсэндээ хэдхэн минутын л ажил гэсэн үг. Тэгэхээр би энэ Боловсролын ерөнхий хуулийг болж өгвөл хамгийн эхэнд нь, болохгүй шиг бол тэр өнгөрсөн долоо хоногийн Даргын дэргэдэх зөвлөлөөр шийдсэн 7 дугаар байранд нь оруулж өгөөч гэдэг горимын санал гаргаж байна. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Боловсролын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явах үед Улсын Их Хурлын гишүүдээс бас олон талын байр суурууд илэрхийлэгдсэн. Үүнтэй

холбогдуулаад бас ярилцах зүйлүүд бас их байгаа учраас энийг дарааллын хувьд төгсгөлд нь хэлэлцэж болох юм гэж үзэж байсан.

Гэхдээ Гонгорын Дамдинням гишүүн горимын санал гаргаж байгаа учраас санал хураалтыг явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Гонгорын Дамдиннямын гаргасан горимын саналаар санал хураалтыг явуулъя.

Боловсролын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэх асуудлын 7 дахь асуудал болгохыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Гишүүд суудлаа эзлээрэй, санал хураалт явуулъя. Санал хураалт.

Дамдинням гишүүний санал 7-д оруулъя. Хэлэлцэх асуудлын 7-д оруулъя гэсэн горимын санал гаргаж байна.

Гонгорын Дамдинням гишүүний гаргасан горимын санал 60 хувиар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдоржийн ирүүлсэн албан бичгийг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын дарга Гомбожавын Занданшатар танаа, Миний бие 2023 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн чуулганы хуралдаанд хэлэлцэх асуудлын дараалалтай холбоотойгоор үг хэлэх зөвшөөрөл олгоно уу гэсэн байна. Одоо Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж хэлэлцэх асуудалтай холбогдуулан үг хэлье.

Б.Пүрэвдорж: Тэтгэврийг тогтоохдоо 7 жилийн цалингийн дунджаар биш, 5 жилийн цалингийн дунджаар тогтоох тухай хуулийн төслийг өргөн бариад 3 жилийн хугацаанд

зүтгэсний үр дүнд бас амжилтад хүрч байна. Энэ хугацаанд нийтдээ 60 гаруй удаа чуулганы эхэнд яг энэ шиг цаг аваад энэ хуулийг хэлэлцэхийг шаардсан байна. 2 удаа жагсаал зохион байгуулсан байна. Хөдөө орон нутгаар маш их олон хэлэлцүүлгийг зохион байгуулж явсан. Нийтдээ хорин аймгийн хорин дөрөв, таван сумуудаар явж энэ асуудлыг би ярьсан байгаа. Өөрийнхөө бүх сум дээр, бүх баг дээр очиж ярьсан аймгийн.

Тэгээд энэний үр дүнд өнгөрсөн долоо хоногт би энэ хэлэлцэх асуудлын дараалалд энэ долоо хоногт орно гэж мэдээгүй. Тийм учраас 4 дэх, 5 дахь өдөр, 1 дэх өдөр жагсаал болох тухай зарлаж, ард түмэндээ зарлаж энэний дагуу жагсаал зохион байгуулагдсан.

4 дэх, 5 дахь өдөр дамжуулан үг хэлсэн. Мөн түүнчлэн жагсаал болох сургаар манай Монгол Ардын намын бүлэг энэ асуудлыг хэлэлцэж энэ долоо хоногийн хэлэлцэх асуудлын дараалалд оруулсан байгаа. Тэгээд үүний дагуу өнөөдөр энэ Их Хурлын чуулганаар хэлэлцэх гэж байна.

Тэгэхээр энэ хоёр, миний өргөн барьсан 7 жилийг 5 жил болгох мөн түүнчлэн 2018 оноос хойш тэтгэвэр тогтоолгосон тэр хүмүүсийг буцааж 5 жилээр бодох энэ хууль, хоёр хууль хоёулаа энэ нийгмийн даатгалын багц хуульд хоёулаа ороод явж байгаа. Дэмжигдсэн саналаар сая Байнгын хороон дээр дэмжигдээд явсан.

Тэгэхээр энэ хуулийг бас санаачилж оруулж ирсэн Монгол Улсын Засгийн газар, багц хуульдаа тусгасан Монгол Улсын Засгийн газар, сайд Булгантуяа, Аюурсайхан нар, мөн түүнчлэн энэ хуулийн талаар Монгол Улсын хэд хэдэн аймаг дээр хэлэлцүүлэг зохион байгуулсан Нийгмийн бодлогын байнгын хороо, түүний дарга Анужин болон гишүүдэд өчигдөр энэ хуулийн анхны хэлэлцүүлгийг хийсэн Байнгын

хорооны гишүүддээ бас талархсанаа илэрхийлье.

Тэгэхээр энэ хууль дээр бас нэг зүйл үлдчихээд байна. Бас өчигдөр би энэ 18 оноос тэтгэврээ 7 жилээр бодуулсан тэр хүмүүсийн тэтгэврийг буцааж 5 жил болгоод тэрний нь тэтгэврийн зөрүүг нь буцаан олго гэдэг ийм зарчмын зөрүүтэй санал гаргасан боловч Байнгын хороо унагаасан байгаа.

Тэгэхээр Монгол төрийн буруу бодлогоос болж энэ хүмүүс хохирсон. Тэрийгээ өнөөдөр засаж байгаа. Тийм учраас энэ 2018 оноос хойш 7 жилээр тэтгэврээ бодуулсан тэр хүмүүс буцаагаад 5 жил болох дээр энэ тэтгэврийн зөрүүг нь буцааж олгох тэр асуудлыг орхигдуулж байна.

Тийм учраас энэ асуудлыг манай Их Хурлын гишүүд энэ анхны хэлэлцүүлэг чуулган дээр явагдахад нь дэмжиж өгөөрэй. Энэ бол тийм айхтар их мөнгө гарахгүй. Энэ хүмүүсийн буруу биш. Насаараа хамгийн өндөр шимтгэлээр 25 хувийн, 24, 25 хувийн шимтгэлээр тэтгэврээ шимтгэл төлсөн тэр хүмүүс төрдөө итгэж л тухайн үедээ хамгийн өндөр ханш бүхий мөнгөөр л шимтгэл төлсөн байгаа. Түүнийгээ өгөх болох дээр уначихсан ханштай. Тэгээд дээрээс нь хамгийн бага тэтгэвэр бодож өгдөг ийм харгис төртэй байж болохгүй шүү дээ.

Энэ 5 жилийг 7 жил болгосны үр дүнд нийт тэтгэвэр авагчдын чинь 89 хувь нь тэтгэврийн доод хэмжээ буюу 400, 500 дээр очиж унаад байгаа байхгүй юу даа.

Тийм учраас одоо энэ 7 сарын 1-нээс тэтгэврээ нэмж байгаа нь сайн байна. Тэгээд энэ 7 жилийг 5 жил болгож байгаа нь сайн байна. Нөхөн бодож өгч байгаа нь сайн байна. Хамгийн гол нь зөрүүг нь олох тэр асуудал дээр манай Их Хурлын гишүүд бас дэмжиж ажиллаарай гэж хүсэж байна.

Мэдээж өнөөдрийн энэ парламентын хэт олонх бол манай Монгол Ардын намын гишүүд байгаа. Аливаа хууль бол та бүхний хичээл, зүтгэл дээр батлагддаг.

Тийм учраас энэ Ардын намын үед гарч байгаа бас олон сайн олон сайн хуулиуд байна. Тэр хууль дээр бид нар дэмжээд явдаг. Бүтэлгүй хуулиуд ч зөндөө их байгаа. Авлига үнэртсэн, хахууль үнэртсэн хуулиуд ч байдаг. Тэр хууль дээрээ бид нар хамтдаа эсэргүүцээд явдаг. Тийм учраас энэ тэтгэврийн зөрүүг буцаан олгох тал дээр манай Булгантуяа сайд энэ дээр мөнгийг нь олоод ирнэ дээ. Та бол тэр талаар бас нэлээн.../минут дуусав./

Л.Мөнхбаатар: Бөхчулууны Пүрэвдорж гишүүн үг хэллээ. Гишүүд үг хэлж дууслаа. Хэлэлцэх асуудалдаа орёё.

Соёлын, бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцье.

Хууль санаачлагчийн илтгэлийг Соёлын сайд Чинбатын Номин танилцуулъя. Номин сайдыг индэрт урьж байна. Ажлын хэсгийг бас мөн оруулаарай.

Ч.Номин: Улсын Их Хурлын дэд дарга, Улсын Их Хурлын гишүүд ээ,

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 1.2-т үндэсний оюун санаа, өв соёл, сэтгэлгээнд тулгуурласан бүтээлч үйлдвэрлэл, бүтээлч Монгол хүн төвтэй улс болно. Монгол хүний оюуны бүтээлийг дэлхийн зах зээлд сурталчлан төсөл хэрэгжүүлнэ гэж 4.2-т бүтээлч үйлдвэрлэлийн хөгжлийн бодлогын суурийг тавьж, бүтээлч үйлдвэрлэлийг эдийн засгийн бие даасан салбар болгон хөгжүүлнэ гэж, 9.5-д Соёлын аялал жуулчлал, бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлж,

соёл урлагийн зах зээлийг өргөжүүлэхэд салбар хоорондын уялдаа холбоог сайжруулна гэж тус тус заасан.

Түүнчлэн Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн, 5 жилийн үндсэн чиглэлийн 4.2.4-д бүтээлч үйлдвэрлэлийн хөгжлийн бодлогын суурийг тавихаар заасан бол Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.6.3.3-д үндэсний агуулгатай инновац шингэсэн соёлын бүтээлч үйлдвэрлэл, инновацын салбарыг хөгжүүлж, Монголын брэндийг бий болгож соёл, урлагийн эдийн засаг, нийгмийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ гэж зорьсон.

Урлахуйн үйлдвэрлэл болох соёлын бүтээлч үйлдвэрлэл нь тогтвортой хөгжлийг хангах үзэл баримтлалыг дэмжиж, эдийн засгаа олон тулгуурт болгох, бүтээлч авьяас билгийг нөхөн сэргээгдэх нөөц байдлаар хамгаалж, хөгжүүлж, эдийн засгийн эргэлтэд оруулахад чиглэгддэг.

ЮНЕСКО-оос хийсэн судалгаагаар соёлын бүтээлч үйлдвэрлэлийн салбарын хувьд 2.2 их наяд ам.долларын орлоготой 30 гаруй сая ажлын байрыг бий болгодог, экспортын нийт орлого нь 253 тэрбум ам.доллар байна.

Тэгвэл Соёлын яамнаас хийсэн Монгол Улсын соёлын бүтээлч үйлдвэрлэлийн суурь судалгаанаас үзэхэд соёлын бүтээлч үйлдвэрлэлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд оруулж буй хувь нэмэр нь 481.4 тэрбум төгрөг буюу улсын дунд 1.4 хувь эзэлж байгааг тогтоосон.

Энэ салбарт 11697 аж ахуйн нэгж байгууллага бүртгэлтэй байгаагаас 5665 нь идэвхтэй үйл ажиллагаа эрхэлж байна.

Түүнчлэн дэлхий нийтээрээ соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих төрөл бүрийн бодлогыг санаачлан хэрэгжүүлж, цар тахлын дараах эдийн

засгийг сэргээх, цаашид улс орны тогтвортой хөгжлийг хангах, бүтээлч авьяас билгийг нөхөн сэргээгдэх нөөц байдлаар хөгжүүлэх гол салбараар нэрлэж байна.

Гэвч манай улсын хувьд дэлхийн эдийн засгийн өрсөлдөөнийг даван туулах мэдлэгт суурилсан бүтээлч эдийн засгийг соёлын салбарт нэвтрүүлэх төрийн зохицуулалт хангалтгүй байна.

Иймд Монгол Улсын өөрийн орны өвөрмөц онцлог, нөөцөд тулгуурласан олон улсын чиг хандлага, технологитой хурдтай хөгжиж байгаатай уялдуулан соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл боловсруулах шаардлагатай гэж үзсэн.

Хуулийн төсөл нь соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих хэлбэр, удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн үндсийг тодорхой холбогдлуудыг бий болгоно.

Уг хуулийн төсөл батлагдсанаар соёлын бүтээлч үйлдвэрлэлийн эко системтэй уялдсан төрийн бодлогыг тогтворжуулж, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх орчин бүрдэн импортыг орлох, экспорт чиглэсэн, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээ нэмэгдүүлэн эдийн засгийн эргэлтэд оруулах үйл явц эрчимжүүлнэ.

Мөн төрөөс үзүүлэх дэмжлэгийн хэлбэр тодорхой болж, соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээ бүтээх, туурвихтай холбогдолтой үе шат бүрд бүртгэл мэдээллийн тогтолцоо нэвтэрч, соёлын нийгэм, эдийн засгийн ач холбогдол хэмжих боломж бүрдэнэ гэж үзэж байна.

Үүний үр дүнд дотоодын нийт бүтээгдэхүүнд соёлын бүтээлч үйлдвэрлэл эзлэх хувь 2027 он гэхэд 4 хувь хүрч боломжтой гэж дүгнэж байна.

Мөн төрмөл авьяас билгийг эрх зүй, санхүү, дэд бүтэц, техник

технологитой хослуулан хөгжүүлэх, гадаад зах зээлд өрсөлдөх нөхцөл бий болгож ажлын байр нэмэгдэнэ.

Улмаар үндэсний агуулгатай соёлын бүтээгдэхүүн үйлчилгээний өсөлт хүртээмж нэмэгдсэнээр аялал жуулчлалын үйл ажиллагааг дэмжих тогтвортой нөөц, нөхцөл бий болохын зэрэгцээ үндэсний соёлын дархлаа бэхжих ач холбогдолтой.

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Соёлын, бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих, дагаж мөрдөх журмын тухай, Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гаалийн татвар, Гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай зэрэг татварын бусад хөнгөлөлт, чөлөөлөлтэй холбогдох болон бусад хуулийн төслүүдийг боловсрууллаа.

Хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Л.Мөнхбаатар: Номин сайдад баярлалаа. Төслийн талаарх Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Бадарчийн Жаргалмаа танилцуулъя. Таныг индэрт урьж байна.

Б.Жаргалмаа: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөлд соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх, импортыг орлох, экспортод чиглэсэн нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлчилгээний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих, хэлбэр, орчныг бүрдүүлж эдийн засгийн эргэлтэд оруулах талаар тусгажээ.

Мөн соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээ бүтээх, түгээхтэй холбоотой үе шат бүрд бүртгэл, мэдээллийн тогтолцоо нэвтэрч, соёлын нийгэм, эдийн засгийн ач холбогдлыг хэмжих боломж бүрдэнэ гэж хууль санаачлагч үзсэн байна.

Хуулийн төсөл батлагдсанаар улсын төсвөөс нэмэлт зардал шаардагдахгүй гэж хууль санаачлагч үзсэн бөгөөд хуулийн төслийг d.parliament.mn цахим сайтад байршуулж, иргэд олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Баярсайхан соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хэрхэн дэмжих талаар, соёл урлагийн ажилтны цалин, хөлсийг нэмэгдүүлэх талаар, чөлөөт уран бүтээлчдийг хэрхэн дэмжих талаар, мөн оюуны өмчийг хамгаалах, тэр дундаа Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах Оронд Монгол Улсын уран бүтээлчдийн бүтээл оюуны өмчийн зөвшөөрөлгүйгээр түгээгдэж байгаа асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Жаргалмаа соёл урлагийн байгууллагуудын өөрийн орлогоо ажилчид байгууллагынхаа үйл ажиллагаанд зарцуулдаг эсэх, соёлын бүтээлч үйлдвэрлэлийн эдийн засагт оруулах хувь нэмэр ямар байгаа талаар, оюуны өмчийг хамгаалах, оюуны өмчийн зөрчлөөс үүссэн хариуцлагын асуудалд хэрхэн тусгагдаж байгаа талаар асуулт асууж, саналаа хэллээ.

Соёлын бүтээлч Үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Гаалийн албан татварыг хөнгөлөх тухай, Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслүүдийг Монгол Улсын Засгийн газраас татан авснаа илэрхийлсэн болно.

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь буюу 54.5 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Соёлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Соёлын өвийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Кино урлагийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Номын сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн

барьцааны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх талаарх Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Жаргалмаа гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Соёлын сайд Чинбатын Номин, Соёлын сайдын ахлах зөвлөх Санжаадоржийн Оюунбилэг, Соёлын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Жигмэдсамбуугийн Отгонбат, Соёлын яамны Хууль, эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Содномжамцын Батцэцэг, Соёлын яамны Соёлын Бүтээлч үйлдвэрлэл инновацийн хэлтсийн дарга Готовцэрэнгийн Батхуяг, Соёлын өвийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Бямбасүрэнгийн Даваацэрэн нар чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож байна.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Нэрсээ өгье. Ундрам гишүүн, Цогтгэрэл гишүүн, Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүнээр тасаллаа. Жаргалмаа гишүүн үг хэлье гэж байгаа юм уу. Жаргалмаа гишүүнээр тасаллаа.

Ганибал гишүүн асуултаа асууя. Гочоогийн Ганболд гишүүнээр.

Н.Ганибал: Өглөөний мэнд. Соёлын бүтээлч үйлдвэрлэл Монгол хэлэнд та бүхний томъёолол хоёр яг яаж орж ирээд өнөөдөр бид нар энийг ойлгох вэ гэдгийг эхлээд асуучихъя.

Хоёрт нь ер нь энэ Монголын төрийн тогтолцооны энэ асуудлыг бид нар эргэж нэг харж үзэхгүй бол ер нь болохоо

байлаа. Өнөөдөр намын харьяаллаар аливаа асуудлыг шийддэггүй ийм босоо тогтолцоонууд Монгол Улсад газар авлаа. Ардчилсан намын 8 аймгийн иргэдийн хуралдай олонх болоод Засаг даргаа томилсон. Ерөнхий сайд нь байж байгаад л нэгийг нь сольдог. Жил болгон Засаг даргыг нь сольдог. Одоо босоо тогтолцоотой шинээр байгуулагдсан хоёр яам байгаа. Соёлын яам, Цахим инновацын яам одоо хүртэл учраа олохгүй хэдэн дарга нар томилох гэж бүтэн 3 жил боллоо бараг. Ардчилсан намаас томилогдсон, ялсан аймгуудын соёлын хэлтсийн дарга нарыг бүүр томилохгүй. Сонирхол байхгүй.

Харин Ардын намаас ялсан аймгууд дээр тэр соёлын мэргэжилтэн байна уу, юу байна уу хамаагүй аваачаад томилчихно. Одоо бас Боловсролын багц хууль нь бас л босоо тогтолцоо яригдаж байгаа. Бид нар ер нь Монгол Улс ер нь Монгол юм уу. Энэ олон намуудын Монгол юм уу, тогтолцоо нь өөрөө яаж явах юм бэ. Энэ улс төрийн ийм шийдвэр гаргадаг ийм төрийн албаар бид нар ер нь цааш нь явах юм уу, явахгүй юм уу. Энэ асуудлаа яаралтай та бүхэн минь цэгцэлмээр байна.

Хоёрдугаар асуудал нэг хууль орж ирэхээр дагалдуулаад гаалийн татварыг хөнгөлөх тухай хуульд өөрчлөлт оруулна. Гаалийн тариф-д өөрчлөлт оруулна. Одоо бүр газрын хуульд өөрчлөлт оруулна. Монголын бүх хуулиудад өөрчлөлт оруулах гээд ингээд ийм хуулиуд оруулж ирэх юм. Асуудал нь яг шийдлээ олох хэмжээнд байгаа юм уу. Бусдын хууль руу гар дүрж хууль өөрчилдөг ийм хуулиуд ер нь хэрэгтэй юм уу. Тэгээд хууль болгоныхоо ард бас сантай. Бүгдээрээ л сан болохгүй байна. Тэр сангаа дагуулаад Төсвийн тухай хуульд бас хүртэл өөрчлөлт оруулдаг. Дандаа л төсвийн татварын мөнгийг ямар нэгэн байдлаар булаацалдсан ийм хуулиуд оруулж ирээд байна. Ингэж Монгол Улс ер нь бүх юмаа төрийнхөө мэдэлд рүү татаж авч татварын мөнгөөр, татвар төлөгчдийн мөнгөөр

өнөөдөр бүх салбараа хөгжүүлнэ гэвэл бүтэхгүй. Өнөөдөр тэр боломж байхгүй. Энийг маш сайн анхаармаар байна.

Дараа дараагийн Засгийн газраас оруулж ирж байгаа хуулиуд зарим хуулиудыг нь дагалдах хуулиуд нь оруулж ирснээ буцаагаад татчихлаа ч гэж байх шиг. Сонин сонин л юм ярих юм. Нэгдсэн нэг бодлоготой нэг шийдлээ гаргаад Засгийн газар энэ хуулиудаа оруулж ир.

Ер нь тэгээд бүтээлч үйлдвэрлэл гэж яг юуг яриад байгаа юм бэ. Тэр хувийн соёлын түгээгч нар тэр хувийнхныгаа дэмжсэн томоохон бодлого л хэрэгтэй шүү дээ. Орон нутаг мэдээж сумууд дээр төрийн дэмжлэг хэрэгтэй байх, аймаг дээр хэрэгтэй байх. Бусад асуудал дээр нь энэ төрийн оролцоог нь л болиулж чадах юм бол энэ соёл чинь бас илүү хөгж.../минут дуусав./

Л.Мөнхбаатар: Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Гочоогийн Ганболд, Дуламдоржийн Тогтохсүрэн, Содномын Чинзориг нарын урилгаар Өвөрхангай аймгийн Баян-Өндөр сумын 2003 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүгдэд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс амьдралд нь аз жаргал, сайн сайхан бүгдийг хүсэн ерөөе.

Асуултад хэн хариулах вэ. Соёлын сайд Номин хариулъя. 85 дугаар микрофоныг өгье.

Ч.Номин: Ганибал гишүүний асуултад хариулъя. Соёлын бүтээлч үйлдвэрлэл гэж ер нь томьёоллын хувьд хүний оюун санаа, авьяас билиг дээр суурилсан үүнийгээ оюуны өмч, техник технологитой уялдуулан үүсгэн гаргаж байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээг томьёолж хэлж байгаа зүйлийг соёлын бүтээлч үйлдвэрлэл гэж нэрлэж байгаа.

Дэлхийн хувьд энэ соёлын бүтээлч үйлдвэрлэл 1995 оноос хойш хөгжиж бий болсон. 2.2 их наядын ийм том зах зээл байгаа. Дунджаар ер нь энэ үйлдвэрлэлийг хөгжүүлсэн улсуудад дотоодын нийт бүтээгдэхүүний 4 хувийг соёлын бүтээлч үйлдвэрлэл эзэлдэг. Одоогийн байдлаар энэ маш өндөр өсөлттэй бүтээгдэхүүн, үйлчилгээ нь дэлхий дахинаа тархалт сайтай байгаагаас үүдэж, дараагийн 10 жилийн дотор дотоодын нийт бүтээгдэхүүний 10 хувь хүртэл өсөх боломжтой байгаа гэж дэлхий дахинаа үзэж байгаа.

Тийм учраас манай Монгол Улс бас олон улсын энэ тогтолцоотой хөл нийлүүлэн алхах нь зүйтэй бөгөөд манай улс бол соёлын өв нь маш баялаг. Энэ соёлын өв дээрээ суурилсан бүтээлч үйлдвэрлэлийг бий болгох буюу энэ креатив индустри гэдэг юмыг буюу мэдлэгт суурилсан эдийн засгийг бий болгож цаашид эдийн засгаа солонгоруулах буюу олон тулгуурт болгох нь зүйтэй гэж үзсэн учраас энэ хуулийн төслийг оруулж ирсэн байгаа бөгөөд энэхүү хуулийн төсөл нь энэ бүтээлч үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа 33 мянган аж ахуйн нэгжийг хууль зүй тогтолцооны хувьд тодорхой болгож өгөхөөр хийгдэж байгаа зүйл байгаа.

Мэдээж орон нутгийн асуудлыг сая оруулж ирж байна. Соёлын яам бол хорин дөрөв, таван жил яамгүй байсан учраас соёлын бодлого хэрэгжилт одоо бүрэн дүүрэн хэрэгжихгүй байдалтай болсон. Энэ утгаараа соёлын бодлого болох босоо болох тогтолцоог Соёлын тухай хуулийнхаа хүрээнд хийсэн. Энэ утгаараа аймаг, нийслэлийн соёл урлагийн газрын даргыг Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас томилдог. Харин үйл ажиллагаа хэрэгжилтийн хувьд бол орон нутагтаа хэрэгжилт нь явж байгаа буюу соёлын төв, театр, музей, номын сангууд үйл ажиллагаагаа яг орон нутагтаа хэрэгжүүлээд явж байгаа ийм тогтолцоотой байгаа.

Харин ч би юу гэж харж байна вэ гэхээр Соёлын яамны хувьд сүүлийн 3 жилийн хугацаанд соёлын бодлогыг орон даяар хэрэгжих тогтолцоог бүрэн хэмжээнд бий болгож, аймаг орон нутагт соёлын асуудал эрхэлсэн байгууллагуудыг үүсгэн байгуулж энэнийхээ хүрээнд соёлын бодлогоо хэрэгжүүлээд явж байгаа гэдэг үзэлтэй байна.

Л.Мөнхбаатар: Яах юм тодруулах юм уу та. Ганибал гишүүн тодруулж асууя.

Н.Ганибал: Номин сайдаа тэгээд яагаад энэ Газрын хуульд өөрчлөлт оруулах гээд газар олголтын асуудал руу яагаад ороод ирэв. Таны тайлбарлаж байгаагаар энэ бүтээлч, соёлын бүтээлч үйлдвэрлэл гэдэг маань арай өөрөөр тайлбарлаад байх юм. Энийг тодруулаад өгөөч.

Л.Мөнхбаатар: Ганибал гишүүний тодруулгад хариулъя. Соёлын сайд Номин. Ажлын хэсгийн 85 дугаар микрофоныг өгье.

Ч.Номин: Тодруулъя. Ер нь бол соёлын бүтээлч үйлдвэрлэл бол Монголын хэмжээнд бол жижиг, дунд бизнесийн хүрээнд юм уу, өрхийн аж ахуй эрхлэх хүрээнд явагдаж байгаа. Ер нь бол томоохон хэмжээний дэд бүтцүүдийг бодлогын түвшинд соёлын салбарт бий болгож явж байж энэ урлахуйн үйлдвэрлэл буюу энэ соёлын бүтээлч үйлдвэрлэлд үйл ажиллагаа явуулж байгаа бүтээлч нараа дэмжих Монгол агуулгатай, Монгол бүтээлийг дэлхийн зах зээлд гаргах шаардлагатай гэж үзсэн. Энэ утгаараа Газрын тухай хууль дээр энэ соёлын бүтээлч үйлдвэрлэлийн цогцолбор аливаа нэгэн паркийг хийсэн тохиолдолд энэхүү газрыг тусгай хэрэгцээнд авах зориулалтыг оруулж ирсэн байгаа. Ингэснээр тухайн газарт томоохон хэмжээний хамтарсан уран бүтээл туурвих, бүтээлч үйлдвэрлэл бий болгох,

бүтээгдэхүүн үйлчилгээ үзүүлэх боломжуудыг бий болгоно гэж үзэж байгаа.

Л.Мөнхбаатар: Одоо Байнгын хорооны дарга Батсүхийн Саранчимэг асуултаа асууя.

Б.Саранчимэг: Баярлалаа. Тэгэхээр хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж байгаа. Тэгэхээр соёл урлаг энэ дэлхийн эдийн засгийн хөгжилд бас дорвитой хувь нэмэр оруулж бүүр томоохон салбарт тооцогдох болж, маш эрчимтэй хөгжиж байгаа. Одоо бүүр энэ салбарыг бүүр бүтээлч эдийн засагч гэж нэрлэж байгаа. Тэгэхээр Америкийн Нэгдсэн Улс, энэ европын орнуудад бүтээлч үйлдвэрлэл эдийн засгийн нэг салбар болтлоо хөгжсөн бол энэ Азийн орнуудад сүүлийн жилд улам энэ соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тэсрэлт болж байна гэж ярьж байгаа.

Тэгэхээр жишээ нь гэхэд Солонгос улс сүүлийн жилүүдэд Korean wave буюу энэ Солонгос давлагаа ч гэсэн энэ соёлын зөөлөн хүчний бодлого явуулснаар дэлхий нийтээр Солонгос хамтлаг дуу хөгжим, кино, үндэсний хувцас, хоол зэргийг түгээн дэлгэрүүлж, энэ нь соёлын бүтээлч үйлдвэрлэл нь олон сая долларыг оруулж ирж байна гэж байгаа.

Тэгэхээр манай улс энэ соёл, урлагийг эдийн засгийн үр өгөөжтэй салбар, хөгжлийн хөшүүрэг болгох чиг хандлагыг хууль, эрх зүйн хүрээнд бас баталгаажуулж ингэж оруулж ирж байгаа нь бол сайшаалтай байна. Миний асуух гээд байгаа асуулт бол оюуны өмчийн тухай хуулиар юм. Тэгэхээр соёлын бүтээлч үйлдвэрлэлийг ярихад зайлшгүй оюуны өмч, энэ зохиогчийн эрх яригддаг. Энийг хангах, хадгалах зайлшгүй шаардлагатай. Эдгээр нь оюуныхаа өмчөөр бас зохицуулагдаж байгаа хэдий ч гэсэн энэ хуультай хэрхэн уялдуулж оруулж ирж байгаа вэ гэсэн нэг асуулт.

Дараагийн асуудал бол энэ соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэхэд авьяаслаг бүтээлч хүнээс гадна соёл, урлагийн салбарын менежмент, борлуулалт, маркетингийн боловсон хүчин зайлшгүй бэлтгэх хэрэгтэй. Тэгэхээр энэ соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэх, хүний нөөцийг бэлтгэх тал дээр дэмжлэг үзүүлэх талаар ийм зохицуулалт хийгдсэн байгаа юу гэсэн ийм асуулт байна. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Саранчимэг гишүүний асуултад хариулъя. Соёлын сайд Номин.

Ч.Номин: Саранчимэг гишүүний асуултад хариулъя. Маш чухал асуулт тавьж байна. Нэгдүгээрт бол энэ соёлын бүтээлч үйлдвэрлэл буюу энэ креатив индустрийг таны хэлсэнчлэн олон улсад маш сайн хөгжүүлж явж байгаа 95 оноос хойш. Мэдээж энэ Азийн орнууд сүүлийн 20 жил бодлоготой хөгжүүлсэн. Солонгос улс бол яг 20 жилийн өмнө бид нартай адилхан энэ бүтээлч үйлдвэрлэлийнхээ хуулийг хэлэлцэж гаргаж ирээд энэ хуулийнхаа хүрээнд цаашид энэ салбараа хэрхэн хөгжүүлэх бодлогоо тодорхойлж гаргаж ирсэн.

Соёлын яамны зүгээс бол өнгөрсөн 2022 оны хувьд соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлогоо тодорхойлж энэ бодлогоо Засгийн газраар оруулж 43 дугаар тогтоолыг батлуулж авсан. Энэ хүрээнд бид нар соёлын бүтээлч үйлдвэрлэлийг 12 салбарын хүрээнд хөгжүүлнэ гэж гаргаж ирсэн. Өв соёл, кино урлаг, дүрслэх урлаг, утга зохиол, цаашлаад бүүр энэхүү олон улсад эрчээ авч байгаа энэ тоглоом хөгжүүлэлт гэх мэтчилэн салбарууд байгаа. Таны түрүүн нэрлэсэнтэй яг адилхан.

Тэгэхээр манай салбарын хувьд бол өөрсдийнхөө тэргүүлж хөгжүүлэх салбаруудаа тодорхойлсон байгаа гэсэн үг. Энэ дотроо 93 чиглэлээр хөгжиж байгаа.

Оюуны өмчийн хувьд бол та маш зөв асуулт асуулаа. Манай Монгол Улсын хувьд Оюуны өмч, Зохиогчийн эрхийн тухай хууль нь олон улсын хуультай маш сайн нийцсэн бөгөөд маш зохицуулалт сайтай хууль байгаа. Оюуны өмчийн тухай хууль бол оюуны өмчийг хэрхэн бүртгэх вэ гэдэг зохицуулалтыг хийж байгаа. Тэгвэл Зохиогчийн эрхийн тухай хууль энэхүү бүртгэсэн оюуны өмчөө хэрхэн хэрэглээнд оруулах вэ гэдэг талыг нь оруулж ирж байгаа. Тэгвэл манай Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тухай хууль бол энэхүү бүртгэгдсэн хэрэглээнд орсон зүйлээ хэрхэн эдийн засгийн эргэлтэд оруулж, хэрхэн хянаж тоолж авч явах вэ гэдэг зохицуулалт нь орж ирж байгаагаараа онцлог болж байгаа буюу одоо энэ хууль 3 хуулийн бүтцээрээ нэгдсэн байдлаараа соёлын бүтээлч үйлдвэрлэлд үйл ажиллагаа явуулж байгаагаа бүтээгдэхүүн, үйлчилгээ эрхэлж байгаа уран бүтээлчдийн бүтээл бүрэн хэмжээнд хадгалагдаж, бүртгэгдэж цаашаагаа эдийн засгийн эргэлтэд орох боломжтой болж байгаа гэсэн үг байгаа.

Мөн та энэ хүний нөөцийг хөгжүүлэх тал дээр асуусан. Хүний нөөцийн хувьд манай үндсэн бодлогын нэг буюу бид нар хүний нөөцөө хөгжүүлэх заалтуудыг маш их хэмжээнд оруулж ирсэн байгаа. Ер нь Монгол агуулгыг бүтээж байгаа Монгол уран бүтээлчдийг дэмжих заалтууд энэхүү хуульд 9 дүгээр бүлэгт нь орсон байгаа.

Л.Мөнхбаатар: Одоо Чинбатын Ундрэм гишүүн асуултаа асууя.

Ч.Ундрэм: Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг төрөөс дэмжих нь бодлогын хувьд зөв л дөө. Бид нар өөрсдийнхөө үндэсний соёлоороо бусдаас ондоошиж, ялгарч ингээд ч илүү давуу байдлыг үүсгэж бүтээгдэхүүнээ дэлхийн зах зээлд гаргах боломжтой болно. Гагцхүү энэ дээр оруулаад байгаа зарим дэмжлэгийг нь би оновчтой эсэхэд нэлээн эргэлзэж байна. Сая энэ Байнгын хорооны танилцуулгыг уншихад хууль

санаачлагчийн зүгээс энэ хууль хэрэгжих юм бол ямар нэгэн зардал гарахгүй гэж хэлсэн гээд тэгж байна л даа. Тэгээд яг хуулиа уншихаар энэ 2 дугаар бүлэг, төрөөс дэмжих дэмжлэгүүд гээд дэмжлэгүүд гээд би бүүр гайхаад байх юм 8.3-т. Хүмүүст талон олгоно гэнэ. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн бараа худалдаж авахад нь зориулаад талон олгоно гээд энэ ямар бүүр гайхамшигтай би бүүр ойлгохгүй, эдийн засгийн хүний хувьд бүүр бүүр нүд орой дээр гарахаар ийм заалтыг хараад сууж байна.

Тэгээд энийг яг юу юм бэ надаа тайлбарлаад өгөөч. Бүр ийм халамжийн систем рүүгээ энэ соёлын бүтээлч үйлдвэрлэлээ нэгтгэх гээд байгаа юм уу. Ийм заалт явж байна.

Дээрээс нь мэргэжилтэн бэлтгэх юм бол, хүний нөөц бэлдэх юм бол хамаг мөнгийг нь Засгийн газар гаргана л гэж байна. Үргэлжлүүлээд явж байсан чинь бүр төрөөс ийм үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага компаниудад өрийн баталгаа гаргана гэнэ. Засгийн газрын баталгаа гаргана, төсвийн дэмжлэг үзүүлнэ, өрийн баталгаа гаргана. Энэ чинь юу гэсэн үг юм бэ. Би ерөөсөө ойлгохгүй байна. Ийм юм арай байж болохгүй байх. Энэ дээр Сангийн яамнаас ямар санал өгсөн юм бол бүүр гайхаад байх юм.

Тэгээд одоо бүүр соёлын бүтээлч үйлдвэрлэлийн парк цогцолбор байгуулж өгнө гэнэ төрөөс. Ийм байдлаар дэмжих нь татвар төлөгчдийн мөнгийг ингэж зарцуулах нь хэр оновчтой юм бэ. Бүүр гайхаад байна.

Тэгээд яах вэ, жишээлбэл гаалийн олон улсын худалдааны хувьд тарифын болон тарифын бус бодлогоор дэмжиж бол болж байна гэж харж байгаа юм л даа. Тэгэнгүүт дахиад нэг сан байгуулна л гэж байна. Энэ сангууд чинь баахан хулгайд автаад хүн амьтан төлөхгүй байна, давуу байдалтай хүмүүс нь олж аваад байна гээд л зөндөө хэл ам гараад байна. Сангийн менежмент манай улсад ер нь олигтой

явахгүй байна шүү дээ. Одоо дахиад л нэг сан. Таны хүсэлтээр кино урлагийг дэмжих тухай сан ямар ч л байсан байгуулагдаад ажил нь эхлээд явж байгаа. Одоо дахиад энэ соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих сан гээд байгуулагдаад явахаар энэ нь хэр үр дүнтэй байх юм бол.

Тэгэхээр нэгдүгээрт энэ талон тараах асуудлаа надаа тайлбарлаад өгөөч.

Хоёрдугаарт энэ төрөөс энэ өрийн баталгаа гаргана гэдэг асуудлыг надаа тайлбарлаад өгөөч. Энэний цаана ямар их эрсдэл гарах вэ гэдгийг судалж үзсэн үү, санхүүгийн хүмүүстэй зөвлөлдсөн үү, Сангийн яамнаас бас санал авсан уу. Тэгээд энэ 9.7.1 дээр гэхэд тэмцээн уралдаан зохион байгуулахад хүртэл ингээд төр мөнгө гаргах гэдэг ийм сонин сонин дэмжлэгүүд ер нь хэрэгтэй юм уу. Тэгээд улсаас ямар ч мөнгө гарахгүй гээд байгаа дүгнэлт чинь шал худлаа байна. Энэ хуулийг харахаар. Тэгээд эдгээр зүйл дээр хариулт хэлж өгөөч.

Л.Мөнхбаатар: Ундром гишүүний асуултад хариулья. Ингэхдээ Соёлын энэ бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуульд өгсөн Сангийн яамны санал, Эдийн засгийн хөгжлийн яамны саналуудыг бас танилцуулчих нь зүйтэй юм байна. Соёлын сайд Номин хариулья.

Ч.Номин: Би Ундром гишүүний асуултад ерөнхийд нь хариулаад, сая дэд даргын хэлсэн саналуудыг үргэлжлүүлээд манай ажлын хэсгээс нэмээд хариулаад явна. Ер нь бол аливаа бизнес аливаа шинэ салбарыг хөгжүүлэх нөхцөлд бол тодорхой үе шат байдаг. Аливаа зүйлийг бойжуулна, хөгжүүлнэ, түгээн дэлгэрүүлнэ гэдэг шатууд байдаг. Монгол Улс бол маш олон бодлогын бичиг баримтууд дээрээ Монгол Улс олон тулгуурт эдийн засгийн суурьтай болно, цаашид мэдлэгт суурилсан эдийн засгийг бий болгоно, дэлхийн чиг хандлагыг суурилж явна гэдэг ийм бодлогыг тодорхойлсон. Энэ хүрээндээ соёлын

бүтээлч үйлдвэрлэл бол шинээр бий болж байгаа эдийн засаг гэсэн үг. Нэг шинэ индастри болж орж ирж байгаа. Дэлхийн жишгээрээ ч, улс орны жишгээрээ ч шинэ эдийн засгийг бид нар бойжуулж авч явдаг. Энэ утгаараа энэ хууль бол шинэ эдийн засгийг бойжуулж авч орох гэж, орж ирж байгаа хууль гэж та бодож болно.

Энэ утгаараа бид нар соёлын бүтээлч үйлдвэрлэлийнхээ эко системийг бүрэн судалсан. Энэхүү эко системд бодлогын дэд систем, үйлдвэрлэлийн дэд систем, судалгаа, хөгжүүлэлтийн дэд систем, түгээлтийн дэд систем гэсэн энэ олон дэд системийн уялдаа холбоог бүрэн хангаж, аль хэсэгт нь зөв дэмжлэг үзүүлбэл энэ салбар энэ олон хүний яриад байгаа эдийн засгийн бие даасан салбар болж Солонгос, Америк, Англи гэх жишгийн энэ улс орнуудтай ижил түвшинд авч явах вэ гэдгийг тодорхойлж гаргаж ирсэн учраас бүтээн туурвих, үйлдвэрлэх, түгээх хэрэглээг дэмжсэн заалтууд орж ирсэн.

Би таны асууж байгаа соёлын ваучер буюу соёлын эрхийн бичгийн талаар ярилцъя. Энэ бол дэлхийд гарч байгаа хамгийн том чиг хандлага байгаа. Энэ ирээдүйд соёл хүртэж сурсан иргэдийг бэлтгэж байгаа заалт орж ирж байгаа. Энэ бол анхлахдаа Франц улс, Герман улс болон Европ улсуудаас үүсэн бий болсон. Өнгөрсөн хугацааны судалгаагаар Нэгдсэн Үндэстний Байгууллагын судалгаагаар үзэхэд 2020 оны хувь байдлаар манай өсвөр насныхан бол соёлын болон бусад арга хэмжээнд хамгийн багаар оролцож байна. Хүний хөгжлийн арга хэмжээнүүдэд хамгийн бага оролцож байна гэж үзсэн учраас бид нар үндэсний нэгдмэл үнэт зүйлийг бэхжүүлэх, ирээдүйд бий болж байгаа иргэддээ соёл хүртэж сурсан соёлоор дамжиж өөрийнхөө өв соёлыг нандигнан хайрлах боломжтой ийм хүмүүсийг бий болгох үүднээс өсвөр насныхан буюу 15-аас, 14-16 насныханд аливаа соёлын арга хэмжээнд оролцох боломжтой эрхийн бичгүүдийг бий болгож оруулж ирэхээр

заалтыг оруулж ирсэн байгаа. Тэгэхээр энэ хүрээнд бид нар энэ заалт орж ирсэн гэж үзэж байна. Нэмэлт хуулийн зүйлийг болохоор манай Хуулийн хэлтсийн дарга Батцэцэг хариулна.

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгийн 83 дугаар микрофоныг өгье. Албан тушаал, нэрээ хэлээд асуултад хариулаарай.

С.Батцэцэг: Батцэцэг. Засгийн газраас үзүүлж байгаа дэмжлэгүүдийн хувьд гэх юм бол хуулийн төслийн 13 дугаар зүйл дээр тодорхой зааж өгсөн. Засгийн газраас тодорхой баталгаанууд гаргах тэр баталгаанууд нь ямар хэлбэртэй байх талаар заасан. Энэ нь Хөрөнгө оруулалтын тухай хуулийн төсөлтэйгөө уялдаж байгаа ийм ерөнхий зохицуулалтын үндсийг нь бий болгоод, Хөрөнгө оруулалтын хуулийн 11 дүгээр зүйлд зохих өөрчлөлтийг оруулж өгсөн.

Хуулийн төслийг өргөн мэдүүлэхэд Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу Сангийн яамны зөвшөөрлийг авсан. Сангийн яамны 2023 оны 4 сарын 18-ны 01/2385 албан бичгээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг зөвшөөрсөн ийм зөвшөөрөл өгсөн байгаа. Засгийн газрын тусгай сангийн хувьд гэх юм бол Соёл урлагийг дэмжих сан гэдэг сан Засгийн газрын тусгай сангийн тухай хууль дээр байдаг. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төслийг боловсруулсантай холбогдуулаад Соёл урлагийг дэмжих санг Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих сан болгон үйл ажиллагааг нь ийм өргөжүүлсэн зохицуулалтаар тусгаж өгсөн.

Л.Мөнхбаатар: Хэн хариулчав. Нэр, албан тушаалаа хэлээрэй. Яагаад гэвэл хэний асуултад хэн хариулж байгаа нь өөрөө протоколд үлддэг дэгтэй шүү. Энийг ажлын хэсгийн гишүүдэд сануулж хэлье. Батцэцэг үү саяынх. За.

Балжиннямын Баярсайхан гишүүн асуултаа асууя.

Б.Баярсайхан: Номин сайд сая та маш хариуцлагагүй үг амнаасаа гаргаж байна шүү дээ. Сүүлийн 20 жил соёлын бодлого алдагдсан гэж. Хэчнээн, хэдийгээр 23 жил бид нар бие даасан соёлын яамгүй байсан ч гэсэн соёлын бодлого ерөөсөө алдагдаагүй. Бүүр Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны харьяанд байхдаа өнөөдрийн та бүхний ажиллаж байгаагаас хавьгүй илүү түвшинд ажиллаж байсан. Харин ч одоо ингээд Соёлын яам байгуулагдаад 3 жил болчихсон байхад сахил хүртээд шал дордов гэгчээр үнэндээ бол Соёлын яам байгуулагдаад бидний хүлээсэн хүлээлтэд хүрч ажиллаж чадахгүй байгаа гэдгийг би хэлчихье. Зүгээр нэг жишээ өнөөдөр бүхэл бүтэн аймаг 100 жилээ хийж байна. Танай яамны хариуцлагагүй хүмүүсийн хар гайгаар шинээр байгуулагдсан театрт нь өнөөдөр 100 жилээ тэмдэглэх гэж байгаа сум орон нутаг, аймагт ширээ ч үгүй, сандал ч үгүй ингээд байж байна шүү дээ. Тэгээд ганцхан хотод хийж байгаа үйл ажиллагаагаа соёлын ажил гэж ингээд үзээд байх юм. Би одоо энийг 3 жил танайхаас бүүр ингээд шаардаж байна шүү дээ. Хөдөө орон нутагт, сум дээр ганц соён гэгээрүүлэх ганц сурах бие биетэйгээ уулзах, учрах, соён гэгээрэх газар нь соёлын төв байдаг юм. Тэнд ямар ч тийм өөр театр юу гэдэг юм, Улаанбаатар хотод байдаг шиг тийм олон газар байдаггүй гэж ярьж байгаа. 3 жил шаардаж байна. Танайх яамнаас энэ хүүхдүүдийн гар утсанд үзээд байгаа Монгол контент Монголоор ярьж байгаа Монгол контентыг үйлдвэрлэж байгаа, хийж байгаа, удахгүй гарна гэж хэлсэн. Энэ асуудал ер нь юу болж байгаа юм. Энэ үйлдвэрлэл нь соёлын бүтээлч үйлдвэрлэлдээ орох уу. Тэгээд Монгол хүүхдүүд дандаа гадаад контент гар утсан дээр үзэж байгаа учраас хэлээ мартаж байна. Мөн үүгээрээ дамжуулаад Монгол соёлыг авч чадахгүй байна. Монгол ахуй, Монгол дотортой Монгол хүн болох энэ бодлого алдагдаж байна. Монгол улсын хамгийн, ер нь ганцхан Монгол ч гэхгүй улс орны хамгийн гол үндэстэн байх

дархлаа чинь хэл, соёлын асуудал байгаа. Тэгээд энэ соён гэгээрүүлэх ажил чинь хийгдэхгүй байна шүү дээ. Хүүхдүүд өнөөдөр Англиар хэлд орж байна. Хүүхдүүд өнөөдөр Монгол үзэх юм байхгүй байна. Тэгээд энэ ажлууд чинь хийгдээд байгаа л гээд байгаа. Хэзээ хийгдэж байгаа юм бэ, энэ соёлын бүтээлч үйлдвэрлэл дотроо орж байгаа юм уу, орохгүй байгаа юм уу тээ. Энийг асуумаар байна.

Тэгээд өнөөдөр улс орнуудын дунд соёлын зөөлөн хүчний бодлого буюу улс орноо сурталчлах, дээрээс нь энэ Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлж байгаа “Монголд зочлох жил” гээд 3 жилийн хугацаанд энэ юу зарлачихлаа. Зорилт зарлаад бид нар явж байна. Тэгээд энэ хууль батлагдсанаараа энэ ажил сайжрах юм уу, энэ ажлууд чинь хийгдэх юм уу. Бид нар сая хэд хоногийн өмнө тэр Тэнгис анимэйшн гээд бүр дэлхийн тавцанд гарахаар хэмжээний чанартай хүүхэлдэйн кино хийж байгаа, бүр ингээд 100 анги сэриал цувралаар хүүхдийн зан чанар төлөвшүүлэх зааж байгаа ийм залуучуудыг ингээд уулзсан байгаа, та нартай уулзах байх. Та бүхнийг цаг аваад уулзаж чадахгүй байгаа юм байна лээ.

Тэгээд энэ үйлдвэрлэхсэн, үйлдвэрлээд л явуулаад байгаа хүмүүсээ та нар өнөөдөр ямар хэмжээнд дэмжиж байгаа юм. Хамгийн гол нь энэ хүүхдүүдээ, орон нутгийн иргэдээ соён гэгээрүүлэх ажил чинь хийгдэхгүй байгаад байна шүү дээ. Тэгээд энэ дээр би хариулт аваад тэгээд тодруулж асууя тэгэх үү.

Л.Мөнхбаатар: Зочин танилцуулъя Улсын Их Хурлын гишүүн Балжиннямын Баярсайханы урилгаар Монгол Улс болон Америкийн Нэгдсэн Улсын хөгжмийн багш нар Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүгдэд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс ажлын амжилт хүсэж, уран бүтээлд нь амжилт хүсье.

Баярсайхан гишүүний асуултад хариулъя. Соёлын сайд Номин хариулъя.

Ч.Номин: Баярсайхан гишүүний асуултад хариулъя. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого Алсын харааг тодорхойлж гаргахдаа эрдэмтэн, судлаачид олон жилийн судалгаан дээр суурилж хийсэн. Ингэхдээ Монгол Улсын соёлын бодлогын тогтолцоо бүрэн алдагдсан байна гэдэг судалгаагаар гарсан учраас энэ судалгаан дээр суурилан Соёлын яамыг байгуулах шийдвэр гарсан.

Соёлын яамны хувьд бол Соёлын яам байгуулагдсан цагаасаа хойш тогтолцооны хувьд шинэчлэгдсэн. Мөн үүнээс гадна төсвийн хувьд нэмэгдсэн. Таны хэлж байгаа орон нутгийн соёлын төвүүд дээр шинээр үүсгэн байгуулагдаж байгаа шинэ соёлын төвүүд дээр тоног төхөөрөмж байхгүй байгаа гэдэг асуудалтай би санал нэг байна. Манайх төсвийн тодотгол, төсвийн үеэр тогтмол энэ соёлын төвүүдийн тоног төхөөрөмжийг шинэчлэх, соёлын төвүүдийг тогтмол үйл ажиллагаатай болгох дээр оруулж ирдэг. Өнөөдрийн байдлаар Монгол орон даяар байгаа 333 сумд байгаа соёлын төвүүдийг бүрэн хэмжээнд тоног төхөөрөмжтэй болгоход бид нар 1 соёлын төвд 291 сая төгрөг буюу нийтдээ 33.7 тэрбум төгрөг шаардлагатай байгаа. Үүнийг бид бас энэ 2024 оны төсөвт санал болгон оруулсан байгаа.

Харин би энэ завшааныг ашиглан энд байгаа бас гишүүддээ энэ нөхцөл байдлыг ойлгож энэ тоног төхөөрөмжийн асуудлыг шийдвэрлэхэд та бүхэн маань оролцоосой гэж хүсэж байна. Дэмжлэг үзүүлээсэй гэж хүсэж байна.

Орон нутагт тийм ээ үнэн. Орон нутагт хүн амьдарч байгаа тэр газруудад сумын соёлын төвүүдээр дамжуулан үйл ажиллагааг явуулж соёлыг хүртээх ёстой. Энэ ч утгаараа манайх “Соёлын сэргэлт” гэдэг арга хэмжээг Монгол орон даяар хийгдэж байгаа. Сүүлийн 60 жилд сум,

багийн түвшинд очиж нийслэлээс соён гэгээрлийн лекцтэй, боловсролын, хүүхэд залуучуудын боловсролын хөтөлбөртэй, урлаг, уран сайхны хөтөлбөртэйгөөр нэгдсэн бодлоготой явсан ажил бол бүрэн хэмжээнд хийгдээгүй. Тэр утгаараа бол манай Соёлын сэргэлт Монгол Улсын 21 аймаг, нийслэлийн 9 дүүрэг, цаашлаад орон нутгийн 330 сумд бүрэн хэмжээнд тойрсон ажиллагаа хийж байгаа. Энэний хүрээнд орон нутагт ажиллаж байгаа ажилтан албан хаагчдаа чадавхжуулах нэгдүгээрт,

Хоёрдугаарт, Орон нутагт байж байгаа иргэдэд соёлын хүртээмжийг нэмэгдүүлэх,

Гуравдугаарт, Соён гэгээрүүлэх лекц, боловсролын хөтөлбөрүүдийг нэмэгдүүлэх дээр ажиллаж байгаа бөгөөд цаашид соёлын төвүүдийг тогтмол үйл ажиллагаатай болгох дээр илүү ажиллаж байгаа.

Ер нь аливаа нэгэн соёлын бүтээгдэхүүн үйлчилгээ нэг сайдын шийдвэрээр гардаг байх тогтолцоо байж болохгүй гэж би үзэж байна. Энэ ч утгаараа энэ Кино урлагийг дэмжих, Соёл урлагийг дэмжих сангууд дээр бодлогыг тодорхой гаргаж энэнд аливаа уран бүтээлчид өөрийнхөө бүтээлийг танилцуулж үүнийхээ хүрээнд шаардлагатай санхүүжилтээ авч явах нь маш зөв тогтолцоо болов уу гэж харж байгаа. Энэ утгаараа Кино урлагийг дэмжих сангийн хүрээнд хүүхдийн кинонд зориулсан санхүүжилтийг дөнгөж сая гарсан. Эхний бүтээл нь кино театрт одоо нээлтээ хийчхээд явж байгаа. Дараагийн бүтээлүүд нь гарч ирнэ. Энэхүү уран бүтээлээ туурвиж байгаа уран бүтээлээр санхүүжилт авах гэж байгаа хүмүүсийн хувьд Кино урлагийг дэмжих санд хандах нь зүйтэй гэж үзэж байна.

Мөн үүнээс гадна Соёл урлагийг дэмжих сангийн хувьд нийт санхүүжилтийнхээ 50 хувийг хүүхэд,

залуучуудад зориулан үндэсний агуулгатай бүтээгдэхүүн үйлчилгээ бий болгох дээр суурилуулан хийдэг. Та мөн Монгол Улсыг олон улсад сурталчлан таниулах, цаашлаад аялал жуулчлалын салбарт хэрхэн, хэр нөлөөлж байгаа вэ гэж хэлж байна. Энэхүү соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжсэнээр энд үйл ажиллагаа явуулж байгаа 12 салбарын 93 чиглэлээр бүтээгдэхүүн үйлчилгээ нэмэгдэнэ. Энэ нь цаашлаад энэ аялал жуулчлалаар ирж байгаа дотоод, гадаадын жуулчдад хэрэгцээтэй, шаардлагатай бүтээгдэхүүнүүдийг нэмэгдүүлэх дээр илүү анхаарч байгаа. Мөн Монгол Улсыг олон улсад соёлоороо дамжин сурталчлан таниулах ажил энэ хүрээнд хийгдэж байгаа.

Л.Мөнхбаатар: Балжиннямын Баярсайхан гишүүн тодруулж асууя.

Б.Баярсайхан: Би та бүхний хийж байгаа гээд байсан тэр хүүхдэд зориулсан контент чинь яг хэзээ гарч дуусах юм бэ гэдэг асуултыг асуусан нэгдүгээрт.

Хоёрдугаарт энэ соёл урлагийг дэмжих санг хүлээн зөвшөөрөхгүй байна. Энэ өмнөх сангуудад гарч байгаа авлигын асуудал дуусаагүй байхад мөн одоо Кино урлагийг дэмжих сангийнхаа үйл ажиллагааг цэгцэлснийхээ дараа энэ Соёл урлагийг дэмжих сангаа та нар байгуулсан нь зөв болов уу гэж бодож байна. Тэрний оронд энэ соёлын салбарынхаа хүний нөөцийг чадавхжуулах, энэ хөдөө орон нутагт ажиллаж байгаа хүмүүсийгээ мэргэшүүлэх энэ соён гэгээрүүлэх энэ ажилдаа илүү төсөв мөнгө үрэхгүй, хүний оюун ухаанд хөрөнгө оруулалт хийх ажил руугаа нэлээн анхаарсан нь дээр байх гэж бодож байна.

Эцэст нь Номин сайдаас нэг зүйл хүсье. Завхан аймгийн 100 жил болж байгаа. Та бүхний буруутай үйл ажиллагаанаас хасагдсан тэр 185 сая төгрөгийн ширээ, сандлыг ядаж энэ 100 жил тэмдэглэж байгаа сумд өгнө үү. Бид

нар хаанаас энэ театртаа ширээ, сандал гуйгаад явах вэ.

Баярсайхан гишүүний тодруулгад хариулъя. Соёлын сайд Номин 85 дугаар микрофон.

Ч.Номин: Би Баярсайхан гишүүний асуултад тодруулж хариулаад, нэмэлт соёл урлагийг дэмжих сангийн талаар нэмэлтээр манай ажлын хэсгээс хариулна.

Нэгдүгээрт төсвийн тухай хуулиараа буюу Хэмнэлтийн тухай хуулиараа энэ орон шинэ төсөв, төсөл, арга хэмжээг хийхгүй гэдэг утгаараа энэ орон нутгийн тоног, төхөөрөмж хасагдсан. Энэ ямар нэгэн байдлаар Соёлын яам болон аль хүний буруутай үйлдлээс биш бодлогын шийдвэр гарсан учраас энэ бодлогын шийдвэр дээр нь шинэ арга хэмжээ хийхгүй гэдгээс болж энэ хасагдсан байгаа.

Бид нарын хувьд бас орон нутгийн 100 жилтэй орон нутгийн байгууллагуудаа дэмжихгүй биш дэмжиж байгаа. Сүүл дөрвөн 100 жилтэй орон манай аймаг байгаа. Эдгээр аймгуудад бид нар уран шинэ уран бүтээл туурвих санхүүжилтийг өгч байгаа. Үүнээс гадна бас нэг зүйл тодруулаад хэлэхэд аливаа зүйл санхүү, хөрөнгө оруулалтгүйгээр хэзээ ч явахгүй. Энэ утгаараа хүний оюун санааг ч гэсэн сайжруулах, хүний оюун санаатай ажиллах байсан ч гэсэн эдгээр зүйл төсөв санхүүжилт ордог. Би дахиад нэг юм тодруулаад хэлье. Кино урлагийг дэмжих.../минут дуусав./

Л.Мөнхбаатар: Гүйцээгээд хариулчихъя. 1 минут.

Ч.Номин: Энэхүү кино урлагийг дэмжих сан болон Соёл урлагийг дэмжих сан шинээр байгуулагдаж байгаа сан огт биш. Өмнө нь байсан сангууд бөгөөд Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль орж ирсэнтэй уялдуулан нэрийн өөрчлөлт орж байгаа сангууд

байгаа юм. Соёл урлагийг дэмжих сангийн тухай нэмэлт хариултыг манай ажлын хэсгээс хариулчих.

Л.Мөнхбаатар: Ажлын хэсэг хэд дүгээр микрофон вэ. 88 уу.

Г.Батхуяг: Соёлын яамны соёлын бүтээлч үйлдвэрлэл, инновацын хэлтсийн дарга Батхуяг. Соёл, урлагийг дэмжих сан бол одоо үйл ажиллагаа нь олон жил яваад ирчихсэн ийм сан байгаа. Энэ Соёл, урлагийг дэмжих сангийн үйл ажиллагааг өргөжүүлэх тухай энэ хууль дээр байгаа. Зүгээр Соёл, урлагийг дэмжих сангийн сүүлийн жилийн үйл ажиллагааг хүүхдийн уран бүтээлийг дэмжих чиглэл рүү 50 хувь нь зарцуулах ийм шийдвэрийг гаргаж жил болгон санхүүжилтийн юуг олгож байгаа. Энэ дэмжих сангийн хүрээнд хүүхдэд зориулсан маш олон дижитал болон контентуудад анимэйшн зэрэг контентууд бий болсон.

Энэ Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн таны, Баярсайхан гишүүний асуусан асуултад хариулахад хүүхдийн үзэж байгаа гар утсанд болон үндэсний агуулгатай контентууд бол мэдээж маш дутмаг байгаа. Өөрөөр хэлбэл телевиз, радио, цахим орчинд гаднын контентын давамгайл байдал үүсчихсэн. Тэгэхлээр энэ хуулийн гол агуулга ерөөсөө үндэсний агуулгыг дэмжих, үндэсний агуулгыг бүх шатад дэмжинэ гэдэг маш том агуулга.../минут дуусав./

Л.Мөнхбаатар: Хариулж болсон уу, гүйцээж хариулах юм уу. Хариулт дууссан байна. Одоо Цэндийн Мөнх-Оргил гишүүн асуултаа асууя.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийг дэмжиж болох байх. Ийм хууль хэрэгтэй байх. Миний ойлгосноор бол креативитийг л дэмжих гээд байна лээ гэж ойлгоод байна шүү дээ. Хэд хэдэн асуулт байна. Тэгээд тэмдэглэж аваад

товчхон хариулчхаач. Би ч гэсэн товчхон асуучихъя.

Энэ 15-18 насны хүүхдүүдэд эрхийн бичиг өгөх юм байна л даа. Заавал ингэж эрхийн бичиг өгч өөрс дээрээ ажил удах хэрэг байна уу. Зүгээр л хүүхдүүдээ энэ театр, музей, соёлын арга хэмжээнүүдэд үнэгүй оруулчихад л хангалттай юм биш үү. Хамаагүй зардал багатай юм биш үү. Тэгээд сургалтын хөтөлбөрт нь оруулаад Боловсролын яамтай яриад.

Хоёрт энэ санг дэмжье гэж байгаа юм байна. Тэгээд сангаасаа Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих сан гэж нэрийг нь өөрчилчхөж байгаа юм байна. Уул нь Соёл, урлагийг дэмжих сан байсан. Тэгээд урлаг гэдэг үгийг нь аваад хаячих юм. Энэ чинь үр дагавар, үр дагавартай шүү дээ. Соёл, урлаг гэдгийг чинь бид нар хоёр өөр л хоорондоо холбоотой боловч хоёр өөр зүйл, өөр үйл ажиллагаа гэж ойлгоод л яваад ирсэн шүү дээ.

Тэгээд 100 сая төгрөг хүртэл оруулсан хандивыг татвар ноогдох орлогоос нь хасах гэж байгаа юм байна л даа. Тэгээд ингэж үнийн дүн тавих буруу л даа. Уул нь бол яах ёстой вэ гэхлээр жишээ нь зарим аж ахуйн нэгжүүдэд 100 сая гэдэг чинь аймаар өндөр үнийн дүн байхгүй юу. Зарим аж ахуйн нэгжүүдэд юу ч биш байхгүй юу.

Тэгэхлээр энэ татвар ноогдох орлогоос хасах дүнг тооцохдоо татвар ноогдох орлогын төдөөс илүүгүй хувийг хандивласан бол гэж тооцмоор байгаа байхгүй юу. Тэгээд жишээ нь тэрбум төгрөгийн хандив өгч байгаа байгууллага 100-гаараа хязгаарлагдахгүйгээр татвар ноогдох орлогын 2 хүртэл хувийн хэмжээтэй хандив өгсөн бол татвар ноогдох орлогоос, татвар ноогдох орлогынхоо үнийн дүнгээс нь хасах хэрэгтэй юм байгаа юм. Тэгж байж энэ санд хандив өгөх ажил жоохон эрчимтэй явах байх л даа. Тийм, зүгээр 100 сая төгрөг гэхилээр чинь наадах чинь бол

хэрэгжихэд хэцүү цөөхөн байгууллага өгнө.

Гуравт энэ Газрын тухай хуульд өөрчлөлт оруулаад тусгай хэрэгцээний газар болгох гээд байх юм. Буруу шүү дээ. Тусгай хэрэгцээний газар гэдэг чинь Газрын тухай хуулиараа бид нар наадах чинь жишээ нь боомтын газрууд, дипломат төлөөлөгчийн газрууд гэх мэтээр ингээд цөөхөн тусгай хэрэгцээтэй газарт авч байгаа байхгүй юу. Энэ дээр бол газрын хөнгөлөлт, газрын төлбөрийн хөнгөлөлт байх хэрэгтэй. Жишээ нь та нарын миний ойлгосноор та нар мөрөөдөл чинь бол том студи байгуулаад л тэндээ ингээд л кино үйлдвэрлэл явуулах гээд байна шүү дээ. Тэнд газрын төлбөрийн хөнгөлөлт байх хэрэгтэй. Тэгэхээр тусгай хэрэгцээний газар байж болохгүй байхгүй юу. Энэ чинь тусгай хэрэгцээний газар гэдэг чинь зориулалт нь өөр. Нийтийн эрх ашигт үйлчилж байдаг, public goods-д зориулсан юманд л ашиглана шүү дээ.

Дөрөвт энэ Барьцааны хуульд өөрчлөлт оруулах гээд их сонин юм оруулаад ирэх юм. Энийгээ бушуухан татаж авсан чинь дээр байх. Ер нь нэгдүгээрт уншаад ерөөсөө ойлгогдохгүй юм.

Хоёрдугаарт ойлгогдохгүй байгаа учраас яг зориулалт нь ойлгогдохгүй юм. Тэр Газрын хөдлөх болон Үл хөдлөх хөрөнгийн барьцааны тухай хуульд чинь одоо та нарын нэмж оруулах гээд байгаа заалт чинь ийм байхгүй юу. Жишээ нь тээвэрлэгч төлбөрөө авахын тулд нөгөө тээвэрлэж байгаа бараагаа барьцаалдаг, эсвэл ажил гүйцэтгэгч төлбөрөө авахын тулд нөгөө барьж байгаа байшингаа барьцаанд авч болдог байхгүй юу. Тэрэнд дараалал харгалзахгүйгээр нөгөө ажлаа хийчихсэн хүн чинь нөгөө орон сууцыг нь борлуулаад, гарсан мөнгөнөөс нь түрүүлээд өөрийнхөө төлбөрийг авдаг эрх байхгүй юу. Та нар тэгсэн чинь яг эсрэгээр нь соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор хүн хөрөнгө босгоод, босгосон хөрөнгийг хөрөнгө босгохын тулд

хөрөнгө барьцаалчихсан. Тэгээд миний энэ барьцаа

Л.Мөнхбаатар: Асуултад хэн хариулах вэ. Та яах юм. Мөнх-Оргил гишүүнд нэмж 1 минут өгье. Гүйцээгээд асуучих.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Тэгээд энэ Барьцааны хуульд оруулж байгаа өөрчлөлт чинь утгагүй, та нарын бодсоноос яг эсрэг юм байна. Энийг ингэж засаж болохгүй. Эцэст нь ерөөсөө энэ соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих энэ бүх арга хэмжээнд чинь явсаар байгаад л хүүхдүүд, тэгээд энэ консерватор, СУИС хоёр л байгаа шүү дээ. Тэгээд энэ хоёр дээрээ яг юу хийж байна. Юу хийх гэж байна. Боловсролын яамтай нийлж юу хийж байна. Энэ 2 байхгүй болчихвол энэ 2 үйл ажиллагаа нь доголдоод эхэлбэл та нар мянга сан байгуулаад, мянга хууль батлуулаад, Монголын соёлын өв цаашаа дараагийн үедээ шилжихгүй. Бид нар бахархдаг энэ соёлын өвөө алдаад л дуусна. Тэгээд энэ дээр юу хийж байгаа юм бэ. Энэ дээр энэ хуульд чинь юу орсон бэ. Ийм 5 асуулт байна.

Л.Мөнхбаатар: Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдоржийн урилгаар Ховд аймгийн Мөст сумын ерөнхий боловсролын сургуулийн 1993 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүгдэд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс ажил, амьдралд нь амжилт, сайн сайхан бүгдийн дээдийг хүсэн ерөөе.

Асуултад хариулъя. Цэндийн Мөнх-Оргил гишүүн 5 тодорхой асуулт асуулаа. Энд нь дугаарлаад хариулаарай. Хэн хариулах вэ. Соёлын сайд Номин хариулъя.

Ч.Номин: Би Мөнх-Оргил гишүүний нэгдүгээр асуулт, гуравдугаар асуулт, дөрөвдүгээр асуултад нь хариулъя. Яг Газрын тухай хуультай, Барьцаа хөрөнгийн тухай хуультай хэсэг дээр нь бол манай хуулийн хэлтсээс хариулна.

Нэгдүгээрт бол та соёлын эрхийн бичгийн талаар асуулаа. Яг өнөөдрийн байдлаар бол манай зохицуулалт дээр Музейн тухай хуулиараа угаасаа 16 наснаас доош хүүхдүүд бол музей үнэгүй үзэх зохицуулалт аль хэдийн байгаа.

Түрүүн би бас хэлсэн. Энэ яг өсвөр насныхны хувьд бол соёлын арга хэмжээ, биеийн тамир, спорт, цаашлаад хүний хөгжилд хэрэгцээтэй арга хэмжээнүүд дээр дандаа орхигдож байгаа ийм судалгаанууд гарч ирсэн. Эдгээр хүмүүсийг бид нар ирээдүйд хамгийн гол нь соёл хүртэж сурсан иргэд болгож бэлтгэхэд бага наснаас нь соёлын хэрэгцээ шаардлагаа хангадаг, шийдвэр гаргах чадвартай, өөрсдөө ном товхимол худалдаж авдаг, кино театраар ордог, театр, үзвэр үйлчилгээ үздэг, музейгээр ордог ийм иргэн болж хүмүүжих энэ суурийг нь тавих ёстой гэж үзсэн учраас энэ заалт орж ирсэн байгаа. Яах вэ, мэдээж нөгөө боловсролын бид нар бол бүх нийтийн соёлын боловсролынхоо хүрээнд Боловсролын яамтайгаа уялдуулан албан боловсролын хүрээнд бол шууд сургуулийн хүүхдүүд бол сургуулийнхаа хөтөлбөрт оруулаад манай музейн боловсролын хичээлүүд дээр тогтмол ирж оролцдог.

Хэдий тийм боловч нөгөө өөрийн шийдвэр гаргачихсан бөгөөд гэр бүлийн түвшинд өөрөө шийдвэр гаргах чадамжтай хүүхдүүд маань өөрсдөө яг санхүүгийн хувьд урлаг, уран бүтээлийн үйл ажиллагаанд оролцох боломж нь хангалттай бус байгаа гэдэг судалгаа гарч ирсэн учраас энэ хүрээнд энэ заалт маань орж ирсэн бөгөөд ирээдүйн бас бүтээлч үйлдвэрлэлд хэрэглэгч бэлдэж байгаа ийм тогтолцоог гэж бид нар харж байгаа.

Цаашлаад соёлын бүтээлч үйлдвэрлэлийн яагаад урлаг, уран бүтээлийг оруулж ирсэнгүй вэ гэдэг та хэлж байна. Бид нарын хувьд бол энэ соёлын бүтээлч үйлдвэрлэл буюу креатив индустри болгож энэ салбар бий болгож хөгжүүлж байгаатай уялдуулан дотор нь 12 дэд салбарууд байж байгаа. Энэ дотор манай тайзны урлаг, цаашлаад кино урлаг, дүрслэх урлаг гэсэн энэ урлагийн бүх арт чиглэлийн салбарууд маань орчихсон байгаа.

Тэгэхээр бид нар энэ бүтээлч үйлдвэрлэл индустри байдлаар оруулж ирсэн учраас нэр нь ингэж солигдсон байгаа. Мөн консерватор болон Соёл урлагийн дээд сургуультай Соёлын яам байгуулагдсан цагаасаа хойш маш нягт ажиллаж байгаа. Бид нарын хувьд хүний нөөцийнхөө нэгдсэн судалгааг гаргаад бид нар хүний нөөцийн бодлогоо тодорхойлж, Монгол Улсын хэмжээнд соёлын салбарт хэрэгцээ, шаардлагатай байгаа сонгодог урлаг болон бусад салбар, нэн ялангуяа соёл урлагийн менежмент, Оюуны өмчийн хууль, соёлын аялал жуулчлал гэх мэтчилэн салбарууд дээр ямар хэмжээний хэрэгцээ, шаардлага байгаа вэ гэдгээ тодорхойлоод бид нар консерватор болон энэ Соёл, урлагийн их сургуультай хичээлийн хөтөлбөр, шинээр анги үүсгэх ажлууд дээр хамтраад ажиллаад явж байгаа.

Үлдсэн хоёр асуултад нь манай Хууль зүйн хэлтсийн дарга хариулна.

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгийн 83 дугаар микрофоныг өгье. Мөнх-Оргил гишүүний асуултад хариулъя

С.Батцэцэг: Соёлын яамны Хууль эрх зүйн хэлтсийн дарга Батцэцэг асуултад хариулъя. Тэгэхээр манай хувьд болохоор хорших, кластераар хөгжихийг нь илүүтэй дэмжинэ гэж байгаа учраас энэ нь өөрөө зардал нь, соёлын бүтээлч үйлдвэрлэгчдийн зардал буурна, ашигт ажиллагааны түвшин нэмэгдэнэ гэдэг

утгаараа паркуудын хувьд зайлшгүй тодорхой хугацаанд тусгай хэрэгцээнд авч дэмжих шаардлагатай. Ингэснээр мэргэжлийн ажилчид нэг дороо цуглах, хамтарч ажиллах нөхцөл бүрдэж байгаа учраас энэ нөгөө соёлын бүтээлч үйлдвэрлэлийн цогцолборыг байгуулах, түүнтэй холбоотой газруудыг тусгай хэрэгцээнд авах нь чухал байна гэдэг агуулгаар энэ заалтыг оруулж, хуулийн төсөлд оруулж ирсэн байгаа.

Харин юуны хувьд гэх юм бол. Дараагийн асуулт нь болохоор Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль дээр болохоор энэ соёлын бүтээлч үйлдвэрлэгчид нэн шаардлагатай буюу анхны хөрөнгө оруулалт, санхүүжилтийг босгох зорилгоор барьцаа байршуулсан тохиолдолд бусад баталгаажсан барьцаанаас давуу эрхтэй байна гэдэг байдлаар шууд заагаад давуу эрх бай байх юм шүү гэдэг байдлаар барьцааны эрх дээр нь барьцаалан барих эрх бүхий этгээдийн давуу эрх гэдэг байдлаар зааж өгсөн. Ойлгомжгүй, тодорхой зүйл байвал бас найруулгыг нь өөрчлөх боломжтой гэж үзэж байна.

Л.Мөнхбаатар: Соёлын сайд Номин нэмж хариулъя. Түүний дараа Мөнх-Оргил гишүүн тодруулж асууж болно.

Ч.Номин: Мөнх-Оргил гишүүний нэг асуулт буюу тэр татвар ноогдох орлогоос хасах асуудал дээр ярилаа. Би тантай 100 хувь санал нэг байгаа. Энийг ингэж дүн заах шаардлагатай гэж бодохгүй байгаа. Хэдий тийм боловч бид нарын оруулсан санал бол ер нь, ер нь бол энэ соёлын салбарт мэдээж төсвөөс ноогдож байгаа санхүүжилтээс гадна бид нар бусад хөрөнгө оруулалтуудыг бий болгож, аж ахуйн нэгжээр дамжуулан нэмэлт санхүүжилтийг бий болгох ёстой гэдэг зохицуулалтын хүрээнд энийг бид нар санал болгож оруулж ирсэн. Бид нарын санал бол татвар ноогдох орлогынх нь 5 хүртэлх хувийг гэдэг ийм санал

байсан боловч бусад хууль тогтоомжтой нийцүүлж байгаа гэдэг нөхцөлөөр Сангийн яамнаас энэ заавал дүн тавьж орж ирэх ёстой гэдэг ийм зохицуулалт орж ирсэн байгаа.

Л.Мөнхбаатар: Цэндийн Мөнх-Оргил гишүүн тодруулж асууя.

Ц.Мөнх-Оргил: Номин сайдаа, ажлын хэсгийнхэн асуулт ойлгогдохгүй байгаад байгаа бол, эсвэл зөрүүлж хариулаад байх юм. Би тэр 15-18 насны хүүхдүүд үнэ төлбөргүй юм үзэхийг чинь эсэргүүцээгүй шүү дээ. Эрхийн бичиг өгч яах гээд байгаа юм бэ л гэж асуугаад байна шүү дээ. Зүгээр л тэд нар үнэгүй иргэний үнэмлэхээ үзүүлдэг юм уу, эсвэл сурагчийнхаа үнэмлэхийг үзүүлээд л, оюутныхаа үнэмлэхийг үзүүлээд л 18 нас хүрээгүй нь тодорхой бол тэгээд л шууд орчиход л хамаагүй зардал багатай шүү дээ л гэж хэлээд байгаа байхгүй юу нэгдүгээрт.

Хоёрдугаарт тэр музейд хүүхдүүд үнэгүй орж байгааг чинь бид нар мэдэж байгаа шүү дээ. Бид нар чинь хуулийг нь баталсан юм чинь. Хуулийг нь санаачлаад, хуулийг нь танай яам байгуулагдахаас өмнө хуулийг нь санаачлаад хуулийг нь баталчихсан юм шүү дээ.

Тэр тусгай хэрэгцээний газар дээр хэрэгтэй гэж бодоод л хийчихсэн юм гээд байх юм. Миний асуулт чинь яг нийтийн эрх ашигт.../минут дуусав./

Л.Мөнхбаатар: Энэ Мөнх-Оргил гишүүний хувьд таван тодорхой асуулт тавиад байгаа юм. Тэгэхээр ер нь бол манай ажлын хэсэг, яамны төлөөллүүд асуултад хариулахдаа тухайн тавьж байгаа асуултуудыг тэмдэглэж аваад тав бол яг дарааллаар нь их цэгцтэйгээр ингэж хариулж баймаар байна. Тэгэхгүй бол энд тэндээс нь хариулаад явчихдаг. Энэ чинь өөрөө Улсын Их Хурлын үйл ажиллагаа, бүх протокол нь бас үлдэж байдаг. Ийм учраас хэн хариулж байгаа, хэддүгээр

асуултад хариулж байгаагаа их тодорхой ойлгомоор байна.

Дэгээрээ таны тодруулах хугацаа болчихсон байна. Асуултад хариулчихъя. Тодруулаад хариулчихъя. Хэн хариулах вэ. Соёлын сайд Номин хариулъя.

Ч.Номин: Мөнх-Оргил гишүүний тодруулгад хариулъя. Би таны санал дээр бас тэр Газрын тухай хууль, Барьцаа хөрөнгийн тухай хууль дээрх асуудлыг бид бас хүлээж авч ажлын хэсэг дээр ярилцах нь зүйтэй болов уу гэж бодож байна. Таны санал бол зөв байна. Бид нар ойлгож авлаа.

Харин 18 нас хүртэлх хүүхдүүдийг яагаад шууд үнэгүй оруулж болохгүй байгаа гэдэг дээр бид нарын хувьд бол энэ бас соёлыг ирээдүйд хүртэж сурахын тулд соёлыг үнэлж сурдаг, үнэлэх хүрээндээ төлбөр төлж сурдаг ийм тогтолцоо бий болох ёстой болов уу гэж харж байгаа.

Цаашлаад нөгөө талдаа энэ нь нөгөө бүтээгдэхүүн үйлчилгээг нэмэгдүүлнэ гэж харж байгаа. Яагаад гэхээр нөгөө талдаа энэ чинь ганцхан төрийн үйлчилгээний байгууллагуудаас гадна соёлын бүтээлч үйлдвэрт үйл ажиллагаа явуулж байгаа нөгөө 11 мянган аж ахуйн нэгж буюу 33 мянган чөлөөт уран бүтээлчдээсээ бас иргэд маань бүтээл туурвилыг хүлээж авдаг, мөн хүртдэг боломжтой болгох гэж энэ тогтолцоо нь орж ирээд байгаа.

Түүнээс биш яг соёлын төрийн ийн байгууллагуудын хувьд бол бид нар үнэгүй үзүүлээд явах боломжтой.

Л.Мөнхбаатар: Монгол Улсын сайд Жамьянхорлоогийн Сүхбаатар асуултаа асууя.

Ж.Сүхбаатар: Би гишүүнийхээ хувиар үг хэлнэ.

Тэгэхээр энэ хууль бол бас их тийм бид нарын шинэ цагийн, шинэ өнгө төрхийг илтгэсэн хууль л даа. Соёлын

бүтээлч үйлдвэрлэл гээд хэвшээгүй л байж байна шүү дээ. Би жишээлбэл одоо энэ үгийг хэлж хэвшээгүй л ингээд байж байгаа. Соёлын бүтээлч үйлдвэрлэл гэж юу юм бэ. Зарим нь ч хэлээд байх шиг бүтээлч болсон юм байна уу, үгүй юу гэж.

Тэгэхээр гол нь юундаа бүтээлч байгаа юм бэ гэхээр энд түрүүн сайд бол бас зөв л яг юугаа хэлсэн байгаа юм. Энэ Монголын соёлын асуудлыг бол тэр дэлхийн бас олон улсын түвшинд нь гаргаж тавих, мөн орчин үед бол өөрөө энэ дэлхийн зах зээл дээр бас энэ улс орноо сурталчлахаас гадна ер нь нэлээн томоохон ийм бизнесийн салбар болж хөгжиж байгаа гэдэг агуулга байж байгаа. Үндэсний identity гэж ярих юм бол үндэсний соёл нь өөрөө тэрний гол бүрэлдэхүүн хэсэг болж байна л даа. Бахархал гээд. Тэгээд яах вэ ингээд харахаараа бүүр даруухан л сонсогдож байна Номин сайд 130-аад сая долларын хэмжээний ингээд бүтээгдэхүүний хэмжээ байж байна. Гэхдээ 11697 аж ахуйн нэгж байгууллага байна. 5665 нь идэвхтэй байна гэж.

Тэгээд би юунд акцент өгөх гээд байгаа юм бэ гэхээр энэ хууль маань гарах хэрэгтэй. Энэ соёлын бүтээлч үйлдвэрлэлийн дэд бүтэц, парк цогцолбор, Жамьянхорлоогийн гэсэн юмнууд байгаа юм. Энэ маш чухал. Би мөрөөдөж байгаа юмыг манай соёлынхон бол ойлгож байгаа тийм ээ. Үндэсний соёл, мэргэжлийн урлагаа би дэмжих ёстой. Сая Чингис хааны музейг Ерөнхийлөгч маань Ерөнхий сайд байхдаа эхлүүлээд сайхан юм хийчихсэн. Одоо гаднынхан зөвлөж байна шүү дээ. Аялал жуулчлал, Welcome to Mongolia-г үзэх газар нь энэ гэж.

Нөгөө талаар динозавруудын ертөнц гэж бидэнд том ийм чиглэл байж болж байгаа. Энэ паркад ороход цогцолбор уу, кластер гээд аль нэгийг нь Өмнөговь аймагт жишээлбэл байгуулж болохоор. Тэгээд тэнд нь тэр нөгөө Холливудын гэдэг шиг дэлхийн юм хумыг хийдэг эсвэл

бид нарыг нөгөө жуулчдаа авдаг. Өвөр Монголд чинь маш олон сая жуулчин ирээд л Монголын үндэсний соёлыг чинь тэнд үзүүлээд байгаа байхгүй юу.

Тэгэхээр жишээлбэл манай Дундговь аймаг байж байна. Монгол дууны соёлыг тэнд парк байх юм уу, цогцолбор байх юм уу. Тэгэхээр энэ хуулийг гаргаснаар та хэд энэ хараа дэд бүтэц, парк цогцолбор, кластер гэсэн асуудлууд байгаа байхгүй юу. Эд нар маань яг явж байж сая соёлын, үндэсний соёлын асуудлууд бизнесийн агуулгуудаар бидний бодитой юм. Мэдээж хэрэг наана нь тэр музей тэр бусад юу гэдэг юм урлагийн бүтээлүүд, үйлдвэрлэлийн асуудлууд ярьж байгаа ч гэсэн Монголыг илүү томоор, тодоор харуулья, аялал жуулчлалаа цаашаа хөгжүүлэе, эдийн засгийг олон тулгууртай болгоё гэж байгаа бол бидэнд юу хэрэгтэй байна вэ гэхээр дэд бүтэц. Тэр тусмаа тэр парк, цогцолбор, кластер гээд.

Тэгэхээр танай яаман дээр сая миний хэлдэг энэ санаа шиг мэдээж олон сайхан сонирхолтой санаанууд байдаг. Гэхдээ Монгол Улсын ерөнхий сайд бас л янз бүрийн зүйлүүд дээр их амбицтай саналуудыг бол ярьдаг шүү дээ. Тэгэхээр энэ дээр бас энэ хууль дээр харахад бол хууль гарснаар, паркаар, цогцолбороор, кластераар, бүсээр, дэд бүтцийн чиглэлүүд дээр юм хийх асуудлууд байж байна. Тэгэхээр энд маш их ирээдүй байж болно.

Ялангуяа бид олон юмтай харьцуулаад байхгүй ядаж хажууд байгаа Өвөр Монголд байгаа Монголынхоо соёлыг сурталчилж байгаа юмнаас дутахгүй тэр давж гарахад амбицтай тийм байх ёстой шүү дээ манай улс чинь бие даасан улс учраас.

Тэгэхээр тэдэнтэйгээ өрсөлдөх, тэдний юмыг харьцуулсан, тэднээс дутахгүй яаж хөрөнгө оруулалт татах вэ, хэнтэй хамтарч ажиллах вэ, тэгээд жишээлбэл Өмнөговь, Дундговь аймгууд

дээр жишээлбэл тийм юм байгаа. Тэгэхээр би Соёлын яам чинь анхны динозавраар эхлээд тэгээд чимээгүй болчихсон шүү дээ ер нь бол. Тэр шиг жишээлбэл динозавруудын ертөнц гээд л жишээлбэл Өмнөговьд байхад тэнд бүтэц, кластер, цогцолбор, парк байлаа гэж бодоход тэнд эртний рок гэдэг юм уу, ардын рокийн гэдэг ч юм уу том рок наадам нь тэнд болж жишээлбэл болж болох байхгүй юу. Кино, элдэв юмнууд гээд. Ингээд мөрөөдөх ёстой л юм байна лээ.

Соёлын бүтээлч үйлдвэрлэл гэдэг бол Эйнштейний хэлдгээр эрдэм мэдлэгээс мөрөөдөл илүү чухал гэдэг шиг. Жоохон мөрөөдөлтэй, дэвшилтэй тийм тэмүүлэлтэй салбар юм шиг байгаа юм. Тэгэхээр энэ чиг.../минут дуусав./

Л.Мөнхбаатар: Сүхбаатар гишүүний асуултад хариулья. Соёлын сайд Номин 85 дугаар микрофоныг өгье.

Ч.Номин: Сүхбаатар гишүүний асуултад хариулья. Та яг бодитоор хуулийн маань голыг олоод харсан байна. Ер нь бол Монгол Улсын хэмжээнд түрүүний хэлсэн энэ 11 мянган аж ахуйн нэгж маань ерөнхийдөө жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид байдаг учраас эдгээр хүмүүст томоохон бүтээн байгуулалтын бүтцүүдийг бий болгож өгч байж үйлдвэрлэл үйлчилгээ маань нэмэгдэнэ гэдэг зорилгоор энэ орж ирж байгаа.

Ер нь бол бид нар соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэхдээ орон нутгийн онцлогт суурилсан соёлын өв дээр нь суурилсан соёлын аялал жуулчлалыг хөгжүүлнэ гэсэн бодлогыг тодорхойлж гаргаж ирж байгаа. Яг таны хэлсэн үнэн. Палеонтологийн олдвор дээрээ илүү суурилсан буюу Өмнөговь, Дундговь гэдэг газрууд дээр бид нар сайт музейнүүд буюу орчинд нь очиж нөхцөл байдалтай танилцдаг ийм музейнүүдийн суурийг бий болгох ажлуудыг хийгдэж байгаа. Одоо хамгийн том хийгдэж байгаа зүйл бол Байгалийн түүхийн музей маань тун

удахгүй барилгын ажил нь эхлэх гэж байна.

Үүнээс гадна бид нар эдгээр музей, номын сангуудаа шаардлагатай дотоод үзмэрүүдийг бий болгох ёстой гэж харж байгаа. Энэ ч утгаараа бид нар яг өнөөдрийн байдлаар Америк Улсад Монгол Улсын хилийг хууль бусаар даван гарсан 3.6 сая долларын үнэ өртөг бүхий томоохон палеонтологийн олдворуудыг Монгол Улсдаа буцаан татан төвлөрүүлэх ажлыг хийж байна. Энэ намартаа багтан орж ирнэ. Энэ мэтчилэн бид нар бас соёлын өв дээрээ суурилсан соёлын орон зайнуудыг бид нар орон нутаг болгонд нь хөгжүүлж, тухайн орон нутгийн онцлогт таарсан бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгоно гэж харж байгаа.

Үүний энэ бас нэг том жишээ бол бид нар Монгол Улс язгуур соёл, нүүдлийн соёл гэдэг. Тэгэхээр энэ нүүдлийн соёлын томоохон фестивалийг бас хийж эхэлсэн. Энэ жил Монгол Улсад олон улсын хэмжээтэй болоод, нүүдлийн соёл иргэншилтэй арваад улсын төлөөллүүд ирж оролцохоор ажил хийгдэж байгаа. Тэр утгаараа бид нар яг өөрийнхөө соёлын онцлог, ижилсэлд суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээнүүдийг энэ соёлын бүтээлч үйлдвэрлэлийн хуулиар дамжуулан бий болгоно гэж харж байгаа.

Энэ хуулийн бас нөгөө тал нь юу вэ гэхээр дандаа төрийн санхүүжилтээр биш бусад эх үүсвэрүүдээс энэ соёлын салбарыг хөгжүүлэх буюу хувийн хэвшлийг илүү татан төвлөрүүлж оруулж ирэх суурийг бий болгох зохицуулалттай байгаа.

Жамъянхорлоогийн Сүхбаатар гишүүн тодруулж асууя.

Ж.Сүхбаатар: Би энэ хуулийн зүгээр хувийн хэрэгт холбогдуулаад бас иргэд ч гэсэн харж байгаа учраас бас хандаад хэлэх юм нь бол ер нь бас Номин сайдаа бол бидний гол юм та нарын явж

байгаа ч гэсэн энэ соёлын яам гэдэг юу юм бэ гэхээр энэ хуулийг гаргасан ч гэсэн Монгол түмний голомт нь манай нутаг дэвсгэр байгаа. Монголчууд бол бид нарын 3 сая 500 мянга энд байгаа хүмүүсээр хэмжигдэхгүй байгаа. Тэгэхээр бидний гол юм бол соёлын орон зайны төлөө тэмцэл гэж таны хэлдэг үнэн. Соёлын орон зай. Тэгэхээр Монголчуудын гал голомт нь үндэсний соёлоо, бид тодруулж хэлэх юм бол аль нэг улсын эсрэг биш, хажууд байгаа хөрш зэргэлдээ Өвөр Монголоосоо илүү их үндэсний соёл, мэргэжлийн урлагийн талаасаа давуу байдлыг өөрийнхөө бааз энэ Монгол түмний гол гал голомт болсон нутаг дээрээ явуулах нь бидний бас гол эцсийн зорилго байх ёстой. Соёлын яам тийм учраас би оршин тогтнох ёстой гэсэн энэ байр суурийг дэмждэг юм гэдгийг бас хэлмээр байгаа юм.

Л.Мөнхбаатар: Сүхбаатар гишүүн дэмжиж үг хэллээ. Одоо Байнгын хорооны дарга Гомпилдоогийн Мөнхцэцэг асуултаа асууя.

Г.Мөнхцэцэг: Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн дэмжих тухай хууль орж ирж байна. Энэ хууль маань бас Байнгын хороогоороо цаашид хэлэлцэгдээд, мөн дээр нь ажлын хэсэг гараад ингээд цаашаа явна.

Тэгээд энэ гишүүдийн асуугаад байгаа ер нь бид нар бас энэ яг үнэндээ соёлын үйлдвэрлэлийг эрхлэгч гэж хэнийг хэлээд байгаа юм бэ. Энэ тодорхойлолтоо бас зөв гаргаж ирэх ёстой байх. Ер нь соёлын үйлдвэрт эрхэлж байгаа энэ зүйлүүдэд бид нар санхүүгийн ямар дэмжлэг үзүүлэх юм бэ, татвараас яаж чөлөөлөгдөх юм бэ гээд ингээд энэ зохицуулалтуудыг хэрхэн тусгаж байгааг бид нар бас анхаарч ажиллах бас шаардлагатай байгаад байгаа.

Ялангуяа тэр соёлын эрхийн бичиг гэдэг зүйлийг хугацаан дээр нь, насан дээр нь бас яаж ингэж тавьж хэрэгжүүлэх юм. Энэ дээр бид нар бас анхаарч ажиллах

шаардлагатай байна гэдгийг бас энэ гишүүдийн ярьж байгаатай бас санал нэг байгаад байгаа юм. Энэ дээр бид нар бас цаашид авч явахдаа энэ зүйл, заалтууд дээр бас ингээд анхаарч ажиллах ёстой гэж ингэж харагдаж байна.

Тэгэхээр энэ Оюуны өмч, Зохиогчийн эрхийн тухай хуулиудтайгаа ер нь давхардал хийдэл нь бас нэлээд байгаад байгаа юм шиг. Ингээд харагдаад байгаа энэнтэй яаж уялдуулж байгаа вэ. Энэ дээр манай Соёлын яам бас тайлбар хэлэх нь зүйтэй байх гэж бодож байгаа.

Мөн л бас энэ соёлын бүтээлч үйлдвэрлэл дотор орж ирж байгаа бас нэг зүйл, заалт ялт ч үгүй энэ соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих үндэсний зөвлөл байгуулна гэж байгаа. Энэ зөвлөлөө ер нь бас яаж байгуулахаар Соёлын яам бодлого болгож байгааг оруулж ирж байгаа юм бэ. Энэ 2 зүйл дээр миний асуулт байна. Бусад нь бол гишүүдийн хэлж байгаатай санал нэг байгаад байгаа учраас цаашид бид нар хуулийнхаа энэ хэлэлцүүлгүүд дээр анхаарах, томьёоллоо бас харах ингээд ийм зүйлүүд бас байгаа гэдгийг бас хэлье. Тэгээд энэ 2 зүйл дээр хариулт, тайлбар авъя.

Л.Мөнхбаатар: Байнгын хорооны дарга Гомпилдоогийн Мөнхцэцэгийн асуултад хариулья. Соёлын сайд Номин хариулья.

Ч.Номин: Мөнхцэцэг гишүүний асуултад хариулья. Тавьсан саналууд анхаарах шаардлагатай зүйлүүдийг ойлголоо. Тэгээд ажлын хэсэг дээр бид бас тантай хамтраад, ойлголтоо нэгтгээд явъя гэж бодож байна.

Ер нь Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн хуулийг бий болгохдоо бид нар энэ хууль бол дан соёлын яам өөрөө үүсгэн гаргаж ирсэн хууль биш. Энэ яг салбарын уран бүтээлчид бүтээн туурвигчидтай хамтран хийсэн 4000 гаруй хүмүүсийн оролцоон дээр суурилж бий болгож гаргаж ирсэн ийм хууль байгаа.

Ингэхдээ бид нар түрүүн хэлсэнчлэн соёлын бүтээлч үйлдвэрлэлийнхээ эко системийг бүрэн хэмжээнд судлаад, ингээд бүтээн туурвих, үйлдвэрлэх, түгээх, хэрэглээг бий болгох энэ үйл явцыг буюу энэ валю чэйн /value chain/ гэж нэрлэдэг гинжин хэлхээн дээрээ хэрхэн дэмжлэгүүдийг зөв зохистой өгснөөр энэ салбар бойжиж явах вэ гэдэг тогтолцоог харж хийсэн.

Оюуны өмчийн асуудал дээр дахиад хариульга. Энэ дээр юу байгаа вэ гэхээр Оюуны өмчийн тухай хууль бол Монгол Улсад оюуны өмчийг хэрхэн бүртгэх вэ, хүний оюуныг бүтээлээс гарсан бүтээлийг хэрхэн бүртгэх вэ гэдгийг тодорхойлдог.

Зохиогчийн эрхийн тухай хууль бол энэхүү бүртгэгдсэн бүтээл нь хэрхэн хэрэглээнд орох вэ тээ мэрчиндайз болох юм уу, яаж хуулбарлах юм, хэрхэн нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн болгоход бүртгүүлэх юм гэдэг талаас нь хардаг.

Тэгвэл Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн хууль бол энэхүү хоёроос гарч ирсэн энэ оюуны өмчид бүртгэгдсэн хэрэглээнд ороход бэлэн болсон бүтээлийг хэрхэн эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлж, эдийн засгийн эргэлтэд оруулах вэ гэдгийг тодорхойлж байгаа учраас энэ гурван хуулийн нэгдлээрээ ингээд зохицуулж бүтээлч үйлдвэрлэлд үйл ажиллагаа явуулж байгаа бүтээн туурвигч нарын маань бүтээл эдийн засагт, эргэлтэд орох энэ тогтолцоог бий болгож байгаа гэж харж байгаа.

Үндэсний зөвлөлийн хувьд бол Засгийн газраас байгуулахаар байгаа. Энэ Үндэсний зөвлөлийн гол зүйл нь юу вэ гэхээр манай соёлын бүтээл үйлдвэрлэлд 12 салбар, 93 чиглэл байгаа учраас энэ бүгдийн уялдаа холбоог хангаж ажиллах нэгдсэн зохион байгуулалтад оруулахад оролцоотойгоор ажиллахаар хийгдэж байгаа.

Л.Мөнхбаатар: Асуултад бас тодорхой хариулчих шиг боллоо. Бусад зүйлүүдийн талаар, одоо бол хэлэлцэх эсэх асуудлыг ярьж байгаа. Хэлэлцэх асуудлыг хэлэлцэхээр шийдсэн тохиолдолд ажлын хэсэг байгуулагдана. Тэр үедээ бусад асуудлуудыг анхаараад явж болохоор юм байна гэж үзэж байна.

Одоо эрхэм гишүүн Борхүүгийн Дэлгэрсайхан асуултаа асууя.

Б.Дэлгэрсайхан: Энэ хуулийг дэмжиж байна. Ер нь бол цаашдаа ч гэсэн бас энэ соёл, өв соёлоо бас энэ боловсролтойгоо бас жоохон уяж, хойч үедээ бас энэ чинь бид нар чинь ийм соёл, өв соёлтой гэдгээ энэ боловсролынхоо хуульд оруулах тийм арга хэмжээ Соёлын яамнаас авч байгаа юу. Ер нь бол бид нар чинь юутай байгаагаа өөрсдөө мэддэггүй л улсууд юм билээ шүү дээ. Юу сургуулийн хүүхэд байтугай том болсон нь мэдэхгүй байгаа шүү дээ. Жишээлбэл энэ жил Дорноговьд 5 дугаар ноён хутагтын 220 жилийн ой болно. Тэгээд энэ танай яамнаас гаргасан тэр тушаалыг үзлээ. Дэмжсэн, тэгээд яахлаараа 3 аймаг хамарч хийнэ гээд тушаал гардаг юм. Энэ чинь хаа байсан Дундговь ер нь энд ямар хамаатай юм. Нэг.

Хоёрдож тийм тушаал гаргаж байгаа бол энэ догшин Ноён хутагтын энэ хүн чинь Монголын хүн шүү дээ. ЮНЕСКО-д бүртгэлтэй. Тэгээд энэ Монголын хүнийг чинь Монгол даяар нь сурталчлах ийм арга хэмжээг Соёлын яам өөрөө зохион байгуулах үүрэгтэй юм байгаа биз дээ. Хөөе сонсож байна уу, үгүй юү. Тийм учраас та нар энэ тушаал, шийдвэрээ эргэж хараарай. Цаашдаа ч гэсэн энэ хүнийг, том хүнийг сурталчлах, тэр уран бүтээлийг нь сурталчлах ийм арга хэмжээг хийх гэж байгаа бол Монгол Улс даяар энэ орон нутаг, орон нутгийн засаг захиргаатай нь хамтарч, тэгээд тэр орон нутагт байгаа соёлын газраараа дамжуулж ийм дэмжлэг, туслалцаа үзүүлэх энэ асуудал дээр яам яаж анхаарах юм. Би өмнө болсон юмыг хэлье жишээлбэл. Уг

нь танай яам байхгүй байхад Байгаль орчны яаманд харьяалагддаг байсан юм шиг байгаа юм. Тэгээд тэр үед Цэрэнбат сайд байсан. Тэгээд очоод танай аймаг, орон нутгийн энэ сүм хийд, Хамрын хийдийг дэмжиж байна гээд 200 сая төгрөг өгсөн, 1 жижигхэн усны машин ламд бэлэглээд тэгээд үлдсэн мөнгө нь алга болсон. Иймэрхүү маягаар сүм хийд чинь олон нийтийн өмч болохоос биш, 1 хүний өмч хөрөнгө биш шүү дээ энэ чинь. Монгол Улс хуульдаа тийм биз дээ. Нийтийн өмч шүү дээ.

Тийм учраас та нар энийгээ энэ хүрээндээ тэр хөрөнгө оруулалт энэ улсын хөрөнгө мөнгийг зүгээр ингээд хэдэн лам нар аваад идэж уучихдаг ийм нөхцөл байдлыг нь жоохон өөрчлөх ёстой юм биш үү. Аймаг, орон нутаг тэр хог шороо бүх субботникийг нь хийдэг, энэ аялал жуулчлалыг аль болохоор татахын тулд тэр орон нутгийнх нь газарт аялал жуулчлалын бааз байгуулах гээд зөндөө арга хэмжээ авах гэхлээр Байгаль орчны яам нь тусгай хэрэгцээнд авна гээд элийрээд юм яриад байдаг. Тэгээд энэ Байгаль орчны сайдаа дагуулж орж ирээрэй дараа нь энэ хууль хэлэлцэхэд. Ярихлаар их олон юм ярьдаг. Бүх газрыг л тусгай хэрэгцээнд авна гээд л яриад байдаг. Тийм бол тэгээд энэ газар чинь хэн, юу хийх юм. Аялал жуулчлал хөгжүүлнэ гэж яриад байдаг тийм учраас энийгээ орон нутагтай нь хамтарч хийнэ шүү нөхөд.

Тэгэхлээр зэрэг би яагаад энэ Соёлын яамнаас энэ юу асуугаад байгаа юм гэхлээр та нар энэ Монгол Улсын хэмжээнд энэ том хүнийг ЮНЕСКО-д бүртгэлтэй энэ хутагтыг яаж Монгол Улсын хэмжээнд сурталчлах арга хэмжээ авах юм. Энэ ойноос нь өмнө. Энэ дээр ямар төсөв, хөрөнгө мөнгө байгаа юм, аймаг орон нутагтай нийлж яаж хийх юм. Энийгээ сайн та нар тодорхой болго. Бид ингээд аймаг орон нутагтаа зөндөө л олон арга хэмжээ зохион байгуулаад байдаг ямар ч дэмжлэг байхгүй.

Тийм учраас энэ дээр бас онцгой анхаарч өгөөрэй гэдгийг хэлье. Тэгээд дараа нь энэ соёлын тухай энэ бас та нарын оруулж ирж байгаа хуулийг дэмжинэ. Тэр ялангуяа энэ бүтээлийг бас оюуны өмчийг бүртгэлтэй болгох.../минут дуусав./

Л.Мөнхбаатар: Дэлгэрсайхан гишүүний асуултад хариулъя. Соёлын сайд Номин хариулъя. Ажлын хэсэг нэмж хариулж болно.

Ч.Номин: Дэлгэрсайхан гишүүний асуултад хариулъя. Бидний хувьд 5 дугаар ноён хутагт Данзанравжаагийн 220 жилийг тэмдэглэн өнгөрүүлэх тогтоолын төслийг оруулахдаа гол суурь нь энэхүү хүн маань Соён гэгээрүүлэгч, театр урлагийг үүсгэн байгуулагч талаасаа илүү судлалыг нь хөгжүүлэх Данзан Равжаагийн судлалыг хөгжүүлэх талаасаа оруулж ирсэн. Тэгэхээр энэ агуулгаараа бид нар цаашид энэхүү хүний энэ ойг тэмдэглэн өнгөрүүлэхдээ ажлын хэсгийнхээ хүрээнд соёл урлагийн газруудаараа дамжуулан хэрэгжүүлнэ гэдгээ бас танд хэлье гэж бодож байна.

Таны асуусан энэ соён гэгээрлийн ажлыг хэрхэн хийж байгаа тал дээр бид нар бүх нийтийн соёлын боловсролын хөтөлбөр хэрэгжүүлээд явж байгаа. Энэ бол Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Боловсролын яам, Цахим хөгжлийн яам болон Соёлын сайдын хамтарсан тушаалын хүрээнд хийгдэж байгаа. Энэ хүрээнд албан болон алба орон бус боловсролоор дамжуулан бүх нийтийн соёлын боловсролыг дэмжих, дээшлүүлэх ажлууд хийгдээд явж байгаа. Даваацэрэн дарга илүү дэлгэрэнгүй өв талаасаа нэмээд хариулчихъя.

Л.Мөнхбаатар: Нэмж хариулъя. 84 дүгээр микрофоныг өгье. Даваацэрэн хариулъя. 84 үү. Тийм байна.

Б.Даваацэрэн: Соёлын яамны Соёлын, өвийн бодлогын хэрэгжилтийг

зохицуулах газрын дарга Даваацэрэн. Данзанравжаагийн ойг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбоотой нэмэлт мэдээлэл өгье. Энэ ойг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбоотой асуудлаар Өмнөговь аймаг, Дундговь аймаг, Дорноговь аймаг, Говьсүмбэр аймгуудаас тодорхой арга хэмжээг зохион байгуулах саналууд ирсэн. Энэ саналуудыг нэгдсэн зохион байгуулалтад оруулаад яаман дээр ажлын хэсэг зохион байгуулагдаад тус тус аймгуудын төлөөллийг оруулсан. Жишээлбэл Өмнөговь аймаг дээр бол хийдийг сэргээн засварлахтай, тохижуулахтай холбоотой ийм ажлыг хийх санал ирсэн.

Мөн Дундговь аймгийн Адаацаг сумд байдаг Сүм хөх бүрдэд бас энэ уран бүтээл зохион байгуулах ийм саналууд ирсэн юм байгаа юм. Энэ саналууд дээр үндэслээд оролцоог нь хангах үүднээс ажлын хэсэгт тэдгээр аймгийн төлөөллүүдийг оруулсан байгаа.

Энэ үйл ажиллагааг зохион байгуулахад Шинжлэх ухааны академиас мөн санал, дүгнэлт гаргуулж авсан байгаа.

Л.Мөнхбаатар: Дэлгэрсайхан гишүүн тодруулж асууя. Дэлгэрсайхан гишүүний микрофоныг өгөөрэй. Тодруулга 1 минут.

Б.Дэлгэрсайхан: Яах вэ энд тэндхийн юм хамж шимээд тушаал гарсан л юм байна лээ. Ер нь энэ чинь Монголын хүн бид одоо энэ ойтой холбогдуулаад энэ том жүжиг, аймгийн театрын жүжигчид энэ нартайгаа нийлээд хийж байгаа. Энэ хэдэн морь уралдаад наадам хийх нэг асуудал.

Дараа нь энэ Улаанбаатарт ирээд тэр хийсэн жүжгийг нь энэ хотод тоглож барихад нь та нар тэр янз бүрийн Драммын театрт нь хэлж энэ жүжгийнх нь зохиолыг тавих барихад нь туслан дэмжиж хэлж өгөөрэй. Тэгэхгүй тэгээд өмчлөөд авчихсан юм шиг баахан мөнгө нэхээд л, тэгээд л тэр уран бүтээлчдийг дарамтлаад

л, аймаг орон нутгаас баахан мөнгө нэхээд л дааж давахгүй ийм юм байж болохгүй шүү дээ. Соёлын энэ ер нь цаашдаа энэ та нар энэ өнөө бид нар яриад байдаг шүү дээ. Өнөө алтан тайз гээд л их л гоё ярьдаг тэрийгээ чөлөөтэй болгох хэрэгтэй шүү дээ. Энэ чөлөөт уран бүтээл хийж байгаа улсууд энэ тэрдээ. Одоо наадах энэ.../минут дуусав./

Л.Мөнхбаатар: Тодруулаад хариулах юм уу. Соёлын сайд Номин хариулья.

Ч.Номин: Энэхүү Данзанравжаатай холбоотой асуудлыг ажлын хэсгийн дүгнэлтээр дээр суурилж шийдвэрүүд нь гарагдаад явна. Би бас өмнө нь хэлсэн бид нар аймаг орон нутгийнхаа өөрсдийн тогтолцоондоо байгаа соёл үйлдвэрлэлийн газраараа дамжуулж арга хэмжээ үйл ажиллагааг хийгээд явна. Тэгээд энэхүү асуудалтай холбогдолтой бус байгаа учраас би танд ажлын шугамаар хариулт өгье гэж бодож байна.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Бадарчийн Жаргалмаа асуултаа асууя.

Б.Жаргалмаа: Та бүхнийхээ өглөөний амгаланг айлтгая. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төслийг мэдээж дэмжиж байгаа. Түүрүүн ч бас гишүүд маань асууж байна. Би асуулт асуухаас өмнө хоёр үг тайлбарлачихъя гэж бодож байна. Үг тайлбар талаас харж байгаад соёл гэдэг бол хүн төрөлхтний бүтээсэн эд баялаг, оюун ухааны ололтын цогц юм. Урлаг үнэн байдлыг уран сайхны аргаар дүрслэн гаргасан бүтээл. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль дээр мэдээж ч урлаг, урлагийн байгууллагууд, тэдний төлөөллүүд, бүхий л салбарынхныг би бас дэмжих бодлого байгаа гэж ойлгож байгаа. Тэгэхлээр энэ дээр дандаа соёлын гэдэг нэр томъёоллоороо орсон учраас урлагийн байгууллагуудаа, мэргэжлийн урлагийн байгууллагуудаа хэрхэн, яаж дэмжих

талаар бас нэг зүйл асууя. Хэрхэн яаж оруулж байгаа вэ гэдэг дээр.

Хоёр дугаарт соёл юунаас эхлэх вэ гэж. Номин сайдаа би таныг бас яг сайдаар томилогдоод орж ирж байх ч хамгийн анхны асуултыг асууж байсан. Соёл гэдэг мэндлэхээс эхэлдэг байх. Хүн байх, бие хүн байх, хүн хүнээ хүндлэхээс эхэлдэг гэж би боддог юм. Тэр ч үүднээсээ яг энэ чиглэлээрээ бусад яамтайгаа ер нь Соёлын яам маань хэрхэн яаж хамтран ажиллаж байна вэ. Яагаад би ингэж асууж байна вэ гэвэл өнөөдөр Монгол Улсад зөөлөн хүчний бодлого гэдэг зүйл дутагдалтай байна. Дэлхий даяараа даяаршиж байгаа энэ цаг мөчид бид Монголоо авч үлдэх хамгийн гол зүйл бол эх хэл, соёл урлаг маань.

Гэтэл өнөөдөр дэлхий дэх Монголыг хэрхэн мэдэж байна вэ. “Ну” гэдэг хамтлаг гарч ирснээрээ бас Монголын рок поп урлаг энэ хэмжээнд очлоо гэдэг зүйлийг бид нар бас бахдан ярьж байсан. Тэгвэл яг энэ мэтээр өөрсдийн уран бүтээлээрээ дэлхийд танигдаж байгаа уран бүтээлчдийн, соёлын урлагийнхныгаа ер нь дэмжих бодлого ер нь ямар хэмжээнд байгаа юм. Зөвхөн уран бүтээлчид өөрсдийн сэтгэл зүрхээрээ гэхээсээ илүүтэйгээр Соёлын яамтай болсон юу билээ, бодлогын хэмжээнд уран бүтээлчдээ дэмжиж гадагш нь гаргаж байгаа зүйл юу байна. Кино урлагийг дэмжих тухай хууль батлагдсан. Энэ боломжоороо бид нар бас Монголын кино урлагийг дэлхийд гаргах тэр боломжийг нь нээж өгсөн гэж харж байгаа. Гадаад харилцааны яаман дээр Гадаад сурталчилгаа, соёл хариуцсан газар гэж байдаг. Тэр зөөлөн хүчний бодлого өөрсдөө аваад явдаг. Яг үүнтэй адилхан Боловсролын яам, Гадаад харилцааны яам, бусад яамтайгаа соёл урлагийг Монголын энэ гайхамшгаа мэдрүүлэх, Монголоо авч үлдэх тал дээр ер нь яам маань юу хийж чадаж байна вэ.

Хөдөө орон нутгаараа соёлын сэргэлтийг зохион байгуулсан бид мэдсэн.

Гэхдээ аймаг орон нутаг, сумын, соёлын төвүүдээ дэмжих тэр бодлого нь ямар хэмжээнд байгаа юм. Энэ зөвхөн соёл урлагийн тоглолт үзүүлээд байх юм биш. Аймаг сумд байгаа тэр соёлын төвийнхөн маань тэр аймаг, орон нутгийнхаа иргэдэд, хүүхэд залуучууд Монголын энэ соёл урлагийг таниулах, мэдрүүлэх энэ үйл ажиллагааг хэрхэн яаж хийж байна вэ. Би өмнө нь бас Байнгын хороон дээр уг нь зөөлөн хүчний бодлого дутагдаад байна гэдэг дээр жишээ аваад хэлсэн. Намайг буруутгаад л өнгөрсөн л. Тэгэхлээр энэ тал дээр ер нь зөөлөн хүчний бодлого би Монгол шүү гэдгээ бахдах тэр сэтгэгдлийг хэрхэн яаж төрүүлж яамнуудтайгаа хамтарч байна гэдэг зүйлийг асууя.

Гуравдугаарт улсын статустай Хүүхэд залуучуудын театр Сонгинохайрхан дүүргийн 5 дугаар хороонд босож байгаа. Гишүүн болсноосоо хойш ер нь энэ соёлын төвийг Хүүхэд залуучуудын театртэй болгоё гэдэг хүсэл эрмэлзлээр Засгийн газарт хүсэлт тавьснаараа Хүүхэд залуучуудын театр маань болсон боссон. Олон хүлээлт байгаа. Уран бүтээлчид ч хүлээж байгаа, манай тойргийнхон ч, Монгол Улс тэр даяараа залуучууд хүлээж байгаа.

Театрын зураг, төсөл дахин дахин солигдоод байгаа. Интерьерийн зураг солигдсон учраас ажлын гэрээ хийгдээгүй байна гэдэг ийм зүйл очсон. Бид нар байнга ажил дээр очиж шалгаж байгаа. Тэгэхлээр энэ ажлыг яаравчлуулах. 7 сарын 11-нд амждаггүй юм гэхэд 9 сарын 1-нд хүлээлгэн өгөх. Бид театраа нээмээр байна. Энэ ажил ер нь ямар шатад явж байна вэ гэдэг дээр та хариулт өгөхгүй юу. Эргээд асууя.

Л.Мөнхбаатар: Жаргалмаа гишүүний асуултад хариулъя. Ажлын хэсгийн 85 дугаар микрофон Соёлын сайд Номин хариулъя.

Ч.Номин: Жаргалмаа гишүүний асуултад хариулъя. Энэ Засгийн газрын

хувьд бол энэ яамд хоорондын уялдаа холбоог маш сайн хангаж ажиллах дээр илүү анхаарч байгаа. Энэ хүрээндээ Монгол Улсыг олон улсад сурталчлан таниулах энэ ажлын хүрээнд Гадаад харилцааны яам Соёлын яам хоёр нягт ажиллаж байгаа. Нэг цонхны бодлогоор явж байгаа. Энэ ч утгаараа соёлын аялал жуулчлал Монгол Улсыг олон улсад сурталчлан таниулах бүх ажлууд бол Соёлын яамнаас уялдаатайгаар буюу Соёлын яамны үндсэн бодлого дээр ороод явж байгаа. Энэ агуулгаараа манай Соёлын яаманд гадаад харилцааны хэлтэс маань өргөжиж, дотроо соёлоор дамжуулан Монгол Улсыг олон улсад сурталчлан таниулах чиг үүргийг нэмэгдүүлж оруулж ирж байгаа.

Таны хэлсэнчлэн Welcome to Mongolia гээд энэ хийгдэж байгаа аяны хүрээнд ч гэсэн Соёлын яам үндсэн өнгө төрхийг тодорхойлох, энэ хүрээнд гарах соёлын арга хэмжээнүүдийг тодорхойлох 69 арга хэмжээний өнгө төрхийг бүрэн болгох дэлхийд таниулах ажлуудыг мөн хийгдэж байгаа. Үүнд урьдчилсан календариудыг бас бид бий болгосон. Үүнтэй адилхан та “Hu” хамтлагийг ярилаа. Манай “Hu” хамтлаг соёл урлагийг дэмжих сангаар бас үүсгэн гарч ирж байсан хамтлагуудын нэг. Үүнтэй адилхан “Уухай” гээд хамтлаг бас мөн гарч ирж байна. Бид нарын хийж хэрэгжүүлж байгаа, таны санаачилсан Кино урлагийг дэмжих тухай хуулийн хүрээнд манай кино урлагийн салбарынхан бол Канны кино наадамд оролцож энэ хүрээндээ анх удаа Монголоос кино бас нэр дэвшсэн ийм амжилт гаргасан байна. Дүрслэх урлагийн салбарынхан маань цаашлаад энэ Венецийн биеннальд оролцдог болсон байна. Манай Морин хуурын чуулга Үндэсний урлагийн их театрууд бол дэлхий дахинаа аялан тоглолтуудыг хийж байна. Өнгөрсөн жил “Эн Эйч Кэй Холл”-д хийсэн. Тэгвэл энэ жил Сиднейн хамгийн том опера театрт хийхээр яригдаж байна. Мөн төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд

Лондонд манай Монголын жүжиг тавигдах гэж байна. Үүнээс гадна Монголын Чингис хааны өв соёлыг таниулах, Монгол Улсын дэлхийд оруулсан хувь нэмрийг таниулах үзэсгэлэн маань мөн энэ Францын Нанат улсад гарах гэж байна гэх мэтчилэн соёл урлаг хамгийн түрүүнд тухайн улсыг таниулдаг, тухайн улсыг сурталчилдаг зүйл учраас соёл урлагаар дамжуулан дэлхийд Монгол Улсыг сурталчлан таниулах ажлууд маш өргөн цар хүрээтэй хийгдэж байгаа.

Мөн үүнээс гадна энэ орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа хүмүүсээ хэрхэн дэмжиж байгаа вэ соёлын сэргэлтээс гадуур гэж байна. Яг өнөөдрийн байдлаар 7 сарын 1-нээс эхлэн соёлын салбарын нийт ажилтан албан хаагчдын цалин хөлс маань 61 хувиар нэмэгдэж байна. Мөн хүний нөөцөө чадавхжуулах ажлуудыг бид нар тогтмол хийж байгаа. Энэ соёлын сэргэлт бол зөвхөн урлаг, уран бүтээлийн тоглолтоос гадна тогтмол соён гэгээрүүлэх лекц хүүхэд залуучуудад зориулсан боловсролын хөтөлбөрүүдийг дагуулаад явж байгаа ийм цогц арга хэмжээ байгаа.

Мөн Соёлын яаман дээр бүх нийтийн соёлын боловсролын хөтөлбөр хэрэгжиж байгаа. Энэ хөтөлбөрийн хүрээнд таны яг хэлсэн мэндлэх, хүндлэх соёлыг хэрхэн залуучууддаа түгээх вэ гэх мэтчилэн кампанит ажлууд хийгдээд явж байгаа.

Хүүхэд залуучуудын театр дээр мөн тантай адилхан бид маш сайн анхаарал тавьж ажиллаж байгаа. Хүүхэд залуучуудын театрыг бид нар 9 сарын 1-нд үйл ажиллагааг нь оруулахаар ажиллаж байна. Интерьер зураг өөрчлөгдөөд байгаа зүйл байхгүй. Анхнаасаа интерьер зураггүй байсан учраас сайжруулалтыг хийж оруулж байгаа.

Л.Мөнхбаатар: Одоо Гочоогийн Ганболд гишүүн. Тодруулах юм уу та.

Бадарчийн Жаргалмаа гишүүн тодруулж асууя.

Б.Жаргалмаа: Би бас 14 хоногийн өмнө “Аглуут” компанийнхантай очиж уулзсан доторх интерьерийн зураг дахин шинэчлэгдсэн учраас ажлын гэрээ дахиж хийгдээгүй байна гэдэг зүйл ярьсан. Би Энх-Амгалан Төрийн нарийн бичгийн даргатай ярилцаад ажлын гэрээг зурж явуул гэдэг ийм чиглэл өгсөн шүү.

Ер нь бол соёлын бүтээлч үйлдвэрлэл гэдэг дээр би бас биет бус уран бүтээлчдийнхээ энэ соёл урлагийн салбарт ажиллаж байгаа бүхий л уран бүтээлчдийн сэтгэл зүрхээрээ ажилладаг энэ уран урлагийн салбарынхныг бас дэмжих бодлого гэж би харж байгаа. Тэгэхлээр яг энэ чиглэл дээр ер нь дэмжлэгийн асуудлыг Их Хурлын гишүүний хувиар дэмжээд явна гэдгээ хэлье. Тэгээд энийг сан бүрдүүлэх асуудал байгаа шүү дээ. Өөрөөр хэлэх юм бол соёлын бүтээлийн сан, мэдээллийн сан мэдээллийн сан мэдээллийн сан. Энэ мэдээллийн сангаар эргээд уран бүтээлчид тэр сэтгэл зүрхтэй улсууд өөрсдөө тодорхой хэмжээний боломжийг бий болгох тэр боломж нь ер нь хэр туссан бэ энэ хууль дээр. Би энэ хуулийн гол зорилго бол энэ гэж бодож байгаа. Өөрөөр хэлбэл тэр сэтгэлгээгээ үнэлэх тэр боломжийг энэ хуулиар нээж өгнө гэж харж байгаа шүү.

Л.Мөнхбаатар: Тодруулгад хариулъя. Соёлын сайд Номин хариулъя.

Ч.Номин: Жаргалмаа гишүүн яг энэ хуулийн бас гол санааг ойлгосон байна. Ер нь бол манай уран бүтээлчдээс гарч байгаа бүтээлүүд маань дандаа энэ хүмүүсийн оюун санаанаас бий болж байдаг. Нэг ёсондоо шууд үнэ цэнийг бүтээж байдаг ийм зүйл байдаг. Энэхүү бүтээгдэхүүн үйлчилгээг хүмүүс хэрэглэдэг. Бид нар аливаа нэг ресторанд орохдоо хүртэл тухайн ресторанд явж байгаа хөгжим та бүхний орчныг бүрдүүлж байдаг. Тэр хөгжмөөсөө тухайн

уран бүтээлч маань хэзээ ч эдийн засгийн үр өгөөж хүртдэггүй. Энэ хуулийн бүртгэл мэдээллийн сан гэдэг зүйл бол энэ дээр бүтээлээ бүртгүүлж, энэхүү бүтээлээ оюуны өмч гэдгийг тодорхойлж, оюуны өмчийн бүртгэл оюуны өмч гэдгийг нь тодорхойлж байгаа. Энэ бүртгэл мэдээллийн сан бол цааш нь эдийн засгийн эргэлтэд оруулах суурь бүртгэл мэдээллийн сан болж орж ирж байгаа. Нэг ёсондоо аливаа нэг хүний бүтээлийг хэн нэгэн хүн хэрэглэсэн тохиолдолд тухайн бүтээлийг их бүтээлийг бий болгосон уран бүтээлч элчид нь эдийн засгийн үр өгөөжийг бий болгож байгаа ийм бүртгэл мэдээллийн сан байгаа юм.

Хүүхэд залуучуудын театр дээр нэмээд хэлэхэд.../минут дуусав./

Л.Мөнхбаатар: Гочоогийн Ганболд гишүүн асуултаа асууя.

Г.Ганболд: Хуулийн танилцуулга, зорилгоос нь харах юм бол их том юм. Дэлхий дээр энэ соёлын бүтээлч үйлдвэрлэлээр 500 тэрбум долларын орлого олдог юм байна. Энэнээс л бид нар бас бас хувь хүртэх зорилгоор оруулж ирж байна. Тэгээд энэ салбаруудаа тодорхойлох гэж байна гэж харах юм бол зөв юм шиг. Тэгээд оруулж ирсэн хуулийг нь харахаар бол хэт буруу болоод явчхаж байна л даа.

Яагаад гэхээр энэ соёлын бүтээлч үйлдвэрлэл гэж юу юм бэ гэх дээр зэрэг бүгдийг нь хамруулчихсан. Кино, тайзны урлаг, гар урлал, ном, соёл гээд ингэсээр байгаад 11697 аж ахуйн нэгж байна гэж байгаа байхгүй юу. Тэгээд би жишээ нь бүтээлч гэдэг нэрийг юунд ашиглах гэж байна гэхдээ зэрэг соёлын үйлдвэрлэлүүд дотроосоо дэлхий дээр өрсөлдөх тийм хэдэн бүтээлч үйлдвэрлэлийг нь ялгаж авч, төрөөс бодлогоор дэмжих хууль юм байна гэж ойлгосон чинь зорилго нь тийм мөртөөсөө яг хууль нь болохоор ерөөсөө хавтгайруулаад хаячихсан.

Тэгээд энэ чинь өөрөө утгагүй болчхож байгаа байхгүй юу. Бид нар ямар салбар дээр яг ямар урлагийн бүтээлч үйлдвэрлэлээр дэлхий дээр өрсөлдөх юм гэдгийгээ л хэдүүлээ тодорхойлж энийг бүүр хумих ёстой. 11697-гоос чинь бүүр хумиад 10, 20-хон төрлийн юман дээр л бид нар дэмжлэг үзүүлэх ёстой байхгүй юу.

Тэгэхээр яг гишүүдийн хэлээд байгаа тэр ваучерын асуудал байна л даа. Яг 15-18 насны Монголд хэдэн хүүхэд байгаа юм, хэдэн залуучууд байгаа юм, хэдэн зуун мянган хүн байгаа юм. Та нарын төсөөлж байгаагаар жилд 1 хүүхдэд, 1 залууд хэдэн төгрөг өгөх гээд байгаа юм. Тэр нь төсөв дээр дарамт үзүүлэх юм уу, хэдэн тэрбум болох юм. Улсын төсөв дээр жилд хэдэн тэрбум төгрөг суулгана гэж төсөөлж байгаа юм. Тэр мөнгийг энэ 11697 аж ахуйн нэгжээс бүгдээс нь авсан хүмүүст өгөх юм уу. Одоо сувенир худалдаж авсан нөхөрт ваучераар авахаар нь өгөх юм уу. Эсвэл яг театр урлагийн юм уу энийгээ хумих юм уу энийгээ тодорхой болгооч.

Тэгээд энэ их юм хэмжээний олон тэрбум төгрөг гарна би мэдэж байна. Энэ мөнгийг чинь тэгээд Сангийн яам яг энэ төслөөр нь дэмжээд жил бүрийн төсөв дээр суулгаад явж чадах юм уу. Энийгээ жаахан тодорхой болгох нь бол зөв байна шүү дээ. Тэгэхээр зэрэг энэ сая соёлын салбарын цалин бас харьцангуй сайн нэмэгдлээ. Тэгэхээр зэрэг энэ цалин хөлс нэмэгдсэнтэй холбоотой Соёлын сайдаа энэ соёл урлагийн төрийн байгууллагуудаа жаахан төрийн юм бол төрдөө эргэж халтуур хийдэггүй болгооч. Аймгуудын 100 жилийн ой гээд л болж байна. Тэгээд л нөгөө Морин хуурын чуулга, Улаанбаатар чуулга бүгдээрээ төрийнх, цалин авч байгаа. Тэгээд л аймгуудаас баахан хамгийн өндөр мөнгө өгсөнд нь явна. Тэгэхээр Соёлын сайд энэ 100 жилийн ойнуудад нь Соёлын яам энэ аймгуудын ойнуудад төрийн соёлын салбар байгууллагуудаа хувааж, хуваарилж өгөх ёстой шүү дээ. Аймгийн

100 жилийн ой чинь төрийн наадам шүү дээ. Хувийн компанийн юм биш. Тэгээд тэрэнд очиж соёлын байгууллагууд нь төрийн соёлын үйлчилгээг сурталчилдаг аймгийн ойгоор дамжуулж. Ийм хэмжээний юм явахгүй бол төрөөс цалин авчхаад эргээд төр дээрээ халтуур хийгээд л төрийн янз бүрийн арга хэмжээ хийхээр мөнгө төгрөг нэхээд л ингээд байх юм бол энэ соёлын салбар чинь ер нь яаж явах юм бэ. Энэ дээр яг Соёлын сайд яг ямар бодолтой байгаа юм. Тэгэхээр энэ хууль дээрээ жоохон хумьж салбаруудаа их тодорхой зааж өгөхгүй бол хэт ерөнхий болгосон байна. Энэ хуулийн хамгийн том алдаа нь энэ байна гэж хэлэх гээд.

Л.Мөнхбаатар: Ганболд гишүүний асуултад хариулъя. Соёлын сайд Номин.

Ч.Номин: Ганболд гишүүний асуултад хариулъя. Энэхүү хуулийн төслийг боловсруулахдаа бид нар олон улсын чиг хандлага, дэлхийн нөхцөл байдал, цаашлаад Монгол Улсынхаа нөхцөл байдал дээр суурилсан. Бид нар соёлын бүтээлч үйлдвэрлэлийн суурь судалгаагаа хийсэн. Энэ суурь судалгаан дээрээ суурилсан. Ер нь энэ креатив индустри гэдгийг ЮНЕСКО өөрөө томъёолчихсон байдаг.

Тэгэхээр бид нар энэ ЮНЕСКО-гийн суурь томъёолол дээр суурилан хийсэн байгаа. Энэ 12 чиглэл гэдэг бол энэ креатив индустри буюу бүтээлч үйлдвэрлэлийн салбарт байдаг олон улсын стандарт дээр суурилсан байгаа. Бүтээлч үйлдвэрлэлийн хуулийг хийхдээ бид нар дэлхийн чиг хандлага, өөрийн орныхоо нөөц, боломж тэгээд ирээдүйн ер нь хаашаа чиглэлтэй хөгжиж байна вэ гэдэг зүйлийг судалж байгаад хийсэн. Тэгэхээр бид нар 12 салбар, 93 чиглэлээ энд хамрагдах ёстой гэж үзэж байгаа.

Харин таний хэлээд байгаа тэргүүлэх чиглэлүүдийг бид нар тогтмол тодорхойлж, үүнийгээ хөгжүүлж авч явах нь зүйтэй гэдэгтэй санал нэг байна.

Үүнийг Засгийн газраас тодорхойлоод явж байгаа. Тэгээд өнгөрсөн жил хийсэн 43 дугаар тогтоолын хүрээнд энэ 12 салбараас 6 салбарыг тэргүүлэх чиглэлээр тодорхойлж илүү түлхүү хөгжүүлэх бодлогыг аваад явж байгаа.

Үүнээс гадна та соёлын ваучертай холбогдолтой хэдэн өсвөр насныхан байдаг вэ гэдэг асуулт асууж байна. Энэ дээр нийтдээ 176 мянган өсвөр насныханд энэ хамрагдана гэж үзэж байгаа. Тэгэхээр бидний хувьд бол энэ Засгийн газраас энэхүү ваучерын журмыг батална.

Ер нь төсвийн хувьд ойролцоогоор 5-17 тэрбум төгрөгийн төсвийг зарцуулах боломжтой гэж харж байгаа.

Л.Мөнхбаатар: Гишүүд танхимд орж ирье. Одоо санал хураалт явагдана.

Зочин танилцуулъя. Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатын шүүхийн Тамгын газрын ажилтнууд, албан хаагчид Төрийн ордон, Улсын Их Хурлын үйл ажиллагаатай танилцаж байна.

Та бүгдийн ажил, амьдралд хамгийн сайн сайхан бүгдийн дээдийг хүсэн ерөөе.

Гишүүд асуулт асууж дууслаа. Одоо Одонгийн Цогтгэрэл гишүүн асуултаа асууя. Цогтгэрэл гишүүнээр гишүүд асуулт асуугаад дуусна. Үүний дараа санал хураалт явагдана.

О.Цогтгэрэл: Соёлын бүтээлч үйлдвэрлэл гээд хуулийн нэр бол их гоё нэртэй хууль байна. Тэгээд бас жоохон тойруулж харлаа. Үнэхээр эндээс тийм онцлог шинэ зүйл бол би бас олж харсангүй. Бүтээлч үйлдвэрлэл гэдэг чинь өөрөө энэ бүхий л салбарт яригддаг тэр шинэ бүтээл, инновац ярьж байгаа тэр олон салбар бүхэнд л байдаг зүйл. Тэгээд эндээс соёлынх гэж онцгойлж авдаг нь тэгээд цаашдаа салбар бүхэн дээр тэр салбарын бүтээлч үйлдвэрлэл гээд ингээд яригдаад явах юм уу. Дахиад яг энэ

агуулгын хүрээнд бол жишээ нь Соёлын хууль гээд хууль байгаа шүү дээ. Тэр Соёлын хуульд яагаад энийгээ нэмэлт, өөрчлөлтийн ийм хэлбэрээр энэ зүйлүүдээ соёлын хуульдаа тусгачхаж болоогүй юм. Энэ хуулиудын нөхцөл байдлуудыг харахлаар энэ дээр их олон зүйл шинээр хэрвээ ийм зүйлүүд байвал их олон зүйл ярьж болохоор. Тэр тусмаа бүтээлч үйлдвэрлэл, тэр тусмаа инновац гэдэг зүйл чинь хувь хүний ур чадвар, хувь хүний тэр бүтээлч сэтгэлгээ энэ зүйл дээр илүү тэгж тогтож байдаг ийм зүйл гэж ойлгож байгаа байхгүй юу. Хувь хүний креатив сэтгэлгээнээс илүү ургаж гарсан зүйл.

Тэгэхлээр энийг өөрийг нь ийм системчилж явах боломж, бололцоо үнэхээр энэ хуульдаа бас байдаг юм уу, үгүй юм уу. Тийм системээрээ явж байгаа тийм бүтээлч шинэ санаа гараад энэний чинь яг тэр бүтээлч уран бүтээлчид, магадгүй энэ аж ахуйнууд дизайн сэтгэлгээ олон зүйл энэний цаана ингээд явдаг. Тэгэхээр энэ бүхэн чинь өөрөө яг энийг ингээд системчлээд улс орнууд хуулийн түвшинд төрийн дэмжлэгтэйгээр босож ирдэг салбар мөн үү, биш үү. Яг энэ дээр судалгаа энэ тэр байна уу.

Би бол энийг тийм төрийн дэмжлэгээр бүтээлч үйлдвэрлэлийн салбарыг, инновац гэдэг зүйлийг төр хийчихдэг гэж бол ойлгохгүй л байгаад байна л даа. Энийг төр хийдэг гэдэг зүйл энэний цаана. Тэгэхээр энэ бүхэн дээр тийм үзэл санааныхаа хувьд ийм энэ чинь хэлэлцэх эсэх явж байгаа болохоор үзэл санааны хувьд тийм тодорхой бас тийм тайлбарууд хэлээч. Энэ инновацыг төрийн дэмжлэгтэйгээр хийгээд түүгээр их айхтар амжилт гаргачихсан улс орон айхтар амжилт гаргачихсан тийм түүх жишээнүүд байна уу. Энэ бол тийм өөр л агуулгатай зүйл байдаг байх шүү. Энэ бүтээлч үйлдвэрлэл гэдгийн цаана.

Л.Мөнхбаатар: Бүлгийн дарга Цогтгэрэл гишүүний асуултад хариулах уу. Үг хэлчхэв үү. Үг хэлчихлээ.

Одоо үг хэлж болно. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан үг хэлэх гишүүн байна уу. Энхбаяр гишүүнээр, Дэлгэрсайхан гишүүнээр тасаллаа. Улсын Их Хурлын дэд дарга Салдангийн Одонтуяа үг хэлэе.

С.Одонтуяа: Би энэ хуулийг дэмжиж байна. Тэгээд бас энэ зарим гишүүд энэ Соёлын хууль дээрээ оруулж болоогүй юм уу. Соёлын хууль бол би өөр гэж харж байгаа. Соёлын хууль ерөөсөө нийт Монгол Улсын соёлын тухай тэр чинь их олон зүйл, заалт орно. Энэ яг бидний нөгөө хүсээд байгаа эдийн засагжуулья, яг тэр хүмүүсийн креатив санааг нь зах зээл рүү оруулж хөгжүүлэе, дэлхийн зах зээл дээрээс жоохон мөнгө босгоё, энэ олон манай зураачид байна, мундаг урлагийн авьяастай хүмүүс байна, дуучид, янз бүрийн хүмүүс энийг ерөөсөө л энэ том дэлхийн зах зээл рүү ойртуулж өгье гэсэн. Энэ бол их тийм зоригтой хууль байна гэж би харж байна.

Тэгээд бодвол энэ сайд нь өөрөө бизнесийн салбарт ажиллаж байсны ач холбогдол нь энэ дээр гарч байх шиг байна. Ер нь дэлхийн улс орнууд эдийн засгийн хөгжил энэ мөнгө олдог юм чинь шал өөр болчихсон шүү дээ. Бид нар л уул уурхайтайгаа зууралдаад л байдаг. Тэдэн тонн нүүрс гаргалаа гээд л энийгээ л эдийн засаг гээд л. Тэгээд л бүх хувийн хэвшлээ хааж авч байгаад л ерөөсөө л их төрийн хэдэн компани уул уурхай нүүрс олоод л, мөнгөтэй болоод л тэрийгээ хуваадаг ийм.

Гэтэл Монголчууд чинь хамгийн мөнгө олж болох салбар чинь яг энэ соёлын бүтээлч салбар байхгүй юу. Өнөөдөр тэр “Hu” хамтлагийг хар. Яаж дэлхийд нэрээ гаргаж байна. Тэр Солонгосын “BTS” гээд хамтлаг дэлхийн тэр улс орнуудын хэдэн мянган тонн сая тонн гаргасан нүүрснээс чинь хэд дахин давсан юмыг л 1 цаг дотор дуулаад л олж байна шүү дээ.

Тэгэхээр төрийн бодлого энэ дээр маш чухал. Одоо Монголчууд иймэрхүү салбар руу зоригтой орохгүй бол өнөөдөр юу болж байна гэхээр нөгөө социализмын үеийн соёлын үйлдвэрлэлээсээ хэтрэхгүй байна шүү дээ. Тэр үед чинь өөр байсан байхгүй юу. Төрөөс дэмжсэн шиг дэмжээд тэр чинь шал өөр байсан. Одоо дэлхий дээр энэ социализм чинь байхгүй. Тэгэхээр зоригтойнохон шиг тэр энэ бүтээлч үйлдвэр рүү нь оруул л даа. Манай зураачдын бүтээл чинь ингээд жоохон дэмжээд тэр зах зээлийнх нь арга хэлбэрийг нь заагаад өгөх юм бол өнөөдөр тэр энэ интернэт худалдаагаар өчнөөн сайхан хөгжиж болохоор байна.

Тэгэхээр энийг бол маш сайн дэмжих ёстой гишүүдээр. Харин хэлэлцүүлэх явцад тэр алдаа оноо нь байвал засаад, чиглүүлээд явах ёстой юм. Би сая энэ хөрш Хятадад очоод тэр эмэгтэйчүүдийн яг тэр гар урлал, үйлдвэрлэлийн салбарын асуудал дээр бас нэлээд уулзлаа. Яаж ядуурлаас гарсан юм, яаж эдийн засаг үгүй ээ ерөөсөө л яг энэ бүтээлч үйлдвэрлэлийг нь л хөгжүүлчихсэн байгаа байхгүй юу. Тэгээд л ерөөсөө тэр үндэстэн, ястан болгоны зүйлүүдийг нь дэмжээд л, сурталчлаад л, соёлыг нь сурталчлаад л түүгээрээ асар их мөнгө олж байна шүү дээ. Тэгээд л үзэсгэлэнгүүд гаргаж байна.

Тийм учраас энэ дээр бол манай улс маш хоцрогдчихсон байгаа шүү. Тэгээд энэ дээр жоохон зоригтой ажилламаар байна. Ерөөсөө бид нар улс улс болгон жижиг жижиг юмаар маш том зах зээлд гарах боломж байна шүү дээ. Тэр Швейцарын хот чинь зөвхөн нэг удаагийн хурал хийгээд л түүгээрээ мөнгө олчхож байна. Зарим улс даатгалынхаа чиглэлээр олчхож байна. Сингапур улс бас яг энэ соёлын юугаар бол маш сайн хөгжиж ирж байна лээ шүү дээ. Нэг хэсэг дандаа л электрон бараа гэдэг байсан. Саяхан очоод л ирсэн чинь ерөөсөө дандаа энэ соёлын бүтээлч үйлдвэрлэлээр л асар их мөнгө олж байна шүү дээ. Тэгээд би Монголын тэр хэдэн залуучууд зургийг

онлайнаар ингээд тэр NFT гэж хэлээд зараад л доор нь цагийн дотор л хэчнээн сая төгрөг босгож байхыг би харсан. Одоо бид нар жоохон ийм юм руу ормоор байна. Тэгээд л уул уурхай уул уурхай ерөөсөө энэ яагаад энэ хэдэн соёлын хүмүүсээ зоригтой дэмжиж болдоггүй бэ. Бид нар өөрсдөө Их Хурлын гишүүд ийм хоцрогдсон байхаар энэ улс чинь яаж хөгжих юм. Энэ дээрээ жоохон зоригтой ажилла л даа. Зоригтой ажиллая гэсэн хүмүүсээ дэмж л дээ.

Энэ чинь соёлын хуулиас шал өөр. Энэ чинь Монгол Улсын энэ олон мундаг хэдэн мянган жилийн түүхтэй хүмүүсийг чинь дэлхийн зах зээл рүү л гаргая, энийг нь хөгжүүлбэ л гэсэн ийм санаа шүү дээ. Тэгээд яагаад ийм бизнесийн санаа, хувийн хэвшлийг нь дэмжих гэсэн зах зээл рүү оруулах гэсэн ийм юмыг яагаад дандаа ингэж хааж боосон юмнууд ярьж байдаг юм бэ. Тэгэхээр энэ асуудалтай зоригтой ажил гэж хэлмээр байна.

Тэгээд төгсгөлд нь хэлэхэд Номин сайд харин тэр Чойжин ламын сүмийн гадаа тэр орчин үеийн хийцтэй янз бүрийн тийм юмыг нь эвдсэн зүйлийг битгий та дэмжээрэй. Тэр бол яг сайхан тэр хавьдаа маш том соёлын өв болоод байгаа шүү. Энэ дээр бол би хатуу зогсоно. Тэгээд энэ соёлын хуулийг бол дэмжиж байна. Хэлэлцэх явцад би бүүр энэ дээр чинь оролцъё, энэ дээр нь өөрсдийн судалгаагаа хийе, дэмжбэ гэж бодож байна.

Л.Мөнхбаатар: Одонтуяа дарга үг хэллээ.

Одоо Хууль зүйн байнгын хорооны дарга Баттөмөрийн Энхбаяр үг хэлбэ. Гишүүд танхимд орж ирээд санал хураалт явагдана.

Б.Энхбаяр: Би дэмжиж үг хэлж байгаа. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд нь дэмжих нь зүйтэй гэсэн ийм саналтай байгаа.

Улсын Их Хурал хэлэлцэх эсэх асуудлыг нь шийдвэрлэсний дараа энэ чинь Боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд харьяалагдаж явах байх. Энэ ажлын хэсгийн хүрээнд байгуулж ажиллах явцдаа энэ бусад дагасан хуулиудын асуудлыг их анхаарч ярилцах хэрэгтэй байна. Энэ дотор тухайлбал би энэ Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулж, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих сан байгуулах асуудлыг би бол эргэлзэж байгаа.

Заавал Засгийн газрын дахиад сан байгуулж байж энийг дэмжих шаардлага ингэхгүй бол хөгжихгүй байгаад байгаа юм уу. Энэ хувийн хэвшил юм уу, иргэний нийгмийн байгууллагын хүрээнд тэр соёлын үйлдвэрлэл эрхлэгчид нь өөрсдөө энэ байгууллага нь энэ сан юмаа байгуулаад энд нь яах вэ бас тодорхой хэмжээний оролцоо юм уу байдлаар явж болохгүй юу гэсэн ийм асуудал байгаа юм.

Энэнтэй холбоотой энэ гаалийн болон НӨАТ-ын татвараас чөлөөлөх асуудлууд бас их орж ирчихсэн байна. Энийг бас Төсвийн байнгын хороон дээр бас нэлээн анхаараач. Энд хэчнээн аж ахуйн нэгж хэдэн тэрбумын үйлдвэрлэлтэй холбоотой асуудлыг бид татвараас чөлөөлөх гээд байгаа юм бэ. Ийм том уут байна уу, эсвэл татвараас хөнгөлж чөлөөлөхгүй бол энэ явахгүй болчхоод байна уу. Энийг бас хэлэлцүүлгийн шатад нь холбогдох мэргэжлийн Байнгын хороод нэлээн анхаараач.

Зөрчлийн хуульд өөрчлөлт оруулах юм байна. Зөрчлийн хуулийнх нь асуудал мэдээж Хууль зүйн байнгын хороогоор орох байх. Энэ дээр заавал тэр соёлын сайдын зөвшөөрөлгүйгээр хувиалан олшруулбал шийдэх ийм хариуцлага байх нь зохимжгүй байх гэж бодож байгаа юм. 1 хүний зөвшөөрөл аваагүй л бол тэр нь зөрчил болдог томъёолол бол би энэ хууль зүйн

техникийн хувьд болохгүй байх. Ийм зөрчил би ер нь Зөрчлийн хуульд байхгүй шүү. Тэгэхээр энэ Засгийн газраас орж байна, Нямбаатар бас сайд байж байна. Энийг хэлэлцүүлгийн шатанд бас засах хэрэгтэй юм шиг санагдаад байна. Сайдаас зөвшөөрөл аваагүй тохиолдолд зөрчил болдог ийм зөрчлийн шийтгэл Зөрчлийн хуульд байхгүй. Мянга хэдэн зуун зөрчил, 1200 зөрчил байгаа шүү дээ. Энэ дотор ийм томъёололтой зөрчил байхгүй. Тэгээд энэ Зөрчлийн хуулийн үндсэн концепцоос их тийм зөрсөн агуулгатай орж ирж байна.

Дараагийн дагасан хууль дээр энэ Газрын хууль. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн бүс, соёлын бүтээлч үйлдвэрлэлийн цогцолбор, паркийн зориулалтаар олгосон газар дээр газрын төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх гээд байх шиг байна тийм үү. Энэ тийм газрын татвар, төлбөр авахгүй л гэсэн санаа байх шиг байна. Энэ их ерөнхий байх шиг санаа л санагдаад байна шүү. Тэгэхээр энэ Газрын хуулийн концепцтой холбоотойгоор соёлын уламжлалт юм байгаа юм гэж хэлээд л тэгээд л газрын татвараас чөлөөлөгдөх гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ халхавч байдлаар энэ татвараас зайлсхийх, газрын төлбөрөөс зайлсхийх, НӨАТ-аас зайлсхийх гээд ялангуяа татвар, санхүү ийм асуудал руу их орсон байна.

Тийм учраас энэ дагасан хуулиудыг ер нь бүгдийг нь их нухацтай авч ярьж байж, ярихгүй бол болохгүй гэсэн би бол ийм зарчмын саналтай байна.

Л.Мөнхбаатар: Зочин танилцуулъя. Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2003 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүгдэд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс ажил, амьдралд нь сайн сайхан бүгдийн дээдийг хүсэн ерөөе.

Гишүүд үг хэлж дууслаа.

Байнгын хорооны саналаар соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Соёлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Соёлын өвийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Барилгын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Кино урлагийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Номын сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт гишүүдээ.

Санал хураалт 57.8 хувиар санал дэмжигдлээ.

Төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт

бэлтгүүлэхээр Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороонд шилжүүлээ. Дараагийнхаа асуудалд орёё.

12.20 цаг

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцье.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн танилцуулъя. Таныг индэрт урьж байна

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль зэрэг төсвийн бодлогын 14 голлох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын нэр бүхий гишүүдийн зүгээс Улсын Их Хуралд өргөн барьж байна.

Төсвийн сайн засаглалыг бүрдүүлэх үүднээс төсвийн сахилга бат, төсвийн тогтвортой байдлыг бий болгох, төсвийн төлөвлөлт, ил тод байдлыг сайжруулах, олон нийтийн оролцоо, хяналтыг дээшлүүлэх, гадаад зээл тусламж болоод өрийн хязгаарлалтын хүрээнд төсвийн шинэчлэлийн 4 бодлогыг энэхүү хуулийн төслийн хүрээнд бодлого болгон дэвшүүлж байна.

Ингээд хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын гишүүдийн бараг тал гаруй хувь нь буюу 34 гишүүн дэмжин санаачилж хамтран санаачлагчаар бас оролцож байгааг та бүхэнд бас энд онцлон тэмдэглэе.

Хуулийн төслийг хууль санаачлагчдын зүгээс 4 сар гаруй хугацаанд 200 гаруй эрдэмтэн, судлаачид болоод их, дээд сургуулиудын багш нар мөн мэргэжлийн холбоонуудын саналыг

нэгтгэж энэ олон жилийн бодлогын алдаанууд болон үүнийг залруулах хөгжлийн гарц, шийдлүүдийг энэхүү хуулийн хэлбэрт нэгтгэн дэвшүүлж байгааг та бүхэндээ бас уламжилж байна.

Юуны өмнө болсон төсвийн шинэчлэлийг дэмжиж, хуулийн төслийг хамтран санаачилж байгаа хууль санаачлагчдаа болон хуулийн төсөлд санал, зөвлөмжөө ирүүлсэн эрдэмтэн, судлаачдаа бас энэхүү индэр дээрээс талархлыг дэвшүүлж байна.

Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль түүнд тусгагдсан тусгай шалгуурууд бол нэг талдаа энэ төсвийн сахилга батын асуудал. Төсөвтэй холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилт болоод төсвийн суурь зарчмууд үндсэндээ хууль батлагдсанаас хойших 13 жилийн хугацаанд нэг талдаа үр дүнтэй хэрэгжиж чадаагүй гэж бол дүгнэж болохоор байгаад байгаа. Тухайлбал 13 жилийн хугацаанд энэ хэлбэрэлтгүй мөрдөгдөх ёстой байсан хуульд нийтдээ 13 удаагийн нэмэлт, өөрчлөлтөөр төсвийн тусгай шаардлагуудыг өөрчилж ирсэн.

Мөн 2012 оноос хойш төсвийн, энэ 10 жилийн хугацаанд төсвийн дунд хугацааны бодлогын баримт бичиг болох стратегийн баримт бичиг болох төсвийн хүрээний энэ 10 удаа батлах ёстой баримт бичиг маань 32 удаа өөрчлөлт орж ирсэн нь бас үнэнийг илтгэж байгаа. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн үндэс, суурь болсон гол үндсэн асуудал бол энэ баялгийн санг бий болгох, хуримтлал үүсгэх асуудал байгаа. Энэ бол өөрөө суурь зарчмын асуудал.

Тэгэхээр төсвийн тогтвортой байдлын хуулийг мөрдөөгүйгээс улбаалаад өнөөдөр ирээдүй өв сан болоод тогтворжуулалтын санд ирээдүйдээ бид бүхэн бас хангалттай хуримтлалыг үүсгэх асуудалд бол анхаарал хандуулах энэ өөрчлөлтийг бол хийх цаг нь болжээ гэж одоо харж байгаа. 2004-2019 оны хооронд

би зүгээр нэг жишээ хэлэхэд уул уурхайн орлогын нийт 95 хувийг бол бид бүхэн хэрэглээндээ зарцуулж иржээ. Зөвхөн багахан хувийг л ирээдүйдээ хуримтлуулж байгаа байдал бол бас үүнийг илэрхийлж байгаа бодит илэрхийлэл болов уу гэж бол бас бодож байна.

Мөн олон нийтийн бүрдүүлсэн татвар буюу энэ төсвийн шийдвэр гаргах бүхий л үе шатад энэ олон нийтийн оролцоог, олон нийтийг мэдээлжих эрхийг бол хангах энэ бол зайлшгүй шаардлагатай байгаа. Тэгэхээр төсвийн засаглалын институтүүдийн бие даасан байдлыг нь би нэмэгдүүлэх, улс төрийн нөлөөллөөс ангид байлгах энэ нөхцөлийг бүрдүүлэх асуудал бол бас бид бүхний анхаарах ёстой чухал асуудлын нэг болж байна.

Тэгэхээр олон нийтийн оролцоог хангах, улсын төсвийн ил тод байдлыг бий болгох, хяналт, хариуцлагыг нарийвчлан тусгахад бол онцгойлон анхаарах зайлшгүй шаардлага бий болсон гэдэг энэ асуудлыг би бас үндэслэл хэсэгтээ бас та бүхэндээ хэлж байна.

Мөн төсөв болоод гүйцэтгэлтэй холбоотой хяналт тавих, хариуцлага тооцох, энэ хуулийн шаардлагуудыг нарийвчлан зохицуулах шаардлагатай байгаад байгаа юм.

Тэгэхээр цаашдаа бид нарын хувьд бас энэ ирээдүйдээ, ирээдүй хойч үедээ энэ төсвийн засаглалыг сайжруулах зарчмын хүрээнд бас энэ суурь төсвийн реформ, өөрчлөлт, төсвийн сайн засаглалыг бэхжүүлэх энэ өөрчлөлтийг хийх цаг нь бол болжээ гэж бас харж байгаа.

Энэ хүрээнд тухайлбал нэгдүгээрт улс орны эдийн засгийн аюулгүй байдал, төсвийн урт хугацаанд тогтвортой байдлыг хангах үүднээс аль ч улс төрийн хүчин эрх барьж байсан, аль ч Засгийн газар бүрэлдсэн төсвийн Үндсэн хууль

болсон энэ Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг заавал мөрддөг бол байх ёстой. Энэ үүднээс Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг заавал хэрэгжүүлдэг байх суурь зарчмыг мөрдөх энэ зохицуулалтыг бас тусгаж оруулж ирснийг нь хэлэх байна.

Хоёрт, жил жилийн Төсвийн хууль батлахтай зэрэгцээд төсөвтэй нийцүүлж нэгхэн жилийнхээ төсөвтэй нийцүүлж бид нар төсвийнхөө хүрээг өөрчилдөг энэ буруу жишгийг бас өөрчлөх энэ асуудлыг хуулийнхаа үндсэн суурь зарчмаар шийдэгддэг болох энэ өөрчлөлтийг бас энэ хуулийн хүрээнд тусгаж орж ирж байгаа.

Төсвийг бүрдүүлэгч татвар төлөгчид болсон иргэд төсвийн төлөвлөлт боловсруулалтад анхнаас нь оролцох оролцоог хангах, мөн төсвийн талаарх мэдээллийг ил тод байлгах өөрчлөлтийг бас энэ хуулийн хүрээнд хийж байгаа.

Төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төлөвлөлтийг иргэд олон нийтийн хяналт болон Төсвийн тогтвортой байдлын зөвлөл, төрийн аудитын байгууллагын хамтын оролцоо, хяналтаар дүгнэх боломж, бололцоо бас энд хуулийн өөрчлөлтийн хүрээнд бий болно гэж бол харж байгаа.

Дөрөвт, иргэд болон иргэдийн төлөөллийн байгууллага болсон Улсын Их Хурал төсвийн талаарх мэдээллээр тухай бүр хангагдах, хангалттай хугацаанд танилцаад шийдвэр гаргах, шийдвэр гаргахад олон нийт оролцох эрхтэй байхаар бас тусгаж оруулж ирж байна. Энэ ч үүднээс Төсвийн хуулийн хүрээнд мөрдөгдөж ирсэн төсвийн цаглаварт бас тодорхой томоохон бас өөрчлөлтүүдийг хийж байгаа.

Төсвийн төслийг үе үе Засгийн газар 10 сарын 1-нд өргөн барьдаг байсан бол энэ удаагийн хуулийн өөрчлөлтөөр Засгийн газар өргөн барих хугацааг 1 сараар наашлуулж 9 сарын 1-нд өргөн

барьдаг байхаар. Ингэснээр олон нийт болоод Улсын Их Хурал, мөн иргэний нийгмийн байгууллагууд, энэ чиглэлийн мэргэжлийн судлаачид ч гэсэн төсвийн төсөөлөлтэй хангалттай хугацаанд танилцах, шийдвэр гаргах хурах хугацаа нь 9 сарын 1-нээс 11 сарын 15 буюу 75 хоног болж өмнөхөөсөө 35 хоногоор нэмэгдэх энэ боломж бололцоо бүрдэнэ гэж харж байгаа.

Төсвийн хяналтын байгууллагууд буюу Улсын Их Хурлын нүд, чих болох Төсвийн тогтвортой байдлын зөвлөл, Үндэсний аудитын байгууллага хамгийн багадаа 20-25 хоногийн хугацаанд төсвийн төсөлтэй танилцаж, санал, дүгнэлтээ гаргах. Ингээд олон нийтэд заавал мэдээлэхээр бас энэ Төсвийн хуулийн хүрээнд тусгаж өгсөн.

Тэгэхээр энэ мэргэжлийн байгууллагын гаргасан мэргэжлийн хүмүүсийн гаргасан санал, дүгнэлт гарсны дараа заавал Улсын Их Хурал хэлэлцэж эхлэх энэ зохицуулалт бас энэ хуулийн хүрээнд тусгаж гаргаж ирсэн.

Мөн гадаад зээл, тусламж, өрийн хязгаарлах бодлогын хүрээнд зээл, тусламж, хөрөнгө оруулалтын ач холбогдол, үр өгөөж энэ үр ашиг эрэмбээр нь ангилж гаргах, үр ашиггүй салбарт хөрөнгө оруулалт хийхийг бас хязгаарлалтыг хийх зохицуулалтууд тусгагдсан байгаад байгаа.

Мөн Засгийн газрын нийт өрийн дүн болон бүтцийн мэдээлэл, мөн ирээдүйн санд хуримтлах хуримтлалын дүн төсвийн төсөлд дэлгэрэнгүй тусгах төсвийн бүрдүүлбэр хэсэг болохоор бол ингээд тусгагдсан байгаад байгаа. Энд бас нэг онцлох зүйл нь ер нь төрөөс санхүүждэг төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагуудыг энэ тэмдэглэлт өдөр, өдөрлөг, ойн баярт хандив, тусламж өгөх, нийгмийн шинжтэй үйл ажиллагаа, төсвийн алдагдал нөхөх зэрэг байдлаар

санхүүжүүлэхийг хориглох нь зүйтэй гэж үзэж байгаа.

Мөн хувийн хэвшлээс аливаа төрийн бус байгууллагуудаас хандив, мөнгө татах, шахаж шаардахыг бас мөн энэ хуулийн хязгаарлалт нөхцөлүүдийг бас тусгаж оруулж ирсэн.

Тэгэхээр энэ хуулийн шинэчлэл маань цаашдаа бид бүхний хийгдэх ёстой төсвийн сайн засаглалыг бэхжүүлэх хүрээнд авах ёстой арга хэмжээнүүдийн шийдлүүдийг бодлогын баримт бичиг болгон хуулийн хэлбэрт оруулж, та бүхэнд өргөн барьж байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төсвийн засаглалыг бэхжүүлэх үүднээс төсвийн шинэчлэлийг хэрэгжүүлэх, засаглалын олон жилийн энэ алдаа, сургамжийг засаж залруулах үүднээс боловсруулсан хуулийн төслүүдийг төсвийн шинэчлэлийн бодлого болгон дэвшүүлж байгааг та бүхэн маань бас хүлээн авч, шийдвэрлэж өгөхийг бас та бүхнээс хичээнгүйлэн гуйж байна.

Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Тэмүүлэн гишүүнд баярлалаа. Төслийн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн зарлагын дэд хорооны дарга Бөхчулууны Пүрэвдорж танилцуулъя. Таныг индэрт урьж байна.

Б.Пүрэвдорж: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 32 гишүүн 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын

тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Төсвийн байнгын хороо 2023 оны 04 сарын 4-ний өдөр хуралдан хэлэлцэж шийдвэрлэлээ.

Төсөл санаачлагч төсвийн тогтвортой байдлыг хангах, төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангах, санхүү, төсвийн зохистой удирдлага болон хариуцлагатай байх зарчмуудыг хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх, Засгийн газрын боловсруулсан төсвийн төсөлд олон нийтийн оролцоог хөндлөнгийн хяналт, төрийн аудитын ажиллах механизмыг тодорхой болгох нь зүйтэй гэж үзэж, хууль, тогтоолын төслүүдийг боловсруулсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин нар үндэсний хөтөлбөр болгож хүрээг нь өргөжүүлэх замаар төсвийн суурь шинэчлэл олгох боломжтой эсэх талаар, төсвийн шинэчлэлийн хүрээнд бусад салбарын хуулийн уялдаа холбоо гарах үр дүнгийн талаар асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан төсвийн шинэчлэлийг хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан дахин боловсруулах ажлын хэсэг байгуулан Засгийн газартай хамтран ажиллах нь зүйтэй, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд дэмжиж байгаа бөгөөд Төсвийн шинэчлэлийн үндэсний хөтөлбөрийг яаралтай боловсруулж, өргөн мэдүүлэхийг Засгийн газарт чиглэл болгох, Улсын Их Хурлын гишүүн Өнөрболор төсвийн оновчгүй бодлого хэрэгжүүлж, мөчлөг дагасан шинжтэй явж ирсэн нь боловсрол, эрүүл мэнд, нийгмийн салбарт сөргөөр нөлөөлж байгааг анхаарах талаар саналуудыг гаргасан болно.

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хувьд дэмжиж хэлэлцэхийг Байнгын хорооны гишүүдийн олонх нь дэмжсэн тул чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төсвийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Пүрэвдорж гишүүнд баярлалаа. Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Өнөрболор гишүүнээр тасаллаа. Өнөрболор гишүүн асуултаа асууя.

Д.Өнөрболор: Энэ өдрийн мэндийг гишүүддээ хүргэе. Ер нь маш чухал төсөл орж ирж байгаа. Ер нь энэ миний бодлоор энэ суурь реформыг бол нэлээн дээр хийх ёстой байсан. Ер нь цаг хугацааны хувьд бас нэлээн хоцорч орж ирж байна гэж үзэж байна.

Ер нь манай улс энэ 2000 оноос хойш төсвийн зардлын бүтэцдээ бараг өөрчлөлтийг оруулж ирээгүй юм байна лээ. Ер нь урсгал зардал хувийг эзэлдэг, хөрөнгийн зардал бол 20 хувийг эзэлдэг ийм бүтцээр явж ирсэн юм байна.

Тэгээд зардлын хэмжээ тогтмол өсөж дотоодын нийт бүтээгдэхүүний 40 орчим хувьд хүрч байгаа. Ер нь улс орнуудын энэ тоон үзүүлэлтүүдээс ингээд аваад үзэхлээр төсвийн зардлын хэмжээ нь үндсэндээ 10-17 хувь дээр ер нь барьдаг ийм л байдалтай байдаг юм байна лээ.

Тэгээд сүүлийн 15 жилийн хугацаанд төсөв бол үндсэндээ өрийг үйлдвэрлэж ирсэн. Тэгээд энэ аудитын дүгнэлтээр 2018-20 онд энэ Засгийн газрын гадаад зээлийн 44.1 хувийг төсвийн алдагдлыг нөхөхөд ингээд зориулсан гэж дүгнэсэн байдаг юм байна. Тэгээд өнөөдөр энэ гадаад өрийн нийт хэмжээний дотоодын нийт бүтээгдэхүүнтэй харьцуулсан харьцаа хөгжиж байгаа орнуудын өрийн хязгаар үзүүлэлтээс 2-3 дахин их байгаа. Манай улсын өрийн эмзэг байдлын шинжилгээний 5 индикаторын 3 дээр нь анхааруулахаас дээд түвшин давсан ийм л дүр зурагтай өнөөдөр бид нар байж байгаа.

Тэгэхлээр энэ төсвийн бодлого дээр шинэчлэлт, өөрчлөлт хийх зайлшгүй шаардлагатай ийм цаг хугацаанд байгаа. Тийм учраас би бас энэ хуулийг дэмжсэн байгаа юм.

Энэ хуулийн өөрчлөлтөөр 3, 4 реформын шинжтэй бас ийм шинэчлэлүүдийг хийж байгаа гэж миний хувьд ойлгож байгаа. Нэн ялангуяа энэ төсвийн төлөвлөлтийг сайжруулах, олон нийт хянах ийм боломжийг бүрдүүлж байгаа. Хуучин Улсын Их Хурал 45 хоног энэ төсөв хэлэлцэж байсан бол одоо 75 хоног болгож нэмэгдүүлсэн байж байгаа. Тэр нь бол олон нийт танилцах, ил тод байх, нийтээрээ хяналт тавих ийм боломжийг бас нээлттэй болгож байгаагаараа ийм давуу тал үүсгэж байгаа.

Нөгөөдөх нь нөгөө гол асуудал нь энэ сая Тэмүүлэн гишүүний ч гэсэн бас танилцуулга дээр гарсан энэ төсвийн бодлогын тогтвортой байх асуудал бол маш чухал байгаа. Тэгээд энэ өөрчлөлтөөр төсөв тогтвортой байх гол үндэс нь энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийг бие даасан, мэргэжлийн бүтэц байх, улс төрөөс ангид ийм олон нийтийн дуу хоолой болсон үндсэндээ мэргэжлийн бүтэц байх асуудал бол хамгийн чухал

асуудал байгаа гэж миний хувьд үзэж байгаа.

Тэгээд энэ нөгөөтээгүүр энэ ирээдүйн өв сангийн хуримтлал үүн дээрээ хийх хуримтлалын асуудлыг бас шийдвэрлэж байгаагаараа онцлог байгаа. Тийм учраас энэ төсвийн бодлого өнөөдөр нийгэм эдийн засгийнхаа үр өгөөжийг өгдөг байх ёстой. Иргэдийн амьдралд тийм үр өгөөжөө өгдөг байх ёстой, үр үйлдвэрлэдэггүй байх ёстой. Тиймээс энэ хуулийг дэмжиж байгаа. Тийм учраас Улсын Их Хурлын гишүүдийг ч гэсэн бас энэ хуулийг бас дэмжээсэй, дэмжээрэй гэж бас уриалж байна. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Гишүүд санал хураалттай. Адышаа гишүүн суудалдаа сууя. Өнөрболор гишүүн дэмжиж үг хэллээ. Одоо үг хэлж болно. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Үг хэлэх гишүүн байна уу. Нямаагийн Энхболд гишүүнээр тасаллаа. Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Нямаагийн Энхболд үг хэлье. Одоо санал хураалт явагдана. Гишүүд суудлаа эзлээрэй.

Н.Энхболд: Баярлалаа. Би дэмжиж байгаа энэ хуулиудыг. Зүгээр ийм юм хэлэлцүүлгийн явцад хэлэлцэх эсэх шүү дээ. Хэлэлцүүлгийн явцад Тэмүүлэн даргаа 28.2.1 гээд заалт байна. Улсын хөрөнгө оруулалтын салбарт тусгуулах төсөл, арга хэмжээний саналыг санал боловсруулах бүх шатад олон нийтэд хэлэлцүүлсэн байна гэж. Энэ дотроо энэ ялангуяа батлан хамгаалах салбартай холбоотой тусгай чиг үүрэгтэй байгууллагуудын зарим хөрөнгө оруулалт гэх мэтчилэн юмнуудыг жоохон ялгаатай хэлэлцдэг тийм дэг юм уу, нэг газар зохицуулалт хийхгүй бол бид нар энэ жил, хойтон жил цэргээ ингэх гэж байгаа, тэгэх гэж байгаа, тэрийгээ ингэх гэж байгаа, тэгэх гэж байгаа гээд яриад байдаг юм бол бараг байдаггүй дээ.

Тэгэхээр үүнийг бас хэлэлцүүлгийг анхаараарай л гэж хэлэх гэж байна. Бусдыг нь бол дэмжиж байгаа. Бүх л улс оронд ийм байдаг. Тоо дүнгээрээ нийт хөрөнгө оруулалтын төдөөс доошгүй хувь нь юу гэдэг юм батлан хамгаалах салбарт энэ тэр гэж ярьдаг л болохоос биш, дотор нь бид нар тэгэх гэж байгаа, ингэх гэж байгаа гэж юмнууд ярьдаггүй. Тэгэхээр энийг хэлэлцүүлгийнхээ явцад анхаараарай гэж хэлж байгаа юм.

Л.Мөнхбаатар: Гишүүд үг хэлж дууслаа. Одоо санал хураалт явагдана. Тэмүүлэн гишүүний төсвийн шинэчлэлтэй холбогдуулж боловсруулсан энэ хуулийн төсөл бараг шууд батлагдахаар хуулийн төсөл байна даа тээ. Нийтдээ 32 гишүүн санаачилж буй хамтдаа өргөн барьсан ийм хууль байгаа. Санал хураалтыг явуулъя. Гишүүд суудлаа эзлээрэй.

Байнгын хорооны саналаар Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хууль тогтоомжийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ирээдүйн өв сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслүүд болон тогтоолын

хавсралтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

55.6 хувиар санал дэмжигдлээ.

Төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлж байна. Дараагийнхаа асуудал оръё.

12.39 цаг

“Олон улсын иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай конвенц”-д нэгдэн орсныг соёрхон батлах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Борхүүгийн Дэлгэрсайхан танилцуулъя. Таныг индэрт урьж байна.

Б.Дэлгэрсайхан: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдөр өргөн мэдүүлсэн агаарын хөлгийг хууль бусаар булаан, юу юм уу айн уучлаарай.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 06 дугаар сарын 26-ны өдөр өргөн мэдүүлсэн “Олон улсын иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай конвенц”-д нэгдэн орсныг соёрхон батлах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд

нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцэн шийдвэрлэж, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.14.3-т заасны дагуу хуулийн төслийн анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн.

Хууль зүйн байнгын хороо 2023 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаараа Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Энхбаяр хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах нь зүйтэй гэсэн зарчмын зөрүүтэй саналыг томьёолон гаргасныг хуралдаанд оролцсон гишүүд санал нэгтгэйгээр дэмжсэн болно.

“Олон улсын иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай конвенц”-д нэгдэн орсныг соёрхон батлах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Олон улсын иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай конвенц”-д нэгдэн орсныг соёрхон батлах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулах талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Дэлгэрсайхан гишүүнд баярлалаа. Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Их Хурлын гишүүн байна уу. Алга байна.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Зарчмын зөрүүтэй 1 санал байна. Гишүүд байраа эзэлье. Санал хураалт явуулъя. Гишүүд байраа эзэлье. Буцаах санал хураалт байна. Байгаа байгаа.

Эрүүгийн хуульд оруулж байгаа нэмэлт, өөрчлөлтийг нь буцаая гэсэн саналын томьёолол байгаа юм.

Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Чинбатын Ундрамын урилгаар Сэлэнгэ аймгийн Зүүнхараа хотын 2 дугаар сургуулийн 1983 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүгдэд ажил, хөдөлмөрийн өндөр амжилтыг хүсэн ерөөе.

Санал хураалт явуулах уу. Санал хураалт явуулъя. Зарчмын зөрүүтэй 1 санал байгаа. Энэ зарчмын зөрүүтэй саналыг би уншиж танилцуулъя.

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Олон улсын иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай конвенцод нэгдэн орсныг соёрхон батлах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр гэсэн байна. Санал хураалт явуулъя.

Хууль санаачлагч буюу Засгийн газарт нь буцаах санал байна.

Монгол Ардын намын бүлгийн дэд дарга Улсын Их Хурлын гишүүн Батжаргал горимын санал гаргая.

Ж.Батжаргал: Би сая буцаах саналыг дэмжсэн юм. Тэгээд эсрэг гарч байна. Тийм учраас санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулж өгөхийг хүсэж байна.

Л.Мөнхбаатар: Батжаргал гишүүний гаргасан горимын саналын дагуу санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Санал хураалт.

Жигжидийн Батжаргал гишүүний гаргасан горимын санал 53.3 хувиар дэмжигдлээ. Саналын томъёоллыг уншиж танилцуулсан. Санал хураалтыг явуулъя. Санал хураалт.

53.3 хувиар санал дэмжигдлээ.

Санал дэмжигдсэнтэй холбогдуулан гарч байгаа Улсын Их Хурлын тогтоолын төслийг танилцуулъя.

“Хуулийн төсөл буцаах тухай”, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.10 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Олон улсын иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай конвенцод нэгдэн орсныг соёрхон батлах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг буцаах нь зүйтэй гэсэн Байнгын хорооны санал, дүгнэлт гаргасныг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай.

Тогтоол батлагдсанд тооцлоо.

Эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Алга байна. Дараагийн асуудалдаа оръё.

12.49 цаг

“Агаарын хөлгийг хууль бусаар авах үйлдлийг хориглох тухай конвенцын нэмэлт протокол”-ыг соёрхон батлах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Борхүүгийн Дэлгэрсайхан танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Б.Дэлгэрсайхан: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдөр өргөн мэдүүлсэн “Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенцын нэмэлт протокол”-ыг соёрхон батлах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцэн шийдвэрлэсэн.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.14.3-т заасны дагуу хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн болно.

Хууль зүйн байнгын хороо 2023 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаараа Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрийн үгүй ээ, Баттөмөрийн Энхбаярын төслийг

хууль санаачлагчид нь буцаах нь зүйтэй гэсэн зарчмын зөрүүтэй саналын томьёолол гаргасныг хуралдаанд оролцогчдын гишүүд санал нэгтгэйгээр дэмжсэн болно.

“Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенцын нэмэлт, өөрчлөлт протокол”-ыг соёрхон батлах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуулийн өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг, зарчмын зөрүүтэй саналыг та бүхэн хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенцын нэмэлт протокол”-ыг соёрхон батлах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Дэлгэрсайхан гишүүнд баярлалаа. Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Байхгүй байна.

Байнгын хорооноос гарсан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Саналын томьёоллыг уншиж .

Улсын Засгийн газраас 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенцын нэмэлт протокол-ыг соёрхон батлах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн

Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр. Санал хураалт.

60.5 хувиар санал дэмжигдлээ.

Санал дэмжигдсэнтэй холбогдуулан гарах Улсын Их Хурлын тогтоолын төслийг танилцуулъя.

“Хуулийн төсөл буцаах тухай” Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.10 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенцын нэмэлт протокол”-ыг соёрхон батлах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг буцаах нь зүйтэй гэсэн Байнгын хорооны санал, дүгнэлт гарсныг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай.

Тогтоол батлагдсанд тооцлоо. Олонх дэмжсэн учраас. Эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Дараагийнхаа асуудалд оръё.

12.54 цаг

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ганибалын Амартүвшин танилцуулъя. Таныг индэрт урьж байна.

Г.Амартүвшин: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 06 дугаар сарын 2-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 06 дугаар сарын 9-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж анхны хэлэлцүүлэг бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Төсвийн байнгын хороо 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу явуулж хуулийн төслийн зүйл бүрээр нь хэлэлцсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Өнөрболор Шинэ сэргэлт аж үйлдвэрийг дэмжих бодлогын хүрээнд эрчим хүчний эх үүсвэрийг нэмэгдүүлэх асуудлыг дэмжиж байгаа хэдий ч түүхий нүүрс ашиглах асуудлыг дэмжихгүй цаашид эрчим хүчний эх үүсвэрийг нэмэгдүүлэх, дэвшилтэт технологи, ногоон санхүүжилт зэрэг олон арга зам байгаа тул иргэдийн эрүүл, аюулгүй байдлыг хангах зорилгоор хот, хөдөөгийн ялгамжтай байдлаар зохицуулах нь зүйтэй гэсэн саналыг хэлсэн.

Улсын Их Хурлын гишүүн Өнөрболор төслийн 1 дүгээр зүйлийн дараа тайлбар хэсэг болгож үйлдвэрлэх гэдэгт нийслэл Улаанбаатар хотод түүхий нүүрс болон стандартын шаардлага хангаагүй түлшийг ашиглах тохиолдолд энэ заалт хамаарахгүй гэж нэмэх зарчмын зөрүүтэй санал гаргасан боловч Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд хуулийн төслийн заалтын үг, өгүүлбэрийн дараа бие даасан агуулга бүхий үг,

өгүүлбэр нэмэхийг хориглосон тул зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хураалгаагүй болно.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Өнөрболор хуулийн төслийг төсөл санаачлагчид буцаах горимын санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй болно.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлт та бүхэнд хүргүүлсэн.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсан баярлалаа.

Л.Мөнхбаатар: Амартүвшин гишүүнд баярлалаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Эрчим хүчний сайд Баттогтохын Чойжилсүрэн, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Бямбарагчаагийн Тэлмүүн, Эрчим хүчний яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Батмөнхийн Ерэн-Өлзий, Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Зоригийн Мөнх-Оргил, Эрчим хүчний яамны Хуулийн хэлтсийн дарга Лувсандоржийн Мөнхжаргал, Эрчим хүчний зохицуулах хорооны зохицуулагч Пүрэвжавын Товуудорж, Эрчим хүчний зохицуулах хорооны Үнэ тарифын газрын

дарга Базарваанийн Эрдэнэбулган нар оролцож байна.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Өнөрболор гишүүнээр тасаллаа. Өнөрболор гишүүн асуултаа асууя.

Д.Өнөрболор: Энэ Аж ахуйн нэгжийн орлогын албан татвартай холбоотой энэ хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж ирэх энэ хууль бол орж ирсэн. Тэгээд Байнгын хороон дээр би бас тодорхой саналуудаа хэлсэн байж байгаа. Сая илтгэгчийн танилцуулгад бол миний хэлсэн дэмжихгүй байгаа шалтгаануудыг бол бас тодорхойлж хэлж байна. Би энэ байр сууриасаа ухраагүй байгаа.

Миний хувьд бол би дахиад хэлэхэд энэ “Шинэ сэргэлтийн бодлого” болон Хөдөөгийн сэргэлт, энэ Боомтын сэргэлтийн хүрээнд авч байгаа энэ эрчим хүчний эх үүсвэрийг нэмэгдүүлэх бодлогын том агуулгыг бол миний хувьд бол дэмжиж байгаа.

Харин нэг гараараа яг энэ нийслэлийн хүн амын амьдралын чанарыг сайжруулна, агаарын бохирдлыг бууруулна гэж баахан хөрөнгө зарчхаад тэгээд нөгөө гараараа үүнийхээ эсрэг Улаанбаатарт утаа үйлдвэрлэхээр орж ирж байгааг л би дэмжихгүй байгаад байгаа байхгүй юу. Гишүүд маань энэ дээр бас анхааралтай хандах хэрэгтэй байна. Нөгөө 200 яндан чинь бол мянга болохоор орж ирж байна. Улаанбаатарт үйлдвэрлэж байсан дөнгөж энэ сайжруулсан шахмал түлш рүү ингээд шилжээд байсан энэ асуудал маань буцаад түүхий нүүрс рүүгээ шилжих ийм нөхцөл Улаанбаатарт утаа үйлдвэрлээд бид нар 5, 10 жилийн өмнө хоолой хорсоод үнэхээр амьдарч болохоо болилоо гэдэг ийм шүүмжлэлийн энэ асуудал дээр бол бодлогоосоо ухарч Эрчим хүчний яам ийм асуудал оруулж ирж байна. Энийг би дэмжихгүй байгаа юм.

Өнөөдөр Монгол Улсад агаарын бохирдлоос шалтгаалсан жилд дунджаар 4 000 гаруй хүн нас барж байна. Харвалт, зүрх судасны өвчлөл, уушгины хавдар, амьсгалын замын өвчний шалтгаан болж байна. Уушгины хатгалгаагаар нас барж байгаа хүүхдүүдийн дийлэнх нь агаарын бохирдлоос үүдэлтэй гэж судалгаа гарч байна. 100 000 хүн тутамд ноогдох агаарын бохирдлоос шалтгаалсан нас баралтын тоо 132 буюу дэлхийн дунджаас 1.4 дахин их байна.

Тэгэхлээр Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сангаас хийсэн энэ судалгаагаар агаарын бохирдлоос үүдэлтэй хүүхдийн өвчлөлд өнөөдөр 24.8 тэрбум төгрөгийн Улаанбаатар хотод зарцуулах шаардлага үүсэж байна гэсэн ийм судалгаануудыг гаргасан байна.

Тэгэхлээр би энэ энэ эрүүл мэндийн энэ өндөр зардал, дундаж наслалт, энэ архаг өвчлөл бууруулахын эсрэг ийм бодлого гаргаж байгаа учраас би энийг бол дэмжихгүй байгаа юм.

Тэгээд энэ миний яриад байгаа зүйл бол энэ хот, хөдөөгийн ялгамжтай байдлаар бүгдээрээ энэ асуудалдаа хандъя. Хэрэв энэ хот, хөдөөгийн ялгамжтай байдлаар шийдэгдэхгүй яг энэ чигээрээ батлагдах юм бол өнөөдөр Монгол Улсын хувьд олон улсын гэрээ, конвенцын амлалтаас буцаж байгаа шийдвэр болж байна гэж бол үзэж байна.

Тиймээс ер нь энэ уур амьсгалын өөрчлөлтийн тухай Нэгдсэн Үндэстни Байгууллагын суурь конвенц, тэнд нийцүүлсэн бодлогоосоо ухарч байгаа бол салбарын сайд нь нэртэйгээр нь ер нь Парисын хэлэлцээрээс бид нар гаръя гээд хэлчих нь бол би зүйтэй гэж харж байна.

Тийм учраас энэ нийслэлд шинээр баригдах энэ дулааны эх үүсвэрт түүхий нүүрс ашиглах, түүний хэрэглээнд татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үйлчлэхгүй байх энэ хязгаарлалтыг тавих нэн шаардлагатай байгаа. Би өнөөдөр

бүтээн байгуулалтын салбарт ажиллаж байсан хүн. Би энэний эсрэг аж ахуйн нэгжүүдээ дэмжихгүй байх ямар ч шалтгаан байхгүй надад. Гол нь юу яаж байна гээд тэгэхлээр өнөөдөр энэ утаа чинь бүр арай дэндлээ. Бид нар агаарын бохирдлыг бууруулах асуудал дээр бол нэг зарчимтай явж байгаа шүү дээ. Олон улс ч амлачихсан байж байгаа, үндэснийхээ хэмжээнд ч энэ бодлогыг шат шатдаа хэрэгжүүлээд явж байгаа.

Тэгээд яагаад өнөөдөр Эрчим хүчний яам энэ технологийн шийдэл энэ их боломжууд өнөөдөр дэлхий дээр байсаар байтал заавал түүхий нүүрсээр тэгээд 1.5 мегаваттаас дээш нүүрсний эх үүсвэр бүхий энэ яндантай яндан зуухнуудыг, дулааны станцуудыг өнөөдөр Улаанбаатар хотод утаа үйлдвэрлэхээр ингэж оруулж ирээд байгаа юм бэ? Би энийг ойлгохгүй байгаа учраас би дэмжихгүй байгаа юм.

Тийм учраас гишүүд энэ дээр бол бас анхааралтай хандахыг уриалж байна.

Нийслэл ер нь бол энэ асуудлыг эсвэл би энэ хурал даргалагчаас эсвэл энийг Байнгын хороо руу буцаагаад шилжүүлж өгөөч.../минут дуусав./

Л.Мөнхбаатар: Асуултад, асуултад хариулъя. Өнөрболор гишүүний асуултад Эрчим хүчний сайд Чойжилсүрэн хариулъя.

Б.Чойжилсүрэн: Улсын Их Хурлын гишүүдийнхээ өдрийн амрыг эрье.

Өнөрболор гишүүн жоохон буруу ойлгоод байх шиг байна. Энэ асуудал юу вэ гэхлээр 1.5 мегаваттаас дээш хүчин чадалтай дулааны станц барьсан тохиолдолд гаалийнх нь татварыг чөлөөлье, үндсэн хөрөнгөд бүртгэгдэх, НӨАТ-ыг нь 4 жил хойшлуулъя гэсэн ийм л асуудал. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар бол ийм тоног төхөөрөмжийг дотооддоо үйлдвэрлээд, импортлох биш

дотооддоо үйлдвэрлэх юм бол 90 хувийн хөнгөлөлт үзүүлье гэсэн ийм л өөрчлөлт орж ирж байгаа юм.

Өнөрболор гишүүн бол магадгүй энэ утаатай тэмцэхийн төлөө бүх Монголчууд, Засгийн газар ажиллалгүй яах вэ. Одоо яг бодит байдлаар ОХУ-аас Хятад руу нийлүүлэгдэх хийн хоолой хамгийн сайндаа, хамгийн хурдандаа, хамгийн ээргээр бодоход яг ажил хэрэг болох нь бол 2029 он, 2030 он хүртэл болох нь.

Энэ хооронд бид нар хүссэн ч байсан хүссэн ч нүүрсээ түлнэ. Ондoo арга байхгүй. Дулаан өвөлжих өгөх ёстой. Дээр нь утаагүй өвөлжих өгөх ёстой. Экологийн хувьд 2 шаардлага байгаа.

Тэгэхээр энэ хооронд бид нар 1.5 мегаватт гэдэг босго тавьсан нь энэ ойролцоогоор 200 орчим айлыг халаах хүч хүчин чадал. 200 яндан зэрэг ажиллаад агаар мандалд хорт хий ялгаруулах, эсвэл энэ 200 янданг цуглуулаад нэг жижиг дулааны станц болгоод энэ нь шүүлтүүр тавиад бүрэн чадалтай болсон тохиолдолд 10 дахин буурч байгаа юм. 200 айлыг 20 айлтай тэнцэх хэмжээний л болгоно гэсэн үг. Утааг бүрэн нүүрс түлж байсан тохиолдолд шийдэж чадахгүй. Аргаа барсан арга.

Энэ байдлаар бид нар ямар ч байсан дундын шилжилт хийгээд 2030 онд тэр газтай, бүрэн газтай болсон үед энэтэйгээ золгоё гэсэн ийм л бодлого байгаа юм. Түүнээс биш бүгдийг нь бол өргөс авсан юм шиг шийднэ гэж ярьж чадахгүй. Олон нийтэд бас зөв хүлээлт өгсөн нь дээр байх.

Тийм учраас гишүүд минь энэ бодит байдлыг зөв ойлгож дэмжиж өгөөч ээ. Би Өнөрболор гишүүнийг бас дутуу ойлгоод байх шиг байна. Уул нь 2 ч удаа тайлбарласан. Ямар шалтгаан байгааг ойлгохгүй байна. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Тодруулах юм уу. Өнөрболор гишүүн тодруулж асууя.

Д.Өнөрболор: Би буруу ойлгож байна уу, эсвэл сайд маань өөрөө өнөөдөр энэ эрчим хүчнийхээ салбарт реформыг хийхийг зорихгүй байгаа нөхцөл байдлаар гацаасан хэлбэрээр зохицуулалт хийх гэж байна уу гэдгийг намар, энэ өвөл бид нар үр дүнг нь харах байх даа гэж би бодож байна.

Тэгэхлээр бол та, би бол бас энэ бүтээн байгуулалтын салбарт ажиллаж байсан хүний хувьд бол яг одоо энэ гаргаж байгаа шийдвэртэй холбоотой энэ хуулийн зохицуулалт дээр бол маш сайн ойлгож байгаа, маш сайн ойлгож байгаа. Тэгээд энэ үр дагаврыг бол яг энэ хууль би ахиад хэлэхэд энэ хууль яг ингээд батлагдаад явах юм бол өнөөдөр Монгол Улс эрчим хүчний салбарт маш ухарсан бодлого гарна. Энэ өвчин, эмгэг асуудлууд бол ерөөсөө ч юу гэдэг юм буурахгүй. Тэгэхлээр утаа үйлдвэрлэнэ гэдэг нь бол маш тодорхой.

Тэгээд би бол энэ Байнгын хороон дээр бол маш тодорхой л зүйл хэлсэн юм. Үндсэндээ нүүрсийг түлэхгүй байя, бид нар түүхий нүүрсийг түлэхгүй байя л гэж байгаа шүү дээ. Тэрнээс сайжруулсан шахмал түлшний асуудал яриагүй би.../минут дуусав./

Л.Мөнхбаатар: Зочин танилцуулъя. Монгол Улсын Их Хурлын дарга Гомбожавын Занданшатарын урилгаар Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын сургуулийн 28 дугаар төгсөлтийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэнд Улсын Их Хурлын дарга Гомбожавын Занданшатарын нэрийн өмнөөс болон Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс та бүгдийн ажил, хөдөлмөрт амжилт, сайн сайхан бүгдийг хүсэн ерөөе.

Тодруулгад хариулъя. Эрчим хүчний сайд Чойжилсүрэн хариулъя.

Б.Чойжилсүрэн: Өнөрболор гишүүн буруу ойлгоод байх шиг байна. Нүүрсний эх үүсвэрээр барих станцуудад сайжруулсан шахмал түлшнүүдийг хэрэглэнэ. Одоо өнөөдрийн байдлаар Улаанбаатар хотод 182 орчим уурын зуух гэж нэрлэдэг ийм дулааны станцууд байна. Багануурын нүүрс түлж байгаа. Энийг ямар ч байсан эхний ээлжид шахмал түлш рүү шилжүүлэх энэ бодлогын ажлууд хийгдээд явж байна судалгаа нь.

Тэгэхээр ингэж гуйвуулж ойлгож хэрэггүй байх. 1.5 гэдэг маань сумын төвийн нэгдсэн халаалтын хамгийн дундаж жишиг хэмжээ болгож л сумын төвүүд дээр байгаа дулаан үйлдвэрлэлийн өртгийг буулгах гэж л оруулж ирсэн хэмжээ. Монгол Улс холбооны улс биш, юунитар нэгдсэн улс.

Тийм учраас хууль бүх Монгол Улсын нутаг дэвсгэр дээр жигд үйлчлэх учиртай. Ийм л зүйл гишүүд минь зөв ойлгоорой.

Л.Мөнхбаатар: 13 цаг болсон байна. Чуулганыг түр завсарлуулъя. 14 цагаас Байнгын хорооны зарчмын зөрүүтэй саналаар санал хураалтаар үргэлжилнэ. Тийм, зарчмын зөрүүтэй санал дээр үг хэлж болно, үг хэлж болно. 14 цагаас чуулганы нэгдсэн хуралдаантай.

13.22 цаг

*Пүрэв гараг 22 Зургаадугаар сар 2023
Төрийн ордон “Их хуралдай” танхим
14 цаг 23 минут.*

**ҮДЭЭС ХОЙШИХ НЭГДСЭН
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ**

Л.Мөнхбаатар: Үдээс хойших чуулганы нэгдсэн хуралдаан эхэлснийг мэдэгдье.

Байнгын хороо хэлэлцэж байгаа асуудлаараа үргэлжилнэ.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууссан.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Зарчмын зөрүүтэй 1 санал байгаа.

Энэ зарчмын зөрүүтэй санал дээр дэмжсэн, дэмжээгүй үг хэлж болно. Тийм, тэгээд би зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг танилцуулаад орхиё.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол, Төсвийн байнгын хороо дэмжээгүй санал байна.

1.Хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Өнөрболор. Тийм, Төсвийн байнгын хороо дэмжээгүй санал гэдгээ хэлсэн, хэлсэн байгаа.

Ганболд гишүүн үг авах юм уу. Кнопоо дар. Өнөрболор гишүүнээр тасаллаа. Гочоогийн Ганболд гишүүн үг хэлье. Зарчмын зөрүүтэй саналтай холбогдуулж.

Г.Ганболд: Хуулийн төслийг бол дэмжиж байгаа. Одоогийн нөхцөл байдалд манайхан нүүрснээс өөр дулааны эрчим хүчний эх үүсвэр бага л даа.

Тэгэхдээ хавтгайруулаад ингээд 1.5 мегаваттын дулааны станцад тэгээд бүгд дээр нь ингээд адилхан юм шиг тавивал бас өөрөө учир дутагдалтай байгаа юм.

Яагаад гэхээр энэ станцууд чинь Хятадын сүүлийн үеийн технологиуд

ямар ч дэгдэмхий гаргахгүй ийм зуухнууд байна.

Гэтэл одоо хоцрогдсон технологитой Варнобол ч гэдэг юм уу, хуучны юу гэдэг юм ... хийгээд эхлэх юм бол энийг яг дэмжих үү, үгүй юү гэдгийгээ тодорхойлохгүй бол тухайн дулааны станц нь нүүрснээсээ бас шалтгаална. Нүүрсний илчлэг, тортог, үнслэг энэ болгонд нь тохируулж бас оруулж ирэх зуухандаа технологийн стандартын бас норм хэдий хэмжээний дэгдэмхий гаргаж байгаа тохиолдолд дэмжих юм бэ гэдгийгээ бас дараа нь хэрэгжүүлэх явцдаа тодорхойлохгүй бол бүгд дээр нь хавтгайруулж тавих юм бол энэ бас дутагдалтай болно.

Тэгээд энэ дээр бас сайд хууль хэрэгжүүлэх явцад дагаж журам гарах юм уу. Энэ дээр анхаарах ёстой байх гэж бодож байна.

Л.Мөнхбаатар: Өнөрболор гишүүн үг хэлье.

Д.Өнөрболор: Миний хувьд яг энэ тухайлсан асуудал дээр бол зарчмын зөрүүтэй санал гаргаад байгаа юм. Тэгээд яагаад ер нь энэ саналыг ингээд хэлээд байгаа юм бэ гэхлээр би бас Ганболд гишүүнтэй бол санал нэг байна. Энэ ахиад би энэ гишүүддээ хэлэхэд Шинэ сэргэлтийн бодлого, энэ Хөдөөгийн сэргэлт, Хөдөөгийн сэргэлт энэ Боомтын сэргэлт энэ эрчим хүчний эх үүсвэрийг нэмэгдүүлэх энэ том агуулгын бодлыг бол миний хувьд дэмжиж байгаагаа би илэрхийлээд байгаа юм. Энэ том бодлоготой зэрэгцээд өнөөдөр Улаанбаатар хотод түүхий нүүрсний утаа үйлдвэрлэх бодлого давхар орж ирээд байгааг л би эсэргүүцээд байгаа байхгүй юу.

Тэгээд надад бол ямар нэгэн ашиг сонирхол байхгүй ээ. Тэгээд энэ ашиг сонирхол дээр тулгуурлаж би бас угаасаа байр сууриа ч илэрхийлдэггүй.

Ер нь бол энэ бол зарчмын асуудал. Бид нар өнөөдөр мөнгө олж болно. Гэхдээ ард иргэдийнхээ эрүүл мэндийг хорлож мөнгө олж болохгүй гэдгийг бол би бас хатуу хэлмээр байна.

Өнөөдөр Монгол Улсад агаарын бохирдлоос шалтгаалаад жилд дунджаар 4 000 гаруй хүн нас барж байна. Харвалт, зүрх судасны өвчин, уушгины хавдар, амьсгалын замын өвчний шалтгаан болж байгаа. Тэгээд энэ уушгины хатгалгаагаар нас барж байгаа хүүхдүүдийн дийлэнх нь өнөөдөр агаарын бохирдлоос үүдэлтэй гэж байгаа юм. 100 000 хүн тутмын 1 өнөөдөр тутамд ноогдох агаарын бохирдлоос шалтгаалсан нас баралтын тоо бол өнөөдөр дэлхий дээр өнөөдөр бид нар дунджаас 1.4 дахин их байгаа. Тэгэхлээр бодит байдал ийм л ноцтой нөхцөл байдалд байгаад байна шүү дээ.

Тийм учраас энэ нийслэлийн ард иргэдийн аюулгүй орчинд амьдрах эрхийг бид нар хангуулах ийм л эрх ашиг байна л гэж миний хувьд байр сууриа илэрхийлээд байгаа юм.

Тэгээд хэрэв байна шүү дээ гишүүд ээ анхааралтай энэ дээр бас ингээд анхаараад өгөөч ээ. Энэ чигээрээ батлагдах юм бол өнөөдөр Монгол Улсын хувьд олон улсын гэрээ, конвенцын шийдвэрээс буцаж байгаа ийм шийдвэр болж байгаа юм нэгт.

Хоёрт төрөөс өнөөг хүртэл агаар энэ орчны бохирдлыг бууруулахад зарцуулсан хөрөнгө, хэрэгжүүлсэн мөнгө, үр дүн ерөөсөө огт үр дүнгүй болж байгаа юм.

Гуравт нийслэлийн иргэд, хүүхдүүдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх зөрчигдөж, агаарын бохирдлоос үүсэх энэ нас баралт, архаг өвчлөл бол өнөөдөр гамшгийн түвшинд гүнзгийрэх ийм нөхцөл байдалтай байгаа.

Тиймээс энэ нийслэлд шинэ баригдах гэж байгаа дулааны эх үүсвэрт

миний санал бол маш энгийн байгаад байгаа юм. Түүхий нүүрс ашиглахгүй байхыг л зориод байгаа юм шүү дээ. Тэгээд энэ түүхий нүүрс ашиглахгүй хот, хөдөөгийн ялгамжтай байдлаар, технологийн хувьд дэвшилтэт, байгаль орчин, ард иргэддээ ээлтэй байдлаар шийдэх нөхцөлийг л оруулж ирэх хэрэгтэй байгаа юм.

Тийм ч учраас би энийг хууль санаачлагчид ингээд буцаагаад арай ч Эрчим хүчний яам жоохон бодлоготой, бодлогоо шинжлэх ухаанчаар, технологитой, шийдэлтэй ингэж оруулж ирээч ээ. Ичмээр юм. Гишүүд та бүгд маань ч гэсэн бас энэ дээр анхааралтай хандаж энэ хууль санаачлагчид буцааж Байнгын хорооны дэмжигдээгүй саналыг та нарыг дэмжиж өгөхийг хүсэж байна. Энэ тэглээ гээд унаж байгаа асуудал биш шүү дээ. Буцаад л энэ ахиад тодорхой хэмжээгээр ялгамжтай байдлаар, шийдэлтэйгээр оруулж ирээч л гэсэн асуудал. Тэрнээс түүхий нүүрсийг нүүрсээр утаа үйлдвэрлээч гэдэг асуудлыг л битгий битгий оруулж ирээч л гэдэг асуудал шүү дээ.

Тэгэхлээр энэ дэмжигдээгүй саналыг та бүгдээс дэмжиж өгөөч гэж хүсэж байна. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Санал хураалт явуулна. Гишүүд үг хэлж дууслаа.

Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал байна.

Хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн Улсын Их Хурлын гишүүн Өнөрболорын санал байгаа. Ингээд Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

51.3 хувиар санал дэмжигдлээ.

Өнөрболор гишүүн яах юм горимын санал гаргах гэж байгаа юм уу та. За.

Д.Өнөрболор: Тийм, дарга би горимын санал гаргая. Би бас энэ дээр юу яачхаж төхөөрөмжтэйгөө буруу харьцсан учраас энэ саналыг хүчингүй болгоод ахиад санал хураалгаж өгөөч гэж хүсье. Уучлаарай.

Л.Мөнхбаатар: Өнөрболор гишүүний гаргасан саналаар саяын санал хураалтыг, энэ чинь дэмжигдчихсэн санал дэмжигдсэн санал учраас боломжгүй юм байна нээрээ. Яагаад гэвэл унасан байх юм бол хураах боломжтой. Дэмжигдсэн санал учраас энийг санал хураалгах дэгээрээ боломжгүй юм байна.

Протоколд тэмдэглэе. Өнөрболор гишүүн өөрөө энэ саналыг гаргасан учраас протоколд тэмдэглэе. Тухайн саналыг дэмжиж санал өгсөн гэдгийг нь. Үгүй ээ биш дэмжиж санал өгье гэсэн ийм санал гаргасныг нь протоколд тэмдэглэе. Тэрнээс биш тооцохгүй. Саналд тооцохгүй тийм. Айн Өнөрболор гишүүн өөрөө дэмжсэн байсан уу түрүүн сая? Үгүй та өөрөө төхөөрөмжтэйгөө буруу харьцсан гэдэг чинь яг юу гэсэн агуулгатай юм. Үгүй ээ үгүй, тийм юм байхгүй, байхгүй. Тийм боломжгүй.

Санал хураалт дууслаа.
Дараагийнхаа асуудалд орёе.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлээ. Дараагийнхаа асуудалд орёе.

14.32 цаг

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулья.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ганибалын Амартүвшин танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Г.Амартүвшин: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 06 дугаар сарын 02-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж анхны хэлэлцүүлэг бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн.

Төсвийн байнгын хороо 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу явуулж хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг та бүхэнд хүргүүлсэн.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаар Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг

хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Амартүвшин гишүүнд баярлалаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулья. Эрчим хүчний сайд Баттогтохын Чойжилсүрэн, Эрчим хүчний яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Батмөнхийн Ерэн-Өлзий, Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Зоригийн Мөнх-Оргил, Эрчим хүчний яамны Хуулийн хэлтсийн дарга Лувсандоржийн Мөнхжаргал, Эрчим хүчний зохицуулах хорооны дарга Пүрэвжавын Товуудорж, Эрчим хүчний зохицуулах хорооны Үнэ тарифын газрын дарга Базарваанийн Эрдэнэбулган нар оролцож байна.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Баагаагийн Баттөмөр гишүүнээр тасаллаа.

Баагаагийн Баттөмөр гишүүн асуултаа асууя.

Б.Баттөмөр: Эрчим хүчний байдал Монголд хүнд байгаа. Монголын эрчим хүчний суурилагдсан хүчин чадал 1 500, 1500 000 мегаватт гэдэг биз дээ тийм ээ. 1570-аад мегаватт, суурилагдсан хүчин чадал бол ер нь дөхчихсөн. Энэ жил бол маш өндөр тийм үзүүлэлт гаргасан. Тэгэхээр энэ 2024 онд Монгол Улсыг хөгжүүлэх төлөвлөгөөнд бол бид нар ярьж байгаад Эрчим хүчний юунд нэлээн томоохон өөрчлөлтүүдийг хийхээр оруулсан байгаа. Энэ өөрчлөлтүүдийг бид хийх нь зүйтэй гэж.

Энэ тарифын хуульд бол яах вэ 4 жил хүртэл хугацаагаар, эсвэл татварыг 4 жилийн хугацаанд хэсэгчлэн төлүүлэх

шийдвэрийг Засгийн газар гаргаж болно гээд ингэж оруулж ирж байгаа юм байна.

Чойжилсүрэн сайд бид нар энэ дээр чинь ингээд шийдвэр гаргалаа гэхэд Үндсэн хуулийн цэц чинь энэ дээр хууль тогтоомж зөрчжээ, Үндсэн хууль зөрчжээ гээд шийдвэр гаргачих магадлал байхгүй, та нар тооцож үзсэн үү. Та бол энэ асуудлыг маш сайн мэдэж байгаа шүү дээ тийм ээ. Шатахууны асуудал дээр гаргасан юуг Үндсэн хууль зөрчсөн гэдэг шийдвэр гарсан. Та энийг хүлээн зөвшөөрөөд л анх баталчхаад дараа нь хүлээн зөвшөөрөөд ингээд яваад байгаа. Сая Төсвийн байнгын хороон дээр. Энэ дээр чинь ийм юм гарах эрсдэлүүд байна уу. Та нар энийг юу гэж тооцож байгаа вэ.

Хэрвээ Үндсэн хууль зөрчсөн гээд Үндсэн хуулийн цэц ийм шийдвэр гаргах юм бол ийм хэрэггүй юм бид нар батлаад хэрэггүй шүү дээ. Үндсэн хуулийн цэцээсээ санал авч байж хуулиа баталдаг юм уу, яадаг юм. Энийг тооцож үзсэн үү гэсэн асуулт байна. Энд хариулаач.

Л.Мөнхбаатар: Баттөмөр гишүүний асуултад хариулья. Эрчим хүчний сайд Чойжилсүрэн хариулья.

Б.Чойжилсүрэн: Баттөмөр гишүүний асуултад хариулья.

Баттөмөр гишүүнээ одоо энэ Гаалийн тарифт зохицуулалтын хуулиараа 2 жил хүртэл хойшлуулах бололцоо байгаа юм. Манай эрчим хүчний салбар өөрөө хүндрэлтэй байгаа учраас мөнгөн урсгалд нь дэмжлэг болох үүднээс 2 жил байгаа харилцааг 4 жил болгоё гэсэн ийм л зохицуулалт өөрчлөлт байгаа юм. Ер нь бол НӨАТ-ын тухайд.

Бусад асуудлаар бол энэ Үндсэн хуулийн эрх нь байгаа. Ямар ч хууль дээр ямар ч үед иргэд гомдол гаргаж болох байх. Тэр нь ингэж тэгнэ ийм эрсдэл байна, хаана гэсэн тийм бололцоо, хэлэх бололцоо байхгүй.

Л.Мөнхбаатар: Тодруулах уу та. Баагаагийн Баттөмөр гишүүн тодруулж асууя.

Б.Баттөмөр: Тэгэхээр ер нь хууль батлахдаа энэ гарч болох эрсдэлүүдийг их сайн тооцох ёстой л доо. Тэгэхээр та нар яг ийм эрсдэл Үндсэн хууль дээр очоод гарах ийм эрсдэлийг бол тооцоогүй, гарч болзошгүй, гарвал тухайн үедээ шийдээд явна гэсэн гэж тэгж ойлгох уу. Чойжилсүрэн сайд хариулт өгөөч.

Л.Мөнхбаатар: Чойжилсүрэн сайд тодруулгад хариулъя.

Б.Чойжилсүрэн: Тийм ээ Баттөмөр гишүүнээ. Яг ямар ч Улсын Их Хурлын шийдвэр дээр, ямар ч цаг үед Монгол Улсын иргэн гомдол гаргах эрхтэй Үндсэн хуулийн цэцэд. Цэц ямар шийдвэр гарахыг урьдчилан мэдэхгүй. Цэц шийдвэр гаргасан тохиолдолд Их Хурал хүлээж авдаг журамтай. Тэр ёстой тухайн үедээ л шийдэгдэх асуудал. Иймэрхүү таны ярьж байгаа эрсдэл байхыг үгүйсгэхгүй.

Л.Мөнхбаатар: Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Батсүхийн Саранчимэг, Энхтайвангийн Бат-Амгалан нарын урилгаар Баянзүрх дүүргийн иргэдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүгдэд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс ажил, амьдралд нь сайн сайхан бүгдийг хүсэн ерөөе.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүллээ.

Санал хураалт байхгүй. Эцсийн хэлэлцүүлэгт шилжүүлж байна. Одоо дараагийнхаа асуудалд орёе.

Эмийн үнийн өсөлтийн шалтгаан нөхцөлийг хянан шалгах асуудлаар Хянан шалгах түр хороо байгуулах тухай Улсын Их Хурлын, долоо дээр чинь юу байгаа тийм ээ.

Боловсролын хууль Дамдинням гишүүнийхээ гаргасан горимын саналын дагуу чинь долоо дээр чинь одоохон. Боловсролын ерөнхий хуулийг хэлэлцэнэ. Хэлэлцэх асуудлын 7 дахь асуудлыг хэлэлцэж эхэлье.

Боловсролын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Гонгорын Дамдинням танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Г.Дамдинням: Улсын Их Хурлын гишүүн дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 06 дугаар сарын 24-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Боловсролын ерөнхий хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2023 оны 05 дугаар сарын 04, 16-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцэж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын Байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаан даргалагчаас гүйцээн

боловсруулах чиглэл өгсний дагуу Байнгын хороо Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-т заасныг баримтлан 6 санал хураалт явуулсан бөгөөд хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн.

Түүнчлэн Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т заасныг баримтлан хуулийн төслийн зарим зүйл, заалтаар дахин санал хураах шаардлагатай гэж Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 3-ны 2-оос доошгүйг нь үзсэн тул ажлын хэсгийн 2 санал болон Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэнгээс гаргасан боловсролын сургалтын байгууллагад судлах гадаад хэл нь сургалтын үндэсний хөтөлбөрийн үзэл баримтлалд заасан хэл байна гэсэн агуулга бүхий зарчмын зөрүүтэй саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн.

Харамсалтай шийдвэрийг гаргасан алдааг манай Улсын Их Хурлын Ардчилсан намын бүлгийнхэн, Ардын намын бүлгийнхэн, Хүн намын төлөөлөл, бие даагчдын төлөөлөл бүгдээрээ 9 дэх санал хураалт дээр эсрэг санал хурааж авч үлдэх, ардын хүүхдэд Англи хэлийг өгөх энэ шийдвэрийг дэмжиж өгнө гэдэгт итгэлтэй байна.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг хуулийн төсөлд тусган эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулга, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын гишүүн дарга, эрхэм гишүүд ээ,

Боловсролын ерөнхий хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Ирц, үгүй ээ харин ирцгүй болчихоод байна. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Боловсрол шинжлэх ухааны сайд Лувсанцэрэнгийн Энх-Амгалан, Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд Ганболдын Ганбаяр, Боловсролын ерөнхий газрын дарга Төмөр-Очирын Ням-Очир байна уу энэ хүмүүс нь? Боловсрол, шинжлэх ухааны яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Огнонгийн Хуягцогт хаа байна. Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Санхүүгийн хэлтсийн дарга Алтаньямын Мөнх-Оргил байхгүй байна. Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Сургуулийн өмнөх боловсролын хэлтсийн дарга Жадамбын Мягмар, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Боловсролын нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын шинжээч Жамцын Нарантуяа, Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга Пүрэвдоржийн Бат-Эрдэнэ хаана байна? Байна уу Бат-Эрдэнэ? Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн секторын эрхлэгч Ухнаагийн Туяа байна уу. Энэ ажлын хэсгийн гишүүд чинь ер нь байгаа хүн байгаа юм уу. Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн захирал Төмөрпүрэвийн Намнан хаа байна. Шинжлэх ухааны академийн Философийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, шинжлэх ухааны доктор, профессор Шажинбатын Ариунаа байна уу. Алга байна. Боловсрол, шинжлэх ухааны яамны Хууль зүйн хэлтсийн ахлах шинжээч Чимэдрэгээний Баярмаа, Боловсрол, шинжлэх ухааны яамны Боловсролын нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Арьяагийн Цолмон, Боловсрол, шинжлэх ухааны яамны Мэргэжлийн боловсрол, сургалтын хэлтсийн дарга Авирмэдийн Халиунаа, Боловсрол шинжлэх ухааны

сайдын орон тооны бус зөвлөх Дарьсүхбаатарын Билгүүдэй, Монголын боловсрол, шинжлэх ухааны үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга Замбалын Цогтгэрэл, Цогтгэрэл байна уу. Алга байна. Монголын хувийн хэвшлийн бага, дунд сургуулиудын холбооны тэргүүн Наранцэцэгийн Номин, Хувийн цэцэрлэгийн үүсгэн байгуулагчдын холбооны тэргүүн Алтангэрэлийн Цэнгэл, Цэнгэл гэж байна уу? Хүн байна уу. Монголын оюутны холбооны ерөнхийлөгч Ганхуягийн Анударь, “Бүх нийтийн боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвслийн ерөнхий зохицуулагч Дондогдуламын Тунгалаг. Энэ ажлын хэсгийн гишүүдийн ихэнх нь алга байна шүү.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан асуулт асуух Их Хурлын гишүүд байна уу. Гомпилдоогийн Мөнхцэцэг, Ундрам, Чинбатын Ундрам гишүүнээр тасаллаа. Содномын Чинзориг гишүүн асуултаа асууя.

С.Чинзориг: Хоёр, гурван зүйл тодруулъя. Энэ яах вэ Байнгын хороон дээр бас би бас нэлээн ярьсан юм. Үндсэн хуульдаа ерөнхий боловсролыг үнэ төлбөргүй олгоно гэсэн Үндсэн хуулийн заалттай, төрөөс тавьсан нөхцөл, шаардлагыг хангаж байгаа бол ерөнхий боловсролыг хувийн хэвшил бас гүйцэтгэж болно гэсэн ийм Үндсэн хуулийн заалттай.

Тэгэхээр энэ хууль маань Үндсэн хуулийн энэ заалттай хэр нийцэж байгаа вэ гэдгийг би эртүүд Байнгын хороон дээр ярьсан. Тэгээд тодорхой ойлголт авч чадаагүй л дээ. Ингээд ярихлаар манайхан мушгиад байгаа юм. Хувийн хэвшлийг дэмжихгүй юм уу гээд. Би хувийн хэвшлийг дэмжихгүй гэж ярихгүй байгаа шүү дээ. Үндсэн хуульд заасан ерөнхий боловсролыг үнэ төлбөргүй олгоно, хувийн хэвшил ерөнхий боловсрол олгож болно. Гэхдээ төрөөс тавьж байгаа тэр нөхцөл, шаардлагыг хангаж байгаа бол гэсэн.

Тэгээд тэр төрөөс тавьж байгаа тэр ерөнхий боловсролыг хувийн хэвшил гүйцэтгүүлж болно гэж байгаа тэр төрөөс тавьж байгаа нөхцөл, шаардлага гэдэг нь ямар ойлголт байна? Энэ хуульд ямар юм орж ирж байгаа юм бэ гэдгээ л тодруулаад байгаа юм. Тэрнээс би бол энэ хувийн хэвشلээр гүйцэтгүүлнэ гэдгийг эсэргүүцээд байгаа юм биш л дээ. Тэгээд одоо энэ хуулийн чинь 6 дахь зарчмын зөрүүтэй санал 43.2 дээр орж ирж байгаа юм. Хувьсах зардлаар нь зохицуулна гээд. Хувьсах зардлаар нь энэ хувийн хэвшлийн ерөнхий боловсролын олгож байгаа хувийн хэвшлийн сургуулиудын сургалтын төлбөрийг ер нь энэ иргэдийн амьжиргааны түвшинтэй холбогдуулж бас зохицуулдаг тийм нэг шаардлага зайлшгүй байна л даа. Боломжтой айлын хүүхдүүд нь хувийн хэвшлийн сургуулиуд сураад илүү бас боловсрол, чадавх эзэмшээд байдаг. Энэнээс чинь үүсээд энэ иргэдийн дунд боловсролын ялгаа, тэгш бусын ялгаа гараад байгаа юм л даа. Тэгээд энийг ярихлаар тэгээд хувийн хэвшлийг дэмжихгүй байгаа юм шиг ингэж бас яриад, мушгиад байгаа юм. Тэр Үндсэн хуульд байгаа. Төрөөс тавьж байгаа тэр нөхцөл, шаардлага гэдэг нь ямар юм байна? Энэ хуульд юу орж ирж байгаа юм бэ гэдгийг нэг тодруулж өгмөөр байгаа юм.

Хоёр дахь асуудал нь энэ орж ирсэн хууль дээр Англи хэлийг тухайлсан заалт орж ирсэн. Энийг бол би ажлын хэсгийн гишүүний хувьд анх ажлын хэсэг дэмжээд явсан. Байнгын хороон дээр энэ чинь нөхцөл байдал өөрчлөгдлөө гээд бид нар Англи хэлийг эсэргүүцээд энийг унагасан юм биш шүү дээ. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж гарсан. Нэг хэлийг тухайлан хуульд оруулах нь учир дутагдалтай байна, геополитикийн бодлого байна. Тийм учраас бол Англи хэлийг үндэсний хоёр дахь хэл болгоно гэдэг энэ заалтаа өөрчилъе, гадаад сургалтын байгууллагууд судлах гадаад хэл нь сургалтын үндэсний хөтөлбөрийг үзэл

баримтлалд заасан хэл байна гээд ингээд оруулья гээд ингээд л дээрээс зөвлөмж өгөөд л, чиглэл өгөөд л Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж гарсан гээд л ингээд л Байнгын хороон дээр энэ санал унаад тэгээд энэ Англи хэлийг бол тэр хөтөлбөрөөрөө, сургалтынхаа хөтөлбөрөөр зохицуулж болно гээд л ингээд л явсан шүү дээ.

Тэгэхээр чинь ажлын хэсгийн ахлагч нь өөрөө ингээд хувийн тоглолт хийгээд Байнгын хороон дээр ч тэгсэн ардын хүүхэд Англи хэл сурч болдоггүй юм гээд л. Сая Байнгын хорооны дүгнэлтийг чуулганы индэр дээрээс уншихдаа ч гэсэн бас ардын хүүхдүүдэд Англи хэлийг сурах боломжийг нь олго, Ардчилсан нам дэмжиж байгаа, бие даагч нар дэмжиж байгаа гээд ингээд попроод хувийн тоглолт хийгээд байх юм уу? Ингээд ажлын хэсгийн ахлагч нь хувийн тоглолт хийгээд нэг их ардын хүүхдийг дэмждэг хүн болоод, бусад нь ардын хүүхдийг дэмждэггүй хүн болоод ингээд байгаа учраас би бол энэ удаагийн хэлэлцүүлэгт оролцох боломжгүй гэж бодож байна. Ингэж хувийн тоглолт хийх юм уу, бидэнд ч бүгдээрэнд нь үндэс .../минут дуусав./

Л.Мөнхбаатар: Үгүй ээ үгүй асуултад хариулсны дараа тодруулж болно.

Та яах юм асуултад хариулт авах юм уу. Содномын Чинзориг гишүүний асуултад хариулья. Хэн хариулах вэ? Ажлын хэсгийн ахлагч Гонгорын Дамдинням хариулья.

Г.Дамдинням: Чинзориг гишүүний асуултад хариулья. Манай Чинзориг гишүүн манай ажлын хэсгийн гишүүн, бас Байнгын хорооны гишүүн л дээ. Тэгээд яах вэ Байнгын хороон дээр бас ямар мэдээлэл явсныг би сайн мэдэхгүй. Хэрэвзээ ямар нэг бичгэн хэлбэрээр гарсан зөвлөмж гарсан бол ажлын хэсгийн даргын хувьд надад харуулах ёстой, үзүүлэх ёстой миний

ойлгосноор бол Монгол хэлний ач холбогдлыг дэмжих чиглэлээр л гарсан юм байна гэж ойлгосон. Ийм байгаа.

Тэр Англи хэлтэй холбоотой асуудал дээр бол энэ Засгийн газрын өргөн барьсан төсөл шүү дээ. Ажлын хэсэг дээрээс юу ч нэмээгүй, Засгийн газраар ороод 2 ч удаа орсон, тэгээд дараа нь Монгол Ардын намын бүлгээр 2 удаа ороод дэмжигдээд, Байнгын хороогоор дэмжигдээд, Улсын Их Хурлын гишүүн нэгдсэн чуулганаар дэмжигдээд эцсийн хэлэлцүүлэгт орж ирсэн ийм л заалт л даа. Тэгээд гишүүд бас өөрсдөө ойлгоно биз дээ.

Эхний асуултын тухайд бол төрөөс тавьсан нөхцөл шаардлага гэж Зөвшөөрлийн тухай, Боловсролын тухай хуульд заасан шаардлагыг ойлгоно. Төслийн 21-23 дугаар зүйл байгаа юм. Тэгээд Зөвшөөрлийн тухай хуулийн ажлын хэсгийнхэн болон Ганхуяг гишүүн болон энэ бусад ажлын хэсэгт ажилласан Их Хурлын Тамгын газрынхантай бид нар уулзаж манай ажлын хэсгийнхэн энийгээ тохируулж оруулж ирсэн байгаа юм. Тэгээд бүгдэд л асуудалгүй л байгаа л даа. Тэгээд энэ нэмэлт хариултыг нь Энх-Амгалан сайд өгчихнө биз дээ.

Л.Мөнхбаатар: Та Энх-Амгалан сайдыг хариулсны дараа авах уу. Тодруулья Чинзориг сайд тодруулж асууя.

С.Чинзориг: Хэрвээ тэр Үндэсний аюулгүй байдлын зөвлөмж нь гарсан бол тэр зөвлөмжийг нь дагаад л энэ Их Хурлын гишүүд ажилламаар байгаа юм. Нэг хэсэг нь тэр Үндэсний аюулгүй байдлын зөвлөмж гарсан юм гээд тэгээд байр сууриа илэрхийлдэг, нэг хэсэг нь болохлоор ингээд хувийн тоглолт хийгээд ардын хүүхдийг Англи хэл үзэхийг энэ хэдэн нөхдүүд эсэргүүцэж байна гээд ингээд хувийн тоглолт хийгээд. Байнгын хорооны дүгнэлт уншихдаа Байнгын хорооноос байгуулсан ажлын хэсгийн ахлагч нь өөрөө индэр дээрээс ардын

хүүхдийг дэмжиж байна, Ардчилсан намынхан дэмжиж байгаа, бие даагч нар дэмжиж байгаа эд нар гэж ийм ярьж байдаг ёс зүйгүй ажлын хэсгийн ахлагч байж болохгүй шүү дээ.

Тийм учраас бол би энэ ажлын хэсгийнхээ ахлагчийг сольж байж дараагаар нь энэ хуулиа цааш явуулах асуудал ярих нь зүйтэй гэж бодож байна. Ер нь Ардын намын бүлэг энийгээ завсарлага авч ярих хэрэгтэй. Яагаад тэр Үндэсний аюулгүй байдлын зөвлөмжтэй гэж бид нарт тийм чиглэл өгч эсрэг санал гаргуулсан юм, яагаад ажлын хэсгийн ахлагч нь тэрийг нь эсэргүүцээд ингээд ардын.../минут дуусав./

Л.Мөнхбаатар: Содномын Чинзориг гишүүний тодруулгад нэмж хариулъя. Боловсрол, шинжлэх ухааны сайд Лувсанцэрэнгийн Энх-Амгалан хариулъя.

Л.Энх-Амгалан: Одоо гишүүд ээ тоглоом тоотой нь дээр ээ Чинзориг гишүүн ээ, Засгийн газрын гишүүн ээ. Одоо ингээд энэ Засгийн газраас өргөн барьсан энэ Боловсролын ерөнхий хуулиар чинь ганцхан Англи хэлний асуудал шийдэх шийдээгүй шүү дээ. Энэ чинь ерөөсөө сая Чинзориг сайдын ярьсан энэ хувийн сургууль, төрийн сургуулиудын ялгаа, хотын сургууль, хөдөөгийн сургуулиудын ялгааг арилгах гэж байгаа л ийм л зарчим орж ирж байгаа шүү дээ. Өнөөдөр сүүлийн 30 жилд бид нар үнэхээр энэ боловсролын чанарын ялгаа чинь нийгэмд баян, хоосны ялгаа үүсгэчихсэн, өдөөдөг. Боловсрол нь өөрөө энэ баян, хоосны ялгаа өдөөдөг ийм тогтолцоо болчихоод байна шүү дээ. Тэгэхээр бид нар энэ энэ сургуулийн хөдөөгийн сургууль, хотын сургууль, хувийн сургууль, төрийн сургуулийн ялгааг бид нар яаж арилгах юм. Бид нар санхүүжилтээр нь л арилгана шүү дээ.

Тийм учраас энэ Боловсролын ерөнхий хууль дээр чинь бид нар 5 том шинэчлэл хийх гээд байгаа асуудал шүү

дээ. Тэрнээс биш нэг хууль дээр бүр тэр тусмаа Боловсролынхоо ерөнхий хууль дээр, яг энэ Засгийн газраас өргөн барьсан хууль дээр тэд дүгээр ангиас нь тэдэн цагаар энэ хэлийг.../минут дуусав./

Л.Мөнхбаатар: Энх-Амгалан сайд гүйцээгээд хариулчих.

Л.Энх-Амгалан: Тийм. Одоо тэгээд энэ Боловсролын хуулийн ингээд энэ ач холбогдлыг зүгээр ингээд ийм Англи хэлний хэрүүл болгоод хэн нь ард түмэндээ хайртай вэ гэдэг ийм уралдаан болгоод дуусгаж болохгүй л дээ. Энэ бол санхүүжилтийн тогтолцоо нь шинэчлэгдэж байгаа юм. Сургууль, цэцэрлэгийн засаглалыг бид нар улс төрчдийн гараас ангилуулж мэргэжлийн тогтолцоо руу шилжүүлж байгаа юм. Энэ Монгол Улсад боловсролын чанарыг ийм түвшинд хүргэсэн энэ хуурамч үнэлгээний тогтолцоо, дүнгийн тогтолцоог халж байгаа юм. Багшийн багшаа бэлддэг энэ тогтолцоо, багш төгсөж очоод ажлын байран дээрээ тасралтгүй хөгжих, сайн багш хамгийн өндөр цалин авдаг, хамгийн сайн нийгмийн баталгаагаар хангагдах энэ тогтолцоог бид нар бас шинэчилж байгаа юм, хөтөлбөрөө шинэчилж байгаа юм. Хөтөлбөр хоцорчихсон уу хоцорчихсон.

Тэгээд цаашдаа хөтөлбөрөө бид нар шинэчлэхдээ ингээд Засгийн газар бүхэн гарч ирэхэд сайд бүхэн гарч ирдэг энэ хөтөлбөрийн шинэчлэлийг ярьдаг биш хөтөлбөр хамгийн багадаа 10-12 жилийн ийм тогтвортой хөтөлбөр хэрэгждэг болъё гэдэг энэ эрх зүйн баталгааг энэ хуулиар бид нар хийж өгч байгаа юм. Одоо тэр хот, хөдөөгийн сургуулийн ялгаа, хувийн сургууль, төрийн сургуулийн ялгааг бид нар арилгаж, хүүхэд хаана сурч байна, хаана амьдарч байгаагаасаа үл шалтгаалаад хамгийн сайн Монголын хамгийн сайн багшаар хичээл заалгах энэ боломжийг бид нар энэ цахим шилжилтээр олгож өгч байгаа юм. Ийм л 5 том шинэчлэлийн хүрээнд хийж байгаа энэ шинэчлэлийг энэ чинь хэдэн удаа нэг

Ардчилсан намын бүлэг завсарлага авлаа. Одоо Ардчилсан намын бүлэг ингээд 2 бүлэг хоорондоо завсарлага аваад одоо ингээд энэ хууль чинь 2 жил энэ Их Хурал дээр байж байна шүү дээ. Үнэхээр л өдөр тутам бид нар хүүхдийнхээ хүүхэд бүрд тэгш боломж олгох гэж байгаа, хүүхэд бүрд багаас нь тэр чанартай Англи хэлний боломж олгох гэж байгаа бол энэ хууль 1 хоногийн өмнө ч юм уу батлагдах нь энэ Монголын ард түмэнд ач тустай гэж би бодож байгаа. Монголын ирээдүйд ач тустай гэж бодож байгаа. Одоо энэ тоглоом бүр тоотой нь дээр шүү дээ.

Ингээд Их Хурлын гишүүд нь хуулиа бүтэн уншихгүй байж байж. Зарим нь 1 дүгээр ангиас Англи хэл заахаар боллоо гээд иргэдийг бухимдуулаад байдаг. Зарим нь 3 дугаар ангиас заах гэж байсан чинь одоо болиулчихлаа гээд бухимдаад байдаг ийм хувийн аминчхан улс төрийн тоглолт бид нар хийж болохгүй шүү дээ. Энэ чинь хэзээ хууль дээр хэзээ аль ангиас, аль хичээлийг хэдэн цагаар заадаг аль улсын хууль дээр ийм зохицуулалт байсан юм. Бид нар үндэснийхээ хөтөлбөр дээр Англи хэлийг 3 дугаар ангиас нь заана, гадаад хэл Англи хэл хоёрдогч, анхдагч хэл байна гэдгийг чинь Үндэсний хөтөлбөр дээрээ бид нар заагаад өгчихсөн байна шүү дээ. Үндэсний хөтөлбөр дээрээ бид нар 3 дугаар ангиас мэдээлэл технологийн хичээл, Английн хичээлийг Англи хэлний хичээлүүдийг дэлхийн түвшинд хүрсэн шилдэг платформоор заана гэдэг энэ хөтөлбөрийг чинь бид нар ингээд батлаад явж байна шүү дээ. Өнөөдөр бид нарт лоозон чухал юм уу, тунхаглал нь чухал юм уу. Өнөөдөр яг хүүхэд өнөөдөр яг Англи хэлтэй болгох тэр дэлхийн түвшний математикийн байгалийн ухааны хичээлийг тэр олон улсын хөтөлбөрийн түвшинд үзэх энэ боломжуудыг олгох нь чухал юм уу гэдэг энэ асуудал дээр бид нар өнөөдөр шийдвэр гаргах л ийм л цаг болж байна шүү дээ. Одоо энэнээс цаашаа энэ Боловсролын хуулийг ингэж хоцроож болохгүй ээ болохгүй. 2 жил бид нар

хэлэлцүүлэг хийнэ шүү дээ. Үндэсний хэмжээний хэлэлцүүлэг хийлээ шүү дээ. Өөр яах юм 2 жил гаруй. Одоо ингэж болохгүй шүү дээ. Одоо ингээд бүх Монголын 1.2 сая хүүхэд тэрний цаана байгаа 3.4 сая хүний хувь заяатай холбоотой шийдвэр дээр бид нар ингэж гоомой хандаж болох юм уу?

Л.Мөнхбаатар: Сая Чинзориг гишүүн бас хэд хэдэн зүйлийг хөндөж ярилаа. Би энэ Боловсролын ерөнхий хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулаад би бас нэг зүйлийг хэлье.

Байнгын хорооны санал, дүгнэлт гэдэг бол тухайн асуудлыг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны даргын гарын үсэгтэй ийм танилцуулга бэлтгэгдэж Улсын Их Хурлын гишүүн индэр дээрээс уншигддаг ийм зүйл байгаа. Энэ саяын Байнгын хорооноос гарын үсгийн даргатай батлагдсан энэ танилцуулга, сая Гонгорын Дамдинням гишүүний хэлсэн индэр дээрээс хэлсэн үг хоёрыг нийцлийг нь шалгаад Тамгын газар надад танилцуулаарай.

Ер нь бол нийтээрээ хэлэлцэж батлагдсан энэ танилцуулгыг л уншиж танилцуулах үүрэгтэй байгаа гэдгийг сануулъя.

Ганибалын Амартүвшин гишүүн асуултаа асууя.

Г.Амартүвшин: Хэдүүлээ энэ боловсролын багц хуулиа явуулмаар байна. Ингэж нэг хэрүүл уруул болгомооргүй байна. 2, 3 жил хэдэн ч удаа энэ ажлын хэсэг нь солигдож өөрчлөгдсөн. Ингээд л нэг юмнаас болоод л хоорондоо үзэлцээд л байх юм. Энийгээ одоо болимоор байна. Яагаад гэвэл гол энэ багц хуулиараа бид нарын шийдэх гээд байгаа юм чинь энэ хувийн болон улсын сургуулиудын ялгааг л арилгаж ер нь тэгш боловсролын байдлыг үүсгэе л

гэсэн л тийм л гол санаа байгаа биз дээ. Тийм болохоор жишээлбэл энэ Англи хэлний том хэрүүл боллоо л доо. Би жишээлбэл гадаад хэлийг аль болохоор бага наснаас нь заах ёстой гэд гэдэгт би итгэдэг. Яагаад гэвэл би ч гэсэн 6 настайдаа эхний гадаад хэлээ сурч байсан. 7, 8 насандаа үргэлжлүүлээд 2,3 хэл сурч байсан. Манай ээж бол Франц хэлний багш хүн байсан.

Тийм болохоор би энэний ач холбогдлыг нь маш сайн ойлгодог хүн. Зүгээр жишээлбэл юу гэдэг юм тэр Монгол Улсын хар хайрцгийн бодлого энэ тэр ингэж ярьж байна лээ л дээ зарим нь. Яах вэ тийм байж болно. Гэхдээ нөгөө талаас яг тэр логигоор хувийн сургуулиуд, цэцэрлэгүүд чинь бүр бага наснаас нь Орос, Хятад, Англи, Япон гээд л хэл зааж байгаа биз дээ. Тэгэхлээр тэр логигоор тэгвэл тэр хувийн сургууль, цэцэрлэгүүдийг тэгвэл бас болиулах ёстой юм байна шүү дээ. Хэрвээ тэгж ярих юм бол. Тийм болохоор би бол энэ гадаад хэлийг багаас нь заах нь зөв гэж.

Харин тэрийг хэзээ, хэд хэддүгээр ангиас нь яаж заах тэр яам нь өөрөө шийдэг. Энэ гол зарчмын асуудал нь энэ байгаа. Тийм болохоор одоо ерөөсөө энэ Боловсролын багц хуулиа явуулах ёстой би сайдын хэлж байгаа үгийг зөв гэж бодож байгаа. Одоо энийг бид нар энэ чуулган завсарлахаас өмнө ер нь батлаад, ингээд хэрэгжүүлэх дээрээ илүү анхаарч ажилламаар байна. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Амартүвшин гишүүн төслийг дэмжиж явуулья гэсэн төслийг дэмжсэн байр суурьтай үг хэллээ гэж ойлголоо.

Одоо Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуултаа асууя.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр яг ийм асуудалтай холбоотой би өөрөө яг энэ тэр түүх мэдэх хүний хувьд бас ярья гэж бодож байна. Тэгэхээр 1992 онд Дээд боловсролын тухай хуульд өөрчлөлт

ороод тэрний дагуу шийдсэн юм уу, аль эсвэл хөтөлбөрөөрөө шийдэгдсэн юм уу ер нь их, дээд сургуулиудад Орос хэл заадаг байж байгаад Англи хэл заадаг болсон юм. Англи хэл.

Тэгээд 92 оны хавар тэр хууль нь батлагдаад тэгээд энэний дагуу манай улс Монгол Улсын Их Сургууль 7-хон Англи хэлний багштай байсан, 7-хон Англи хэлний багштай байсан. Би дахиад эхнээс нь ярьчихъя.

Л.Мөнхбаатар: Дэгээрээ асуулт асуух эрхтэй. Тийм учраас Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуултаа асуу. Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух дэгтэй. Тийм учраас Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуултаа асууна.

Б.Пүрэвдорж: 1992 онд Дээд боловсролын тухай хуульд өөрчлөлт ороод тэрний дагуу хөтөлбөрөөрөө шийдсэн эсэхийг би сайн мэдэхгүй байна оюутан байсан учраас. Тэгээд манай их сургууль ерөөсөө уртаашаа 7-хон багштай тэгээд тэр тухайн үед чинь дөнгөж их сургууль, төрийн өмчийн сургуулиуд л байсан. Өөр хувийн сургууль ерөөсөө гараагүй байсан. Тэгээд манай их сургууль 7-хон Англи хэлний багштай. Манай анхны төгсөгч нар бид нар манай ангийнхан л даа 11-үүлээ байсан юм. Тэгээд 93 оны 9 сарын 1-нээс тэр хавар нь хууль батлагдаад тэрний дагуу 93 оны 9 сарын 1-нээс Англи хэлийг бүх оюутнуудад заахаар ийм шийдвэр гаргаад тэрний дагуу бэлтгэл ажил гэж ерөөсөө тухайн үед байгаагүй. Тэгэхдээ бүх ангиудад Англи хэлний хичээлийг тухайн үед бүгдэд нь орсон. Бид нарыг бид нар 3 дугаар курст байж байхдаа их сургуулийн багшаар, цагийн багшаар цалин өгөөд бид нарыг ажил дээр гаргаж байсан байхгүй юу даа. Тэгээд манай ангийн 11 хүүхэд 11-үүлээ их сургуулийн багш хийгээд ингээд явж байсан. Тэгээд одоо энд сууж байна тэр манай Жавхлан сайд. Би Жавхлангийн ангид хүртэл хичээл зааж байсан.

Тэгэхээр ийм тухайн үеийн манай ухаантай бас тэр Их Хурлын гишүүд ба тухайн тэр энэ асуудлыг шийдвэрлээд хэчнээн Англи хэлний багш нарын дутагдал байсан ч гэсэн энэ асуудлыг шийдээд ингээд явж байсан. Тэгээд бүүр оюутнуудад заана гэдэг чинь маш хэцүү. Бид нар ганц хоёр буруу үг хэлдэг. Тэгэнгүүт нь нөгөө Англи хэл мэддэг оюутнууд бид нарыг шоолдог, байдгаараа нүүр улайдаг. Тэгээд л байдгаараа хичээсээр байгаад л энэ энэний ажлын ард гарч байсан юм л даа. Тэгээд манай ангийн охидууд бүгдээрээ их сургуульд багш хийж байгаа.

Тэгэхээр ер нь бид нар энэ анхандаа энэ хууль дээрээ Англи хэл хоёрдогч хэл байна гэсэн ийм заалт орж ирсэн. Тэгэхээр ер нь хөтөлбөр рүүгээ аваад энэ нь 3 дугаар ангиас нь Англи хэлний хичээл заана гээд ингээд явах нь бас зөв өө л гэж би үзэж байна. Хамгийн гол нь тэр хөтөлбөр дээрээ заавал тусгаж өгөх ёстой. Болбол хуульчилчихвал хуульчилчихвал илүү энэ зорилтынхоо төлөө бүх бүгдээрээ их зүтгэх байхгүй юу даа.

Тийм учраас энэ Англи хэлийг дэлхийн хэл болчихлоо. Бидний хүүхдүүд тухайн үед бид нарыг оюутан болж байхад юун утас, интернэт юу ч байхгүй. Тэр үед л манай ухаант ах нар энэ Англи хэлийг их, дээд сургуульд хоёрдогч хэл болгоод оруулаад, Орос хэлийг болиулаад ингээд явж байсан шүү дээ. Тийм учраас энэ Англи хэлний багш нарын чадавхыг сайжруулах тэр ажил дээрээ илүү сайн ажиллах ёстой. Тэгж байж бид нар энэ дэлхийн хэлнээс хоцрохгүй, хүүхдүүдээ ялгамжгүйгээр Англи хэл сурах тэр боломжийг нь олгох тэр ажлуудыг хийж явахгүй бол болохгүй. Бид нар тийм энэ хэл сурлаа гээд хил хязгаараа алдчихна гэж ерөөсөө байхгүй. Нэг тийм өчүүхэн бодлоос та нар хойшоо суух хэрэгтэй. Энэ Монголын тусгаар тогтнол гэдэг чинь нэг тийм жижигхэн, сажигхан зүйлээр хэврэгшдэг зүйл биш.

Тийм учраас энэ зорилтоосоо айх хэрэггүй урагшаа алхах ёстой л гэж би та бүхэнд хэлэх байна. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Пүрэвдорж гишүүн үг хэлчихлээ тийм ээ. Одоо Наянтайн Ганибал гишүүн асуултаа асууя.

Н.Ганибал: Боловсролынхоо хуулийг яаралтай хэдүүлээ хэрэгжүүлээд энэ 9 сарын 1-нээс ашиглаад, хэрэглээд явах нь зөв л дөө. Бид нарт боловсролын тал дээр маш их олон өөрчлөлтүүд энэ хуульд ороод явж байгаа. Нэн ялангуяа энэ тэгш боломжийн асуудлууд бол бид бүхний хувьд зайлшгүй хурдтайгаар шийдэж, Монголын ирээдүйд бас тэр тэгш боломжийг нь олгохын төлөө бид зорих нь зүйн хэрэг.

Мэдээж энэ хууль дээр бас гацаа үүсгээд байгаа Монгол Улсын боловсролын үндсэн гадаад хэл бол Англи хэлээ гэж зааж оруулья гэдэг энэ санал дээр зөрөлдөөд байна л даа. Тэгээд энэ саналыг унах тэр санал гаргахдаа хар хайрцгийн бодлого гэдэг үгийг ашигласан. Уг нь Монгол Улсын Улсын Их Хурал гадаад бодлогоо эцсийн байдлаар тодорхойлж томъёолоод түүнийг нь төлөөлөх эрхтэй хүмүүс нь ашигладаг болохоос Үндэсний аюулгүй байдлын зөвлөл Улсын Их Хуралд энэ асуудлыг тулгадаг ийм хууль, дүрэм бас байхгүй байх. Байхгүй байх гэж бодож байгаа. Ер нь Үндсэн хуулиараа тэгээд заачихсан байгаа.

Үнэхээр хар хайрцгийн бодлого байгаа бол Их Хурал дээр нээлттэй байх юм уу, хаалттай байх юм уу тэрийгээ ярь л даа. Тэгээд юу нь болохгүй болоод өнөөдөр нэг заалтын төлөө хар хайрцгийн бодлого гээд ийм нэр томъёолол оруулж ирээд ингээд асуудалд хандаад байгаа нь л сонирхол татаад байна. Хэн тэр бодлогыг мэдээд байгаа юм, хэн тэрийг яагаад тулгаад байгаа юм. Тэрийг нь бид нар бас мэдмээр байна шүү.

Ер нь Монгол Улс гадаад хэлийг, Англи хэлийг сурах тэр боломжуудыг хөдөө орон нутагт хэдэн багш нар маань курсээр хүрч ирээд л сураад л, Энхтайваны корпусаар сайн дурынхан очоод л заагаад тэгээд өнөөдөр Монголын хүүхэд залуучууд маань Англи хэл нь бид нараасаа 10, 20 дахин илүү хаана ч явсан замаа зөв заалгаад хоолоо олоод идэх хэмжээнд сурчихсан шүү дээ. Энийгээ л бид нар улам гүнзгийрүүлж дэлхийн хүүхдүүд болгохын төлөө энэ заалтыг өнөөдөр оруулж ирсэн байх гэж бодож байгаа юм. Бид яагаад заавал хоцрогдох ёстой юм бэ. Бид дэлхийн хэмжээнд бүх юмыг сурах шаардлагатай шүү дээ. Тэрийг нь бид нар боломжийг нь олгож өгөх нь өнөөдөр Улсын Их Хурал мөн шүү дээ. Хөтөлбөрт оруулах нь нэг хэрэг ээ хөтөлбөрт оруулах нь нэг хэрэг. Хуульдаа заагаад өгөх юм бол илүү хүчтэй болно, илүү их тэмүүлэлтэй болно. Энэ хууль үнэхээр сайн хууль болж гарна. Тийм учраас яаралтай энэ хуулиа оруулж ирсэн тэр хувилбараар нь батлах нь зөв. Англи хэлээ оруулах нь зөв гэж би бодож байна.

Л.Мөнхбаатар: Ганибал гишүүн төслийг дэмжиж үг хэллээ тийм ээ. Одоо Хассуурийн Ганхуяг гишүүн асуултаа асууя.

Х.Ганхуяг: Сайн байцгаана уу. Энэ өдрийн мэндийг хүргэе. Яах вэ Боловсролын хуулийг бид нар үндсэндээ бас сүүлийн 2 жил хэлэлцэж ирлээ. Би өөрөө ажлын хэсгийн гишүүнээр ч ажиллалаа. Зарим нэг боловсролын хуулийн ахлагчаар нь явж байна. Яах вэ энэ дээр нэг юм хэлэх гэсэн юм. Бид нар “Алсын хараа-2050” гээд хуулийг баталсан. “Алсын хараа-2050”-ийн салшгүй хэсэг нь боловсролын хууль шүү.

Яагаад ингэж байна гэхээр бид нар ямар хэмжээний үйлдвэр барих юм, хаана уурхай хийх юм, ямар зүйл хийж хөгжүүлэх юм энийг чинь салшгүй хэсэг нь хүний нөөцийн асуудал байхгүй юу. Бид нар жил болгон боловсролын салбарын хөрөнгө оруулалтыг

нэмэгдүүлээд ирж байгаа. Төсөв ч гэсэн овоо тавигддаг болсон. Энэ олон улсын түвшин хэмжээнд тавигдаж байгаа 15 хувьтай дүйцэж байгаа. Тэгээд тэр их хэмжээний мөнгийг зарцуулаад тэгээд тэрнээс гарах бүтээгдэхүүн нь ямар бүтээгдэхүүн байх вэ, ямар хүний нөөц тэрнээс бэлдэж ирэх вэ гэдгийг л өнөөдөр нэг зангилаа дээр нь ирчхээд л ингээд хэлэлцээд сууж л байна л даа. Хөтөлбөрт оруулна аа гэж манай сайд ярьж байна, яам ярьж байна. Болно.

Гэхдээ өнөөдөр манай мэдээлэл технологийн хөтөлбөр сурах бичиг бол 95-2000 оны хооронд бичигдсэн сурах бичиг ашиглаад явж байгаа. Тэгэхээр хөтөлбөрт оруулна гэдэг асуудал бол тийм онц ач холбогдолгүй л гээд юу гэдэг юм бэ дээ хоцорч явж байдаг л гэдгийг би хэлэх гээд байгаа юм. Тэгэхээр бид нар энийг хуульд оруулж өгөх ёстой юм. Энэ Англи хэлний асуудлыг. Тэгж байж тэр дээр чинь бид нар төсвөө тавина, гадаадын зээл тусламжаар шаардлагатай бол багш нараа бэлдэнэ, хөтөлбөрөө бэлдэнэ, ингэж явахгүй бол хөтөлбөрийг бэлдэнэ гэсэн байдлаар ер нь хэдэн ч жил явж чадна.

Өнөөдөр Улсын Их Хурал дээр ирчхээд Англи хэлний асуудлаа шийдэж чадахгүй байгаа байдал сайд шийдэж чадах юм уу гэдэг л асуудал байхгүй юу. Хар хайрцгийн асуудал ярьж байна. Би өөрөө олон улсын харилцааны мэргэжилтэй хүн байхгүй юу. Миний анхны мэргэжил гадаад харилцааны мэргэжилтэн. Хар хайрцгийн бодлого чинь шал өөр юм байдаг шүү. Үндэсний чин тусгаар тогтнолын гол зарчмууд тэр хар хайрцгийн бодлого гэж явдаг юм. Тэрнээс гарч ирээд попордог асуудал биш байхгүй юу. Англи хэлтэй байснаар бид нар ямар үр дүнтэй байхыг бүгдээрээ маш сайн мэдэж байгаа. Тэр нэг Англи хэлтэй гагнуурчин, Монгол хэлтэй гагнуурчин 2-ын цалингийн үнэлэмж ямар байдаг билээ. Зүгээр Англи хэлтэй таксины жолооч, машины жолооч, Англи хэлгүй жолоочийн цалингийн үнэлэмж ямар

байдаг билээ. Бид нар өнөөдөр Монгол хүний үнэ цэний асуудлыг ярьж байж зүгээр нэг байдаг хуулийн заалтыг ярилцаж байгаа юм шиг ярилцаад байгаа байхгүй юу. Харин хар хайрцгийн бодлого гэж ярьж байвал энэ заалтыг нь оруулаад дүлий дүмбэ царайлж байгаа оруулаад бид нар энийг батлаад явуулах ёстой шүү. Яах вэ магадгүй зарим гишүүдийн хооронд үл ойлголцол гарсан байж магадгүй юм шиг байна. Ажлын хэсгээс гараад Байнгын хороон дээр орж ирэхэд. Өнөөдөр яг энэ дээр бид нар дүлий дүмбэ царайлж байгаад улс эх орныхоо төлөө хар хайрцгийн бодлогынх нь төлөө энийгээ бид нар батлаад явуулах ёстой юм шүү. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Ганхуяг гишүүн бас төслийг дэмжиж үг хэллээ тийм ээ. Асуулт байхгүй гэж ойлголоо.

Одоо Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүн асуултаа асууя.

Д.Өнөрболор: Би үндсэндээ Боловсролын сайдын энэ ерөнхий хуулийн төслийг үргэлжлүүлээд явуулах ёстой гэсэн саналтай бол санал нэг байна. Гэхдээ энэ хууль дээр чинь сая энэ орж ирсэн байж байгаа энэ Байнгын хорооны нэр, томъёоллын энэ боловсрол эзэмших сургалтын хэл гэдэг дотор тийм ээ энэ 6 дугаар зүйл дээр Энх-Амгалан сайд аа, 6.6 дээр энэ боловсролын сургалтын байгууллагад судлах үндсэн гадаад хэл нь Англи хэл байна гээд ингээд ороод ирчихсэн учраас энэ дээр одоо Байнгын хорооноос өгсүүлээд л энэ ингээд энэ зарчмын маш их зөрчилдөөнүүд ингээд гарч байна гэж бол харагдаж байна л даа. Тэгэхлээр энэ өөрөө хууль дээрээ тусгахаар иймэрхүү хэлбэрээр ингээд ороод ирчихсэн байгаа учраас л энд зөрчилдөөн үүсээд байна гэж харж байна.

Миний хувьд энэ, ер нь энэ шинжлэх ухааны байгууллагууд ороогүйгээр ер нь боловсролын салбарт 2418 байгууллага байдаг юм байна. 106 гаруй мянган албан хаагчтай 1.2 сая

суралцагчтай манай Монгол Улс тиймээ. Тэгэхлээр энэ цар тахлын дараа энэ Дэлхийн эдийн засгийн форумын боловсролын 4, 0 энэ санаачилгыг бас гаргасан энэ бодлогын зөвлөмжүүдээс ингээд харах юм бол дэлхийн хөгжлийн явцад энэ шинээр бий болж байгаа маш их олон ийм ур чадваруудыг эзэмшүүлэх чухал асуудал болоод байна гэж бол харагдаад байгаа юм.

Тэгээд мэдээж би энэ ерөнхий хууль дээр ингээд уншаад үзэхлээр бол бас энэ тал руугаа чиглэсэн их олон дэвшилтэт шинэчлэлүүдийг бол бас тусгасан байна л даа. Тэр юу гэдэг юм энэ дэлхийн чиг хандлагаар аваад үзэх юм бол энэ ур чадварууд тухайлах юм бол инновацийн ч байдаг юм уу, эсвэл бүтээлч ур чадвар ч байдаг юм уу, дэлхийн иргэншлийн ур чадвар ч байдаг юм уу, технологийн ур чадвар ч байдаг юм уу, харилцааны ур чадвар гээд энэ боловсролын салбарт бол ийм цоо шинэ ийм ойлголтууд орж ирж байна л даа. Тэгээд энэ ойлголтыг нэвтрүүлэх хөл нийлүүлж алхахад наад захын хэрэгцээ бол Англи хэл. Би тэрийг бол үнэхээр санал нэг байна. Гадаад хэл нэл ялангуяа энэ Англи хэл бол ач холбогдлоороо бол маш өндөр гэдэгтэй бол ер нь хэн ч маргахгүй байх.

Нөгөөтээгүүр энэ боловсролын тэгш байдлын том гараа бол угаасаа Англи хэл. Үүнтэй ч бас хүмүүс ингээд маргахгүй байх гэж би бодож байна. Гэхдээ нөгөөтээгүүр бид нар бас бодолцох ёстой маш олон асуудлууд байгаа гэдгийг бол бас гишүүд бас хэлж байна л даа. Тухайлах юм бол шинжлэх ухаан талаасаа ч тэр, мөн сая энэ боловсролын тэгш боломж талаасаа ч хэллээ, бизнес хөгжил талаасаа ч бас бодсон, мөн геополитик талаасаа ч гэсэн аваад үзсэн цөөн хүн амтай 2 их гүрний дунд оршиж байгаа манай улсын хувьд гээд тэгэх юм бол энэ нэн стратегийн ач холбогдолтой асуудал.

Ер нь энэ хууль дээр тухайлах юм бол төрлөх эх хэл, үндэснийхээ түүх, утга

зохиолын хичээлүүдээс чухалчилж илүү өндөрт тавьж үзэх бол гадаад хэлийг боломжгүй гэж би үзэж байна л даа. Ер нь Монгол хүнийг энэ бэлтгэх дэлхийд Монгол иргэн болж ирээдүй хойч үе маань төлөвшихөд бол эх хэлнээс давсан гадаад хэл гэж бол байхгүй. Би тэгээд энийг нэг зүйл энэ хууль дээр орж ирсэн энэ Монголын үндсэн гадаад хэл гэдэг энэ нэр томъёоны утга учрыг ерөөсөө огт ойлгохгүй байна. Энийг асуучихмаар байна би.

Ер нь бол энэ заавал энийг ингэж хуульчилж өгч байснаас үндсэндээ энэ хөтөлбөрт, хөтөлбөртөө шинэчлэл хийгээд Англи хэл заах энэ багшаа бэлтгэх ажилдаа бол илүү их анхаарах нь бол чухал гэж бол үзэж байна. Энэ орон нутагт ажиллах боловсон хүчний асуудлаа та нар цэгцэлсэн юм уу? Англи хэлээр сургах ийм хүрэлцээтэй багш нар байгаа юм уу? Дээрээс нь багш бэлтгэх энэ дээд сургуулийн шинэчлэлээ энэ холбогдох төсөв, хөрөнгөө шийдсэн юм уу? Гадаад хэлний заах орчин нөхцөл, тогтолцоогоо давхар сайжруулах хэрэгтэй нөхцөл байдлаа та нар яг яаж зохицуулсан юм.

Л.Мөнхбаатар: Өнөрболор гишүүний асуултад хариулья. Хэн хариулах вэ. Боловсрол шинжлэх ухааны сайд Энх-Амгалан хариулья.

Л.Энх-Амгалан: Өнөрболор гишүүн ээ одоо бид нарын эцсийн хэлэлцүүлэг хийгээд батлах гээд байгаа хууль чинь л таны асуултад л хариулт болох гээд байгаа юм. Санхүүжилтээ шийдсэн юм уу гэж байна. Санхүүжилтийг шийдэх цоо шинэ үндсэн хувьсах зардал ер нь Монгол Улсын чинь боловсролын санхүүжилтийн хамгийн том механизм чинь ерөөсөө 1 хүүхдийн сурах хувьсах зардал шүү дээ. Тэгээд хуучин чинь 1 хүүхдийг сургадаг хувьсах зардал чинь байгууллага, сургууль, цэцэрлэг санхүүжүүлдэг ийм тогтолцоо байсан. Одоо ингээд энэ шинэ хууль маань батлагдаж гарах юм бол бид нарт

ямар боломжуудыг олгож байна вэ гэхээр хувийн сургуульд сурч байна уу, төрийн сургуульд сурч байна уу, Баян-Өлгийд сурч байна уу, Дорнодод сурч байна уу, Улаанбаатарт сурч байна уу гэдгээс үл шалтгаалаад энэ хүүхдүүдийн боловсролын чанарын ялгааг арилгах ийм уян хатан хувьсах зардлыг л бид нар хийж өгөх гээд байгаа.

Тийм учраас Баян-Өлгийд очиж Англи хэлний чанартай Англи хэл заах багшийн цалин сая төгрөгийн цалин өгчихөөр олон улсын энэ шалгалтад тэнцэхээр энэ хүүхдүүдийг бэлд гэдэг энэ үүргийг, энэ ажлыг сая төгрөг хүрэхгүй цалинтай Англи хэлний багш хийж чадах уу? Чадахгүй байсаар ирсэн учраас л өнөөдөр бид нарын энэ хот, хөдөөгийн сургуулийн ялгаа, төрийн сургууль, хувийн хувийн сургуулийн ялгаа ингэж гарсан шүү дээ. Багшийн цалин үнэлэмжийн асуудал байна.

Өнөөдөр бид нар Англи хэлээ хийгээд дэлхийн түвшиндээ хүргэе гэж байгаа бол дор хаяж энэ багш нарынхаа цалинг мянган долларын хэмжээнд хүргэж байж бид нар энэ багш нараас үр дүн шаардах ёстой шүү дээ. Тэрний эхний алхам нь энэ хуулиар хийх гээд байгаа юм. Энэ санхүүжилтийн шинэ тогтолцоогоор хийх гээд байгаа юм. Хамгийн сайн багш, хамгийн ур чадвартай багш дээр бид нар өндөр цалин өгдөг энэ тогтолцоог бид нар энэ хууль шинэ хувьсах зардлын тогтолцоогоор нь хийх гээд байгаа юм. Тэр хөдөө орон нутагт сурч байгаа хүүхдүүдэд яг энэ хувийн өндөр төлбөртэй сургуулиудад заадаг Англи хэлийг нь яг тэр платформоор нь заах гээд байгаа юм. Тэр санхүүжилтийг энүүгээр хийх гээд байгаа юм. Тэр хувийн сургуульд үзэж байгаа хүүхдүүдийн үнэтэй сурах бичгийг яг төрийнхөө хүүхдэд, ардын хүүхдэд тэгш боломж олгох гээд байгаа юм. Энийг нь бид нар хувьсах зардлаараа өгөх гээд байгаа юм. Багшаа бид нар яг олон улсын хэмжээн дээр Кэмбрижийн хэмжээнд энэ багш нараа бэлддэг, багш төгсөж очоод ажлын

байран дээр тасралтгүй суралцдаг энэ санхүүжилтийн тогтолцоог нь энэ хуулиар энэ хувьсах зардлын санхүүжилтээр өгөх гээд байгаа юм.

Урьд нь ийм ерөөсөө 1 хүүхдийн сурах хувьсах зардал дээр энэ сургалтын чанарыг дээшлүүлэх ийм санхүүжилтийн дэмжлэг ийм санхүүжилтийн тогтолцоо байгаагүй байхгүй юу. Тийм ч учраас өнөөдөр ингээд хотын сургууль, хөдөөгийн сургууль, нэг нь байгалийн ухааны лабораторитой, нэг нь лабораторигүй, нэг нь мэдээлэл технологийн лабораторитой нөгөөд нь лабораторигүй, нэг нь Англи хэлний сайн багш заадаг, нөгөөдөх нь Англи хэлний багш байхгүй ийм л ялгаа гарч байна шүү дээ.

Яагаад гэвэл санхүүжилтийн ийм тогтолцоо байгаагүй юм. Тэгэхээр энэ бүх зүйлийн бэлтгэл ажлуудыг бид нар хийх энэ санхүүжилтийн тогтолцоог сургуулийн байршил, хүүхдийн тэр тэгш боломжоос нь шалтгаалаад, хүүхдийн ялгаатай суралцах хэрэгцээг дээр нь үндэслэж бид нар 1 хүүхдийн хувьсах зардлыг олгодог энэ шинэчлэлийг л бид нар хийхээр зорьж одоо энэ хуулийн чинь амин сүнс нь энд байгаад байгаа шүү дээ.

Хуучин бид нарт ямар тогтолцоо байсан гэхээр ерөөсөө сүүлийн 15 жилд бид нар 4-5 удаагийн хөтөлбөрийн шинэчлэл хийх гэж оролдсон. Харамсалтай нь санхүүжилтийг нь бид нар шийдэж өгөөгүй, мөнгийг нь шийдэж өгөөгүй, багшаа бэлдээгүй, хөтөлбөрөө бэлдээгүй, сурах бичгээ бэлдээгүй, тэр сургуулийн орчныг нь, орчнуудыг нь сайжруулах тэр санхүүжилтийнх нь эх үүсвэрийг бид нар хийж өгч чадаагүй байсан шүү дээ.

Тэгэхээр ийм бүтнээр нь, цогцоор нь санхүүжилтийн тогтолцоо, багш бэлтгэх тогтолцоо, цахим шилжилтийн тогтолцоо, үнэлгээний тогтолцоо, засаглалын тогтолцооны асуудлыг ингээд цогцоор нь хийж байгаа Боловсролынхоо

ерөнхий хуулийн энэ гол концепцыг зөвхөн ганцхан Англи хэл тойрсон ганц заалтаар ингэж бүдгэрүүлж ард иргэдийг дунд нь ингэж хувааж талцуулах ер нь ямар шалтгаан байна. Энэ ер нь хэнд ашигтай юм бэ. Ямар улс төрчид ашигтай юм бэ.

Л.Мөнхбаатар: Энэ Энх-Амгалан сайд та өөрөө юу яах юм уу асуулт асуухад нэрээ өгсөн байх юм. Та тодруулах юм уу тээ. Өнөрболор гишүүн тодруулж асууя.

Д.Өнөрболор: Үгүй ээ уул нь би сая асуухдаа Энх-Амгалан сайдын байр суурийг дэмжиж, асуудалд хандаж, асуудлаа тодруулсан юм. Тэгээд тэгсэн чинь яах вэ бас нарийвчлаад бас тайлбар хэлэх шаардлагатай бол ингээд хэлж байх шиг байна л даа. Үндсэндээ би бол тантай бол 100 хувь санал нэг байгаа. Энэ үнэлгээний, тогтолцооны хувьд энэ шинэчлэлийг бол өнөөдөр дэлхийтэй хөл нийлүүлээд алхах ёстой гэдэгтэй санал нэг байгаа.

Гэхдээ гол асуудал чинь таны энэ багц хуулийн чинь гол асуудал нь өнөөдөр энд хууль дээр энэ Англи хэлний асуудал орж ирчхээд байгаа асуудал чинь л хамгийн том асуудал болоод зөрчилдөөн үүсгээд байна л гэж бас яахлаар. Тэгэхлээр та сайдын хувиар байр сууриа тодорхойлох нь бас зүйтэй байгаад байна л даа. Хууль дээр тусгах нь зүйтэй юм уу, эсвэл хөтөлбөртөө тусгаад явах нь зүйтэй юм уу. Хэрэв хөтөлбөртөө тусгаад явахлаар өнөөдөр сайд өөрчлөгдөх тусамд ингээд байнга энэ бодлогын асуудал ингэж өөрчлөгддөг учраас тогтвортой бодлого хангагдахгүй байна тийм учраа.../минут дуусав./

Л.Мөнхбаатар: Асуултад хариулья. Энх-Амгалан сайд хариулья.

Л.Энх-Амгалан: Өнөрболор гишүүн ээ энэ ийм байгаа юм. Бид нар энэ Боловсролын ерөнхий хуулийн эцсийн хэлэлцүүлэг хийж байгаа байхгүй юу

Боловсролын ерөнхий хуулийн. Тэгэхээр Англи хэлийг бид нар ерөнхий боловсролдоо би заах гэж байгаа гэж ойлгоод байгаа шүү дээ. Энийг залгуулаад бид нар сургуулийн өмнөх боловсрол болон ерөнхий боловсролын хуулиа бид нар ярина шүү дээ. Дараа нь бид нар Мэргэжлийн боловсролын хуулиа ярина, бид нар дараа нь Дээд боловсролын тухай хуулиа ярина. Ингээд энэ чинь багц хууль байхгүй юу. Тэр Англи хэлний зохицуулалтуудыг бид нар илүү энэ ерөнхий хуулийнхаа энэ зохицуулалт руу орж ирж ингэж энэ маргааныг уг нь тарих хэрэггүй л байсан юм. Энэ бол би ажлын хэсгийн ахлагчийг сайн ажилласан гэж үзэж байгаа. Үнэхээр сайн ажилласан. Гэлээ гэхдээ ерөнхий боловсролын, сургуулийн өмнөх ерөнхий боловсролын тухай хууль дээр байсан заалтыг энэ ерөнхий хууль руугаа татаж авчирчхаад л ингээд нэг ийм маргаан тариад байгаа л ийм л асуудал байхгүй юу. Одоо би та бүхэнд хэлье л дээ эрх эрх биш итгэх байлгүй. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөр.../минут дуусав./

Л.Мөнхбаатар: Гүйцээгээд хариулчихъя 1 минут.

Л.Энх-Амгалан: Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал энэ байна. Цагаан дээр хараар. Энэ дээр бүх түвшний боловсрол эзэмших сургалтын үйл ажиллагааны хэл нь Монгол хэл байна. Боловсролын сургалтын байгууллага судлах үндсэн гадаад хэл нь Англи хэл байна гээд энэ цагаан дээр хараар биччихсэн энэ үзэл баримтлал. Энэ үзэл баримтлалын дагуу бид нарын хийх гэж байгаа шинэчлэлээр бага боловсролын 3-5 дугаар ангид шинээр нэмэгдэх хичээл нь Англи хэл. Англи хэл нь үндсэн гадаад хэлээр заагдана. Мэдээлэл технологийн хичээл, мэдээлэл технологийн хичээл нь цахим ур чадварыг олгох ийм 2 хичээлийг бид нар 21 дүгээр зууны ур чадвар чинь энэ 2-оор

л бид нар хойшоо суучхаад байгаа юм шүү дээ.

Тийм учраас энийг бид нар 3 дугаар ангиас нь ийм ийм цагаар заагаад өгнө, заана гэдгээ ингээд энэ хичээлийн хөтөлбөрийн хуваарь чинь энэ байгаад байна шүү дээ. Тэгээд энэ хууль дээр чинь ерөнхий хууль дээр чинь ерөөсөө үндэсний хөтөлбөр хамгийн багадаа 10 жил хэрэгжиж байж дараагийнхаа хөтөлбөр лүү шилжинэ.../минут дуусав./

Л.Мөнхбаатар: Монгол Улсын Шадар сайд Чимэдийн Хүрэлбаатар асуултаа асууя.

Ч.Хүрэлбаатар: Би нэг Англи хэлтэй холбоотой л үг хэлье гэж бодож байгаа юм. Тэгээд Монгол Улс бол богинохон хугацаанд бас хөгжмөөр байна, Монголчуудынхаа амьдралыг түвшин бас нэммээр байна, ард иргэдийнхээ орлогыг бид нар нэмэх ёстой. Тэгээд Монгол Улс хөгжихийн тулд гарцаа яаж сонгох вэ гэдэг л ийм сонголт байгаа. Тэгэхээр ард иргэдийн боловсролоо л энэ Монгол Улсын хөгжлийн хамгийн гол түлхүүр байна гэж үзэж байгаа. Тэгээд яагаад Англи хэлийг тойроод ийм их том асуудал нийгэмд болоод байна гээд зарим хүн нь гайхаад байх шиг байх юм. Гайхаад байх зүйл бол энэ биш.

Англи хэл дэлхийн 53 улсын албан ёсны хэл. 53 улс, бараг ихэнх орны албан ёсны 2 дахь хэл. Дээр нь Англи хэл бол аялал жуулчлалын хэл, Англи хэл бол техник технологийн хэл, Англи хэл бол бизнесийн хэл, болж байгаа бүх арга хэмжээнүүд дийлэнх нь. Монголын хилээс гараад та нар хурал цуглаан, үзэсгэлэн экспо, бүгдэд нь яваад үз. Ямар хэл дээр явагдаж байна Англи хэл дээр.

Тэгэхээр Монгол Улс хөгжих энэ хөгжлөө түргэсгэе энэ боломжийг хурдан ашиглая гээд үзэх юм бол бид нар Англи хэл дээр онцгой ач холбогдол өгөх ёстой. Тийм учраас энэ Англи хэл дээр бид нар

онцгойлон ач холбогдол өгч, тэр битгий хэл Монголын нийгэм, ард түмэн энийг тойроод яриад байгаа юм. Бусад заалтуудыг нь мэдэхгүй ч байж байгаа байх зарим нь.

Тэгэхээр бид нар энэ дээр чухал шийдвэр гаргах ёстой. Одоо яриа нь бол үгүй ээ хуульгүйгээр явчихна хөтөлбөр ч гэдэг ч юм уу энд тэнд бичиж байгаад тэгээд явуулчихна гэж яриад байна. Тэр бол үлгэр. Хэрвээ хүүхдийн мөнгийг өгнө гэж хууль дээр байгаагүй бол хүүхдийн мөнгө өгөгдөхгүй. Хууль дээр заасан учраас олгогдож байгаа юм. Тийм учраас хэдүүлээ энэ дээр ухаан уралдуулаад ч гэдэг ч юм уу, эсвэл нэг явган заль гаргадаг ч юм уу, овжин зан гаргаж байгаад энийг тойрчихъё гэж бодоод байх шиг байна. Тийм юм байхгүй. Одоо хэдүүлээ анхнаасаа өргөн баригдахад дотор нь байсан тэр Англи хэлний тухай заалтыг хэдүүлээ эргүүлээд босгох хэрэгтэй.

Тэгэхээр би гишүүдийг энэ кноподоо гар хүргэхгүй байж байгаад Чинбүрэн гишүүний гаргасан тэр саналыг унагаах хэрэгтэй. Энэ чинь улс орноо бодох хэрэгтэй шүү дээ бид нар. Ирээдүйн хүүхдүүдийнхээ хөгжил, дэвшил сайхан амьдралынх нь төлөө бид нар шийдвэр гаргах ёстой. Магадгүй өнөөдөр бид нарын гаргасан шийдвэр 20 жилийн дараа үр дүнгээ өгөхийг үгүйсгэхгүй. Тэгээд энэ хууль гарна, багш нараа бүгдийг нь бэлдэнэ, Монгол Улсынхаа бүх сумдад энэ Англи хэлний хичээлийг заана.

Би бол бүүр 1 дүгээр ангиас нь эхлээд заах ёстой гэж үзэж байгаа. Би яах вэ Англи хэлийг их сургуульд байхдаа сурсан. Миний аялга бол тийм хатуудуу ярина. Бага хүүхдээсээ бол яг эх хэлтэйгээ адилхан юм шиг сурна шүү дээ. Тэр хүүхдүүд чинь дараа нь өчнөөн сургуульд орно, өчнөөн ажлын байранд орно, сайхан сайхан ажил хийгээд явах боломжийг нь бид нар хааж болохгүй шүү. Энэ бол хааж байна гэсэн үг.

Хэрвээ энэ хуулийг дэмжихгүй, энэ заалтыг буцааж босгохгүй бол Англи хэл хааж байгаатай яг адилхан. Тийм учраас би гишүүд ээ энэ кноп дээр ерөөсөө хүрч болохгүй шүү. Монгол Улсын үр хүүхдүүдийн ирээдүй энэ Монгол Улсын ирээдүйн хөгжил дэвшлээс өөр ямар эрхэм сонголт бидэнд байгаа юм. Бид нар тангаргаа өргөчихсөн улс төрчид шүү гэж хэлье.

Л.Мөнхбаатар: Хүрэлбаатар шадар сайд байр сууриа илэрхийлж үг хэллээ.

Одоо Лувсанцэрэнгийн Энх-Амгалан гишүүн асуултаа асууя.

Л.Энх-Амгалан: Үгүй ээ үгүй би үг хэлнэ л дээ. Гишүүнийхээ хувьд үг хэлэх гээд байгаа юм. Бас сайдын хувьд.

Тэгэхээр яг ийм л юм л даа. Сургалтын байгууллагын үндсэн гадаад хэл нь Англи хэл байна аа гэдэг энэ заалт сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын хууль дээр нь байгаа юм. Тэгэхээр энэ заалтыг бид нар ерөнхий хууль руугаа татаж авчирч маргаан тарих уу? Ерөнхий хууль гэдэг маань өөрөө юу юм гэхээр сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, мэргэжлийн боловсрол, дээд боловсролын зохицуулалтыг хийж байгаа ийм ерөнхий хууль байхгүй юу. Ерөнхий хууль.

Тэгэхээр энэ заалт дээр одоо энэ ерөнхий хууль дээрээ сургалтын байгууллагад судлах гадаад хэл нь сургалтын Үндэсний хөтөлбөрийн үзэл баримтлалд заасан хэл байна гэдэг энийг л томъёолоод л бид нар дэмжиж явж байгаа л ийм байхгүй юу. Тэгээд Үндэсний хөтөлбөрийн үзэл баримтлалд чинь өөрөө боловсролын сургалтын байгууллага судлах үндсэн гадаад хэл нь Англи хэл байна гээд ингээд би түрүүн хэлж байна шүү дээ. Цагаан дээр хараар биччихсэн байна. Яг энэ хөтөлбөрийнхөө дагуу 3 дугаар ангиас Англи хэл, мэдээлэл технологийн хичээлийг заах энэ

төлөвлөгөө, хичээлийн төлөвлөгөө гарчихсан байна. Энэ төлөвлөгөө гарчихсан байна.

Тэгээд энэ хөтөлбөр одоо тэгээд байна л даа одоо ганцхан хөтөлбөрөөр явчихаар нөгөө сайд нь солигдохоор, Засгийн газар нь солигдохоор ингээд ийм тодорхой өөрчлөлт гарчих юм биш биз дээ гэсэн ийм болгоомжлол байгаа юм. Энэ үнэн.

Гэхдээ бид нарын өнөөдрийн энэ батлах гээд сууж байгаа энэ хууль дээр чинь хөтөлбөрийн хэрэгжилт, Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт хамгийн багадаа 10 жил байна. Тэгж байж бид нар нэг хөтөлбөрөөс нөгөө хөтөлбөр рүү шилжинэ гээд. Энэнээс илүү эрх зүйн баталгаа ер нь байгаа юм уу нэгдүгээрт.

Хоёрдугаарт Үндэсний хөтөлбөрийн энэ үзэл баримтлалыг Монгол Улсын Засгийн газар батална. 10 жилийн хугацаатай, хүчинтэй. Өөрөө хууль дээрээ бид нар Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг 10 жил гээд хуулиараа бид нар баталгаажуулаад өгчихлөө. Өнгөрсөн хугацааны бид нарын гашуун сургамж юу байсан гэхээр ерөөсөө ойр ойрхон хөтөлбөрийн шинэчлэл хийх гэж зарладаг, хөтөлбөрөө бэлддэггүй, багшаа бэлддэггүй, сурах бичгээ бэлддэггүй, тэр хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилтийн тогтолцоог нь хийж өгч чаддаггүй байсан учраас л өнөөдөр лоозон болж хувирсан байхгүй юу. Өнгөрсөн 30 жилийн өнөөдрийн энэ боловсролын чанарын ялгаа чинь өнөөдрийн нийгмийн тэгш бус байдлыг өдөөчихсөн, боловсрол өөрөө нийгмийн тэгш бус байдлыг өдөөчихсөн ийм л тогтолцоо болчихоод байгаа юм.

Тэгэхээр цөмөөрөө ингэж энэ хүмүүсийг ер нь толгойг нь ингэж эргүүлэх хэрэг байгаа юм уу. Бүгдээрээ хуулиа нэг мөсөн заалт заалтаар нь уншвал яасан юм. Заалт заалтаар нь. Тэгээд ойлголтуудаа нэг болгохгүй бол нэг Их Хурлын гишүүн гарч ирээд 1

дүгээр ангиас Англи хэл заана гэж ард түмэнг үймүүлээд, нөгөө Их Хурлын гишүүн нь нөгөөдөр нь гарч ирээд 3 дугаар ангиас заахыг нь болиулчихлаа гээд хэр нь ингэж үймүүлж, талцуулах хэрэг байна уу. Энэ чинь ерөөсөө Монгол Улсын Засгийн газраас өргөн барьсан энэ хууль дээр чинь Англи хэлийг яг 1 дүгээр ангиас нь заана, 3 дугаар ангиас нь заана гэсэн нэг ч заалт байхгүй байна шүү дээ. Би ийм хууль өргөн бариагүй шүү дээ. Тэгээд хуулийнхаа заалт бүрийг уншиж энэ танхимын, энэ танхимаас хэлж байгаа энэ үг бол бүгдээрээ хариуцлага, маш их үр дагавар дагуулдаг. Бид нар сэтгэлийн эмоциор хандаж болохгүй, улс төрийн ашиг хонжоогоор бид нар үгүйсгэж болохгүй. Ойлгож байна өнөөдөр энэ 76 гишүүн бүгдээрээ Монголын ард түмний хүүхдийн хувь заяаны төлөө шийдвэр гаргана гээд бид нар тангараг өргөчихсөн. Энэ тангаргаасаа няцах нэг ч гишүүн байхгүй гэдэгтэй би итгэл үнэмшил нэг байна. Тодорхой хэлэлцүүлэг хийх нь зөв, үндэсний зөвшилцөл хийх нь зөв. Өнөөдөр Англи хэлнээс ухарчихсан Англи хэлийг заахаа болиод ардын хүүхдийн Англи хэл сурах боломжийг хулгайлчихсан нэг ч гишүүн энэ танхимд байхгүй шүү дээ. Цаашаа байх ч үгүй.

Тэгэхээр ийм байдлаар бид нар асуудалд нь ийм субъектив хэлбэрээр хандаж одоо ингээд ард түмнийг, энэ ард түмнийг нэг жаахан тайван байлгаж болохгүй юм уу. Үг бүрийн төлөө хариуцлага хүлээх ёстой бид нар. Одоо ингээд энэ хууль батлагдсаны дараа би бүүр заалт заалтаар нь энэ ард түмэнд энэ бүх мэдээллүүдийг өгнө. Тэгэхээр ард түмэн хэн нь үнэн хэлж байсан, хэн нь худлаа хэлж байсан, хэн нь цаг хугацааны ашиг хонжоо хайж байсан, хэн нь урт хугацааны ард түмнийхээ төлөө байсан юм байна гэдгийг нэг ялгаж салга.../минут дуусав./

Л.Мөнхбаатар: Энх-Амгалан гишүүн үг хэллээ.

Одоо Тогмидын Доржханд гишүүн асуултаа асууя.

Т.Доржханд: Би маш тодорхой байр сууриа илэрхийлмээр байна. Нэгдүгээрт хэдийгээр эрх барьж байгаа биш байлаа ч гэсэн Хүн намын мөрийн хөтөлбөр тодорхой заагдсан нэг зүйл байдаг. Тэр нь бол Англи хэлийг албан ёсны 2 дахь хэл болгоно гэдэг. Бид энэ байр суурь дээр хав хатуу байна. Үүнтэй холбоотойгоор 3 зүйлийг хэлмээр байна.

Нэгдүгээрт дэлхий ертөнц дээр 200-аад улс байн. Үүнээс хөгжилтэй 40 гаруй улс байгаа. Энэ дотроо 2 хуваагдаад байгаа. Том улсууд, цөөн хүн амтай жижигхэн улсууд. Том улсууд гээд тэгэхээр Америкийн Нэгдсэн Улс, Англи, Франц, Герман ч гэдэг юм уу, Испани ч гэдэг юм уу эдгээр улсууд бол өөрсдийнхөө хэлийг сураач ээ зах зээлийг бий болгодог, бизнесийг бий болгодог, түгээлтээ хийдэг, тулгадаг.

Гэтэл нөгөө талд нь Швейцар, Люксембург ч гэдэг юм уу, Финлянд ч гэдэг юм уу, Швед ч гэдэг юм уу цөөхөн хүн амтай хөгжсөн улсууд байна. Энэ улсуудын бодлого юу байдаг вэ гээд тэгэхлээр аль болох олон хэлийг хүүхдүүддээ зааж өгдөг, иргэддээ зааж өгдөг. Бид нар мэднэ шүү дээ хамгийн их 1 хүнд оногдох орлогоороо өндөрт тооцогддог Люксембург гээд тэгэхэд өөрсдийнх нь хэл нь Лаксенбург гэж гэж байдаг. Гэхдээ тэд нар албан ёсны 2 дахь хэл нь Англи хэл, Францууд орж ирэхлээр нь Франц хэл дээр санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг, Германууд орж ирэхлээр Герман хэл дээр үзүүлдэг. Ингээд 1 хүүхэд сургууль төгсөхдөө 4 хэлтэй байдаг. Гэхдээ албан ёсны хэл бол Англи хэл гэж явдаг. Ингэж дархлаагаа үүсгэдэг юм жижиг улсууд чинь. Үндэсний аюулгүй байдал ярьж байгаа бол энэ шүү, урт хугацаа ярьж байгаа бол энэ шүү.

Хоёрдугаарт Монгол Улс 3.4 сая хүн амтай, 2 том гүрэнтэй. Монголчуудын давуу тал юу юм бэ. Түүхэндээ бид нар

хурд байсан шүү дээ. Маш хурдтай юмыг зохион байгуулдаг, дэлхийн түүхийг бүтээсэн, олон улс орныг байлдан дагуулсан чинь хурд байсан шүү дээ. Өнөөдөр Монголд ингээд шинэчлэл хийхэд давуу тал юу байдаг вэ гээд тэгэхлээр бид нар маш хурдтайгаар зохион байгуулалтад орж болдог байхгүй юу. Бид нар Хятадын нэг мужид хийж байгаа тэр хурдаар бид нар хийдэг юм шүү дээ. Хятад нэг шинэчлэлийг хийхэд 15-20 жил болдог бол манайд 2-3 жил хийж болдог юм.

Ийм болохлоор хурдтайгаар энийг хийх боломж Монголчуудад байгаа 3.4 сая иргэдэд. Богино хугацаанд бид нар зохион байгуулаад Англи хэлний хөтөлбөрийг буюу хөрөнгө оруулалтыг татах хуульдаа тусгасан тохиолдолд багш нараа бэлтгэх, онлайнаар бэлтгэх, цахим технологийг ашиглах гээд бүрэн боломж нь байгаа. Энэ бол шалтгаан шүү.

Тэгэхлээр энийгээ ашиглах хэрэгтэй. Эдийн засгийн онолд хөгжлийн эдийн засаг гэж онол байдаг юм. Энэ дээр хувь хүний хүчин зүйл өндөр. Хувь хүний хүчин зүйлийг өсгөдөг юм чинь юу вэ гээд тэгэхлээр шинжлэх ухаан, технологи, эрдэм боловсрол шүү дээ. Үүний чинь суурь дэвсгэр нь юу байна вэ гэхлээр шинжлэх ухааны хэл, бизнесийн хэл, Англи хэл.

Дараагийн нэг зүйл нь юу байна гээд тэгэхлээр хэрвээ энийг хуульд тусгах юм бол ямар давуу талтай юм, тусгахгүй хөтөлбөр байдлаар тусгах юм бол ямар сул талтай юм бэ гээд. Хуульд тусгаж байж энэ чинь төсөв хөрөнгө нь тавигдана, үнэн. Сая Хүрэлбаатар сайд ярьж байна үнэн. Сангийн яам бол ингэж ажиллана. Гадаадын зээл, тусламж тэгж явдаг юм. Би 10 жил энийг хариуцаж байсан. Тэгж явдаг юм. Гаднын хөрөнгө оруулалт татахад бас ингэж явна. Хэрвээ санаж байгаа бол ноднин жил Улсын Их Хурлын гишүүн гишүүд Америкийн Нэгдсэн Улс руу айлчилсан. Сенат болон ...тай очиж уулзсан. Би ажлын хэсгийг нь

ахалж явсан. Ундрам гишүүн тэгэхэд 330 сумдад Англи хэлний багшийг авъя гээд явж байхад сөрж асууж байсан асуулт нь танайх яг ямар хэлтэй, ямар хэлийг дэмждэг юм, хуульдаа байдаг уу, үгүй юү гээд асууж байсан. Бодитой шүү дээ. Ингэж асуудаг байхгүй юу. Ингэж байж цаашаа ажил явдаг юм, ингэж байж цаашаа бид нар багш нарыгаа бэлдэх боломж нь бүрдэх юм, ингэж байж бид нар энэ ажлыг өнөөдөр эхлүүлснээрээ түүх бүтээнэ шүү. Энэ түүх өнөөдрийн 2 айлчлалаас илүү чухал шүү. Энэ түүх магадгүй ирээдүйн Монгол Улсын дархлаа байж чадна шүү.

Ийм болохлоор энэ дээр Улсын Их Хурлын гишүүн гишүүд улс төржиж байгаа юм огт биш. Гэхдээ бодлого ярих гэж.../минут дуусав./

Л.Мөнхбаатар: Доржханд гишүүн дэмжиж өгүүллээ тийм ээ.

Одоо Ардчилсан намын бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл асуултаа асууя.

О.Цогтгэрэл: Англи хэлийг бага ангиас үзэх, судлах гэдэг заалтыг Ардчилсан намын бүлгийн зүгээс бүрэн дүүрэн дэмжиж байгаа. Тэр тусмаа зөвхөн нэг үзэх, судлах гэдэг үүднээсээ биш, бүүр энийг тийм сургах тал руу нь үзэх, судлах гэдэг чинь өөрөө нэг тоон шинж чанартай, чанарын шинж чанаргүй. Харин энийг яаж яаж сургадаг болох юм. Зөвхөн үзсэн, судалсан гэдэг биш. Энэ сургадаг болох дээр чанарын үзүүлэлт рүү нь харин яаж ойртуулах юм гэдэг дээр их томоохон бодлогын асуудлууд энийг дагалдаж энэ хуулийг дагаж мэдээж гарах ёстой байх.

Ер нь энэ Англи хэл зөвхөн Монгол улс энэ хязгаарлагдмал 2 хөрштэй ялгаатай байх энэ олон нөхцөл байдлын үүднээс Монголчууд Монголын төрөл гэж байдаг Англи хэл болоод энэ мэдээллийн технологи гэдэг энэ 2 зүйл дээр бүрэн дүүрэн дэмжиж ажиллах ёстой л гэж боддог. Тэгээд мэдээллийн технологийн

дэд бүтэц, олон зүйл. Тэр мэдээллийн технологийн өөрийнх нь хэл, алгоритм үйлдлийн систем гэдэг зүйл чинь бүгдээрээ ерөөсөө Англи хэл дээр л бичигддэг.

Тэгэхээр энэ Англи хэл болоод мэдээллийн технологи гэдэг энэ 2 багана бол Монгол Улсын ирээдүйн хөгжлийн үндсэн суурь гэдэг ийм л зарчмын зүйл зүйрлэлээр санал зөрөхгүй байх л гэж бодож байна.

Ер нь Ардчилсан намын бүлэг яагаад Англи хэлийг чухалчлан бүгдээрээ бүрэн бүрэлдэхүүнээрээ дэмжих ёстой вэ гэж. Энэ дээр зөвхөн 1 намын бүлэг гэдэг үүднээс биш, энэ өөрөө манай намын үзэл баримтлалтай ч холбоотой гэж бид бүхэн боддог. Монголчууд сайн сайхан амьдрах, баян чинээлэг амьдрах, ядуучууд нь ядуурлаас гарах үндсэн арга зам бол эдийн засаг өсөх. Эдийн засаг өсөх арга замыг тэр их том төр биш, эрх чөлөөтэй иргэн хүн нь эдийн засгаа өсгөнө л гэж бид нар боддог. Эрх чөлөөтэй иргэн хүн нь эдийн засгаа өсгөнө. Тэгвэл тэр эдийн засаг өсөх тэр эрх эрх чөлөөтэй иргэн хүнд чинь тэр эрх чөлөө гэдэг чинь явсаар байгаад бусад эрх чөлөө биш, энэ боловсролоор дамжсаныг нь мэдлэгийн эрх чөлөөтэй иргэн хүн л энийг бий болгоно. Тэгээд цаашаа ахивал мэдлэгийн эрх чөлөө гэдэг чинь Англи хэлтэй л холбоотой юм байна ер нь. Явсаар явсаар байгаад энэ Англи хэл чинь бид бүгдийн сайн сайхан амьдрах, тэр тусмаа 2 хөршөөсөө ялгаатай байх, тэр тусгаар тогтнол, аюулгүй байдлын гэдэг бүх асуудал руу чинь суурь ийшийгээ ингээд явж орох нь.

Тэгэхээр үүн дээр маргалдах, хэлэлцэх хүмүүс, гишүүд бас байхгүй байх л гэж бодож байгаа. Харин зүгээр тодруулж асууя гэж бодсон зүйл. Харин үнэхээр Англи хэл дараа дараагийн үеүдэд сурахад илүү дөхөм болохын тулд тэр. Дэлхийн мэдлэгийн сан байдаг хэл рүү ойртохын тулд, харин бид нар хэлнээсээ гадна энэ үсэг, бичиг үсэг

шриффтээ бид нар өөрчлөх шаардлага яваандаа гарах уу? Ажлын хэсэг дээр энэ дээр яригдсан зүйл байна уу? Хэрэвзээ Латин хэлэнд шилжвэл цааш цаашдаа энэ дэлхийн мэдлэгийн санд илүү ойртох боломж бололцоо байдаг уу? Жишээ нь Казахстан улс 25 оноос Латинд шилжинэ гээд шийдвэр гарсан гэдэг ийм мэдээллүүд явж байдаг жишээ нь. Энэ бүхэн дээр энэ ажлын хэсэг дээр болоод энэ хуулийн хүрээнд хэлэгдсэн, яригдсан, улам илүү энэнтэй ойртох, улам ингэвэл давуу тал үүсдэг эсэх тийм судалгаа болоод нотолгоо энэ дээр яригдсан зүйл байдаг уу? Энэ тухай л харин энэ хариулт авахыг хүсэж байна.

Л.Мөнхбаатар: Хэн хариулах вэ? Ажлын хэсгийн ахлагч Гонгорын Дамдинням асуултад хариулья.

Г.Дамдинням: Цогтгэрэл гишүүний асуултад хариулья. Монгол Улс бол 5 дугаар ангиас 7 хоногт 2-3 цагаар Англи хэл зааж байна. Олон улсад бол 1-3 дугаар ангиас 7 хоногт 3-5 цаг зааж байгаа.

Латин хэлтэй холбоотой асуудал бол манай хуулийн төслийн ажлын хэсгийн хүрээний бол яригдаагүй. Тэгээд энэ бол дараачийн өөр сэдэв байх гэж бодож байна. Тийм, баярлалаа.

Л.Мөнхбаатар: Байнгын хорооны дарга Гомпилдоогийн Мөнхцэцэг асуултаа асууя.

Г.Мөнхцэцэг: Асуулт гэхээсээ илүү үг хэлэх юм. Тэгээд энэ Ерөнхий хуулийг дагаад ер нь бас хэтэрхий их улс төржилт яваад байна л даа. Тэгээд бид энэ Боловсролын ерөнхий хуулийг 2, 3 жил бараг шахуу хэлэлцэж байна. Маш олон ажлын хэсэг хуралдсан, маш олон судалгааг, суурийг үндэслэж бид нар бас энэ зүйл заалтуудыг оруулж ирсэн. Тэгээд энэ өчнөөн жил ажилласан энэ ийм хөдөлмөр ийм үнэ цэнгүй болж хувирч байгаад бас нэг харамсаж байна.

Ялангуяа би Дамдинням гишүүнийг бас хэтэрхий их ийм цөмөрсөн тийм тоглолт хийгээд байгаа юм уу гэж ингэж харж байна. Яагаад гэвэл та Байнгын хороон дарга байсан хүн, өөрөө Байнгын хороон даргаар ажиллаж байсан. Ингэж байхдаа өнөөдөр сая гэхэд л энэ индэр дээрээс санал, дүгнэлтээр ингээд үг хэлээд, нэмээд уншчихдаг ийм дэг байдаг юм уу? Та ер нь өөрөө энийг юу гэж үзэж байгаа юм?

Хоёрдугаарт энэ ажлын хэсгийг та ахлаад явж байгаа. Таныг маш хичээл зүтгэлтэй бас их идэвхтэй ингэж ажиллаж байгааг чинь хэн хүнгүй харж байгаа, ойлгож байгаа. Таны гадаад, дотоод боловсрол эзэмшсэн энэ олон боломжуудыг чинь бид нар ашиглаж бас энэ Байнгын хорооны гаргасан ажлын хэсгийг ахлуулаад ингээд явуулж байгаа гэж бас ингэж ойлгож байгаа, дэмжиж байгаа.

Гэтэл одоо энэ хууль эцэслэн батлагдаагүй байхад гарч мэдэгдэл хийж ингэж нийгмийг бас хуваан талцуулах ийм шаардлага байсан юм уу, үгүй юм уу гэж ингэж бодож байна. Гишүүд шуугилдаж байна. Аргагүй талцан хуваагдаж байна аргагүй. Яагаад гэвэл энэ хуулиа бас сайн уншаагүй байна, энэ хуульд ерөөсөө Англи хэл заах, заахгүйн тухай ямар нэгэн байдлаар Байнгын хорооноос санал, дүгнэлт гаргаад ингээд санал хураалгасан зүйл огт байхгүй. Мэдээж хэн бүхэн ойлгож байгаа. Англи хэл дэлхий хэл мөн үү мөн, дэлхийд гарах гарц мөн үү мөн. Англи хэл заах заахгүйн тухайд ямар нэгэн маргаан энд одоо огт тусаагүй. Ийм саналын томьёоллоор бид бас санал хураагаагүй та бүхэн мэдэж байгаа.

Тэгэхээр ер нь бас энэ хуулиа жоохон судалж, хуулиа бас мөн дээрээс нь бас энэ зүйл, заалтуудаа бас харж байж бас ингэж нийгэм рүү гал тавих хэрэгтэй гэж бас ингэж хэлэхийг хүсэж байна. Мэдээж бид нар бас энэ эх орныхоо

ирээдүйг энэ ингэж энэ хуулиар боомилоод байгаа зүйл огт байхгүй юм.

Тэгэхээр Байнгын хороон дээр ямар зүйл, заалтаар саналыг нь томъёоллоор санал хураасан бэ. Яагаад энэ 7, 8 гишүүн ингээд энэ саналыг дэмжсэнээрээ буруутгаад ингээд өнөөдөр нийгэмд чичлэгдээд байгаа юм бэ гэдгийг бас нийгэм мэдээж тодорхой хэмжээгээр харж байгаа байх гэж би бодож байна. Энэ 6.7 дээр л байгаа энэ заалт. Энэ заалтад юу гэж орж ирж байгаа вэ гэхээр “сургалтын байгууллагад судлах гадаад хэл нь сургалтын үндэсний хөтөлбөр үзэл баримтлалд заасан хэл байна” л гэж байгаа юм. Үндэсний үзэл баримтлалд чинь өөрөө Англи хэл байна л гээд л ингээд л байж байгаа.

Энэ ямар нэгэн байдлаар утга алдагдуулсан юм уу, энэ томъёолол дээрээ л бид нар өөрчлөлтийн саналын томъёолол гаргаж ингэж санал хураалгасан ийм явдал болсон. Үүнийг ямар нэгэн байдлаар улс төржүүлээд Англи хэлийг заах гэж байна, заахгүй гэж байна гээд ингээд ийм санал хураалт болоогүй гэдгийг албан ёсоор бас хэлэхийг хүсэж байна.

Дээр нь 1 дүгээр ангиасаа заана гэдэг юм уу, 3 дугаар ангиасаа заана гэдэг юм уу ийм томъёолол огт энэ ерөнхий боловсролын энэ ерөнхийн хууль дотор, ерөнхий боловсролын энэ ерөнхий хууль дотор огт байхгүй гэдгийг бас албан ёсоор ингэж хэлэхийг хүсэж байна.

Ер нь мэдээж Англи хэл цаашаа аваад явах энэ хууль дотор байж байгаа зүйл, заалтуудаа бид нар бас дэмжээд явна. Энэ Англи хэл заана гэдгийг бид нар бас дэмжиж байгаа шүү. Бүгдээрээ л дэмжиж байгаа. Энэ ойлголтын зөрүүгээ нэг талд нь гаргаж өгөөч ээ. Нийгмийг ингээд хэтэрхий их ингэж бугштал нь ингэж бас галлах ямар хэрэгтэй юм бэ? Тийм.

Л.Мөнхбаатар: Асуултдаа хариулт авах юм уу. Асуулт асуусан уу. Гонгорын Дамдинням асуултад хариулъя.

Ц.Даваасүрэн: Би бас гишүүддээ хандаад нэг юм хэлчихье. Яах вэ манай парламент олон нийтэд нээлттэй байх чиглэлд их санаачилга гаргаж ажиллаж байгаа. Биднийг бол олон нийтэд зайлшгүй нээлттэй, шуурхай, тодорхой мэдээллүүдийг өгч бай гэдэг ийм чиглэлийг ч өгч байгаа. Бид ард олныг төлөөлж нийтийн дуу хоолойг илэрхийлэх үүрэгтэй.

Тийм учраас би бол энэ шинжлэх ухаан технологийн давуу талыг олон нийтэд хүрэх боломжийг олгосон энэ нийгмийн сүлжээний хэрэгсэлд бол харьцангуй идэвхтэй ажилладаг Их Хурлын гишүүн. Тэгээд тэр маань бас буруу, зөрүү ойлголт төрүүлсэн бол уучлал хүсье.

Тэгэхдээ надад ганцхан л үүрэг байгаа. Монгол Улсын Засгийн газраас өргөн барьсан Боловсролын ерөнхий хууль, түүнийг дагалдан баригдсан багц хуулиудыг Монгол Ардын намын бүлгээр оруулаад, дэмжүүлээд, дэмжүүлсэн тэр саналын томъёоллуудаа ямар нэг аргаар л энэ Их Хурлын босгыг давуулж гаргах нь ажлын хэсгийн даргын үүрэг. Би ажлаа хийгээд явж байгаа. Бид нар яах вэ тэгээд л улс төрчид бие биедээ энд янз янзын юм хэлдэг л байх. Тэгэхээр тэр дээр бол бас ойлгож шингээж хүлээж аваарай л гэж хүсье.

Миний хувьд бол буруу, зөрүү ойлгуулчихъя гэсэн ерөөсөө ямар ч бодол байсангүй шүү. Ажлаа л аваад гарчих юм сан. Боловсролын шинэчлэл маань бүтэн 2 жил хойшиллоо. 21 оны 4 дүгээр сард өргөн баригдсан хууль ингээд 2 жил гаруйн дараа орж ирж байна. Одоо ингээд бид нар нэг ганцхан жил үлдчихлээ, төсөв орж ирэх гэж байна. Ингээд энэ бүхэн дээр л яарсан хүний л, хэт их зүтгэсэн хүний л алдаа гаргасан байж магадгүй. Тэгэхдээ би бол тэрийгээ бүрэн хүлээж

авна гэж бодохгүй байна. Тэгээд тал талдаа ярьж байгаад л хэдүүлээ шийдчихье дээ тэгээд. Тэгж л хариулья.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн гишүүн Гонгорын Дамдинням болон нийт гишүүдэд хандаж бас нэг анхааруулгыг хэлье. Улсын Их Хурлын гишүүн чуулганы нэгдсэн хуралдаан бол өөрийн дэгтэй явагддаг. Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэгдэж байгаа бүх асуудал тус тусын Байнгын хороогоор хэлэлцэгдэж хамтын шийдвэр болоод албаждаг, төрийн албан хэрэг хөтлөлтийн дагуу албажиж Улсын Их Хурлын индрээс танилцуулагддаг байгаа.

Гэтэл сая одоо Дамдинням гишүүн Байнгын хорооны, Байнгын хорооны дүгнэлт уншихдаа санал, дүгнэлтийг уншихдаа өөрийн хувийн байр суурийг нэмж өгүүлбэрүүдийг бас нэмж хэлсэн байна.

Энд харамсалтай нь шийдвэр гаргасан алдааг манай Улсын Их Хурлын Ардчилсан намын бүлэг, Ардын намын бүлэг, Хүн намын төлөөлөл, бие даагчдын төлөөлөл бүгдээрээ 9 дэх санал хураалтаар эсрэг санал хураалгасан байна. Ардын хүүхдэд Англи хэлийг өгөх шийдвэрийг дэмжиж өгнө гэдэгт итгэлтэй байна гэх мэтчилэн өгүүлбэрүүдийг Байнгын хорооны албан ёсны албажсан санал хураалт дээр нэмж байр сууриа илэрхийлсэн байна.

Ер нь тодорхой Байнгын хорооны санал, дүгнэлтийг танилцуулахдаа хувийн байр сууриа илэрхийлэхгүй байхыг нийт гишүүдэд анхааруулж байна.

Чинбүрэн гишүүн асуултаа асууя.

Ж.Чинбүрэн: Энэ өдрийн мэнд хүргэе. Тэгэхлээр энэ Боловсролын ерөнхий хууль маш чухал. Өнөөдөр бид иргэдийнхээ хүүхдүүдийг хөрөнгө чинээнээс үл хамааран жигд боловсрол олгоно гэдэг бол ерөөсөө туйлын том зорилго. Тэр ч утгаараа Ундрам гишүүний

санаачлаад бага насны хүүхдийг Англи хэлний боловсролыг дэмжих лобби бүлэг байгуулья гэхэд нь хүртэл би өөрөө гарын үсэг зурж байсан хүний нэг. Өнөөдөр бид нарын ярьж байгаа зүйл бол Үндэсний хөтөлбөртөө орчихсон байгаа зүйлийг заавал хуульчлах гээд байгаа сонирхол хаана байгаа вэ гэдэг л чухал байна. Бид 200 жил Манжийн дарангуйлалд байхдаа Манж хэлийг үндсэн гадаад хэлээ болгоогүй. Тийм Монгол Улс, тийм үндэстэн.

Бид 70 жил Зөвлөлт Холбоот Улсын эдийн засаг, улс төрийн хамааралд байхдаа хуульдаа Орос хэлийг үндсэн хэл болгож батлаагүй. Энэ бол бид нарын өмнөх ахмад үеийн улс төрчдийн эх орноо, тусгаар тогтнолоо хамгаалах гэсэн энэ асар ухаан. Өнөөдөр Энх-Амгалан сайд хэлж байна Үндэсний хөтөлбөртөө орчихсон байгааг та бүхэнд бүр зураг, жишээгээр харуулж байна. Энэ нь өөрөө 10 жилээр батлагдаад, түүнийг нь хууль, эрх зүйн орчинд хамгаалах шийдвэрүүдийг нь гаргаж энэ боловсруулалт төсөлд орчихсон явна.

Тэгвэл яагаад заавал дахин энийг хуульд оруулах гээд байгаа юм, хэний ашиг сонирхол энд байгаа юм бэ? Энийг би асуумаар байгаа юм. Бид ардын хүүхдүүдийг Англи хэл сурахгүй ээ гэдэг бодолтой нэг ч Их Хурлын гишүүн энэ зааланд байхгүй. Нэг ч Их Хурлын гишүүн байхгүй.

Харин та битгий Их Хурлын гишүүдийг бусдаас ялгагдаж энийг эсэргүүцэж байгаа мэт болгооч. Би Энх-Амгалан сайдын үгийг давтмаар байна. Ард түмэнг тайван байлгаач. Бид ард түмэндээ энэ боловсролыг олгохын төлөө бүгд энд хичээн сууж байна. Энэ хуулийг явуулахын төлөө бүгд хичээн ажиллаж байна. Өнөөдөр тэр хар хайрцаг гэж юу байгаа юм гэж асууж байгаа байх. Тэгвэл дөнгөж саяхан бид Байтаг Богдын 95 жилийн тулааныг шийдвэрлэсэн тухай бид өнөөдөр ойн арга хэмжээг тэмдэглэлээ. Тэр хил дээр байсан айлууд

тонуул дээрэм, алаан хядаан байсан ч гэсэн эх орныхоо өнцөг булан бүрээс нүүгээгүй байна шүү. Энэ бол Монгол хүний зүрх сэтгэлд байдаг үндэсний хар хайрцаг, эх орноо хайрлах бодлого. Энийг би ярьсан юм. Энэ бол Монгол хүн болгоны зүрх сэтгэлд байдаг зүйлэх оронч сэтгэлийн.

Өнөөдөр хуульд байхгүй байгаа зүйлийг 1, 3 дугаар анги байхгүй зүйлийг энэ Үндэсний хөтөлбөр дотор 3 дугаар ангиас оруулна гээд бүүр хөтөлбөр нь орчихсон илтгэлийг нь сайд нь өөрөө танилцуулаад байж байна шүү дээ. Энэ зааланд сууж байгаа 70 гишүүнээс хэн нь ч Англи хэлийг ард иргэдээ, ардын хүүхдэдээ сургахгүй ээ гэдэг бодлогыг дэмжиж байгаа нэг ч хүн байхгүй. Та юу яриад байгаа юм. Жоохон хариуцлагатай улс төр хий л дээ. Бид улс төрч байж болно, бас төрийн зүтгэлтэн шүү бид. Улс эх орноо боддог төрийн зүтгэлтэн байх ёстой. Ганцхан улс төр буюу өнөөдрийн ойрын бодлын оноо авах гэсэн ийм оролдлого хэрэггүй. Намайг харлуулж болно, намайг муугаар хэлж болно би тоохгүй. Би эх оронч, эх орныхоо төлөө байнга зогсоно. Монгол түмний зүрх сэтгэлд байдаг эх оронч сэтгэл бол Монголын хар хайрцаг шүү.

Тийм учраас бид одоо энэ хуулиа дэмжээд явна. Дэмжиж явахдаа миний гаргасан бас саналыг та бүгдийг дэмжээсэй гэж бодож байна. Ингэснээрээ Монголын нэг ч хүүхдийг Англи хэлгүй болох бодлого биш, энэ угаасаа байгаа гэдгийг хариуцлагатай хэлье.

Л.Мөнхбаатар: Чинбүрэн гишүүн үг хэллээ тийм ээ. Асуулт байхгүй үг хэллээ гэж ойлголоо. Та, горимын санал юм уу? Монгол Ардын намын бүлгийн дарга Дуламдоржийн Тогтохсүрэн горимын санал гаргая.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. Боловсролын ерөнхий хууль Улсын Их Хуралд өргөн баригдаад 2 жил гаруй болж байгаа юм. Энийг хэлэлцэж, батлах

зайлшгүй шаардлага байгаа гэдгийг бүгд ойлгож, мэдэрч байгаа. Боловсролын ерөнхий хуулийн анхны хэлэлцүүлэгт бэлтгэх явцад энэ бэлтгэсэн талаар өнөөдөр нэгдсэн чуулган хэлэлцэж байна. Тэгээд энэ Боловсролын ерөнхий хуулийн өргөн баригдсан хуулийн 6.7-той холбоотой асуудлаар гишүүдийн хооронд байр сууриар нэлээд хэмжээний зөрүү байна. Бас нийгэмд ч гэсэн янз бүрийн ойлголтууд өгч байна.

Тийм учраас Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлэг энэ Боловсролын ерөнхий хуулийн энэ анхны хэлэлцүүлэг хийж байгаа асуудлаар байр сууриа нэгтгэх зайлшгүй шаардлага үүсэж байгаа учраас ажлын 3 хоногийн завсарлага авах хүсэлтийг гаргаж байна. Шийдвэрлэж өгөхийг хүсье. Баярлалаа.

Монгол Ардын намын бүлгийн дарга Дуламдоржийн Тогтохсүрэн горимын санал гаргаж байна. Энэ Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 15 дугаар зүйл дээр хуралдаанаас завсарлага авах асуудлыг зохицуулсан байгаа. Энэ дээр энэ хуульд өөрөөр заагаагүй бол нам, эвслийн бүлэг Улсын Их Хурлын тухай хуулийн 33.1.4-т заасны дагуу завсарлага авах эрхтэй. Завсарлага авах хугацаа ажлын 5 өдрөөс илүүгүй байна гэсэн ийм зохицуулалт байна. Ийм учраас Дэгийн хуулийн 15.1-д заасны дагуу Монгол Ардын намын бүлэг тухайн хэлэлцэж байгаа асуудлаар байр сууриа нэгтгэх шаардлагатай байна гэж үзсэн учраас Улсын Их Хурлын чуулганаас завсарлага өгч байна. Ажлын 3 өдрийн завсарлага өглөө.

Дараагийнхаа асуудалд оръё. Тийм, дараагийн асуудлууд байгаа байгаа. Одоо ингээд асуудлуудаа хэлэлцээд явна. Боловсролын хууль ирэх 7 хоногт эцсийн хэлэлцүүлэг хийгдэнэ гэж ойлгож болно. Тийм, завсарлага дуусахаар. Дараагийн асуудалдаа оръё.

Эмийн үнийн өсөлтийн шалтгаан нөхцөлийг хянан шалгах асуудлаар Хянан шалгах түр хороо байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Төслийн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Батсүхийн Саранчимэг танилцуулна. Саранчимэг гишүүнийг индэрт урьж байна.

Б.Саранчимэг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Чинбүрэн нарын 28 гишүүнээс 2023 оны 06 дугаар сарын 09-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хянан шалгах түр хороо байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Нийгмийн бодлогын байнгын хороо 2023 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хороо Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.1 дэх хэсэгт заасны дагуу Хянан шалгах түр хороо байгуулах асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүд асуулт асуугаагүй бөгөөд Улсын Их Хурлын гишүүн, Байнгын хорооны дарга Анужин Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсэгт заасан үндэслэлээ тогтоолын төсөлд тусгаагүй, үг, найруулгын шаардлага хангаагүй талаар тусгайлан санал хэлж, төсөл санаачлагчийг тогтоолын төслийг хуульд нийцүүлэн дахин өргөн мэдүүлэх талаар санал хэлсэн болно.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэгт заасны дагуу Хянан шалгах түр хороо байгуулах

тухай тогтоолын төсөлд Байнгын хороо сэдэв, хүрээ, хязгаар, агуулгын хувьд засвар хийх боломжгүй бөгөөд зөвхөн төсөл санаачлагч гишүүд санал нэгдэн зөвшөөрснөөр тус төсөлд агуулгын шинжтэй засвар оруулж болох юм.

Байнгын хороо уг тогтоолын төслийг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн хүрээнд хэлэлцэж, хуульд заасан хүрээ хязгаарын дагуу санал, дүгнэлтээ гаргасан болно.

Байнгын хороо тогтоолын төслийн хэлэлцүүлгийг явуулж хуралдаанд оролцсон гишүүдийн олонх Эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлийг хянан шалгах, түр хороо байгуулах нь Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчөөгүй гэж үзэж дээрх тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хянан шалгах түр хороо байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцсэн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээс хүсье.

Л.Мөнхбаатар: Саранчимэг гишүүнд баярлалаа. Байнгын хорооны санал дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух, үг хэлэх гишүүд байна уу. Байхгүй байна. Анужин гишүүнээр тасаллаа. Байнгын хорооны дарга Анужин асуулт асуултаа асууя.

П.Анужин: Баярлалаа. Энд нэг асуудал үүсээд байна. Хянан шалгах түр хороо байгуулах тухай тогтоолын үндэслэл хэсэг дээр Байнгын хороо бас эргэж харах шаардлага үүслээ. Байнгын хорооны бас тодорхой нэр бүхий гишүүд энэ үндэслэл хэсгийг нь эргэн харах

зайлшгүй шаардлага байна гэж үзсэн учраас тийм, энийг Байнгын хороонд нь энэ тогтоолын төслийг анхны хэлэлцүүлэгт нь буцааж өгөх ийм горимын санал гаргаж байна.

Л.Мөнхбаатар: Анужин гишүүн та горимын санал гаргаж байгаа юм уу. Анужин гишүүнд нэмээд 1 минут өгье.

П.Анужин: Сая би хэлсэн тогтоолын төслийн үндэслэл хэсэг дээр бид нар Байнгын хороо эргэж ажиллах ийм нөхцөл байдал үүссэн учраас хууль санаачлагчийн энэ төслийг Байнгын хороо руу ахиж хэлэлцүүлэхээр буцааж өгнө үү гэсэн хүсэлт гаргаж байгаа.

Л.Мөнхбаатар: Гэхдээ Анужин гишүүн ээ та горимын санал гаргаж байгаа гэж ойлгож байна тийм үү. Байнгын хорооны буцаах горимын санал гэсэн үг үү тээ. Гэхдээ энийг санал хураалтаар шийдэх ёстой. Дэгээрээ ийм зохицуулалттай юм.

Улсын Их Хурлын гишүүн Чинбүрэн нарын 28 гишүүнээс 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хянан шалгах түр хороо байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг холбогдох Байнгын хороо Улс Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль болон Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.1-д заасны дагуу хэлэлцэн санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж ирсэн.

Тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж байгаа энэ үед Анужин гишүүн тогтоолын төслийг дахин хэлэлцүүлэх ийм горимын санал гаргасан байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.3-д нэгдсэн хуралдаан шаардлагатай гэж үзвэл уг асуудлыг дахин хэлэлцүүлэхээр

холбогдох Байнгын хороонд буцааж болно гэсэн ийм заалт бий. Ийм учраас горимын санал гарсан учраас санал хураалтыг явуулъя. Горимын саналаар санал хураалт явууллаа. Санал хураалт.

Хуралдаанд оролцсон гишүүдийн 51.3 хувь нь дэмжсэн байна. Ийм учраас нэгдсэн хуралдаан дэмжсэн учраас уг асуудлыг дахин хэлэлцүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүллээ. Дараагийнхаа асуудалд оръё.

16.02 цаг

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт хуулийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Жамъянхорлоогийн Сүхбаатар танилцуулна. Таныг индэрт урьчихъя.

Ж.Сүхбаатар: Энэ төрийнхөө индрийг хүндэлнэ шүү хөөе.

Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяагаас 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдөр Монгол Улсын Засгийн газраас 23 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр тус тус өргөн мэдүүлсэн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэхийг Улсын Их Хурлын гишүүн Адьяагаас

өргөн мэдүүлсэн төслийг 2023 оны 01 дүгээр сарын 13, Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн төслийг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Хууль зүйн байнгын хорооны 2023 оны 6 дугаар тогтоолоор дээрх хуулийн төслүүдийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар нэгтгэн хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатар, бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Мөнхбаатар, Пүрэвдорж нар, холбогдох бусад албан тушаалтнууд ажиллалаа.

Ажлын хэсгийн ахлагч хуулийн төслүүдийг хэлэлцэхдээ Засгийн газрын өргөн мэдүүлсэн хуулийн төсөлд суурилан нэгтгэн хэлэлцэх горимын санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн.

Хууль зүйн байнгын хороо 2023 оны 20-ны өнөөдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт заасныг баримтлан хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан.

Хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Адьшаа, Дэлгэрсайхан нар хуулийн төсөл болон зарчмын зөрүүтэй саналын томъёололтой холбогдуулан асуулт асууж, хариулт авсан.

Хууль зүйн байнгын хорооны хуралдаанаар хуулийн төсөлтэй холбогдуулан ажлын хэсгийн гаргасан саналуудыг нэг бүрчлэн хэлэлцэж, дараах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд танилцуулж байна.

Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч гэснийг өргөтгөх үүднээс эцсийн өмчлөгч гэж нэмэх, улс төрд нөлөө бүхий зарим этгээдэд тавих хориглолт хязгаарлалтыг зөрчсөн нь Монгол Улсын Үндсэн хууль холбогдох бусад хуульд заасны дагуу Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт, шүүхийн хүчин төгөлдөр шийдэх тогтоолоор гэм буруутай нь тогтоогдсон бол тухайн албан тушаалтныг чөлөөлөх, огцруулах, эргүүлэн татах үндэслэл болох, хамт өргөн мэдүүлсэн Нийтийн албанд болон нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 20.1 штрих 2-т заасан этгээд нь 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдөр холбогдох эрх бүхий албан тушаалтанд мэдэгдэж, ажлаас чөлөөлөгдөх арга хэмжээ авах хугацааг 2023 оны 10 дугаар сарын 01-ний өдөр болгож хойшлуулах, Улсын Их Хурлын гишүүн Б.Дэлгэрсайхан төслийн 1 дүгээр зүйлийн хүүхэд гэдэгт эхнэр, нөхөр, хамтран амьдрагчийн төрсөн, дагавар, үрчлэн авсан хүүхдийг ойлгоно гэсэн тайлбар хэсгээс дагавар таслал гэснийг хасаж, хамтран амьдрагч гэсний дараа одоо хамт амьдарч байгаа гэж нэмэхээр зарчмын зөрүүтэй саналын томъёолол гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн.

Нийтийн албанд болон нийтийн хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг

сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгийн ахлагч Сүхбаатар сайдад баярлалаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Пүрэвжавын Сайнзориг, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Дорждэрэмийн Цолмон, Монголбанкны Удирдлага, төлөвлөлтийн газрын Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх асуудал хариуцсан ахлах референт Базаргүрийн Гантуяа, Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн Мэдүүлгийн бүрдүүлэлт, дүн шинжилгээний албаны дарга Батмөнхийн Баярсайхан, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах шинжээч Шагдарсүрэнгийн Цолмон, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын шинжээч Мөнхдэлгэрийн Цолмон нар оролцож байна. Манай Хууль зүйн яамны гурван Цолмон оролцож байгаа юм байна. Тийм, Нямбаатар сайд Цолмон гэдэг нэртэй хүн өргөдлөө өгөөд байх юм бол авахаар л байгаа юм байна даа.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу. Байхгүй байна. Нямаагийн Энхболд гишүүнээр тасаллаа. Төрийн

байгуулалтын байнгын хорооны дарга Нямаагийн Энхболд асуултаа асууя.

Н.Энхболд: Сая жоохон хоцорч орж ирээд яг оруулж ирсэн хуульд ямар засвар хийчхэв ээ гэдгийг нь сайн, дутуу сонсчихлоо. Санал хураахаас өмнө тэрийг нь тодруулчхаж болох уу асуугаад, нэгдүгээрт.

Хоёрдугаарт. Ер нь энэ авлигатай тэмцэх элдэв янзын юмыг дэмжилгүй яах вэ. Хамаг муу юмны эх үүсвэр энд байгаа. Энийг бүрэн дүүрэн ойлгож байгаа.

Гэтэл бусад хууль тогтоомжуудтай нийцүүлэх ялангуяа Үндсэн хуультай нийцүүлэх энэ юмнууд ер нь хэр зэрэг яригдсан, бодогдсон байдаг юм бол. Байнгын хороон дээр энэ талаар яригдсан уу. Нөгөө л яс, үндэс, хэл ус, нас, хүйсээр ялгахгүй байх тухай санал энэ тэр гэдэг зүйлүүдийг хэр зэрэг яригдсан бол гэж тодруулах гэсэн юм. Тийм.

Нямаагийн Энхболд гишүүний асуултад хариулья. Ажлын хэсгийн ахлагч Сүхбаатар сайд хариулья.

Ж.Сүхбаатар: Ер нь яах вэ манай ажлын хэсгийн хүрээнд ч тэр Байнгын хороон дээр бол тодорхой хөндөгдсөн асуудлууд энэ чиглэлтэй холбоотой юм байсан л даа. Зүгээр нэг нь юу юм бэ гэхээр ер нь үгүй ээ манай Дэлгэрсайхан гишүүний гаргаад дэмжигдсэн санал явж байгаа л даа. Энэ эхнэр нөхөр, хамтран амьдрагчийн гэдэг дээр төрсөн хүүхэд гэхээд дагавар, үрчлэн авсан хүүхэд дотроос энэ дагавар гэснийг нь хасъя. Бас энд чинь бол хамт амьдарч байгаа гэж ялгахгүй бол бас хүүхдүүдийн хувьд бас болохгүй гээд. Ингээд тэгээд ахуй амьдралын жишээнүүд бид нар ярьсан. Тийм нэгдүгээрт. Тэгээд ингээд дэмжигдчихсэн санал явж байна.

Хоёрдугаарт таны хэлдгээр бас энэ хуулийн заалтаас болоод өөр тэр хүүхэд нь гараад явчихсан, тусдаа амьдарч байгаа улсууд эд нар дээрээс гэнэт хувьцаатай

холбоотой асуудал гарангуут шууд Ерөнхийлөгч, Их Хурлын гишүүн ч юм уу, Ерөнхий сайд ч юм уу, Засаг дарга нь ч гэдэг юм уу шууд огцроод явчих юм шиг энэ дээр томьёолчихсон байсан. Тэгэхээр тэрийг нь холбогдох хуульд нь нийцүүлсэн. Тухайлах юм бол нэрлэж заасан л байгаа л даа. Үндсэн хууль, холбогдох бусад хуульд заасны дагуу л тэр үндэслэл юм хумаа авч үзнэ шүү гэдгийг нь бас заахгүй бол юу юугүй энэ дээр ингээд л харангуутаа өө та чинь ингэчихсэн юм байна гээд бас тэгж болохгүй.

Яагаад гэвэл тэр нь бусад хууль, Үндсэн хууль дээр хүртэл зарим нь тодорхой заагдчихсан. Тэгэхээр тэрэнтэйгээ бас зөрчилдөж магадгүй ийм заалт байсан учраас энийгээ тодотгож ингэж оруулсан. Тэр дахиад нэг оруулж байгаа юм нь яах вэ нөлөө бүхий хувьцаа эзэмшигч гээд орхичихсон чинь, 5 хувь гээд ингээд дээш гэсэн чинь эцсийн өмчлөгч гэдгийг нь бид нар томьёолж оруулаагүй байна гэж үзсэн ажлын хэсэг дээр. Тэгээд цаанаа бол эцсийн өмчлөгчид нь бас үлдчихээд байсан учраас эцсийн өмчлөгч гэж нэмээд, энийгээ төслийн юмыг ингээд жоохон өргөтгөж өгсөн.

Дараагийнх нь хугацааг бас хойшлуулж өгсөн. Албан тушаалтай асуудлууд байх юм бол 10 дугаар сарын 1-нээс энэ асуудлаа шийд, хувьцаа тэр бусад асуудалтай холбоотой асуудлууд байгаа бол тэрийгээ тэгээд энэ хууль хүчин төгөлдөр мөрдөгдөөд ингээд явж байгаа юм чинь тэрийгээ тэгээд дараа нь, одоо нөгөө хүчин төгөлдөр байгаа хэдэд нь хамаарахгүйгээр энэ хууль мөрдөгдсөнөөс хойш бол тэрийгээ үйлчлүүлээд явъя ч гэдэг юм уу ийм байдлаар л юм хийсэн. Өөр бол том анхаарал татсан өөрчлөлт тийм юм байхгүй. Яг энэ асуудлуудаар л, хэдхэн асуудал байгаа. Тийм, тэгээд тодотгосон юм нь бол хууль тогтоомжийн шаардлагад нийцүүлээд уг хуулийн гарсан ч гэсэн яг энэнээс энэ хууль гарахаас өмнө хүчин төгөлдөр байгаа гэрээ, хэлцэл бол

үйлчилнэ. Үйлчлээд яваад дуусахаар. Тэрнээс нь хойш мөрдөгдөнө. Тэгэхгүй бол энэ хууль гарахаас чинь өмнө хэвийн хэмжээнд явж байгаа гэрээ, хэлцэл байгаа шүү дээ. Тэр хамаарал бүхий этгээдэд нь. Тэгэхээр тэрийг нь бол яах вэ энэ гэрээ, хэлцэл нь дууссаны дараа энэ хууль үйлчлэхээр гээд ингээд томьёолол, тэгээд дугаарууд өөрчилж байгаа л ийм асуудал байгаа юм.

Л.Мөнхбаатар: Асуулт асууж, хариултаа дууссан. Багаагийн Баттөмөр гишүүн асуултаа асууя.

Б.Баттөмөр: Энэ авлигатай тэмцэх чиглэлээр Нийтийн албанд нийтийн болон хувийн сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зохицлоос урьдчилан сэргийлэх тухай хуульд оруулж байгаа энэ өөрчлөлтийг дэмжиж байгаа.

Ер нь өнөөдөр бол манай тулгамдсан асуудал тийм авлигатай холбоотой, ажил, албан тушаалаа ашигладаг, улс төрд нөлөө бүхий хүмүүс өөрийн хамаарал бүхий улсуудад тийм давуу эрхийг л олгодог ийм практик, ийм зүйл бол маш их болчихсон байгаа. Тэгээд яг энэ чиглэлээр яах вэ ер нь энэ ийм хууль гарах нь зүйтэй. Дэмжиж байгаа. Зүгээр ямар статистик, судалгаа байдаг юм. Би ажлын хэсгийн ахлагчаас асууя. Ер нь улс төрд нөлөө бүхий хүмүүс яг энэ хуульд орж байгаа өөрчлөлтүүдээр ямар тийм тодорхой шүүхээр тогтоогдож, нотлогдсон ийм практик, шүүхийн практик гэж байдаг шүү дээ тийм ээ яг энэ чиглэлээр ийм практик байна уу, энэ судалгаа байна уу гэсэн нэг дэх асуулт байгаа.

Хоёр дахь асуулт энэ Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт Хүнийг үндэс, угсаа, хэл, арьс өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна

гэсэн нэг ийм заалт байгаа. Энэ заалттай энэ хуульд оруулж байгаа 20 штрих 1, 3 дугаар зүйлүүдийг нь хэр зэрэг нийцэж байгаа. Ажлын хэсэг дээр ямар өөрчлөлт орсон нь надад ямар ч нэгэн материал ирээгүй байна. Би төслөөр нь ярьж байна л даа. Яг энэ 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгтэйгээ энэ 2 заалт маань ер нь хэр зэрэг нийцэж байгаа юм. Хуульд нийцүүлж л бид хуульдаа өөрчлөлт оруулах хэрэгтэй. Тэгэхгүй бол бас практикууд, янз бүрийн практикт гарч байна шүү дээ. Хүний эрхийг зөрчсөн, ингэсэн, тэгсэн гээд. Ийм хоёр асуултад хариулт авъя.

Л.Мөнхбаатар: Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн байнгын хороон дарга Ганзоригийн Тэмүүлэн, Улсын Их Хурлын гишүүн Ёндонпэрэнлэйн Баатарбилиг нарын урилгаар Архангай аймгийн Булган сумын цэцэрлэгийн багш нар Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүгдийн сурган хүмүүжүүлэх их үйлсэд амжилт хүсье.

Санал хураалт явуулъя. Асуултад хариулъя. Баттөмөр гишүүний асуултад хэн хариулах вэ. Ажлын хэсгийн ахлагч Сүхбаатар сайд хариулъя.

Ж.Сүхбаатар: Энэ хуулийн төсөл маань нэгдүгээрт Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн төсөл. Монгол Улсын ерөнхий сайд Оюун-Эрдэнэ энэ хуулийн төслийн талаар Улсын Их Хурлын чуулган дээр бол өөрийнхөө бодлого, зорилтыг бол танилцуулсныг та бүхэн мэдэж байгаа.

Хоёрдугаарт энэ хуулийг анх 12 жилийн өмнө би Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга байхдаа энэ Тэмүүжин гишүүнтэй, Ж.Энхбаяртай санаачлаад батлуулж байсан ийм хууль юм байгаа. Одоо ингээд 13 дахь жил рүүгээ мөрдөж байна уу.

Гуравдугаарт бол энэ ийм юм байгаа юм. Үндсэн хуулийн асуудал дээр бол эрхэлсэн ажил, албаар нь гадуурхаж болохгүй гэж байгаа боловч энэ төрийн өндөр албан тушаалтнуудын асуудал байгаа. Төрийн зарим албан тушаалд тавих хуулиар тавьсан шаардлагыг тавьж болно гэсэн ийм заалт бол Үндсэн хуульд байдаг.

Тэгэхээр энд хэн хамаарч байгаа юм гэхээр уг нь их өргөн хүрээтэй хийх гэж байснаа больсон. Монгол Улсын Ерөнхийлөгч, Их Хурлын гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, аймаг, нийслэлийн Засаг дарга гэсэн ийм 5 төрлийн статустай төрийн өндөр албан тушаалтнуудыг хязгаарлалтад оруулъя.

Ер нь дээрээсээ эхлээд тийм шаардлага өндөр чангатгачихъя. Тэгвэл дараа нь эргээд бусад этгээддээ шаардлага тавих бололцоо үүснэ гэдэг энэ зарчим энд үйлчилсэн. Энэ утгаараа бид нар 105 төрийн өндөр албан тушаалтан энд хамаарагдаж байгаа. Ерөнхийлөгч, Их Хурлын 76 гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын Их Хурлын гишүүн биш гишүүд ч бас орж байна. Аймгийн 21 Засаг дарга, нийслэлийн Засаг дарга гээд. Ингээд 105 албан тушаалтны хамаарал бүхий хүүхэд, эхнэр, нөхөр гэхихсэн энэ ангиллын хүрээнд явж байгаа юм. Ингээд үзэхээр ер нь 300 гаруй хүний асуудал ер нь энэ хуулийн үйлчлэлд хамаарч байгаа гэж ойлгож болохоор байгаа.

Ингэснээрээ бол энэ тэргүүн түшмэлээр хамт, тэргүүн түшмэлийн албан тушаалд бол энэ эхнэр, нөхөр, хамтран амьдрагчийн төрсөн, тэр үрчлэн авсан хүүхэд орохгүй гээд бодохоор манай Монгол Улсад төрийн захиргааны тэргүүн түшмэлд хамаарах тийм 121 албан тушаал байна. Тийм, 121 албан тушаал байна.

Ингээд чангатгаснаар бол бид нар энэ цаад утгаараа төрийн өндөр албан тушаалтныг хамгаалж байгаа юм. Тэгээд л тэнд ч тендер, хандив, зээл, хувьцаа.

Ингээд л төрийн төсөл, хөтөлбөрт оролцоод ингээд төрөөс хөнгөлөлт аваад байна. Төсөл, хөтөлбөрт нь орчихсон байна, санхүүжүүлж байгаад концесс авчихсан байна гэдэг энэ асуудлыг бол хязгаарлаж ингэж явж байгаа.

Мэдээж энийг шийдсэнээрээ бусад бүх асуудлыг ингээд шийдэх гэж байгаадаа биш цаана нь Сонирхлын зөрчлийн хуулийн бусад зохицуулалтууд угаасаа бусдыг нь зохицуулчихсан юм байгаад байгаа юм. Гол онцолж хэлж байгаа нь энэ албан тушаалтнуудыг оруулсан ийм хэмжээгээр байгаа юм.

Ер нь авлигатай тэмцэх бодлогыг хүчтэй болгоё гээд Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг Засгийн газар оруулчихсан. Их Хурал ингээд энэ хэдэн асуудлын дараа удахгүй ингээд хэлэлцэнэ. Тэгэхээр энэ бол Монгол Улс авлигажсан категория өөрчилье гэдгийн хамгийн том хүчтэй зохицуулалт бол Сонирхлын зөрчлийн хууль дээр оруулж ирж байгаа юм байгаа юм. Энэ бас урьдчилан сэргийлж байгаа.

Мэдээж тодорхой гэр бүлийн хүмүүст нь бол нөлөөлөл бас амаргүй гэдэг юм уу, юу гэдэг юм шударга бус ч юм уу янз бүрийн асуудлууд үүсэж болох байх л даа.

Гэхдээ өнөөдөр цаг үе, нөхцөл байдал, төрийн өндөр албан тушаалтанд бид нарыг хэнийг ч хүчээр ажилла гэж хэлээгүй. Өөрсдөө зөвшөөрөөд сонгогдчихсон, томилогдчихсон. Тэгэхээрээ илүү их бусдаасаа илүү хязгаарлалтад орьё. Тэр хэмжээгээрээ бас өөрсдөө ч гэсэн зөрчлөөс сэргийлэгдье, ажил албаа хэвийн явуулъя л гэдэг ийм л үүднээс нь ойлгож, хүлээж авах байдлаар зохиц зохицуулсан үйл байж байгаа. Хууль зүйн асуудал дээр нь янз бүрийн санал бодол гардаг.

Гэхдээ би ажлын хэсэг бол Үндсэн хуулийн зөрчилгүй болох талаасаа бас

ажиллаад ингээд л оруулсан ийм л эд байгаа юм.

Л.Мөнхбаатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Санал хураалт явуулна. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг танилцуулъя.

Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал байна. Нийтдээ 9 санал бий. Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 20¹.1 дэх хэсэг, 3 дугаар зүйлийн “нөлөө бүхий хувьцаа” гэсний дараа “эзэмшигч, түүний эцсийн өмчлөгч” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Жамъянхорлоогийн Сүхбаатар, Лхагвын Мөнхбаатар, Бөхчулууны Пүрэвдорж. Цаашид Ажлын хэсэг гэх, ажлын хэсэг. Санал хураалт.

65.9 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн Тайлбарын “17.1-д заасан” гэсний дараа “томилогдох” гэж нэмж, “18.1.1-д заасан төрийн захиргааны” гэснийг “18.2-т заасан” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

65.9 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 20¹.3 дахь хэсгийн “зөрчсөн нь” гэсний дараа “Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тухай, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон холбогдох бусад хуульд заасны дагуу Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт,

шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор гэм буруутай нь тогтоогдсон бол тухайн” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

65.9 хувиар санал дэмжигдлээ.

4.Төслийн 1 дүгээр зүйлийн Тайлбарын “төрсөн,” гэсний дараах “дагавар,” гэснийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Дэлгэрсайхан. Санал хураалт.

68.3 хувиар санал дэмжигдлээ. Дэлгэрсайхан гишүүний санал дэмжигдлээ.

5.Төслийн 1 дүгээр зүйлийн Тайлбарын “хамтран амьдрагчийн” гэсний дараа “одоо хамт амьдарч байгаа” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Борхүүгийн Дэлгэрсайхан. Санал хураалт.

Яах юм, өө асуух юм уу. Үг хэлж болно. Дэгээрээ үг хэлэх боломжтой зарчмын зөрүүтэй санал дээр. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн үг хэлбэ.

Б.Бат-Эрдэнэ: Үгүй ээ үгүй та нар ингээд Энх-Амгалан сайдаа тэгээд нэг юм хэлэх гэхээр зэрэг л Засгаас өргөн барьсан хууль гээд ингээд дайраад байж болохгүй шүү дээ. Энэ засгаас кабинетын зарчим, кабинетын зарчим баримтлаагүй юм байхгүй. Үгүй ээ энэ байна шүү дээ. Энэ ороод ирсэн Их Хуралд ороод ирсэн Засгийн газрын өргөн барьсан хуулийн төслийн хувилбараас чинь өөр болчихоод байгаа учраас би үг хэлэх гээд байна шүү дээ.

Би яагаад энийг хэлэх гээд байгаа юм гэхээр зэрэг бид нар бол арай л хэтрүүлсэн улс байна лээ дээ. Энийг 10 гаран жилийн өмнөөс бараг 20 жил болж байна даа. Үгүй ээ та нар минь энэ төрийн албыг төрлийн алба болгохоо болиоч, ах дүү, авгай, хүүхдүүд энэ юугаа ингээд төрийн ажил албыг зайдлуулаад суулгаад

байдгаа та нар больж үзээч гээд энд 10 гаран жил үндсэндээ шаардсан. Тэгээд бид бол энэ үр дүнд хүрэхгүй юм байна гээд ингээд ерөнхийдөө бол горьдлого тасраад цөхөрчихсөн байсан гэж хэлэхэд болно.

Харин энэ Ерөнхий сайд Оюун-Эрдэнэ бол үнэхээр зориг, хүч гаргаж байна. Тэгээд энийг тэгээд энийг яаж байна вэ гэхээр зэрэг Одонтуяа битгий би хоёр үг хэлээд дуусчихъя л даа. Би таныг үг хэлж байхад би хэзээ ч дундуур чинь тасалж юм хэлж байгаагүй шүү дээ. Та нар ингээд арай дэндүү бүдүүлэг юм. Үгүй ээ хэцүү юм ингээд юм хэлүүлэхгүй. Энэ бол бүүр зориуд ийм санаа зорилготой байдаг юм шиг байна л даа. Тэгээд би бол ойлгож байгаа. Манай Их Хурлын гишүүд бол Нийтийн ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой энэ хуулийг батлахад наашаа харж инээж, цаашаа харж уйлж байж энэ кнопыг дарж байгаа гэдгийг би ойлгож байгаа. Яг бодит байдлаар энэ чинь арай хэтэрсэн юм. Бид нар энэнээсээ гармаар байгаа байхгүй. Одоо энэ 5 дугаар энэ заалт чинь хамтран амьдрагчийн гэсний дараагаар одоо хамтран амьдарч байгаа гэж. Тэгээд энэ юу гэж ойлгогдож байна вэ гэхээр зэрэг хүүхдүүд нь бол мэдээж том болчихсон ингээд тусдаа гараад явчихсан. Тэгээд тийм учраас бол одоо хамтарч амьдарч байгаа биш л байх юм бол тэр ажил албан тушаалд нь хэвээр үлдээхээр ийм зохицуулалтыг хийж байна шүү дээ. Ингэж жишээлэх юм бол хуулийн ийм гаргалгаагаар энийг цаад талд нь гаргаж байгаа явдал бол үнэхээр харамсалтай байгаа юм.

Энэ Засгийн газраас өргөн барьсан хуульд бол яг л өөрийнх нь төрсөн үр хүүхдүүд, эхнэр, нөхөр ийм хүмүүс байгаа бол энийгээ чөлөөл. Түрүүн Сүхбаатар ажлын хэсгийн ахлагч бол тодорхой хэлж байна шүү дээ. Бид нарыг Их Хурлын болон энэ Засгийн газарт ажилла, төрийн өндөр ажил, албан тушаал хариуцаж ажилла гэж хэн ч албадаагүй. Бид өөрснөө энийг хийе, чадна, нийтийн эрх ашгийн

төлөө ажиллая гээд ингээд ажиллаж байгаа улсууд.

Тийм учраас өөрөө төдийгүй өөрийнх нь шадар шахам хамт амьдарч байгаа гэр бүл, үр хүүхдүүд нь нэгдсэн нэг ойлголттой энэ нийтийн эрх ашгийн зөрчилтэй холбоотой юмнаас бол хязгаарлалт хийлгэж ингэж ажиллах ийм цаг үе нь ийм шаардлага байна.

Энэ хуулийн төслийг анх яригдаж байх үед би бас тодорхой саналаа хэлж байсан. Яг энэ цаг үед бол бид нар ийм хууль гаргахаас өөр нөхцөл байхгүй байна шүү. Энэ өөрийнхөө хамаарал бүхий улсуудыг ажил албан тушаалууд томилдог, цаашлах юм бол төр, ард түмний нэр барьж авсан зээл, бондоос авдаг, энэ элдвийн сангуудыг цөлмөдөг, авдаг, энэ хувийн аж ахуй, бизнесээ дэмждэг ийм юм чинь бол ингээд бүүр Монголын төрд ингээд соёл болоод тогтчихсон. Энийг дагасан авлигал, хээл хахууль энэ улс орныг урагш нь, цааш нь гишгүүлэхгүй байгаа бүх юмны чинь уг үндэс, шалтгаан чинь энд байна шүү гэдгийг бол хэлж байсан.

Тийм учраас энэ хуулийг уг нь Засгийн газрын өргөн барьсан тэр хувилбарынх нь дагуу батлаад явсан бол хэл амгүй ингээд явчих байсан юм даа. Ийм зүйлийг хэлье. Асууж болохгүй болохоор бол би сая тодорхой үндэслэл гаргаж хэллээ.

Л.Мөнхбаатар: Асуулт, хариулт байхгүй. Үг хэлэх дэгтэй. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн үг хэллээ. Саналын томъёоллыг уншиж танилцуулсан. Санал хураалт.

68.3 хувиар санал дэмжигдлээ.

Найруулгын санал байна.

Төслийн 1 дүгээр зүйлийн 20¹.1 дэх хэсгийн “Засаг даргын албан тушаал эрхэлж байгаа хүн” гэснийг “Засаг дарга” гэж өөрчилж, “хөтөлбөр” гэсний дараах

“эсхүл” гэснийг хасаж, 20¹.3, 29.6 дахь хэсгийн “20¹ дүгээр зүйлд” гэснийг “20¹.1, 20¹.2-т” гэж өөрчилж, мөн 29.6 дахь хэсгийн “төр,” гэснийг хасаж, төслийн 2 дугаар зүйлийн “мөн хэсгийн “дарга,”” гэсний өмнө “байгууллагын” гэж, “тэдгээрийн” гэсний дараа “тэргүүн дэд дарга, дэд дарга” гэж, “орлогч” гэсний дараа “дарга” гэж нэмэх.

Хоёр.Төслийн энэ ингээд санал хураалт юм байна. Санал хураалт, найруулгын санал хураалт.

Санал хураалт 70.7 хувиар санал дэмжигдлээ.

Хоёр. Яах юм үг авах юм уу. Хишгээгийн Нямбаатар гишүүн үг хэлье.

Х.Нямбаатар: Энэ Ашиг сонирхлын зөрчлийн хууль дээр бид нар бас энэ Байнгын хороон дээр ч гэсэн хэлэлцүүлгийн явцад ярьсан юм. Нэг зүйлийг энэ чуулганы хуралдаан дээр тэмдэглэлд үлдээе гэж ярьж байгаа юм. Энэ юу вэ гэхээр Монгол Улсын Үндсэн хуулийн 2 дугаар бүлэгт заасан аж ахуй эрхлэх эрхийнхээ хүрээнд нийтийн албанд ажилладаг хүн өөрт хамаарал бүхий аж ахуйн нэгж байгууллага нь сургууль, цэцэрлэгийн үйлчилгээ эрхэлдэг тохиолдолд тухайн хүүхдийн хувьсах зардлыг төрөөс орж байгаа энэ үйл явц бол энэ Ашиг сонирхлын зөрчлийн хуулиар тогтоосон хязгаарлалтад хамаарахгүй байя. Энэ хэрвээ энийг ингээд яг энэ Ашиг сонирхлын зөрчлийн хуулийн хязгаарлалтаар өргөжүүлээд хамаатуулж байгаа тохиолдолд энэ өөрөө хуулийнхаа яг үндсэн агуулга, концепцтэй зөрчилдөнө гэдэг зүйлийг бид нар Байнгын хороон дээр ярьсан.

Тийм учраас цаашид энэ Их Хурлын энэ хуулийн хувийн хэрэгт энэ өнөөдрийн хуралдааны тэмдэглэл хадгалагдана. Тийм учраас би протоколд тэмдэглэлд юу гэж үлдээж байгаа вэ гэхээр тэр аж ахуй эрхлэх эрхийнхээ

хүрээнд аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг тэр эрхэлсэн үйл ажиллагаа нь төртэй ямар нэгэн байдлаар хувьсах зардал байдлаар холбогдож байгаа тохиолдол болгоныг Ашиг сонирхлын хуулийн хязгаарлалт гэж үзэхгүй ээ л гэж тэмдэглэлд үлдээх гэсэн юм.

Л.Мөнхбаатар: Нямбаатар гишүүний хэлсэн үг бол тэмдэглэлд үлдэж байгаа. Тэмдэглэлд үлдэхийн ач холбогдлыг бол та бүхэн бүгд мэдэж байгаа. Уг хуультай холбоотой аливаа маргааныг хянан шийдвэрлэхдээ Улсын Их Хурлаар хэлэлцсэн тэмдэглэлийг бас харгалзан үздэг гэдгийг агуулгаар нь одоо тэмдэглэлд үлдээж байна.

2.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн агуулга, зарчмыг хөндөхгүйгээр нэр томьёо, хэл найруулга, дэс дарааллыг нийцүүлж өөрчлөх. Санал хураалт.

Хуралдаанд оролцсон гишүүдийн 70 хувь нь дэмжлээ.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Нийтийн албанд болон нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг танилцуулья.

Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал байна.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “2023 оны 07 дугаар сарын 01-ний” гэснийг “2023 оны 10 дугаар сарын 01-ний” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

67.5 хувиар дэмжье санал дэмжигдлээ.

2.Төсөлд доор дурдсан агуулгатай 1 дүгээр зүйл нэмэх

1 дүгээр зүйл. 2023 оны энэ баталсан өдрөөс нь тооцох юм байна. Тэр баталсан Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнө хууль тогтоомжийн шаардлагад нийцүүлж байгуулагдсан уг хуулийн 20¹.1-д хамаарах гэрээ, хэлцэл хүчин төгөлдөр хэвээр байна. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

68.3 хувиар санал дэмжигдлээ.

Найруулгын санал байна.

Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн дэс дараалал, зүйл, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

73.2 хувиар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлж байна. Дараагийнхаа асуудалд орёе.

16.35 цаг

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулья.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга Пүрэв-Очирын Анужин танилцуулна. Та горимын санал гаргаж байгаа юм уу. Монгол Ардын намын бүлгийн дарга Дуламдоржийн Тогтохсүрэн горимын санал гаргаж байна.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. Даргаа Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон энэтэй холбоотой 5 том хууль байгаа юм. Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хууль гэсэн 5 хууль байгаа юм. Энэ 5 хууль бол нэлээн нухацтай ярих ийм шаардлагатай хуулиуд байгаа.

Тийм учраас маргааш өглөөний 10 цаг хүртэл Монгол Ардын намын бүлэг энэ 5 хууль дээр завсарлага авч байгаа юм. Маргааш 10 цагаас явуулъя гэж. Тийм учраас завсарлага өгөхийг бас танаас хүсье.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасны дагуу Монгол Ардын намын бүлгийн даргын саналыг үндэслэн маргааш өглөөний 10 цагийг хүртэл завсарлага өглөө. Дараагийнхаа асуудалд орё.

16.37 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 04 дүгээр дүгнэлтийг хэлэлцье.

Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Жуужаагийн Эрдэнэбулган танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Ж.Эрдэнэбулган: Монгол Улсын Их Хурлын дэд дарга болон эрхэм гишүүд ээ та бүхэнд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 04 дүгээр дүгнэлтийг уншиж сонсгоё.

Онцгой албан татварын тухай хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Г.Туулхүү даргалж, Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн гишүүн Ш.Солонго, Б.Буяндэлгэр, Г.Баясгалан, Ж.Эрдэнэбулган, илтгэгч нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Б.Баяржаргалыг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч иргэн Ч.Цолмонбат, А.Энхтүвшин, Э.Эрдэнэцэцэг болон Монгол Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нар оролцов.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар Онцгой албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5, 5 дугаар зүйлийн 5.1.6, 6 дугаар зүйлийн 6.1.10 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2, 5 дугаар зүйлийн 4, 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн холбогдох заалтыг тус тус зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв. Үндэслэл:

1.Монгол Улсын Их Хурал 2021 оны 7 дугаар сарын 6-ны өдөр Онцгой албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4.1.5, 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн, 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн 10 дахь заалтуудад газрын тосны үйлдвэрлэлийн дайвар

бүтээгдэхүүн керосинд онцгой албан татвар ноогдуулахаар нэмэлт оруулжээ.

Төрийн санхүү, зээл, татвар, мөнгөний бодлого нь иргэдийн амьжиргаа, эдийн засаг, үйлдвэрлэл зэрэгт шууд нөлөөлдгийг харгалзан шинээр татвар тогтоох, эсвэл өөрчлөхдөө хууль тогтоогч холбогдох тооцоо судалгаанд үндэслэхийн зэрэгцээ төрийн бусад бодлоготой уялдуулах хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжтой нийцүүлэх ёстой. Иймд Хууль тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.2 дахь заалтад хууль тогтоомжийн төсөлд уг төслийн үзэл баримтлал товч болон дэлгэрэнгүй танилцуулга, хэрэгцээ шаардлагыг тандан судалсан, эсвэл хэрэгжилтийн дагаварт үнэлгээ хийсэн, үр нөлөөг нь үнэлсэн, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийсэн тайланг хавсаргахаар заасан.

Гэтэл Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг холбогдох судалгаа, бүрдүүлбэрийн хамт өргөн мэдүүлсэн байх боловч дүгнэлт, судалгаа нь иж бүрэн бус, бодит байдалд нийцэхгүй, түүнчлэн тухайн хуулиар зохицуулах харилцаанд оролцогч талуудын эрх зүйн байдал болон улс орны эдийн засагт хэрхэн нөлөөлөх асуудлыг тусгаагүй байна.

Тухайлбал, Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцсэн Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн хуралдааны тэмдэглэлээс үзэхэд тус хуулийн төслийн үр дагаврын талаарх дүгнэлт болон бусад баримт мэдээлэл нь хуулийн төслийн танилцуулга, хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандсан судалгаанд тусгаадаагүй болохыг тэмдэглэсэн байна.

Мөн Монгол Улсын Засгийн газар уг хуулийн төсөл нь газрын тосны дайвар бүтээгдэхүүн, керосин зэргийг өөр

зориулалтаар ашигладаг импортлогч, үйлдвэрлэгч, хэрэглэгч нарт татварын дарамт, аж ахуйн үйл ажиллагааны хүндрэл үүсгэж болзошгүй байгааг анхаарах ёстой гэсэн санал, дүгнэлт гаргажээ.

Дээрхээс үзэхэд Монгол Улсын Их Хурлын Хурал 2021 оны 07 дугаар сарын 06-ны өдөр Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа Үндсэн хуульд заасан хууль дээдлэх зарчмыг алдагдуулсан гэж үзэхээр байна.

2.Аливаа улс татварын тогтолцоогоо бүрдүүлэхдээ үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, нийгмийн хөгжлийг хангах зорилгыг үндсэн шалгуур болох хүрээнд хууль тогтоогч татварын хуулийг батлахдаа нотолгоо, судалгаа, үр дүнд суурилж нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөллийг тооцох шаардлагатай.

Гэтэл бүрэн бус судалгаанд үндэслэн татварын суурийг өргөжүүлэхдээ газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн, керосинд холбогдуулан онцгой албан татварыг шатлалгүйгээр тогтоосон нь түүхий эд импортлож байгаа үндэсний үйлдвэрлэгч нарт ялгамжтай байдал бий болгосон байна.

Энэ нь Үндсэн хуульд заасан төрийн үйл ажиллагааны тэгш байдлын зарчмыг зөрчиж, үндэсний эдийн засгийн аюулгүй байдал аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулахаар заасанд нийцэхгүй байна.

Иймд Онцгой албан татварын тухай хуулийн маргаан бүхий заалтууд нь Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2, 5 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн холбогдох заалтыг тус тус зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 64 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 66 дугаар

зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалтын холбогдох хэсэг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг тус тус удирдлага болгон Монгол Улсын Үндсэн хуулийн нэрийн өмнөөс дүгнэлт гаргах нь:

Онцгой албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн 4.1.5 дахь заалтад газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн, керосин гэж, 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн хүснэгтийн 6 дахь заалтад газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн, керосин, 1 тонн, 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн хүснэгтийн 10 дахь заалтад газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн, керосин, 1 тонн, 285 мянга гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн тэгш байдал, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн, 5 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна гэснийг тус тус зөрчсөн байна.

2.Онцгой албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5, 5 дугаар зүйлийн 5.1.6, 6 дугаар зүйлийн 6.1.10 дахь заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн шударга ёс нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн, 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна гэж заасныг зөрчөөгүй байна.

3.Онцгой албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5, 5 дугаар зүйлийн 5.1.6, 6 дугаар зүйлийн 6.1.10 дахь заалтуудыг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2023 оны 6 дугаар

сарын 16-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

4.Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

Даргалагч Г.Туулхүү, гишүүд С.Солонго, Б.Буяндэлгэр, Г.Баясгалан, Ж.Эрдэнэбулган.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Эрдэнэбулган гишүүнд баярлалаа. Цэцийн дүгнэлтийн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Борхүүгийн Дэлгэрсайхан танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Б.Дэлгэрсайхан: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Онцгой албан татварын тухай хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 04 дүгээр дүгнэлтийг 23 оны 6 дугаар сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд ирүүлснийг Улс Хууль зүйн байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 82 дугаар зүйлд заасан журмын дагуу 23 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн, итгэмжилсэн төлөөлөгч Тэмүүлэн Улсын Их Хурлын Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 23 оны 04 дүгээр дүгнэлтийг агуулгыг танилцуулсан болно.

Хууль зүйн байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Үндсэн

хуулийн цэцийн дүгнэлтийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар стандарт бус шатахуун, хуурамч шатахууны талаар ойлголт хэрэв хуурамч шатахууны хэрэглэж байгаа бол хуулиар хориглох ёстой талаар, мөн Улсын Их Хурлын гишүүн Мөнх-Орил Цэцийн дүгнэлтийн үед хууль хоорондын зөрчлийг арилгах боломж байгаа эсэх талаар санал гаргасан. Мөн Улсын Их Хурлын гишүүн Раднаасэд Монгол Улсын Цэцийн дүгнэлтийн тухай хуулийн заалтыг түдгэлзүүлснээр үйлчлэл зогсож байгаатай холбогдуулан төсөвт гарах татварын алдагдлын талаар, мөн Монгол Улсын Их Хурлын гишүүн Баттөмөр Монгол Улсын Үндсэн хуулийн цэц дүгнэлт гаргахдаа олон талаас нь авч үзэж шийдвэр гаргаагүй гэж үзэж байгаагаа илэрхийлээд Монгол Улсаас өөр газар газрын тосны дайвар бүтээгдэхүүн ашиглаж шатахуун найруулж байгаа улс орон байдаг эсэх талаар, мөн бүтээгдэхүүн ашиглаж, шатахуун найруулж байгаа эсэх талаар, Монгол Улсын Их Хурлын гишүүн Энхбаяр мэдээлэл гаргагч иргэн Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар эцсийн бүтээгдэхүүн буюу бензин, дизель түлш импортлогч нарт давуу байдал үүсгэсэн талаар дурдсан байх бөгөөд хэрхэн давуу байдал үүсгэж байгаа талаар тус тус асуулт асууж хариулт авсан болно.

Мөн Монгол Улсын Их Хурлын гишүүн Пүрэвдорж Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй талаар дурдаад газрын тосны дайвар бүтээгдэхүүн, керосин зэргийг хольж найруулан хямд зардлаар стандарт бус шатахуун үйлдвэрлэн зах зээлд нийлүүлж байгаа нь хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд ялгаруулж буй хорт бодисын хэмжээ их, ашиглагдаж байгаа тээврийн хэрэгслийн явах эд анги муудах эвдрэлд оруулж байгаа их хэмжээний эдийн засаг санхүүгийн хохирол учруулж байгаа талаар, Монгол Улсын эдийн засагт их санхүүгийн хохирол учруулж байгаа

талаар, Улсын Их Хурлын гишүүн Адъяаа Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн 23 оны 04 дүгээр дүгнэлтийг дэмжиж байгаа бөгөөд эдийн засагт өрсөлдөөнийг сайжруулах зорилгоор гуравдагч зах зээлээс бүтээгдэхүүн оруулж ирэх боломжийг нээж өгөх талаар, Монгол Улсын Их Хурлын гишүүн Баттөмөр татвар, тарифын асуудлаар Монгол Улсын Үндсэн хуулийн цэцээр шийдвэр гаргаж байгаа нь зөв эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Мөнх-Оргил Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй талаар дурдаад үнэхээр эрүүл мэндэд хортой асуудал бол татварын хуулийн асуудал биш, хуулиар хориглох асуудал хоргүй тохиолдолд татвар ноогдуулах байдлаар эцэслэн тогтоох нь зүйтэй. Түүнчлэн Үндсэн хуулийн цэц хууль тогтоомжийг төслийн бүрдүүлбэр нь хэлбэрийн шаардлага хангасан эсэхийг хянах жишиг байдаг ч бүрдүүлбэрийн агуулгыг хянах нь зохимжгүй бөгөөд хууль хоорондын зөрчил бүрийг хууль дээдлэх зарчим зөрчсөн гэж явцууруулж дүгнэж болохгүй талаар хэлсэн болно.

Онцгой албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-ийн хэсгийн 4 дүгээр зүйлийн 1.5-ын...энэ ямар бүдэг юм бэ энэ чинь...заалтад гарсан газрын тосны үйлдвэрийн дайвар бүтээгдэхүүн болон керосин үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн явуулсан мөн 1 тонн, 6 дугаар, алив энийгээ Энхбаяраа жоохон тод юм байхгүй юм уу. Энэ чинь канондчихсон юм өгчхөөд. Хаана байна? Одоо болж байна.

Онцгой албан татварын 4 дүгээр зүйлийн 4.1-ийн хэсгийн 4.1.5 дугаар заалтад газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн, керосин гэж, мөн 5 дугаар зүйлийн 5.1-ийн хэсгийн хүснэгтийн 6 дахь заалтад газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн, керосин, 1 тонн штрих, 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн хүснэгтийн 10 дахь заалтад газрын тосны үйлдвэрлэлийн

дайвар бүтээгдэхүүн, керосин, 1 тонн, 285000 төгрөг заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн тэгш байдал, хууль дээдлэх төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн, 5 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна гэснийг тус тус зөрчсөн байна гэж гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн 23 оны 04 дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэж үзсэн болно.

Монгол Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн 23 оны 04 дүгээр дүгнэлтийг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Дэлгэрсайхан гишүүнд баярлалаа. Цэцийн дүгнэлтийн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн байнгын хороон дарга Ганзоригийн Тэмүүлэн танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Онцгой албан татварын тухай хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 04 дүгээр дүгнэлтийг 2023 оны 06 дугаар сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Төсвийн байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны

дэгийн тухай хуулийн 82 дугаар зүйлд заасан журмын дагуу 2023 оны 6 дугаар сарын 21, 22-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 04 дүгээр дүгнэлтийг хэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Тэмүүлэн миний бие Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн 2023 оны 04 дүгээр дүгнэлтийн агуулгыг танилцуулсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн 04 дүгээр дүгнэлтийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Пүрэвдорж стандарт бус чанарын шаардлага хангахгүй шатахуунаар хэрэглэгчдэд үйлчилж байгаа нь агаарын болон орчны бохирдол, тээврийн хэрэгслийн ашиглалтад сөрөг нөлөөтэйгөөс гадна хэрэглэгчдийн эрх ашгийг зөрчиж байсан, харин хууль батлагдсан 2 жилийн хугацаанд дээрх зөрчлүүд багассаныг анхаарч зөв шийдвэр гаргах нь зүйтэй, Улсын Их Хурлын гишүүн Батжаргал Үндсэн хуулийн цэцийн Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим заалтуудыг хүчингүй болгосон дүгнэлтийг холбогдох төрийн захиргааны байгууллагын болон мэргэжлийн шинжээчдийн дүгнэлтийн дагуу үндэснийхээ эрх ашигт нийцсэн шийдвэрийг гаргахад анхаарч уг асуудлыг түр хугацаагаар хойшлуулах нь зүйтэй, Улсын Их Хурлын гишүүн Амартүвшин Татварын хуулиар өрсөлдөөнийг хязгаарлах нь зохицохгүй тул Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх, харин хуурамч шатахууны асуудалд холбогдох яам болон мэргэжлийн байгууллагууд стандартыг мөрдүүлж, хяналт тавьж ажиллах нь зүйтэй, Улсын Их Хурлын гишүүн Баттөмөр онцгой албан татварыг хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэг газрын тосны бүтээгдэхүүнд ноогдуулахаар хуульчилсан боловч Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтээр

газрын тосны дайвар бүтээгдэхүүнд татвар ноогдуулахгүй болж байгаа нь Үндсэн хуулийн 1.2-т заасан тэгш байдал гэсэн зарчимтай нийцэж байгаа эсэх, мөн 2022 оны байдлаар 22 аж ахуйн нэгжид газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг олгосон талаар Аудитын дүгнэлт тусгасан боловч одоогоор нэг ч үйлдвэр байхгүй зөвхөн дайвар бүтээгдэхүүнүүдийг шатахуунд хольж хуурамч шатахуун үйлдвэрлэж байгаа нь хөгжиж буй улс орнуудад хэрэглэдэг хоцрогдсон технологи бөгөөд энэ төрлийн бизнес нь мөнгө угаах хэрэгсэл байж болзошгүйг анхаарах нь зүйтэй гэсэн саналуудыг гаргасан болно.

Онцгой албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн 4.1.5 дахь заалтад газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн керосин гэж, 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн 6 дахь заалтад газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн керосин, 1 тонн, 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн 10 дахь заалтад газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн керосин, 1 тонн, 285 000 төгрөг гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн тэгш байдал, хууль дээдлэх нь төрийн захиргааны төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн, 5 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна гэснийг тус тус зөрчсөн гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн 2023 оны 04 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэж олонх нь үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн 2023 оны 4 дүгээр дүгнэлтийг хэлэлцсэн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг

хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Тэмүүлэн даргад баярлалаа. Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Байхгүй байна. Цогтгэрэл, Пүрэвдорж гишүүнээр тасаллаа, Адьшаа гишүүнээр тасаллаа. Одоо Одонгийн Цогтгэрэл гишүүн асуултаа асууя. Цогтгэрэл гишүүний микрофоныг өгье. Та картаа уншуулаарай. Орчихлоо.

О.Цогтгэрэл: Энэ хуурамч шатахуун гээд Их Хурал дээр болоод нийгмээрээ ийм талцсан зүйл рүү л орчихлоо. Яг үнэндээ хуурамч, хуурамч биш гэдгийг чинь тогтоосон, би энэ яг энэ асуултыг мэргэжлийн байгууллагын дүгнэлт асуух гээд байна л даа. Хэнээс асуух ёстойг нь сайн мэдэхгүй байгаад байна. Хуурамч шатахуун гэдэг чинь өөрөө үнэхээр хуурамч юм бол тэрийг энэ чанарын шаардлага хангахгүй хуурамч гэсэн дүгнэлт гаргадаг газар нь яг ямар газар вэ? Тэр газар нь энэ технологиор хийсэн шатахуун нь хуурамч гэдгийг тодорхойлоод гаргачихсан уу. Хэрвээ гаргачихсан бол энэ чинь өөрөө угаасаа хууль бус, стандартын бус үйл ажиллагаа энэний цаана яваад байгаа юм биш үү. Хэрвээ энэ нь өөрөө стандартын шаардлага хангаж байна гэвэл энэ чинь өөрөө бас хуулийн дагуу дахиад нэг өөр төрлийн үйл ажиллагаа болж хувирах гээд байна. Тэгвэл хэрвээ энэ стандартын шаардлага хангадаг гэсэн дүгнэлт байдаг бол би хувьдаа тэр бизнесийн талд, тэнд Монгол Улсад нэмүү өртөг, нэмүү үнэ цэн, нэмүү ажлын байр бий болж тодорхой хэмжээний гуравдагч эх үүсвэр үүсэж байгаа талд нь энэ асуудлыг дэмжих ёстой гэж хувьдаа боддог.

Нөгөө талд нь хэрвээ энэ стандартын шаардлага хангахгүй бол энэ чинь угаасаа хууль бус. Тэгэхээр яг энэ дээр энэ технологиор хийж байгаа, хольж

байгаа гээд байгаа энэ технологи нь өөрөө стандартад нийцсэн эсэх талаар мэргэжлийн байгууллагын дүгнэлт байгаа юу? Мэргэжлийн байгууллага энэ мэргэжлийн байгууллага гэдэг нь Мэргэжлийн хяналт байдаг юм уу, уул уурхай дээрээ байна уу хаанаа байдгийг нь бүү мэд. Газрын тосны газар дээрээ байдаг юм уу ямар ч байсан энд мэргэжлийн байгууллага нь энэ гарсан бүтээгдэхүүнийг чанарын шаардлагад нийцэж байгаа, Монгол Улсын стандартад нийцэж байгаа, болж өгвөл дэлхийн тэр ЕВРО 5-д нь нийцэж байгаа эсэх гэдэг талаар мэргэжлийн байгууллагын ямар дүгнэлт байдаг вэ. Энэ өөрөө гишүүдийн болоод яг энэ асуудалд дэмжих, эс дэмжих, хүлээж авах, эс хүлээж авах гэдэг асуудлын шийдэл нь л ерөөсөө ганцхан энд л байгаа байх. Энэ бол яг үнэндээ улс төрчдийн шийдэх асуудал бас биш болоод хувирчихсан болов уу л гэж бодож байна. Тэгэхээр мэргэжлийн байгууллагын талын дүгнэлтийг танилцуулж өгөөч.

Л.Мөнхбаатар: Цогтгэрэл гишүүний асуултад хэн хариулах вэ? Төсвийн байнгын хорооны даргаар Тэмүүлэн дарга хариулья.

Г.Тэмүүлэн: Миний бие Үндсэн хуулийн цэцийн маргаан дээр Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр болбол Улсын Их Хурлын шийдвэрийг хамгаалж цэцийн хуралдаанд оролцсон.

Тэгэхээр би бол нэг талдаа та бол сая энэ хуурамч шатахуун гэж яг байдаг эсэх, эсвэл юу гэдэг юм тэр стандарт бус гээд байгаа шатахуун нь яг стандартын шаардлага хангадаг эсэх, нийцсэн эсэх гэдэг асуудлыг мэргэжлийн асуултыг асууж байх шиг байна л даа. Тэгэхээр би бол зүгээр яг Цэцийн дүгнэлтэй холбогдуулж өөрийнхөө илэрхийлсэн байр суурийнхаа талаар болоод Улсын Их Хурлаас тухайн тэр энэ хуулийг баталж байхтай холбоотой энэ асуудлуудаар л байр сууриа илэрхийлж тайлбараа өгөх боломжтой гэж үзэж байгаа.

Саяын таны хэлсэн энэ хуурамч шатахуун гэдэг асуудал бол миний ойлгож байгаагаар энэ албан бус ярианы хэллэг байх гэж харж байгаа. Бид бүхний ярьж байгаа Улсын Их Хурлаас явуулсан Цэцийн энэ асуудал дээр бол бид бүхнээс гаргасан тайлбар дээр бол ямар нэг хуурамч гэдэг зүйлийг хэлээгүй, стандарт бус бензин гэдэг асуудлыг, түлш гэдэг асуудлыг ярьж байгаа юм.

Улсын Их Хурал болоод Төсвийн байнгын хороонд аудитын байгууллагаас бол энэ газрын тос болоод нефтийн завсрын нэмэлт бүтээгдэхүүний талаар төрөөс хэрэгжүүлж байгаа бодлого, үйл ажиллагааны хэрэгжилт, түүний үр дүнд хийсэн Аудитын тайланг бол бас ирүүлсэн байсан. Энэ аудитыг бол 2022 онд бол хийсэн байгаа. Үүн дотор бол яг таны хэлж байгаа саяын тэр импортолсон бүтээгдэхүүний үйлдвэрлэл, зориулалт, зарцуулалт гэдэг юм уу түүний тэр стандарт дээр хяналт тавих чиг үүрэгтэй байгууллага нь бол Уул уурхайн яам байгаад байгаа. Ашигт малтмал, газрын тосны газар байгаад байгаа. Хуучнаар бол Мэргэжлийн хяналтын ерөнхий газрууд бол байгаад байгаа. Энэ дүгнэлт дээр ярьж байгаагаар энэ хяналтын газрууд нь хяналтынхаа тавих чиг үүргээ бол хангалтгүй хэрэгжүүлсэн л гэсэн ийм л дүгнэлтийг бол ямар ч Аудитын дүгнэлт, тайлан дээр бол байгаад байгаа.

Тэгэхээр би танд Төсвийн байнгын хороонд ирүүлсэн энэ Аудитын дүгнэлтийн хүрээнд болоод Үндсэн хуулийн цэц дээр илэрхийлсэн байр суурийнхаа хүрээнд л тайлбар өгөх бол боломжтой байна л гэдгээ эцэст нь хэлэх байна.

Л.Мөнхбаатар: Тодруулж асууя. Цогтгэрэл гишүүн тодруулья 1 минут.

О.Цогтгэрэл: Тэгэхээр энэ хуурамч, хуурамч бишийн тухай яриа, стандартад нийцсэн, стандартад нийцээгүйн тухай яриа нь өөрөө яг энэ маргааны үндсэн эх сурвалж болсон тэр

мэргэжлийн байгууллага нь ямарваа нэгэн дүгнэлт гаргалгүйгээр ямарваа нэгэн тэрний аль нэг талдаа дүгнэлт байхгүй, хуульд нийцсэн эсэх, стандартад нийцсэн эсэх гэдэг дүгнэлт гаргалгүйгээр бид нар энэ яг энэ асуудлыг яриад тэр тусмаа Цэц үүгээр дүгнэлт гаргаад, магадгүй яах вэ тэр татвартай холбоотой дүгнэлтүүд бас яваа юм шиг байна лээ.

Тэгэхээр энэ бол үнэхээр энэ дээр хувь гишүүдийн хувьд итгэл үнэмшилтэйгээр асуудалд оролцоход үнэхээр боломжгүй л юм байна. Энэ хуульд нийцсэн, стандартад нийцсэн бүтээгдэхүүний тухай бол дэмжмээр, хуульд нийцээгүй, стандартад нийцээгүй бүтээгдэхүүний тухай яриа бол энийг эсэргүүцмээр.

Тэгэхлээр энэ тухай нь ямарваа нэгэн дүгнэлт байхгүй. Тэгээд бид нар энийг зөв, буруугийн тухай дэнсэлнэ гэдэг тэр бензин, дизелийн тосыг бид нар амталж, үнэрлэж байгаад сайн, муу, нийцсэн, нийцээгүй, эрүүл мэндэд зөрчсөн, зөрчөөгүй.../минут дуусав./

Л.Мөнхбаатар: Тодруулгад нь Хууль зүйн байнгын хорооны дарга Баттөмөрийн Энхбаяр хариулья.

Б.Энхбаяр: Үгүй яах вэ манай Байнгын хороон дээр яригдаж байхад энэ үнэхээр хүн амын эрүүл мэндэд хортой, үндэсний тэр бүүр зүйл бол, энэ чинь Татварын хуульд татвар авах биш бүүр өөр харилцаа хуулиар хориглох харилцаа болно шүү дээ гэдэг асуудал бол хөндөгдөж байсан. Татвар авч байгаа бол энэ чинь бид зөвшөөрсөн бараа бүтээгдэхүүнээсээ татвар авч байгаа шүү дээ. Тийм бүүр болохгүй юм бол энэ чинь татвар авах ёстой ч асуудал биш болж хувирна гэсэн үг. Энэ Татварын хуулийн асуудал биш байхгүй юу гэдэг ийм яриа хөөрөө яригдаж байсан гэдгийг хэлье.

Л.Мөнхбаатар: Одоо Баагаагийн Баттөмөр гишүүн асуултаа асууя.

Б.Баттөмөр: Манай Их Хурал энэ асуудлыг маш шуурхай хэлэлцэж байна. Их сайн байна. Өнгөрсөн 5 дахь өдөр үдээс хойш Цэц хуралдаад 1 дэх өдөр дүгнэлтээ авчирч өгөөд, 2 дахь өдөр Хууль зүйн байнгын хороогоор ороод, 3 дахь-д Төсвийн байнгын хороогоор ороод, өнөөдөр чуулганаар хэлэлцэж байна.

Бүх асуудалд л ингэж л хандах ёстой юм байгаа юм. Эндээс чинь л энэ ард түмний хардлага гэдэг юм чинь үүсээд байгаа шүү дээ. Энд сая Цогтгэрэл гишүүний асуусан асуултад хариулахгүй юм байгаа юм шүү дээ. Сайд нь алга. Уул уурхайн сайд уг нь энд байж байх ёстой шүү дээ. Энийг энэ чинь Цэцийн дүгнэлтийг 14 хоногийн дотор хэлэлцэх ёстой шүү дээ. Яагаад 6-хан хоног болгоод ингэж хандуулаад байна. Энэ мэргэжлийн байгууллагуудаасаа тэр чанарт үнэхээр бүтээгдэхүүн мөн юм уу, биш юм уу гэдгийг дүгнэлт гаргуулж болно шүү дээ энэ чинь. Үйлдвэрлээд яваад байгаа юм чинь бас нэг юм байгаа байх үнэн, худалч гэсэн. Тэрийг нь бас үзэж болно шүү дээ. Тэр нь байхгүй.

Энэ 2018 онд жишээлбэл сүүлийн үед нийт гаднаас авсан шатахуунаасаа борлуулалтын хэмжээ нэмэгдчихсэн байгаад байгаа байхгүй юу. Жишээлбэл, 2018 онд 48 хувиар импортоосоо борлуулалтад авчихсан, 2019 онд 19 хувиар давчихсан, 20 онд бүүр 66 хувиар давсан гээд ингээд энэ Аудитын тайланд байж байгаа байхгүй юу. Энэ л нөгөө л ингээд л найруулдаг юм чинь л явж байгаа байхгүй юу. Төвөгтэй энэ одоо. Энэ яах вэ ядуу буурай орнуудад очиж мөнгө угаадаг л схем л дээ. Африкийн хэдэн орнуудаас хөөгдөөд тэгээд л одоо Монголд ирчихсэн тэгээд л. Ингэж яарч ингэж хэлэлцдэг нь бол бас хардлага төрүүлж байгаа юм. Энэ вокзал дээр, төмөр зам дээр 360 вагон зогсож байгаа гэж байгаа шүү дээ. Тэрийг энэ бид хүлээгээд авчих юм болов бол онцгой татваргүй энэ бүтээгдэхүүнүүдээ авах ийм нөхцөл бүрдэх юм байна. Тэгээд энэ тэрийг сайн үзэх ёстой.

Энд нэг аюултай юм байгаа юм. Сая тэр Энхбаярын хэлж байгаатай л би санал нэг байна л даа. Үнэхээр энийгээ тодорхойлчих хүний биед эрүүл бас нөлөөгүй гэх юм бол энийгээ тэр татварынхаа асуудлыг дахиад ярих байх, нөлөөтэй юм бол энийг хориглох асуудал ярих ёстой. Монголын энэ агаарын замаар өвчлөгсдийн тоо бол дэлхийн дунджаас 10 дахин их, нас барагчдын тоо 4 дахин их байгаа. Энд бол энэ хуурамч гэж нэрлэгдэх шатахууны асуудал бол орно шүү дээ. Тэгээд ийм байгаа юм л даа. Тэгээд өнгөрсөн 2015-2021 он хүртэл 193 тэрбум, 200 тэрбум төгрөгийн онцгой татвар улсын төсөвт орох тийм боломж алдсан байгаа байхгүй юу. Энэ бол энэ жилийн төсөвт өөрчлөлт орох ёстой бас. Ингээд хүлээгээд авчих юм бол энэ хэмжээ чинь 20, 30 хувиар онцгой татварын хэмжээ буурна нэгдүгээрт.

Хоёрдугаарт бол энэ шатахуун импортлогч компаниудыг л лоббид л гээд байгаа байхгүй юу. Эд нар чинь тэр онцгой татвараа, бүх татвараа төлж байгаа шүү дээ. Тэгэхлээр энэ яагаад ингээд төлдөггүй юм бэ? Энийг оруулж ирээд оруулж ирээд хийж байгаа юм бол хэрвээ шатахуун үйлдвэрлэж байгаа бол онцгой татварыг нь авах ёстой. Нэг ч үйлдвэрлэл байхгүй. Монголд энэ Аудитын энэ дүгнэлтэд байж байгаа шүү дээ. 22 аж ахуй нэгжид төслөөр нь үйлдвэрийн зөвшөөрөл олгочихсон. Үйлдвэрлэж байгаа нэг ч үйлдвэр байхгүй. Энэ Цэцэд өргөдөл гаргасан, гомдол гаргасан улсуудын ч байхгүй гээд энэ нэрээр нь заачихсан байж байгаа шүү дээ. Ийм л аюултай юм байгаа юм л даа. Тэгээд Хүний эрхийн конвенцын их олон зүйл, заалтыг зөрчиж байгаа тийм л эд байгаа юм. Энэ дээр та бүгд өөрснөө дүгнэлтээ.../минут дуусав./

Л.Мөнхбаатар: Цэцийн дүгнэлтийг хэлэлцдэг тусгайлсан дэгтэй. 82 дугаар зүйлээр Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хэлэлцэх журмыг баталсан байгаа. Энд бол Үндсэн хуулийн цэц

дүгнэлт гаргасан бол түүнийг ёсчилсноос хойш 24 цагийн дотор Их Хуралд ирүүлэх дэгтэй. Энэ Цэцийн дүгнэлт ирснээс хойш Цэцийн дүгнэлтийг чуулганы үеэр хүлээж авсан бол 7 хоногийн дотор, чуулганы чөлөө цагт хүлээн авсан бол ээлжит болон ээлжит бус чуулган эхэлснээс хойш 5 хоногийн дотор Хууль зүйн болон холбогдох Байнгын хороогоороо хэлэлцэж санал, дүгнэлт гаргана гэсэн ийм дэгтэй. Энэ дэгийн дагуу хэлэлцэгдэж байгаа гэдгийг хэлье.

Баттөмөр гишүүний асуултад хэн хариулах вэ? Төсвийн байнгын хорооны дарга, Баттөмөрийн Энхбаяр Хууль зүйн байнгын хорооны дарга хариульа.

Б.Энхбаяр: Баттөмөр гишүүн бол манай Хууль зүйн байнгын хорооны хуралдаанд оролцож бас яг энэ байр суурь илэрхийлж, асуулт асууж, хариулт авсан. Улсын Их Хурлын дэгийн хуульд зааснаар бол Цэцийн дэг гаргасан шийдвэртэй холбоотойгоор Улсын Их Хурлыг төлөөлж Үндсэн хуулийн цэцийн маргаанд орсон итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс асуулт асууж, хариулт авна гэсэн ийм дэгтэй.

Баттөмөр гишүүний хөндөж тавьж байсан асуудал бол илүү Үндсэн хуулийн цэц буюу тэр шийдвэр гаргасан этгээд Баттөмөр гишүүний энэ хөндөж байгаа асуудалд бүрэн дүүрэн хариулт өгөх ийм боломжтой байсан. Тийм асуудал хөндөж асуугаад байсан. Ер нь Улсын Их Хурал цаашдаа энэ дэгийн хуулиа бас боловсронгуй болгоод энэ удаа дараа Цэцийн дүгнэлт хөндөгдөхөд ийм асуудал гараад байгаа юм. Үндсэн хуулийн цэцээсээ асуулт асуумаар байгаад байгаа юм гишүүд ер нь. Гаргасан байгууллагаасаа. Тэгэхгүй болохоор жишээлбэл, Тэмүүлэн гишүүн шийдвэр гаргасан этгээд нь бас биш байгаад байгаа юм. Итгэмжлэгдсэн төлөөлөгч. Тэгэхээр Цэцийн өмнөөс буюу Цэцийн нөгөө шийдвэр гаргасан байгууллагыг төлөөлөөд яг хариулт өгнө гэхээр бас тийм байдалтай ийм болчхоод байна.

Ер нь манай жишээлбэл шүүхийн хуулийг хэлэлцэж байхад яг энэ асуудал дээр жишээлбэл ганцхан Үндсэн хуулийн цэцээс биш, тухайлбал тэр нөгөө хуулийг яг хэрэглэж шийдвэрээ гаргаад байгаа Улсын дээд шүүхээс жишээлбэл гишүүд асуулт асуумаар байна гээд байсан байхгүй юу. Тэгж байж нөгөө хуулиа илүү зөв, буруу гаргах гэж байна уу, үгүй юү гэдгийг илүү их мэдэж байж энэ хууль тогтоох үйл ажиллагааны чанар, хүртээмж илүү сайн болох агуулга бас байгаад байгааг ер нь энэ цаашдаа бас бид анхаарч, Үндсэн хуульд орсон өөрчлөлтийн дагуу би дэг шинэчлэгдэнэ гэж ойлгож байгаа.

Тэгээд энийг, энэ Дэгийн хуулийг хийх ажлын хэсэг маань бас анхааралдаа авч л яагаад баймаар юм байна лээ. Тэгэхгүй бол яг хүний өмнөөс хариулах болчихоод байгаа байхгүй юу. Тэгэхээр хүний өмнөөс юу бодож яв гэдгийг тааж мэдэж хариулалтай ч биш, өөрийнхөө бодлыг жишээлбэл би ч тэр, Тэмүүлэн гишүүн ч тэр Байнгын хороог төлөөлж хариулаад байдаг, Байнгын хороо чинь бас хамтын шийдвэртэй байгууллага байдаг. Өөрийнхөө бодлоор хариулаад байлтай биш ийм юм яг энэ Цэцийн шийдвэрийг хэлэлцэх дэг дээр яг үүсээд байгаа.

Л.Мөнхбаатар: Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуултаа асууя.

Б.Пүрэвдорж: Энэ богинохноор хуурамч шатахуун гэж яригдаад байгаа энэ хуулийг 2021 оны 07 сарын 04-ний өдөр манай энэ Их Хурлын гишүүд баталсан байгаа. Тэгээд энэ хурал дээр хэлж байсан мэргэжлийн дээрээс нь яг энэ Ёндон сайдын үгийг би та бүхэнд давтаж хэлж өгье. Дэлхий нийт Евро-5 бензинийг хэрэглэхээр зүтгэж байна. Үүний хүхрийнх нь ислийн хэмжээ арав, энэ нэг саяд 10 хэсэг байна гэж. Өөрөөр хэлбэл 10 PPM байна л гэж.

Гэтэл энэ хүнд фракцаар хольсон энэ шатахуун 5000-аас дээш PPM-тэй байна гэж байгаа юм. Өөрөөр хэлбэл европчууд 10 PPM-тэй шатахуун хэрэглэж байхад манайх 500 дахин хортой 5000-аас дээш PPM-тэй ийм шатахууныг энэ хольцын хүрээнд хэрэглэдэг болж байгаа юм. Энэ мэргэжлийн хүний хэлсэн үг шүү.

Тэгээд энэнээс үүдээд үүдээд ерөөсөө ингээд одоо хямд тэр хүнд фракцын хольцыг хэн авдаг вэ гэх дээр төрийн өмчийн компаниуд авдаг. Тэгээд энэ Улаанбаатар хотын шатахууны энэ автобусны компаниуд авдаг хямдхан үнэтэй болохоор. Тэр нь тэгээд хар утаа хаядаг. Хоёрхон жилийн өмнө энэ хууль батлагдахаас өмнө тэр замын хажуу талын гэрлийн шон 50 см хүртлээ тас хар байсныг санаарай. Одоо тийм юм байхгүй болсон. Хүнд фракц чинь 1 метрээс дээш дэгддэггүй юм. Бид нар тэргийг чинь амьсгалдаггүй байхгүй юу. Биднийг хөтөлж яваа тэр алдрай үрсэд чинь тэргийг чинь амьсгалж өвддөг байхгүй юу. Хүүхдүүд чинь өчинөөс салахгүй удаан шаналж байгаад байгаагийн гол шалтгаан чинь энэ шүү дээ. Тэр нүүрснээс чинь хортой байхгүй юу даа. Дээрээс нь цахилгаан карбюратор машины цахилгаан карбюратор тэр дизель аппаратурыг чинь жил болгоод л эвдээд хаячихдаг, Монголчуудыг бүгдийг нь хохироодог. 1 жилдээ 230000 тонн керосин, нафта орж ирээд холиод тэрийгээ зах зээл дээр гаргадаг. Тэндээсээ татварын зөрүү, үнийн зөрөөнөөс 100 тэрбум төгрөгийн ашгийг олдог. 2000 хэдэн онд ч билээ 2, 3 Орос зүгээр үүргэвчтэй, пүүзтэй Улаанбаатар хотын вокзал дээр буусан гэж байгаа юм. Тэд нар өнөөдөр Швейцарын иргэншилтэй тэр нөхдүүд Сингапурт амьдарч байна. Бид нарыг өвтгөн өвтгөн бид нарыг хохироон хохироон тэр хүмүүс жилдээ 100 тэрбум төгрөгийн ашигтай тэнд ажиллаад ингээд явж байна. За яах вэ тэгээд би нэг зүйлийг л хэлж байгаа юм. Одоо энэ Аудитын дүгнэлт, шинжээчийн дүгнэлтээр байна шүү дээ тийм ээ нийт Чойр дээр Чойр

хавьд тэн дээр хольж байгаа нийт 80 хувийг нь, бараг 90 хувийг нь хольдог.

Тэгээд би тэнд, тэгээд энэ Аудитын дүгнэлтээр тэнд үйлдвэр байхгүй гээд гарчихсан шүү дээ. Үйлдвэр байхгүй. Үгүй тэгээд би одоо энийг ингээд дэмжээд үйлдвэрлэлд хохирол учруулж байна гэж хэлж яриад байгаа тэр хүмүүст би ганцхан л зүйл хэлж байгаа юм. Үгүй тэнд очоод нэг зураг аваад үйлдвэр надад үзүүлчих юм бол би энэ тэмцлээсээ больчихъё л гэж байна шүү дээ. Тэгээд ийм асуудалтай юмыг өнөөдөр ингээд оруулаад энэ дээр хэлэлцэж байгаад би их харамсаж байгаа.

Тэгэхдээ би 2 жилийн өмнө ялсан. Би энэ асар их мөнгөний эсрэг зогсож би ялсан, өнөөдөр ялагдаж байна. Бас ялагдлын шалтгаан нь бол Анандбазар энэ Баттөмөр гэдэг хоёр нөхөр бас энийг ярьж явсантай холбоотой байхгүй юу. Миний тэмцлийг хүчгүй болгож байгаа юм.

Тэгэхдээ тун удахгүй ийм хортой бүтээгдэхүүнээр эсрэг тэмцэж байсан байна гэдгийг Монголын ард түмэн мэднэ. Тэгэхэд би ялна.

Л.Мөнхбаатар: Пүрэвдорж гишүүн байр сууриа илэрхийлж үг хэллээ. Одоо Ширнэнбаньдын Адьшаа гишүүн асуултаа асууя.

Ш.Адьшаа: Би асуулт байхгүй, үг хэлчихье. Өнөөдөр Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн энэ дүгнэлтийг Улсын Их Хурал хэлэлцэж байна. Энэ цэцийн дүгнэлтийг би дэмжиж байгаа. Өнөөдөр энэ хуурамч шатахуун, үнэнч шатахуун гэдэг нийгмийг талцуулсан энэ асуудлыг бид гаргаж ирж хэвлэл мэдээлэл, бүх сувгуудаар л ингээд л аймшгийн юмыг Монгол улс нүүрлэсэн мэтээр ингэж ярьж байна. Энэ хуурамч шатахуун гэдэг юу хаанаас гарч ирсэн юм, яг энийг хэдэн машин, техник эвдэрсэн юм гэдэг судалгаа өнөөдөр байхгүй байна. Энэ Оросын зах зээлийг зээл шатахуун, тослох материалын зах зээлийг Монгол Улсад нийлүүлж байгаа хэдхэн тооны

хүмүүс байгаа, хэдхэн тооны компаниуд байгаа. Бид 70 жил энийг эдэлж хэрэглэж ирсэн.

Гэтэл энд 2 дахь, 3 дахь зах зээлийг оруулж ирэхээр яагаад эсэргүүцээд байна. Энэ баруун Европын орнууд, түүнчлэн Дундад Азийн орнуудад энэ технологийг чинь хэрэглээд, нэвтрүүлээд өнөөдөр гаргаад ирлээ. Нэг орны хараат байдлаас бид нар яагаад гарч болдоггүй юм. Яагаад 3 дахь зах зээл байж болдоггүй юм. Хуурамч шатахуун гэдэг айдас хүйдсээр ард түмнийг айлгаж цаана бизнес хийдэг ийм бохир технологи болих хэрэгтэй байна. Бид нар энэ дээр дүгнэлт хийх хэрэгтэй байна. Үнэхээр өнөөдөр Монголын Засгийн газар Монголын төрөөс хуурамч, хуурамч бишийг тогтоосон нэг ч баримт өнөөдөр байхгүй байгаа. Зүгээр л тийм ам яриа үлгэр PR л яваад байгаа болохоос биш би энэ асуудлыг бас зохицуулахын тулд Улсын Их Хурлын гишүүний хувьд би хуулийн төсөл өргөн барьсан юм. Их Хурал хэлэлцэхгүй байгаа юм, хэлэлцэхийг хүсэхгүй байгаа юм.

Тэгээд би энэ Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар гэдэгт би асуулт тавьсан. Надад өнөөдөр албан ёсоор 4 сарын 10-ны өдөр хариулт ирүүлсэн. Нэг ч тийм гомдол тэмцэл ирээгүй байна гэж энэ албан ёсоор энэ Их хурлын гишүүд надаас аваарай, хэвлэлийнхэн аваарай. Дээр нь өнөөдөр энэ Монгол улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газраар дамжуулж төрийн өмчит компаниудын олон техник хэрэгсэл эвдэрсэн гэдэг асуудлыг ярьдаг. Үүнийг сөхөж ярьснаас хойш олон зүйл нэвтрүүлэг хийж энийг хэлсэн хүн бүхнийг хардуулахыг оролдсон ийм юмыг та бүгд харж байгаа. Энийг ярьсан хүн Ардын баатар, энийг ярьсан хүн ардын дайсан хоёр ийм төгсгөл дээр бид нар байж байна. Өнөөдөр төрийн өмчит 100 гаруй компаниас энэ бичигч нэг ч тийм техник эвдэрсэн гэсэн юм байхгүй байна. Энийг та нар Их Хурлын гишүүд энэ материалыг үзээрэй.

Дээр нь өнөөдөр энэ Улаанбаатар хотын Эрүүл мэндийн газар, Нийслэлийн Стандартын газраас агаарын бохирдол, эрүүл мэндэд ирсэн талаар нэг ч гомдол ирээгүй гэж албан ёсоор ирүүлсэн байгаа юм.

Тэгэхлээр бид нар өнөөдөр 3 дахь зах зээлийг оруулья, хэрэглэгч хаан гэдэг байр суурийг хийе. Монгол Улсын Үндсэн хууль өнөөдөр хууль дээдлэх зарчмын хүрээнд татвар, төсөвтэй холбоотой асуудлыг Засгийн газар шийднэ гэсэн энэ зарчим алдагдсан байна л гэсэн. Цэц хэн нэгэн бизнесийг зөрүүлж хууль гаргаж болохгүй л гэсэн ийм л асуудлыг ярьсан шүү дээ.

Л.Мөнхбаатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо Байнгын хороодын саналаар санал хураалт явуулна. Гишүүд байраа эзэлье. Санал хураалт явуулахын өмнө санал хураалт явуулах ерөнхий журмын дагуу хууль сануулья.

Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 14.10-т гишүүн хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой үйл ажиллагааны үр дүнд өөрөө болон гэр бүлийн гишүүд нь орлого олж байгаа, эсхүл бусад хэлбэрээр ашиг сонирхлын зөрчилтэй бол энэ тухай хуралдаан даргалагчдад урьдчилан мэдэгдэж санал хураалтад оролцохгүй гэсэн энэ заалтыг сануулья.

Ингээд Байнгын хороодын саналаар санал хураалт явуулья. Санал хураалт, 6 санал хураалт байна.

1.Онцгой албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн 4.1.5 дахь заалтад “газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн, керосин.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... тэгш байдал, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж заасныг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн

дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураая. Санал хураалт.

71.8 хувиар санал дэмжигдлээ. Дараагийн санал хураалт.

Онцгой албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн хүснэгтийн 6 дахь заалтад “Газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн, керосин, 1 тонн” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... тэгш байдал, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж заасныг зөрчсөн байна гэсэн саналын томьёоллоор санал хураая. Санал хураалт.

71.8 хувиар санал дэмжигдлээ.

3.Онцгой албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн хүснэгтийн 10 дахь заалтад “Газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн, керосин, 1 тонн, 285 000 төгрөг” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... тэгш байдал, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураая. Санал хураалт.

69.2 хувиар санал дэмжигдлээ.

4.Онцгой албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн 4.1.5 дахь заалтад “газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн, керосин.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсгийн “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.” гэж заасныг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн

саналын томьёоллоор санал хураая. Санал хураалт.

69.2 хувиар санал дэмжигдлээ.

5.Онцгой албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн хүснэгтийн 6 дахь заалтад “Газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн, керосин, 1 тонн” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсгийн “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.” гэж заасныг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураая. Санал хураалт.

71.8 хувиар санал дэмжигдлээ.

6.Онцгой албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн хүснэгтийн 10 дахь заалтад “Газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн, керосин, 1 тонн, 285 000 төгрөг” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсгийн “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.” гэж заасныг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураая. Санал хураалт.

71.8 хувиар санал дэмжигдлээ.

Байнгын хороодын саналаар санал хурааж дууслаа. Одоо тогтоолын төслийг танилцуулъя.

Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн 2023 оны 4 дүгээр дүгнэлтийн тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн томьёоллоор санал

хураалт явуулна. Тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын тогтоол, Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 04 дүгээр дүгнэлтийн тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.2.3 дахь заалт, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан Төсвийн болон Хууль зүйн байнгын хорооны хуралдаанаас гаргасан санал, дүгнэлтийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Онцгой албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн 4.1.5 дахь заалтад газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн, керосин гэж, 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн хүснэгтийн 6 дахь заалтад газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн, керосин, 1 тонн, 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн хүснэгтийн 10 дахь заалтад газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн керосин, 1 тонн, 285 000 төгрөг гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн тэгш байдал, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн, 5 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна гэснийг тус тус зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 04 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

Санал хураалт. Уг санал 70 хувиар дэмжигдлээ. Тогтоол батлагдлаа.

Тогтоолын эцсийн найруулгатай саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Дараагийн асуудалдаа орёе.

17.27 цаг

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Гонгорын Дамдинням танилцуулъя. Таныг индэрт урьж байна.

Г.Дамдинням: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 06 дугаар сарын 24-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Боловсролын ерөнхий хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг өдөр Улсын Их Хурал 2021 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо 2023 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаараа Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу зүйл бүрээр хэлэлцэн дараах санал дүгнэлтийг та бүхэнд танилцуулж байна.

1.Боловсролд хүүхэд бүр тэгш хамрагдах, суралцагчийн ялгаатай хэрэгцээнд тохируулан хичээл, сургалтын үйл ажиллагааг зохион байгуулна.

2.Суралцагчийн дийлэнх олонх нь хүн амын өөр хэл бүхий үндэстний болон хэлний цөөнх байх тохиолдолд сургалтыг хос хэлээр зохион байгуулах ахлах

сургуулийг сургалтын хөтөлбөрөөс нь хамаарч төрөлжүүлнэ.

3.Сургуулийн өмнөх болон боловсролд өмнөх боловсролд 2-5 настай хүүхэд хамрагдах бөгөөд 5 настай хүүхдийг заавал хамруулна.

4.Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүсэлт гаргаж бага ангийн сургалтын хөтөлбөрийг гэрээр эзэмшүүлнэ.

5.Ерөнхий боловсролын сургуульд номын санч, цэцэрлэгт сэтгэл зүйч, хоол зүйч ажиллуулна.

6.Зайн болон цахим боловсролыг хөгжүүлж, хүүхэд хаана амьдарч байгаагаас үл хамааран сайн багшаас боловсрол эзэмших зэрэг асуудлыг зохицуулахаар тусгалаа.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрэм ерөнхий боловсролын сургуулийн номын санчийг олон улсын жишигт нийцүүлэн номын санч багш гэж нэрлэх нь зүйтэй гэсэн саналыг хэлсэн болно. Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваанаас хөдөө аж ахуйн салбарт ажилладаг иргэдийн хүүхдийг 7 настайгаас сургуульд элсүүлэх талаар гаргасан зарчмын зөрүүтэй саналыг Ерөнхий боловсролын хуульд тодорхой тусгасан тул давхардуулах шаардлагагүй гэж үзэн Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй.

Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх тус Байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг та бүхэнд тур тараасан.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд
ээ,

Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрөөтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгийн ахлагч Гонгорын Дамдинням гишүүнд баярлалаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулья.

Боловсрол, шинжлэх ухааны сайд Лувсанцэрэнгийн Энх-Амгалан, Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд Ганболдын Ганбаяр, Боловсролын ерөнхий газрын дарга Төмөр-Очирын Ням-Очир, Боловсрол, шинжлэх ухааны яамны Сургуулийн өмнөх боловсролын хэлтсийн дарга Жадамбын Мягмар, Боловсрол, шинжлэх ухааны яамны Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын шинжээч Жамцын Нарантуяа, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн секторын эрхлэгч Ухнаагийн Туяа, Боловсрол, шинжлэх ухааны яамны Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах шинжээч Чимэдрэгзэнгийн Баярмаа, Боловсрол, шинжлэх ухааны яамны Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Арьяагийн Цолмон, Монголын боловсрол, шинжлэх ухааны үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга Замбалын Цогтгэрэл. Эдгээр хүмүүс чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож байна.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Байхгүй байна.

Батжаргал гишүүнээр тасаллаа. Монгол Ардын намын бүлгийн дэд дарга Жигжидийн Батжаргал асуултаа асууя.

Ж.Батжаргал: Баярлалаа.

Тэгэхээр энэ сургуулийн өмнөх хийгээд Ерөнхий боловсролын сургуулийн тухай хууль бол яах аргагүй энэ Монгол Улсын бүх нэгжүүдэд үйлчилж байгаа гол хууль байх ёстой гэж ингэж хараад байгаа. Энэ биднүүс үндэсний өв соёл бүх юмаа тээдэг хүмүүсийг л төлөвшүүлэх тухай л ярьцгаагаад байгаа л даа. Тэгээд тэр СӨБ-ын хөтөлбөрийн ЕБС-ын агуулга эд нарыг хуульчилж оруулсан юм билээ. Тэр дотор тэр үндэсний гэдэг үг юмнууд ер нь байхгүй. Тэрүүнийг ер нь яаж хангана гэж ойлгоцгоогоод байна. Дэлхий нийтээрээ өөр өөрийнхөө үндэстнийг бэлтгэх тухай асуудал яригдаад зарим манай нэлээн тийм сэтгэгч маягийн улсууд ярихаараа зэрэг бид энэ барууны боловсрол гэдэг юм уу, олон улсын стандарттай боловсрол эзэмшүүлээд байгаа нь хүний хүн бэлдээд байна гэдэг юм яриад байгаа шүү дээ.

Тэгэхээр зэрэг тэр үндэстнээ бэлтгэх үйл ажиллагаа чинь энэ хуульдаа ер нь яаж зохицуулагдаж орсон юм бэ гэдэг нэг ийм асуудлыг ажлын хэсгээс асуумаар байна. Та хэд энэ анхны хэлэлцүүлгийн үед яаж энэ асуудлыг одоо харав гэж.

Хоёр дахь зүйл байгаль цаг уур, эдийн засгийнх нь чиглэл бас тодорхой онцгой нөхцөл байдлаас уялдуулаад хичээлийн жилийн эхлэх хийгээд дуусах амралт энэ тэрийг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн зохицуулж болохоор ийм заалт байгаа юм. Энэ заалт бол яах аргагүй бас энэ хөдөө аж ахуйн салбарын цаг үеийн ажил, асуудлуудыг нь нугалах, тэр тусмаа энэ хүүхэд багачуудыг бага наснаас нь энэ өөрсдийнхөө үндэсний ахуй амьдралтай ойртуулах бас хөдөлмөрийн хүмүүжил төлөвшилтэй хүн болгож гаргахад бол их зөв л заалт л орчихлоо л доо.

Гэхдээ өнөө ерөнхий хичээлийн жилийн эцсийн шалгалт шүүлэг балансжуулалтыг хооронд нь зохицуулах талын асуудлыг ер нь давхар юу гэж харж байгаа вэ. Жишээ нь 12 дугаар ангийн хүүхдүүд чинь элсэлтийн ерөнхий шалгалт улсын хэмжээнд нэг л яваад байгаа шүү дээ. Гэтэл эхэлдэг, барьдаг цаглавар юмнуудаа өөрчилнө гээд ингээд шийдэл хийчихээр зэрэг үүнтэйгээ ер нь ямархуу байдлаар хангагдаж орох вэ гэдэг нэг ийм асуудал байна. Үүнийг одоо юу гэж ойлгоод байна гэж.

Дараагийн нэг зүйл ийм сонин юм байгаад байх шиг байгаа юм. Ерөнхий боловсролын сургуулиудад дотор багш мэргэжлийн сонгон хичээллүүлж болдог, тэрийгээ амжилттай төгсөнгүүт нь багш бэлтгэх их, дээд сургуульдаа төрийн хөнгөлөлттэй сурч болох тухай ийм заалт яваад байгаа юм. Тэгээд тэрийг ажиллуулах, барих, тэр сонгоныг хичээллүүлэх барих тэр бүх журам юмнуудыг нь боловсролын асуудлаа хариуцсан Засгийн газрын гишүүн батлахаар ингээд орчихжээ. Тэрний шалгалт юмнуудыг нь ямархуу байдлаар авагдаж барих, тэгээд үнэхээрийн төрөөс үзүүлэх гэж байгаа хөнгөлөлт юмнууд гэдгээ ер нь одоо та нар хуульд үг, үсэг оруулахыг бодоход барагцаа юм томсгосон тооцоогоор харсан байлгүй дээ. Ер нь хэдий хэмжээний хүн энэ хэмжээний сонгонд хамрагдах уу, үүнд ямар хэмжээний хөнгөлөлт үзүүлэх вэ, ийм бололцоо боломж одоо бидэнд энэ орон нутгуудын чинь ерөнхий боловсролын сургуулийн материаллаг бааз, боловсон хүчний нөөц энэ бүх юм нь байгаа юу энэ тэр гээд нэлээн том тооцоолуудыг хийсэн байх гэж би ингэж бодоод байна.

Л.Мөнхбаатар: Батжаргал гишүүний асуултад хариулъя. Ажлын хэсгийн ахлагч Гонгорын Дамдинням хариулъя.

Г.Дамдинням: Батжаргал гишүүн маань их чухал асуулт асууж байна.

Ялангуяа бас энэ Монгол хүний нэг ийм цүлх ухаан, Монгол хүний нэг өөрийн онцлог өв уламжлалтай холбоотой асуудал дээр манай Батжаргал гишүүн бас их тодорхой ярьж, анхаарал тавьж, санал өгч явсан. Тэгээд энэ дээр би Батжаргал гишүүндээ хэлэхэд энэ бид нар 2020 оны сонгуулийн дараа орж ирээд үйл ажиллагааны хөтөлбөр баталсан, үндсэн чиглэл баталсан. Ингэхэд олон улсад өрсөлдөх чадвартай үндэсний боловсролын тогтолцоо бий болгоно гэж зорьсон. Энэний хүрээнд бид нар таны саяын хэлсэн агуулгыг Боловсролын ерөнхий хуулийн 14 дүгээр зүйл, өөрөөр хэлбэл 2 дугаар бүлэг буюу 14 дүгээр зүйл боловсролын хөтөлбөр, агуулга, стандарт гэсэн хэсэгт 14.1-д одоо оруулсан байгаа юм.

Юу гэж оруулсан байгаа вэ гэхээр албан боловсролын агуулга нь суралцагчийн нас, хөгжлийн онцлог, авьяас, сонирхол, хүн, хувь хүний болон нийгмийн хэрэглээ, үндэсний соёл, өв уламжлал, шинжлэх ухаан, технологийн хөгжлийн хандлагад нийцүүлэн боловсролын зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэнэ гээд. Ерөнхий хуулийн 14.1-д одоо бид нар ингээд тодорхой оруулчихсан. Тэгэхээр хөтөлбөр дээрээ энийгээ тусгаад явна гэсэн үг.

Хоёр дахь асуултын тухайд бид Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль дээр хичээлийн жил эхлэх болон дуусах хугацааг 5.8 дээр нь СӨБ, ЕБС-ийн хууль дээр заачихсан юм байгаа юм. Тэгээд хэд бид нар бас нэг юмыг ойлгоорой. Юу вэ гэхээр энэ багц хууль бие биедээ ингэж харилцан үйлчлэлтэй зохион байгуулагдсан, нягт уялдаатай ийм л хууль явж байгаа юм.

Тэгээд хуулийн төслийн ажлын хэсгийн хэлэлцүүлгийн явцад нэлээн саналууд орж ирсэн. Жишээ нь намрын ид ажлын үеэр энэ оюутан, сурагчдыг 10 сарын 1-нээс хичээлдээ эхлүүлж байвал яасан юм бэ гэж. Ийм санал нэлээн давуу,

бүүр судалгаа, шинжилгээтэй ч хүмүүс уулзаж байсан.

Тэгээд энэ дээр бол бид нар 5.8 дээр заачихсан байгаа хичээлийн жил эхлэх, үргэлжлэх, дуусах болон ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн амралтын хугацааг өөрчлөх, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн сургалтын үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоохыг хориглоно гэж. Өөрөөр хэлбэл онцгой нөхцөл байдал гарахаас бусад тохиолдолд боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналаар ингээд шийднэ. Энэ дээр тасалдуулахгүй байх талаас нь л ялангуяа СӨБ, ЕБС-ийн хууль дээр тусгаж өгсөн байгаа.

Дараачийн асуултыг нь гурав дахь асуултыг нь Энх-Амгалан сайд хариулчихвал зохимжтой.

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгийг нэмж хариулж болно. Ажлын хэсэг дээр хэн байна. Дэд сайд хариулах уу. Дэд сайд хариулъя. Хэддүгээр микрофон бэ. 82 дугаар микрофон өгье. Ажлын хэсгийн.

Г.Ганбаяр: Батжаргал гишүүний асуултад хариулъя. Тэр хичээл* сургуулийн үйл ажиллагаа дээр зохицуулалт оруулах юм бол шалгалт нөхөх үү гээд байгаа. Тэгээд энэ яг энэ өнөөдрийн хэлэлцэх эсэх, эхний хэлэлцүүлэг хийгдэж байгаа Сургуулийн өмнөх болоод ерөнхий боловсролын тухай хуулийн 5.6, 5.7, 5.8 дээр энэ агуулгуудыг маш тодорхой заагаад өгчихсөн. Энэ дээр хичээлийн жилийн эхлэх, үргэлжлэх хугацаа өөрчилсөн тохиолдолд сургалт, үйл ажиллагааны агуулгыг нөхөн эзэмшүүлэх ажлыг төлөвлөн зохион байгуулна гээд үүрэгжүүлчихсэн байгаа учраас ийм асуудал үүссэн тохиолдолд бол хүүхдүүд хичээл, сургалтынхаа агуулгыг нөхөж эзэмшээд тэгээд хичээл, сургалтынхаа төгсөх болоод элсэлтийн ерөнхий шалгалтаа ороход бол ямар нэгэн саад

учрал учруулахгүй гэсэн ийм зүйл байгаа юм.

Гурав дахь асуудал дээр нь бол энэ ерөнхий хуулийн багш бэлтгэх тогтолцоо дээр бид нар аль болохоор илүү чанартай сайн багш бэлтгэх тогтолцоогоор өнөөдөр 12 ерөнхий хуулийн 12.2 дээр байгаа ерөнхий сургуулийн ахлах ангид багш мэргэжлийн сонгон бүлэг хичээллүүлж амжилттай төгссөнийг багш бэлтгэх дээд боловсролын байгууллагад элсүүлэхэд нь төрөөс дэмжлэг үзүүлнэ гэж байгаа. Энэ дэмжлэгийн журмыг бол Засгийн газар батална. Улсын төсөв дээр боловсролын зээлийн сантай холбоотой энэ багш бэлтгэх тогтолцоо дээр тодорхой санхүүжилт шийдэгдэх учраас энэ зээлийн сангийн багш бэлтгэх энэ тогтолцооныхоо хүрээнд шийдвэрлэх бүрэн бололцоотой гэдэг ийм тооцоо судал тооцоо судалгаа бол гарсан байгаа.

Л.Мөнхбаатар: Та тодруулах уу. Жигжидийн Батжаргал гишүүн тодруулж асууя.

Ж.Батжаргал: Үгүй ээ насан туршийн боловсролын түвшинд яриагүй л дээ. СӨБ, ЕБС хоёрын чинь түвшинд л ярьж байна. Сургалтын хөтөлбөрийн гэж яриад байгаа тэр хуулийн төслийн 10.1 дээр энэ хуулийн 8.2, 9.2-т заасан агуулгын хүрээнд сургалтын хөтөлбөр боловсруулна гэж байгаа юм. 8.2 нь СӨБ-ынх 9.2 нь ЕБС-ийнх л байгаад байгаа байхгүй юу. Тэгээд тэр 2 заалт дотор чинь ер энэ Монголын өөрийнх нь онцлог, үндэсний өв, соёлынх нь тухай үг, өгүүлбэр байхгүй. Тэгэхээр энэ СӨБ, ЕБС хоёрын чинь сургалтын хөтөлбөрөөр Монгол хүн болж төлөвших тэр төлөвшил нь яаж хангагдах юм гэдгийг би асуугаад байгаа юм. Тэр насан туршдаа боловсрох тухай асуудал дээр яриагүй.

Л.Мөнхбаатар: Энх-Амгалан сайд хариулъя.

Л.Энх-Амгалан: Батжаргал гишүүн ээ энэ түрүүний Англи хэлийг

хэддүгээр ангиас заах вэ, ямар цагаар заах вэ гэдэгтэй адилхан маргаан үүссэнтэй адилхнаар ингээд яг одоо СӨБ-ын түвшинд, ЕБС-ийн түвшинд ямар хичээлийг хэдэн цагаар заах вэ гэдэг чинь яг энэ хууль батлагдаад бид нар хөтөлбөрийн үзэл баримтлалаа батална шүү дээ Батжаргал гишүүнээ.

Тэгээд хөтөлбөрийн үзэл баримтлалууд ингээд батлахад бид нар одоо бага боловсролын анхан шат буюу 1-2 дугаар анги дээр бүүр онцлох хичээл гэж байгаад энэ Монгол ёс гэж хичээл одоо орох гэж байна Батжаргал гишүүнээ. Монгол ёс гэдэг хичээл дээр үндэсний ёс, заншил, хүндлэх ёс, Монголын бахархалт зүйл гэсэн ийм агуулгатай нэмэлт хичээлүүдийг одоо бид нар орж.

Ер нь бол энэ хуулийн гол зорилго чинь 21 дүгээр зууны аж үйлдвэрийн 4 дүгээр хувьсгалд амьдрах гэж байгаа Монголын альфа үеийнхнийг яаж Монгол хүн болгож бэлтгэх вэ, яаж Монголын ондоошил, national identity гэдэг юмнуудаа бид нар яаж хамгаалж үлдэх вэ гэдэг юмаар л бид нар одоо

Л.Мөнхбаатар: Гүйцээж хариулъя. 1 минутад багтаая.

Л.Энх-Амгалан: 1 минутад яг тайлбар хийхээр чинь хэцүү юм. Би хурлын дарга 3 минут яагаач тээ. Яг хууль тайлбарлаж байгаа учраас 1-хэн минут гэхээр ерөөсөө ямар ч тайлбар хийх бололцоогүй тасарчхаад байх юм. Тэгээд ийм л учиртай юм шүү дээ Батжаргал гишүүнээ. Одоо бид нарын энэ өмнөх хөтөлбөрийн сул тал юу байсан бэ гэхээр хүүхдийг дандаа академик мэдлэгээр бөмбөгдсөн байна. Нөгөө танхимаар авсан мэдлэгээ амьдрал дээр ур чадвар болгодог энэ чадварууд нь Монголын боловсролын сул тал юм байна, хөтөлбөрийн сул тал юм байна гэж.

Тэгэхээр цаашдаа бид нарын энэ гол зүйл бол мэдлэг, чадвар, төлөвшил гэсэн одоо энэ концепцуудаар явах нь

зүйтэй. Тэр дотроо одоо Монгол 21 дүгээр зуунд амьдрах Монгол хүнд заавал эзэмших ёстой энэ ур чадваруудаас гадна Монгол хүн болж төлөвших энэ агуулга, энэ хөтөлбөрүүд чинь яг энэ хуулийнхаа хөтөлбөр, агуулгынхаа хүрээнд хийгдээд ингээд л явчих юм.

Яг таны яг асуугаад байгаа аль аль дээд анги дээр яг ямар ямар хичээлүүд орох вэ гэдэг бол илүү хөтөлбөрийнхөө, хөтөлбөр батлагдсаны дараа хичээл хичээлийн цагуудаараа зохицуулагдаад явах.

Л.Мөнхбаатар: Батжаргал гишүүнээ та ахиад 1 удаа тодруулж болно. Тэнд нь 1 минутад багтаан бас хариулт өгөх боломж бол байна.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо санал хураалт явуулна. 33 зарчмын зөрүүтэй санал байна. Санал хураалтаа явуулах уу гишүүд ээ. Зарчмын зөрүүтэй 33 санал байна.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтын томъёоллыг та бүгдэд танилцуулъя.

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн төслийн талаар Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Нэг.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо дэмжсэн саналууд байна.

1.Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “эдгээртэй” гэснийг “эдгээр хуультай” гэж өөрчилж, 2.2 дахь хэсгийн “нэгдэн орсон” гэснийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Дамдинням, Амартүвшин, Баатарбилиг, Батшугар, Баярсайхан, Булгантуяа, Ганхуяг, Жаргалмаа, Мөнх-Оргил, Гомпилдоогийн Мөнхцэцэг, Ц.Мөнхцэцэг, Пүрэвдорж, Ундрам,

Чинзориг, Энхтүвшин цаашид ажлын хэсэг гэнэ. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Улсын Их Хурлын гишүүн гишүүн Чойжилсүрэн горимын санал гаргая.

Б.Чойжилсүрэн: Саяын санал хураалт дээр Мөнхбаатар даргаа энэ төхөөрөмж гацах шиг боллоо. Тэгээд саяын санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалгаж өгнө үү гэсэн горимын санал гаргаж байгаа юм.

Л.Мөнхбаатар: Чойжилсүрэн гишүүний гаргасан горимын саналаар энэ санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Санал хураалт.

51.4 хувиар санал дэмжигдлээ.

Хоёр, одоо санал хураалтаа явуулъя. Сая хүчингүйд тооцлоо. Санал хураалтын томъёоллыг уншиж танилцуулсан. Санал хураалт.

56.8 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн “оюун ухаан” гэснийг “танин мэдэхүй” гэж, 3.2 дахь хэсгийн “ёс зүйтэй” гэснийг “ёс суртахуунтай” гэж, 3.3 дахь хэсгийн “Сургалтын байгууллага” гэснийг “Хүүхдийн цэцэрлэг /цаашид “цэцэрлэг” гэх/, ерөнхий боловсролын сургууль” гэж, “захиргааны байгууллагатай” гэснийг “захиргааны байгууллага, иргэний нийгмийн байгууллагатай” гэж өөрчилж, 3.3 дахь хэсгийн “асран хамгаалагч” гэсний дараа “харгалзан дэмжигч,” гэж /цаашид тохиолдол бүрд/ нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

54.1 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийн 3-аас 5. За томъёоллыг уншаад танилцуулаадахъя.

Төслийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийн “3-5” гэснийг “2-5” гэж өөрчилж, 4.7 дахь хэсгийн “сургуульд” гэсний өмнө “ерөнхий боловсролын гэж” нэмж, мөн зүйлийн 4.3 дахь хэсгийг төслөөс хасаж, 4.1 дэх хэсгийг доор дурдсаар өөрчлөн найруулах:

4.1.Сургуулийн өмнөх боловсролыг 4, бага боловсролыг 5, суурь боловсролыг 9, бүрэн дунд боловсролыг 12 жилд эзэмшинэ. Санал гаргасан ажлын хэсэг.

Ирц хүрэхгүй болсон байна. Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 14.12-т заасны дагуу санал хураалтыг маргааш өглөө 10 цагаас үргэлжлүүлэн явуулна.

Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул чуулганы нэгдсэн хуралдааныг өндөрлүүлье.

Гишүүд, ажлын хэсэгт баярлалаа.

17.49 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР*

